



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ **ЁС**

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ,
ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ



ХУУЛЬ ТОГТООМЖ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ,
СУРТАЛЧИЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ

ХУУЛЬ ЁС ДЭЭДЛЭХ ЁС



2004
№2(05)

Улаанбаатар хот

Сонин, сэтгүүлийн нэгдсэн зөвлөлийн бүрэлдэхүүн:

Ц.Бат-Орших	- Сонин, сэтгүүлийн нэгдсэн зөвлөлийн ерөнхий эрхлэгч
А.Доржготов	- Улсын дээд шүүхийн шүүгч
Б.Цэрэялтал	- Улсын ерөнхий прокурорын орлогч
Н.Ганбаяр	- Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга
Ж.Амарсанаа	- Хууль зүйн үндэсний төвийн захирал
Ж.Эвхнасан	- Хууль зүйн үндэсний төвийн Захиргааны хэлтсийн дарга
Т.Мэндсайхан	- Хууль зүйн үндэсний төвийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч
Э.Лхагвасүрэн	- Үндсэн хуулийн цэцийн ажилтан
П.Цэцгээ	- Улсын дээд шүүхийн Судалгааны төвийн захирал
А.Эвхжав	- Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төвийн дарга
Ж.Сайнжаргал	- Цагдаагийн ерөнхий газрын Тамгын газрын дарга
Я.Сайнжаргал	- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын Ажлын албаны дарга
Б.Пүрэвням	- Монголын Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч
А.Оюунчимэг	- Монголын Нотариатчдын танхимын Ерөнхийлөгч
Д.Магдахбаяр	- Зөвлөлийн нарийн бичгийн дарга

Дугаарыг эрхэлсэн: **Н.ГАНБАЯР** -/Шүүхийн ерөнхий зөвлөлийн
Гүйцэтгэх нарийн бичгийн дарга/

М Э Н Д Ч И Л Г Э Э

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХАМТ ОЛОНД



Хүний эрх, хууль ёс, эрх чөлөө, шударга ёсыг дээдэлсэн хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах эрх зүйт төрийг төлөвшүүлэхэд бидний бүхий л үйл ажиллагаа чиглэгдэж ирсэн. Энэхүү зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, “Эрх зүйн шинэтгэл”, “Сайн засаглал” хөтөлбөр зэрэг бодлогын шинжтэй баримт бичгүүдийг боловсруулан батлуулж амжилттай хэрэгжүүлж ирлээ. Даяаршил, шинжлэх ухаан, мэдээллийн шинэ шинэ нээлт, хөгжил дэвшлийн эрин үед олон улсын эрх зүйд нийтлэг чиг хандлагыг баримжаа болгон хэрэгжүүлдэг буй эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үр нөлөөтэй тогтолцоог бий болгов. Үүний зэрэгцээ цаг үедээ нийцэж ажиллах чансаатай хуульчдыг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байгаа билээ.

Үүнтэй уялдуулан Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 121 дүгээр тогтоолоор Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төвийг байгуулсан явдал юм. Уг төв эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, мэдээллийн ажлыг төвлөрүүлж хуульчдыг сургах, давтан сургах их үйлсийн гараагаа амжилттай эхлээд байгааг тэмдэглэхэд нэн таатай байна. Энэ чиглэлээр хамгийн сүүлд УИХ-аас баталсан хуульчдаас сонгон шалгаруулах журмын тухай хуулийг хэрэгжүүлэх эрхийн хүрээнд аяа удаа ХЗДХЯ-тай хамтран уг шалгалтыг зохион байгуулсан явдал юм.

Үүний зэрэгцээ ХЗҮТ-ийг шинэ байртай болгох асуудлаар Монгол Улсын Загсийн газар, Дэлхийн банкны хооронд зээлийн гэрээ байгуулах “Шүүх эрх зүйн шинэтгэл” төслийг хэрэгжүүлэх болсон билээ. Энэ үндсэн дээр тус төслөөс ХЗҮТ-ийн барилгыг сүндэрлүүлэн ашиглалтад хүлээлгэн өгч байна.

Мэргэжил нэгт Та бидний төдийгүй эрх зүйн шинэ тогтолцооны түүхэнд шинэ хуудас болсон баярт энэ үйл явдлыг тохиолдуулан Та бүхний ажил үйлсэд улам их амжилт хүсэн ерөөе.

Энэ дугаарт:

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

Үндсэн хуулийн хөгжлийг сэдлэхэд шинэ хандлага нэн чухал (Гавиат хууль, доктор, профессор, ХЗУТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.ЧИМИД).....	3-14
Хууль зүйн нэр томъёог оновчтой болгох, зөв хэрэглэх асуудал (ХЗУТ-ийн секторын эрхлэгч С.ГЭРЭЛМАА).....	15-17
ХБНГУ-ЫН Үндсэн хуулийн шүүх-шүүх эрх мэдлийн хамгийн дээд зэргэмжийн шүүх болох нь (Үндсэн хуулийн цэцийн ажилтан Э.ЛХАГВАСҮРЭН).....	18-22

Иргэний хууль тогтоомж

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТҮҮХЭН ХӨГЖИЛ (ХЗУТ-ийн ЭША, докторант Н.ОТГОНЧИМЭГ).....	23-28
ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТЭМДЭГЛЭГЭЭ (ХЗУТ-ийн секторын эрхлэгч, Удирдлагын Академийн ахлах багш Д.ЦОЛМОН).....	29-36
ӨӨРТӨӨ ТУСЛАХ ЭРХИЙН МӨН ЧАНАР, ОНЦЛОГ (ХЗУТ-ийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч, доктор Т.МЭНДСАЙХАН).....	37-39
БУСДЫН ГАЗАР ДЭЭР БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ ЭРХ (ХЗДХЯ-ны ахлах мэргэжилтэн Д.ОТГОНЧИМЭГ).....	40-42
"НЭР, НЭР ТӨР, АЛДАР ХҮНД, АЖИЛ ХЭРГИЙН НЭР ХҮНДИЙН ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА НЬ (Нийслэлийн шүүхийн шүүгч Л.ВЯМБАА).....	43-44

Шүүх эрх мэдэл

ГААЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ЗӨВ ХЭРЭГЛЭХ АСУУДАЛ (УДШ-ийн шүүгч О.ЗАНДРАА).....	45-46
ФИДУЦИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ (УДШ-ийн дэргэдэх шүүхийн судалгааны төвийн захирал П.ЦЭЦГЭЭ).....	47-48
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА (ХЗУТ-ийн ЭША, докторант Н.ОТГОНЧИМЭГ).....	49-53
ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН БАЙДЛЫН СУДАЛГАА (ШУА философи сошиологийн эрх зүйн хүрээлэн Хууль зүйн судалгааны төв ЭША Д.ЗОЛЗАЯА).....	54-56

Прокурорын хяналт

МОРДОН БАЙЦААХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮРЭН ЭРХ (УЕШГ-ийн туслах, мордон байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Т.СҮХБААТАР).....	57-64
---	-------

Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ БА ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ (ХЗУТ-ийн ЭША Ч.НАРАНТУЯА).....	65-71
ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ЭРХ ЗҮЙН ТУХАЙ ВЕНИЙН КОНВЕНЦ БА "МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ" (ХЗУТ-ийн ЭША С.ДОЛЖИН).....	72-74

Криминологи

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН БОЛОН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН ШИНЭТГЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ (ХЗУТ-ийн секторын эрхлэгч, доктор, профессор Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ).....	75-79
--	-------

Эрх зүйн үйлчилгээ

ЭРҮҮГИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНД ӨМГӨӨЛӨГЧ МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭГ ТАЛ БОЛОХ НЬ (МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч Я.НЯМЖАВ).....	80-84
ХУУЛИЙН ЗӨВЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДАЛ ХЗУТ-ийн ЭША БАТТОГТОХ.....	85-90
НОТАРИАТЧДАД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ (Монголын Нотариатчдын танхимын ажилтан П.УЯНГА).....	91-92
ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН НЭР (Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ю.ЭНХТҮВШИН).....	93-96

Мэдээлэл

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ.....	97
АМЕРИКИЙН БААРЫН ХОЛБООНЫ "АЗИЙН ЭРХ ЗҮЙН САНААЧИЛГА ТӨСӨЛ".....	98

Үндсэн хуулийн хөгжлийг судлахад шинэ хандлага нэн чухал



Гавьяат хуульч, доктор, профессор, ХЗҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Б.ЧИМИД

Монгол Улсын хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны Үндэсний төвийн өргөөг нээж, зулыг асаах үйл явдлыг тохиолдуулан хийж буй¹ Олон улсын онол, эрдэм шинжилгээний бага хуралд илтгэл болсноо аз завшаантай учрал хэмээн бэлэгшээж байна.

Энэ ялдамд Үндсэн хуульд байгуулалд шиджихийн төлөө ахмад үеийн мятаршгүй хүчин чармайлт, дэвшилтэт үзэл хийгээд мөнхийн гавьяат үйлсийг магтан дуулахын хамт Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжлийг үечлэх асуудлаар өөрийн арга буюу хүрсэн дүгнэлт, сэтгэлдээ тээж явдаг зарим санааг хол, ойрын зочин Та бүхэнтэй хуваалцах гэсэн юм.

1. Судалгааны арга зүй, гол хандлагыг шинэтгэх нь

Монголын ард түмэн Үндсэн хуульд байгуулалд шилжсээр найдам арванг илээв. Анхны Үндсэн хуулийн 80 жилийнх нь ой 2004 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 16 цаг 17 минутад тохионо. Тэртээ 1924 оны мөн сар, өдөр, цагт Улсын анхдугаар Их Хурал БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийг санаад нэгтэй баталж “Бүх Монгол Улсыг үүнээс хойш Бүгд Найрамдах Бүрэн эрхтэй Ард Улс гэж Улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн улсын аливаа хэргийг Улсын Их Хурал ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүсэглэн дагавал зохино” гэж тунхаглажээ.

Үндсэн хууль батлагдсантай холбогдуулан Улсын анхдугаар Их Хурлаас гаргасан сэнхрүүлэн ухуулах бичигт БНМАУ-ын Үндсэн хууль батлан тогтоосон нь “... бидний монгол язгууртанд хэдэн зуун оноос нааш үзэгдсэнгүй гайхамшигт хэрэг болох...”²-ын тул гэр бүл бүр мэдэж, хүн бүр ухаж нийтээр журамлан дагаж биелүүлэхийг уриалжээ. Тэр цагаас анхны Үндсэн хуулийг 16 жил орчим дагаж мөрдсөн

ажгуу. Түүнээс хойш Монгол Улс 1940, 1960 оны Үндсэн хуулийг дараалан 20-30 жил мөрдөж, 1990 оны “Үндсэн хуудийн нэмэлтийн хууль”-аар дамжин өдгөөгийн шинэ Үндсэн хуульд шилжсэн юм. Монгол Улсын Үндсэн хуулийг БНМАУ-ын Ардын Их Хурал 1992 оны 1 дүгээр сарын 13-нд баталж, мөн оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Түүнд 2000 онд 7 зүйлийн өөрчлөлт оруулжээ.

Эдгээр Үндсэн хууль Монгол Улсын тусгаар тогтносон бүрэн эрхт байдал, төрийн байгууллын тогтолцоог хуульчлан бэхжүүлж ирсвэрээ онцгой ач холбогдолтой, нийтлэг шинжтэй билээ. Тэгвч гүйцэтгэсэн түүхэн үүрэг, бүтэц агуулгын, түүгээр ч барахгүй мөн чанарын хувьд Үндсэн хуулийн хоёр өөр хэв маягт хамаарах зарчмын ялгаатай юм.

Монголчуудын хувьд Мөмнөх Үндсэн хуулиудыг саяхан болтол гагцхүү ангич, намч байр суурь, марксист-ленинст онол, арга зүйн үүднээс хандан судалж, дийлэнхдээ магтах өнгөөр тайлбарлаж ирсэн. Тэр цаг үед судлагдахуун нь бүхэлдээ социалист маягт багтах нийгэм, өөрөөр хэлбэл, социализмд шилжих буюу түүнийг байгуулахад шууд

1.Төвийн байрыг 5 дугаар сарын 19-нд нээхээр захиалагч, гүйцэтгэгч хоёр тохирсныг үндэслэн Олон улсын Бага хурлыг энэ үйл явдлыг тохиолдуулан хийхээр төвлөж гадаадын зочидод урилга явуулсан юм. Гэтэл гүйцэтгэгч ажлаа цагтаа амжуулаагүй тул барилга хүлээлэх нь хойшилж Бага хурал нь 20-индоо болж өнгөрөв. Б.Ч

2.БНМАУ-ын Их Бага Хурлын тогтоол. Үндсэн хууль, Тунхагууд. Улсын хэвлэлийн газар, УБ., 1956 он, 28 дахь талд.

чиглэсэн бодлого, харилцаа байв. Өмнөх 3 удаагийн Үндсэн хууль цаг, төрөө дагаж Монгол орны тусгаар тогтнол, хөгжилд өөр өөрийн чухал ач холбогдлыг үзүүлсэн магтах ч, бахархах ч юмтай нь маргаангүй болов уу. Гэсэн хэдий ч түүгээр сонгосон зам, томъёолсон үзэл, тогтоосон зарчим нь сүрхий гажуудалд хүргэсэн нь одоо нэгэнт тодорхой болжээ. Учир иймд Монгол Улс 1990 оноос тэр зам, түүний луужин болсон марксист сургаал тэргүүтнээс татгалзаж, хүн төрөлхтний жам ёсны хөгжлийн замыг сонгож, түүний үндэс зарчмыг шинэ ардчилсан Үндсэн хуулиараа бэхжүүлсэн юм.

Энэ мэт эрс тэс өөрчлөлт нь намч, ангич, үзэл сурталч байр сууриас ангижирч төрийн эрх зүйн үзэгдлийг онолын шинэ хандлага, арга зүй, аргаар шинжлэн судалж, үнэн магадтай дүгнэлт хийж, сургаж авах зайлшгүй шаардлагыг төрүүлэв.

Үндсэн хуулийн хэв маяг (төрөл), хэлбэр гэдэг бол дур зоргоороо биш, бодит шалгуураар тодорхойлдог шинжлэх ухааны (мэргэжлийн) ойлголт мөн.

Монголын нийгэмд шинэтгэл хийж эхэлсэн 1990-ээд оноос хойшхи цөөн жилд нийгмийн ухамсар, тэр дундаа эрх зүйн ухамсар эрх биш шинэчлэгдсээр буй нь ойлгомжтой. Гэвч бид шинжлэл судлалынхаа хуучин хандлага, аргаас төдий л зоригтой салж, олигтой холдож чадаагүй, айдас хүйдсээс ч бас бүрэн ангижраагүй, тэр ч байтугай илт хуучинсагаар хандах явдал байсаар буйг нуухын хэрэг огт үгүй. "Даравч дардайна, булавч бултайна" гэдэг билээ.

1992 оноос хойш манай оронд Төрийн буюу Үндсэн хуулийн эрх зүйн^{*} ном зохиол элбэгшсэн нь талархан дэмжүүштэй үйлс мөн. Шинэ Үндсэн хуульд тулгуурласан ном зохиолд шинэ соргог санаа байлгүй яахав. Харин Монгол Улс Үндсэн хуульд байгуулалд шилжин орж, оршин хөгжсөн үйл явц, үр дагаврыг өмнөх, хойнохтой нь жишин шинжих, бүхэлд нь судлах шинжлэх ухааны арга зүй, арга хандлага нь хэр шинэчлэгдэж вэ? гэдэгт сэтгэл ханах хараахан болоогүй мэт. Ялангуяа Үндсэн хуулиуд, тэдгээрт холбогдох актуудыг тухайн үеийн амьдралтай холбож түүхчлэн, харьцуулан судалж учир шалтгааны дүгнэлт хийх нь төдий л ажиглагдахгүй байна. Түүнчилэн дэлхийн бусад орны ижилсэх, ондоосох үзэгдэл юмтай харьцуулан харгалзах буюу баримжаалахын оронд бүх юм цоо шинээр гэнэт гарч ирсэн юм шиг, эсхүл дэлхийн улсуудад байгаа бүхэн нь Монголд яг тохирох хосгүй хувилбар мэт өнгөц салхилж, дээгүүр шуурах, түүхэн үзэгдлийг зөвхөн эдүгээчлэх, хий хоосон орон зай байсан мэт үгүйсгэх зэрэг хандлага үзэгдсээр буйг тэвчихэд бэрх.

Монгол Улс маань Үндсэн хуулийн "үнэр авч" тийм байгуулал тогтоох онол ном судалж, олон хувилбар боловсруулж хэрэглэсээр бараг 100 жил болж буй орон шүү дээ. Ахмад үе алдсан, оносон ч их зүйл хийсэн, судалж номлосон байдаг. Сүүлийн жилүүдэд (1992 оноос хойш) гарч буй бүтээлүүдээс үзэхэд Үндсэн хуулийн хөгжлийг их л бодож батлагдсан оноор нь үечлэх, өчнөөн төчнөөн бүлэг, зүйлтэй гэхчлэн зөвхөн бүтцээр хучиж,

мөн чанарыг бүрхэгдүүлэх, онолын ултай дүгнэлт хийхийн оронд хуулиа хуулбарлан хуудас зузааруулахаас нэг их хэтрэхгүй байна. Энэ бол бидний сүрхий доголдол мөн. Ер нь хэлбэрдэж, хялбарчлаад үзэл баримтлал, мөн чанар, гүйцэтгэсэн чиг үүрэг зэрэг агуулгын чанартай шалгуурыг баримтлан Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны ангилал хийж, дүгнэлт өгөхөөс зайлсхийгээд байх шиг. Ийм үлэвгэр хандлага танин мэдэхүйд хийгээд ажил хэрэгт ач тусаа өгөхгүй нь тодорхой. Харин Үндсэн хуулийн үзэл баримтлал, тогтоосон улс төрийн дэглэм, төр, нийгмийн харилцааны мөн чанарын үүднээс агуулгын чанартай шалгуураар ангилан үзвээс түүний үүрэг, ач холбогдол, үр дагаврыг ойлгоход илүү дөхөм үзүүлнэ. Үндсэн хуулийн хөгжлийн үечлэл, тэр бүхнийг агуулга, мөн чанарын нийтлэг хийгээд онцлог нь эрх зүйн бусад салбарын хөгжлийг зөв үечилж тодорхойлох арга зүйн үндэс, суурь шалгуур болно. Иймд он цагийн тоон үзүүлэлтээр биш, онцгой ач холбогдлыг нь илэрхийлэх шалгуураар ангилах нь илүү унацтай байхсан билээ. Жишээлэхэд төр, нийгмийн байгууллын үндсийг тодорхойлохдоо:

* ямар онол буюу үзэл баримтлалыг удирдлага болгон бэхжүүлснээр нь Үндсэн хуулийг марксист үзэл онол баримталсан, либерал үзэл баримталсан гэсэн хоёр хэв маягт;

* нийгмийн байгууллын ямар үндэс, улс төрийн ямар дэглэм тогтоосныг нь гол шалгуур болговоос ардчилсан бус (тоталитар, авторитар гэх

* Энэ хоёр ойлголт ялгавтай ч судлах зүйлийн хувьд нэлээд хэмжээгээр давхцаж тул адилсах талаас нь авч үзэв. Зохиогч.

мэт), ардчилсан гэхчилэн ангилан ялгах нь зүй. Эцсийн дүнд мөн чанараар нь социалист маягийн, ардчилсан маягийн Үндсэн хууль гэсэн хоёр их хэв маягт хуваан үечлэх нь Монголын Үндсэн хуулийн хөгжлийн, улмаар бусад салбар эрх зүйн өнгөрсөн, одоог тодорхойлох суурь ач холбогдолтой юм. Гэтэл Монголын 4 удаагийн үндсэн, 1 удаагийн нэмэлтийн хуулийг энэ мэт шалгуураар биш зөвхөн батлагдсан он дараалаар “үечлээд” түүний хөгжлийг 1924-1940; 1940-1960; 1960-1992 орны; 1992 оноос өдгөө гэсэн дөрвөн үед хуваадаг зуршил тогтжээ. Энэ бол хамгийн хялбар, маргашгүй мэт боловч нэгэнт өнгөрөн төгссөн цаг, түүхэн үйл явцын гадна талыг буюу бүрхүүлийг нь харуулснаас биш, “арьсан доорхи” гүнд орж мөн чанар, олон талын ач холбогдлыг илэрхийлсэн үнэлэмж болж хараахан чадахгүй байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжлийг үечлэх нь
Үечлэхэд үзэгдлийн уг чанарыг илэрхийлэхүйц шалгуур чухал. Хэрэв дэлхийн улсуудын үндсэн хуулиудын төрөл буюу хэв маягийг харгалзан үзэл баримтлал, мөн чанарын шалгуур баримтаас Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжлийг нь:

1) социалист (тоталитар) маягийн Үндсэн хуулийн;

2) ардчилсан маягийн Үндсэн хуулийн үе гэх хоёр үндсэн үед хуваан үзэх нь арга зүйн хувьд илүү оновчтой мэт. Эхлээд үндсэн үед хуваах нь түүний доторхи Үндсэн хууль нэг бүрийн талаархи хууль тогтоомжийн хөгжлийг бичил буюу зурвас үеүдэд хуваан үзэхийг үгүйсгэхгүй харин чухалчлах юм. Гэхдээ үндсэн үечлэлийг алгасах нь мөн чанар,

үүрэг, ач холбогдлыг нь гуйвуулан төөрөгдүүлэхэд хүргэнэ гэдгийг хайхрахгүй байж болохгүй. Нөгөөтэйгээр нэг үндсэн үеийн доторхи дорвитой “тоон” өөрчлөлтийг эс анзаарвал хөгжлийн талаархи зэрэг, сөрөг талыг олж харахгүй бүдүүвчлэхэд хүрч мэднэ. Ерөнхийгөөс тусгайд шилжин шинжлэх гэдэг энэ буюу.

3. Социалист маягийн Үндсэн хуулийн тухай

БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулийг социалист гэх нэгэн маягт хамааруулж ангилах нь үнэнд илүү нийцнэ. Харин энэ гурвын дундаас анхны Үндсэн хууль онцгой агаад, түүнийг яагаад социалист маягт хамааруулах тухай эргэлзэх хүн байж болох юм. Үүнийг энгийн ухамсрын түвшинд нотлон ойлгуулах нь амаргүй бололтой. Юуны өмнө “Завсрын нийгэм” гэж байхгүй. Харин нэг тогтолцооноос салж, нөгөөд шилжих гэж бий.

XX зуунд колони, хараат байдлаас ангижирсан орнуудын нэг хэсэг нь социалист (Зөвлөлт) нөгөө хэсэг нь “хөрөнгөтний” нийгмийн чиг баримжаагаар замнасныг түүх мэднэ. Энэ шалгуураар үзвэл Монгол Улсын анхны Үндсэн хуулийг шууд социалист биш гэхнээ тэр зүгийн чиг баримжаатай хууль гэж ангилахаас аргагүй юм.

Нэн хураангуйлбал, Улсынхаа зорилгыг нийгэм журмын чиг баримжаагаар тунхагласан, төрийн нийгмийн үндсийг гагцхүү жинхэнэ ардын (ангийн) үүднээс бэхжүүлсэн, төрийн төв, орон нутгийн байгууллагын тогтолцоог Зөвлөлүүдийн үзэл санааг удирдлага болгон тодорхойлсон, Үндсэн хуулиа Орос-Зөвлөлтийн үндсэн хуулийн агуулгаар болон Коминтерний

заавар, шууд оролцоотойгоор боловсруулж, хэлэлцэн баталсан зэрэг нь уг хуулийг социалист чиг баримжаатай болгожээ. Зорилгын тухай хойно товч дурдав. Харин уг төслийг хэлэлцэхэд Коминтерний төлөөлөгчид УИХ-ын төлөөлөгч лугаа адил 20 гаруй удаа үг хэлж тайлбарлаж, санал оруулж батлуулан бас хяцан найруулах комиссоод орж ажилласныг “тус” гэж үзэхээсээ бүрэн эрхт улсын дотоод хэрэгт хутгалдан оролцож өөрсдийн үзэл зорилгоо тусгасан гэж дүгнэх нь бодитой болов уу!

Анхны Үндсэн хуулийг ийнхүү ангилах нь Монгол төр улсад түүний гүйцэтгэсэн дэвшилт үүргийг үгүйсгэхэд хүргэж болохгүй билээ.

3.1. Анхны Үндсэн хуулийг онцлон үзэхийг учир

Монгол Улс бол хүн төрөлхтний хөгжлийн жам ёсны замаас хазайж олон он жил алгуурласан хэдий ч колончлолын тогтолцоонд татагдан орсон Азийн орнуудаас бараг хамгийн түрүүн улс төрийн тусгаар тогтнолоо тунхаглаж, Үндсэн хуульт байгуулалд шилжсэн орон билээ. Тухайлбал, анхны Үндсэн хуулиа бүүр 1924 онд батлан 16 жил мөрдсөнийг өмнө дурдсан. Үүгээрээ монголчууд бид бахархах эрхтэй.

Анхдагч байна гэдэг үнэхээр нэр төртэй, ач гавьяатай үйлс мөх. Тэр гавьяат үйлсийг амар хялбарар бүтээгээгүй. Тоймлон өгүүлбэл XX дугаар зууны эхэн үеийн ардчилсан үзэлтнүүдийн тэргүүлсэн ахмад үе маань 1911-1921 онд Үндэсний эрх чөлөөний төлөө болон үндэсний ардчилсан (үргэлжилсэн) хувьсгал хийж, улс орноо манжийн эзэгнэлээс гаргаж, харийн түрэмгийлэгчдийг зайлуулан өөрсдөө эзэн сууж, улмаар 1921 оноос хамжлагат ёсыг халахад чиглэсэн өөрчлөлт

хийж эхэлсэн юм. 1921-1924 онд урьдач бүх нөхцөлийг нь бүрдүүлэн энэ ололтоо төрийн гол хуулиар бэхжүүлсэн нь үнэнхүү дэвшил байв. Энэ бүхнээс зөвхөн Үндсэн хууль боловсруулж, баталсан хийгээд уг хуулийн үүрэг, ач холбогдол, үндсэн шинжийг илэрхийлэх нь төрийн эрх зүйн шинжлэх ухааны шууд үүрэг билээ.

Монголчууд олон жилийн тэмцлийнхээ ачаар 1911 онд манжийн захиргаанаас гарч тусгаар тогтнолоо зарласны хойно төр улсаа орчин үеийн жишгээр төвхиүүлэхийн тулд барууны хөгжилтэй орнуудын төрийн байгуулал, эрх зүйн тогтолцоог сонирхон судлах болжээ.

Богд хаант улсын Засгийн газар 1912 оноос номч мэргэн хүмүүст даалгавар өгч, судлуулахын зэрэгцээ тэр үеийн ардчилсан үзэлтнүүд парламентат ёс, Үндсэн хуулийн байгуулал тогтоох эрмэлзлэлтэйгээ илэрхийлсэн, эхэлж оролдсон баримтууд цөөнгүй бий.

1914 онд хаанд зөвлөх эрхтэй Улсын дээд, доод хурал байгуулсан нь барууны Үндсэн хуульд хаант ёсыг харгалзсан хэрэг мөн байлаа. Энэ үед Богдын Засгийн газрын Ерөнхий сайд, Сайн ноён хан Намнансүрэнгийн даалгавраар Цэвээн Жамсранов хөгжилтэй орнуудын төрийн эрх зүйн талаар тоймчилсон судалгаа хийж “Улсын эрх” гэдэг судалгааны тайлан бичиж үлдэсэн байдаг. Түүнийг түүхч С.Ичиноров шинэ үсэгт хөрвүүлж, МУИС-ийн Хууль зүйн сургууль “Эрх зүй” сэтгүүлдээ нийтэлжээ¹. Мөнхүү Цэвээн Жамсранов, түүнчлэн Ж.Бодоо нарын боловсруулсан гэх Үндсэн хуулийн төслийн ноорог Улсын түүхийн архивт хадгалагдаж буй нь дотоод,

гадаадын судлаачдын сонирхлыг татсаар буй. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг Засгийн газрын төвшинд боловсруулах ажил 1922 онд Засгийн газрын тусгай комисс байгуулснаар албан ёсоор эхэлсэн² гэж тооцдог.

Мөн 1920-1921 онд Үндэсний хувьсгалт тэмцлийн гол зорилгыг тодорхойлон боловсруулсан зүтгэлтэн нар “Ардын засгийн үндсэн журам”, “Монгол Улсын шинэ ард олны эрхийг төвийн ба нутгийн засгийн янз төлөв” өгүүлэл хийгээд “Монголын ардын хэргийг түр ерөнхийлөн захирах газар” байгуулсан тухай тогтоол, тунхаглал зэрэг гол гол баримт бичигт Үндсэн хуульд Бүгд Найрамдах байгуулал тогтоох тухай санаа зорилгоо ил тодоор илэрхийлж байжээ. Жишээлбэл, 1921 оны 3 дугаар сарын 13-нд Ардын түр Засгийн газрыг байгуулсан тухай тогтоолд “... Монгол Ардын Төлөөлөгчдийн Их хурлыг зарлан хуралдуулж үүрд байх Засгийн газрыг байгуулж улсын үндсэн цааз дүрмийг тогтоолгосугай”³ гэж бичсэн бий. Энд “Конституци” гэдгийг Үндсэн цааз дүрэм гэсэн бололтой.

Бодоо тэргүүтэй Засгийн газар 1921 оноос үндсэн хуульчилсан актууд боловсруулах ажилд орсны зэрэгцээгээр 1922 онд Засгийн газрын 1922 оны 5 дугаар сарын 19-ний 21 дүгээр хурлын тогтоолоор Ардын засгийн Шүүх явдлын яамны тэргүүн сайд Магсаржав тэргүүтэй комиссыг байгуулсан бөгөөд тус комисс барууны ардчилсан гэх орнуудын хууль зүйлийг судалж, орчуулж байсан баримт бий. Энэ ажилд шинэхэн байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнг оролцуулсан бололтой байдаг.

Үндсэн хууль батлахын явц Монгол Улс нь 1921-1924 онд “Монгол Улсын Ардын Засгийн газрын Хурлын түр зуурын дүрэм” (1921.09.12); “Улсын түр цагийн хурлын дүрэм” (1921.09.20); “Тангаргийн гэрээ дүрэм” (1921.11.01); “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм” (1921.03.05); “Бүгд Найрамдах засаг тогтоон явуулах тухай Ардын Засгийн газрын тогтоол” (1924.06.13) гэх зэрэг Үндсэн хуулийн шинжтэй цөөнгүй дүрэм, тогтоол гарган төр улсаа төвхиүүлж, анхны үндсэн хуулиар Бүгд Найрамдах засгийг бэхжүүлэх хууль зүйн нөхцөл бүрдүүлсэн байдаг. Энэ бүхэн нийгэмд Үндсэн хуулийн шинэ ухамсар бүрэлдэхэд бодитой нөлөөлсөн нь магадгүй билээ. Тухайн үед үндэсний ардчилсан үзэлтнүүд, Коминтерний талыг баримтлагчдын хооронд үзэл баримтлалын зөрөө гарснаас барууны орнуудын чигийг баримталсан өмнө комиссыг татан буулгаж Ерөнхий сайд Б.Цэрэндорж тэргүүтэй өөр комисс байгуулжээ. Т у с комисс коминтерний оролцоотойгоор БНМАУ-ын Үндсэн хуулийн шинэ төслийг богино хугацаанд боловсруулж УИХ-д оруулсан түүхтэй. Уг төслийг Монгол Улсын Анхдугаар Их Хурал 1924 оны 11 дүгээр сарын 25-26-нд 2 өдөр зүйл бүрээр нь хэлэлцэж 26-ны 16 цаг 17 хоромд, мөн Их Хурлын 14 дүгээр тогтоолоор баталсан байна. Энэхүү Үндсэн хууль нь БНУ-ыг тунхаглаж, түүний үндэс тулгуурлыг бэхжүүлсэн бөгөөд Монголын шинэ эрх зүйн суурь болсон анхны гол хууль мөнөөрөө ХХ зууны Монгол төр эрх зүйн түүхэнд сод байрыг эзэлнэ. Энэ бол бидний гол үнэлэмж болно.

1. “Эрх зүй” сэтгүүл, 2000 он №2-3

2. С.Жалан-Аажав. Ардын төрийн хууль тогтоох үйл ажиллагаа (1921-1940). УБ., 1967.

3. Монгол Бүгд найрамдах засаг байгуулсан нь /баримт бичгийн эмхтгэл/. УБ., 1970 он, 7 дугаар талд.

Анхдугаар Үндсэн хууль нь 4 зүйлт оршлоос гадна:

1 дүгээр бүлэг Жинхэнэ ардын эрх чөлөөг илтгэн тунхаглах нь
2 дугаар бүлэг Улсын дээд эрхийг барих газрын тухай

- Улсын Их Хурлын тухай
- Улсын бага хурлын тухай
- Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн тухай
- Засгийн газрын тухай

3 дугаар бүлэг Нутгийн захиргааны тухай

4 дүгээр бүлэг Сонгох сонгогдох эрхийн тухай

5 дугаар бүлэг Улсын орлого зарлагын эрхийн тухай

6 дугаар бүлэг Улсын тамга ба сүлд тэмдэг, туг далбаа гурвын тухай

3 зүйл
26 зүйл

4 зүйл

3 зүйл

10 зүйл

4 зүйл

бүгд 6 бүлэг, 50 зүйлтэйг бүгд мэднэ. Харин мөн чанар, хууль зүйн ач холбогдол, дэвшилтэд хийгээд сул тал нь юу вэ? гэдэг бол Үндсэн хуулийн тухай олонын судалгааны гол асуулт мөн. Түүний үндсэн ач холбогдлыг дараах хэдэн зүйлээр тодорхойлж болох болов уу?

• Монгол Улсынхаа тусгаар тогтнолыг Үндсэн хуулийн хэмжээнд тунхагласнаар түүнийгээ олон улсын “нүдний өмнө барьж” улс төр, эдийн засгийн бүрэн тусгаар байдлын төлөө тэмцэх хууль зүйн үндсийг тавьсан. Хэдийгээр эл зорилгод удтал бүрнээ хүрч чадаагүй ч дараа дараагийн Үндсэн хуульд залгамжлуулан дэлхийн II дайны дараа БНХАУ болон бусад зарим оронд, 1961 онд НҮБ-ын гишүүн болсноор хамтын нийгэмлэгийн гишүүн бүх оронд тус тус бүрэн эрхт тусгаар улс гэдгээ хүлээн зөвшөөрүүлж чадсан юм.

• Хамжлага эзэмшлийн харилцааг үндсээр нь калж хамжлага, шавь, ардыг эзний хараатаас улсын иргэн болгож, хүн амын олонхи болох жинхэнэ ардын (иргэдийн) эрх, үүрэг гэдэг цоо шинэ институт бий болгосон. (Гэхдээ энэ нь “хүний эрх”-ийн гэсэн үг биш);

• Төрийн захиргааны хаант хэлбэрийг халж, илүү дэвшилтэй Бүгд найрамдах ёсыг тогтоон, Монголын төрийн

байгууллагуудын /Их, бага хурал, түүний Тэргүүлэгчид, Засгийн газар, яамд гээсн/ шигэ тогтолцоог бэхжүүлсэн;

□Төрийн байгууламжийн нэгдмэл хэлбэрийг тогтоож, нутгийн захиргааны 5 шатат тогтоолцооны (10 гэр, баг, сум, хошуу, аймгийн) үндсийг бэхжүүлсэн;

• Улсын эдийн засгийн суурь, улсын төсвийн орлого, зарлагын тогтолцоог тодорхойлсноороо төрийн эдийн засаг, санхүүгийн үндсийг анхлан тогтоосон;

• Хууль зүйн хувьд БНМАУ-д эх газрын төстэй, Зөвлөлтийн нөлөөтэй эрх зүйн шинэ тогтолцоо бүрдэх суурь нь болж өгсөн зэрэгт түүний гол ач холбогдол оршино.

“Сайны хажууд саар” гэгчээр бас Анхдугаар Үндсэн хуульд өдгөө түүхээр нэгэнт гэрчлэгдсэн ноцтой сөрөг тал байсныг үнэнээр өнгөрүүлэхээс зайлсхийх хэрэгцээ, шаардлага байхгүй. Чингэвээс сургамж авч, зөв замаар тууштай урагшлахад далдуур боловч саад бэрхшээл учруулахгүй гэх газаргүй. Түүний сөрөг тал гэвэл:

• Дэлхийн улсуудын хөгжлийн сонголтын үүднээс үзвэл бусдын эзэгнэл, колончлолоос гарсан буурай хөгжилтэй орнуудын өмнө ардчилал, зах зээлийн гэх жам ёсны хөгжлийн, эсвэл нийгэм журам гэх гажуудлын ийм 2 зам

тулгарсан бөгөөд монголчууд 1924 оны Үндсэн хуулиараа сүүлчийн замыг сонгосон нь төөрөгдөл болжээ.

• Хэдийгээр төрийн захиргааны өмнөхөөс илүү, орчин цагийн БНУ хэлбэрийг сонгосон хэдий ч түүнийг хэрэгжүүлдэг засаг төрийн байгууллагын төвлөрсөн тогтолцоог бэхжүүлсэн байв. Үүнийг цаг үеийн шаардлага мэтээр тайлж болох талтай боловч тэр нь чинагшид залгамжлагдан чангарсанаараа гажуудалд хүргэжээ. Уул нь Үндсэн хууль бол урсгал байдал буюу “цаг үеийн шаардлага”-д үл захирагдах учиртай.

• Төрийн байгууллын нийгэмшлийн үндсийг “большевик” маягаар сонгож пролетари буюу эсвэл “ажилчин, тариачин” хэмээний оронд “жинхэнэ ард” гэж хүн амын асар олонхийн хамгийн ядуулаг хэсгийг засгийн эрхийн эх үүсвэр болгосон байна. Ингэснээр монголын ард түмнийг улс төрийн хагарал оруулж нэг хэсэг нь нөгөө хэсгийгээ “ангийн хувьд устгах” хэт зүүний үзэл баримтлалд автан “улаан хувьсгалч”-ийн хэлмэгдүүдэлд хүргэсэн гэх үндэстэй. Тухайлбал, Монголын нийт хүн амын дотрөөс 5 бүлэг¹ иргэний, түүний дотор:

- 1) ашгийг эрмэлзэн бусдыг зарж амьдрагчид;
- 2) жинхэнэ худалдааны ба мөнгө хүүлэгчид;

1.1924 оны БНМАУ-ын Үндсэн хуулийн 35 дугаар зүйл.Эл зүйл ёсоор ухаан солио гэж тогтоогдсон хийгээд ялтын /шийтгэгдсэн хүний/ сонгуулийн эрхийг мөн хягаарласан нь эрх зүйн чадамжийн үүднээс зүй ёсны гэж үзэж болох юм.Б.Ч.

3) ван, гүн, хутагт хувилгаад, сүм хийдэд үргэлж суух санваартан лам нарын сонгох, сонгогдох буюу хэрэг дээрээ улс төрийн эрхийг хассан байв. Энэ бол олон мянган хүнийг хэлмэгдүүлсэн аймшигт үр дагаварт хүргэсэнээрээ уг Үндсэн хуулийн хамгийн том хар толбо болсон юм.

Эхний гурван давхрааны иргэдийг одоогийн хэллэгт буулгавал үйлдвэр, худалдаа эрхлэгчид (бизнесмен) хөрөнгөтөн, язгуур угсаатан нар, шашин номын үйл эрхлэгчид гэх утгаар эрхийг нь хасаж оруулсан бололтой байна. Үүнийг тэр үед Засгийн газраас гаргасан 1924 оны Үндсэн хуулийн албан ёсны тайлбар нотолно. Тэнд "... нэгдгээр, хоёрдугаар ангид дурдсан хүмүүс болвоос ард түмний ашиг тусыг өчүүхэн ч хайхрахгүй, дан ганц өөрсдийн хувийн ашиг завшааныг эрхэмлэн ямагт бусдыг мөлжин хохируулагчид болох" гээд 1 дүгээр ангийн хүмүүс монголд хараахан байхгүй ч хойшид гарч ирвэл үгүй болгоход бэрх. 2 дугаар ангийн хүмүүс хааяа үзэгдсээр буй, гуравдагч ангид дурдсан ван, гүн, хутагт хувилгаад бол ард түмнийг хээсэг, бүлгээр нь боолчлон дарлаж ирсэн учраас тэдэнд, бас төрөөс шашныг тусгаарласан тул лам нарт сонгох, сонгогдох эрх олгох нь үл зохиолдоо гэх зэргээр тайлбарлажээ.

Дурдсан үзэл баримтлалыг 1940 оны Үндсэн хуульд улам лавшруулсан аж. Энэ тухай уг хуулийн төслийн комиссын дарга, Ерөнхий сайд агсан Х.Чойбалсангийн илтгэлд: "... Манай засаг бол ардын засаг мөн. Бид нар мөлжимтгийг феодальн ангийг устгасан боловч эрх ямба ба хөдөлмөрчин ардыг сороон мөлжиж хураасан

хогшил хөрөнгөнөөс хувьсгалаар зайлуулагдсан феодальн ба тэдгээрийн туслагч болох хуучин түшмэд ба лам нарын үлдэгдлүүд байсаар баймой. Эл этгээдүүд дор хөдөлмөрчин ардын нэг адил улс төрийн эрхийг олговоос нивээдэмтэй бөгөөд тэнэг хэрэг болно" гэжээ. Ийм үзэл баримтлалын ёсоор 1940 оны Үндсэн хуульд 1924 оны Үндсэн хуулийн заалтуудыг хэвээр үлдээсэн төдийгүй "хамжлагатай байсан бөгөөд тэрхүү хамжлагаа хатуу чангаар дарлаж явсан тайж нар, хошуу шавь захирагч байсан түшмэд, нөлөө бүхий бөө удгаан, цагаан цэрэг ба хувьсгалын эсэргүү бослогод идэвхтэйгээр оролцогчид" гэж жирийн ардыг хүртэл хамарсан шинэ заалт нэмжээ. Түүнийг биелүүлэхийн тулд 1941-1942 онд энгийн ардуудыг эсэргүү хэрэгт оролцсон гэх шалтгаанаар баг, сумын хурал, аймгийн комиссууд хэлэлцэн эрхийг нь хасах шийдвэрийг гаргаж байсан баримтэлбэг бий. Энэ мэт нь тухайн үед хэлмэгдүүллэт хүчтэй байсны тусгал болов уу. Үүнд бас "социализмын байгуулалт гүнзгийрэх тусам ангийн тэмцэл хурцдана" гэсэн сталинизмын үзэл нөлөөлсөн ч байж магадгүй. Монголын Засгийн газрын хүсэлтээр 1940 оны Үндсэн хуулийн төслийг боловсруулахад Зөвлөлт засгийн газар шууд оролцож тусалсан аж. Энэ тусалцаа нь Монголын өөрсдийн боловсруулсан 122 зүйлт төслийг 95 зүйл болтол хураангуйлж гол чухал томъёоллыг зарчмын хувьд өөрчилсөн зэргээр уг төслийн хууль зүйн мэргэжлийн төвшинг дээшлүүлсэн гэх үндэс байна. Гэсэн хэдий ч Зөвлөлүүдийн үзэл хүчтэй тусгагдсан нь архивт буй эхээс

нь авч Хууль зүйн үндэсний төв эрхлэн нийтлэхээр зэхаж буй орос хэлээрх дөрвөн баримт бичиг ямар нэг хэмжээгээр нотолж байна. Москвад шинэчилсэн тэрхүү төслийн талаар түүнийг боловсруулагчдын бичсэн "товч тайлбар тэмдэглэл"-д "ВНМАУ-ын Конституци (Үндсэн хууль)-ийн энэхүү төсөл нь ВНМАУ-ын бүрэн эрхт төлөөлөгчдийн ирүүлсэн төслөөс язгуур үндсээрээ ялгаатай юм" гээд анхны төсөлд найруулгын зарим засвар оруулснаас гадна зарчмын шинэжтэй 21 өөрчлөлт оруулсан гэдгээ жагсаан цухас тайлбарлажээ.

Дашрамд дурдахад Үндсэн хуулийн төслийг боловсруулахдаа бусад орны эрдэмтэн, мэргэжилтний саналыг тандаж, түүнийг авах, гэхээ өөрсдөө шийдвэрлэх нь зүйн хэрэг бөгөөд зөв хандвал тустай билээ. Харин улсын бүрэн эрхт байдал (суверенитет) дотоод дээд засгийн асуудлаа, ялангуяа Үндсэн хуулийн хувьд гадаад аль нэг орны засаг төрийн дээд байгууллагаар албан ёсны төсөл хийлгэж, тэр чигээр нь батлах явдал улсын бүрэн эрхт байдлын зарчимд үнэхээр осолтой буюу зөөлөн хэлбэл зохисгүй. Гэсэн хэдий ч Монгол Улсын Засгийн газар өөрөө хүсэж гүйцэтгүүлдээ нэгэнт л зөвшөөрсөн бол энэ талаар эргэлзсэн, гажсан гүйл байлаа ч бурууг бусдад тохож булзах хэрэггүй юм. "Өөрөө унасан хүүхэд уйдаггүй" гэдэг байх аа. Эр нь бусдаас гуйж гувшчихаад эргээд гоочлох нь итгэлтэй түншлэгчийн мөс чанар биш. Харин хүсэл зоригоо тулган хүлээлгэсэн, эрх тэгш бус байдалар хандаж төрийн дотоод хэрэгт хөндлөнгөөс дайрч оролцсон бол тохирсон хариу барих нь зүйн хэрэг. Ийм

ялгаг улс төрийн бодлого, эрх зүйн харилцаанд соргогээр харж, заагтайгаар хэлж ярьж, хийж бүтээх учиртайг дашрамд тэмдэглэе.

3.2. 1940, 1960 оны Үндсэн хуулийн тухай хэдэн санаа

Анхдугаар Үндсэн хуулийг залгамжилсан Үндсэн хуулийг 1940 оны 6 дугаар сарын 30-нд БНМАУ-ын Улсын VIII их хурал; түүнийг залгамжилсан Үндсэн хуулийг БНМАУ-ын Ардын Их Хурлын 4 дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1960 оны 7 дугаар сарын 6-нд тус тус баталсан түүхтэй. Эх сурвалжаар нь бидний тооцсоноор 1940 оны Үндсэн хуульд 20 жилд 7 удаа; 1960 оны Үндсэн хуульд 30 жилд 13 удаа өөрчлөлт, нэмэлт оруулжээ.

1940 оны Үндсэн хуульд оруулсан хамгийн том нэмэлт, өөрчлөлт бол нийтийн биш, тэгш бус, олон шатат ил сонгуулиас нийт, шууд, тэгш эрхийн үндэслэл дээр саналаа нууцаар гаргах сонгуулийн шинэ зарчмыг тунхаглаж, төрийн төв, орон нутгийн байгууллагууд тогтоцдоог дорвитой өөрчилсөн заалтууд юм. Үндсэн хуульд Улсын IX Их Хурлаас оруулсан энэхүү

нэмэлт, өөрчлөлтөөр анх 95 зүйлтэй Үндсэн хууль 108 зүйлтэй болж томорсон бөгөөд хэдийгээр нэг намын залуураар хэлбэрдэлд орсон ч гэсэн сонгуулийн ардчилсан зарчмын үзэл санааг Монголд нэвтрүүлсэн ач холбогдолтойг тэмдэглэх нь зүйтэй болов уу. Гэвч үүнийг энд гол асуудал болгох гэсэнгүй, харин энд хоёр Үндсэн хууль хоёр өөр төвшин, хоёр өөр мөн чанарын биш утгаа жинхэнэ социалист маягийн нэгэн утга агуулгатай хууль гэж ангилах шалгууруудыг илэрхийлэхийг оролдов.

1940, 1960 оны хоёр Үндсэн хууль нь бүтэц, зохиомжийн болон зарим зүйл нь агуулгын ялгаатай боловч тодорхойлсон зорилго, төр-нийгмийн байгууллын үндсэн зарчмуудын хувьд нэгэн адил социалист маягийн хууль мөн. Үүнийг дараах нийтлэг шинж буюу шалгуураар нотлон харуулж болно. Үүнд:

Нэгдүгээрт: Тэдгээр үндсэн хуулиар тогтоосон үндсэн зарчмууд адил утга агуулгатай байна. Тухайлбал:

1) зорилгын хувьд нэг (Энэ нь нийгэм журам байгуулах,

социализмын бүрэн ялалтыг хангах гэсэн агуулгатай);

2) засаг төрийн нийгэмшлийн үндэс нь хөдөлмөрчин анги (1940 оныхоор малчин, ажилчин, сэхээтэн 1960 оныхоор ажилчин анги, хоршоолсон ард) мөн;

3) эдийн засаг нийгмийг улсын (төвлөрсөн) төлөвлөгөөний үндсэн дээр хөгжүүлэх нь төрийн эдийн засгийн гол зарчим (1940-4, 1960-15);

4) газар түүнийг баялаг, эдийн засгийн бүх өндөрлөг төрийн өмч мөн (1940-5; 1960-8);

5) "улс нийгмийн бүх байгууллагуудыг удирдах гол хүч нь МАХН мөн" (1940-95, 1960 оны оршил ба 82 дугааар зүйл);

6) төрийн эрх барих ба захиргааны байгууллагууд нь дээрээс доош төвлөн захирч, доороос дээш ажлаа хариуцан тайлагнадаг бөгөөд бүхэлдээ нам, АИХ-д хянагдах 4-5 дэд тогтолцооноос бүрдсэн;

7) орон нутаг нь мөн дан ганц төрийн удирдлагатай;

8) Үндсэн хууль болон нийтийн засаг захиргааны байгууллагын үйл ажиллагаа шүүхийн хяналтаас гадуур үлдсэн зэргийг хэлж болно. Энэ бүхнийг харьцуулбал:

Тогтоосон гол зарчим Улсын зорилго нь	1940 оны Үндсэн хууль	1960 оны Үндсэн хууль
Төрийн "улс төрийн үндэс" нь	Нийгэм журамд дэвшин өрхөн тулд улс орныг хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдалыг хангах (1 дүгээр зүйл)	Социализмыг төгөлдөр байгуулж, цэвэр давамгайлсан коммунист нийгэм байгуулах (оршил 5 дахь хэсэг)
Нийгэмшлийн үндэс ("амгийн үндэс") нь	Хөдөлмөрчин ардын хурлууд чөл (1)	Ажилчин анги, хоршоолсон ард, хөдөлмөрчин сэхээтэн (2 дугаар зүйл)
Засгийн эрхийн уг сурвалж нь	Хот, хөдөөгийн хөдөлмөрчин	Ажилчин анги, хоршоолсон ардын холбоо (3)
Эдийн засгийн үндэс нь	Бүх газар, ой мод, ус, тэдгээрийн баялаг, улсын үйлдвэр — улсын өмч	Социалист аж ахуйн систем, үйлдвэрлэлийн хэрэгслийг нийтээрээ өмчлөх социалист өмч (8 дугаар зүйл)
Эдийн засгийн үндсэн зарчим нь	Аж ахуйн соёл, нийгэмлэгийн аж байдлыг улсын төлөвлөгөөний үндсэн дээр өөрчилж зохиох — (4)	Эдийн засгийг улс армын аж ахуйн нэгдсэн төлөвлөгөөгөөр удирдан хөгжүүлэнэ (15)
Төрийн улс төрийн дэглэм нь	Нэг намын удирдлага ("улс нийгмийн бүх байгууллагуудыг удирдах гол хүчин болгох МАХН" 95 дугаар зүйл)	Нэг намын удирдлага ("төр нийгмийг удирдан чиглүүлэх хүч бол... МАХН мөн" (оршил 1), улсын ба хөдөлмөрчин олон түмний бүх байгууллагын мөхлөглөгч бөгөөд жолоодогч МАХН...) (82)
Төрийн байгууллагын тогтоцдоо нь	Тус тусай дараах дэд тогтолцоо (бүх шатны хурал, захиргаа, шүүх, прокурор, ардын хяналтын)	Нэг төвтэй 5 дэд тогтоцдоо (хурал, захиргаа, шүүх, прокурор, ардын хяналтын)
Орон нутгийн удирдлага нь	Орон нутгийн "төрийн" эрх барих (А.Т.Х ба захиргаа)	Орон нутгийн эрх барих (А.Д.Х ба гүйцэтгэх захиргаа)
Шүүх эрх мэдэл нь	Дэд шүүх УИХ-д (Хараат)	Дэд шүүх АИХ, түүний Тэргүүлэгчдэд ажлаа хариуцан тайлагнадаг

Харьцуулсан хүснэгтээс үзэхэд төр нийгмийн байгууллыг:

□ Нийгэмшлийн үндсийг “хөдөлмөрчин” гэсэн ангийн үүднээс тодорхойлсон ч түүний бүтцийн ялгааг тусгасан;

□ Эдийн засгийн үндэс нь 1940 оны Үндсэн хуульд малчин ард иргэдэд мал, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн буюу “багаж хэрэгсэл” бүтээгдэхүүн орлогоо өмчлөх хувийн өмчийг

зөвшөөрсөн онцлогтой ч улсын эдийн засгийн зонхилох өндөрлөгүүдийг төрийн өмчид байхаар тогтоосон тэр гол чанараараа болон 1950-иад онд нийгэмчилсэн үр дүнгээрээ 1960 оны хуультай адилсах мэт.

Хоёрдугаарт: Үндсэн хуулийн мөн чанарыг илэрхийлдэг нэгэн гол шалгуур болох хүний эрх, эрх чөлөөний тухайд энэ хоёр хууль үзэл баримтлал нэгтэй гэж болно.

“Иргэдийн үндсэн эрх, үүрэг тэдгээрийн нэгдэл” гэсэн бидний уламжлалт ойлголтоор “Хүний эрх” гэсэн орчин үеийн шинжлэх ухааны үзэл номлолыг оролцуулан тайлбарлах аргагүй болжээ. Хэдий тийм боловч түүхэнд болж өнгөрснийг байснаар нь өгүүлэхэд буруугүй тул Монгол Улсын Иргэдийн үндсэн эрхийн тухай хоёр хуулийн заалтыг харьцуулж харцгаая:

№	1940 оны Үндсэн хууль	№	1960 оны Үндсэн хууль
1.	Бэлчээрийг үнэ төлбөргүй хэрэглэх (88)	1.	=
2.	“Төр аж ахуй соёлын бүх салаа мөчирт мэдлэг хөдөлмөрөө хэрэглэх” (88)	2.	Хөдөлмөрлөх, хөдөлмөрийнхөө тоо чанарт төхирсон цалин хөлс авах (77)
3.	Амрах (89)	3.	Амрах (87)
4.	Боловсрох (90)	4.	Сурч боловсрох (80)
5.	Эдийн тусламж авах (91)	5.	Эдийн засгийн тусламж авах (78)
6.	Үндэс угсаа ялгаварлахгүй тэгш эрх эдлэх (91)	6.	Эр, эм, шашин шүтлэг, нийгмийн гарал байдлаар ялгаваргүй тэгш эрхтэй, үндэсний тэгш эрхийг хангах (76, 83)
7.	Эмэгтэйчүүд эрэгтэйчүүдтэй адил тэгш эрх эдлэх (93)	7.	Эмэгтэйчүүд төр, аж ахуй, нийгэм улс төр, соёлын бүх салбарт эрэгтэйчүүдийн нэг адил эрх эдэлнэ (84)
8.	Шүтэх, шашны эсрэг суртал нэвтрүүлэх (94)	8.	Шүтэх бишрэх, шашны эсрэг суртал нэвтрүүлэг явуулах (86)
9.	Эвлэлдэн нэгдэх (95)	9.	Эвлэлдэн нэгдэх (82)
10.	Гомдол, өргөдөл гаргах (96)	10.	Өргөдөл, гомдлоо өгөх, хариу авах (85)
11.	Чөлөөтэй шилжин явах, оршин суух газраа сонгох (97)	11.	=
12.	Үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан, жагсаал, ёслол хийх (98)	12.	Үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал, ёслол үйлдэх эрх чөлөө (87)
13.	Биед болон орон сууцанд халдаж үл болох, захидлын нууцаа хамгаалуулах	13.	Амь бие, орон сууц, захидал харилцааны халдашгүй эрхээр хангагдах (88)

Хүснэгтэд харьцуулснаас үзвэл иргэдийн эрх, үүрэг агуулгын хувьд нэг адилаар тодорхойлогдсон байх бөгөөд тэр бүхэнд ангийн байр сууринаас хандсаныг бас анхаарч оношлох учиртай.

Ийнхүү сайхь хоёр Үндсэн хууль гол зарчим, агуулгын хувьд нэг маягт хамаарах боловч бүтэц, томъёоллын хувьд онцлог ялгаатай. Түүнийг бүлэг зүйлээр нь нэг бүрчлэн судалж

тайлах нь чухал боловч нэгэн өгүүлэлд багталцахгүйг харгалзан зөвхөн бүтцийг зэрэгцүүлэн харуулбал зарим ялгаа нь эрх биш тодрох болов уу.

*. Уртавтар зарим заалтын утгыг гажуудуулалгүйгээр хураангуйлав. Зохиогч.

1940 оны Үндсэн хууль* /оршилгүй/ Бүлгийн дугаар, нэр /хэсэггүй/		Зүйлийн тоо	1960 оны Үндсэн хууль /томоохон оршилтой/ Бүлгийн дугаар, нэр			Зүйл-ийн тоо
Нийгмийн байгууламж	9 (1-9)		I хэсэг БНМАУ-ын нийгэм-эдийн засгийн байгууламж	1.	Төрийн мөн чанар, зохион байгуулалтын ерөнхий зарчим	7 (1-7)
Засаг төрийн байгууламж	3 (10-12)			2.	Төрийн эдийн засгийн Үндсэн зарчим ба үүрэг	10 (8-17)
Улсын Их Хурал	15 (13-27)		II хэсэг БНМАУ-ын Төрийн байгууламж	3.	Төрийн эрхийг барих дээд байгууллагууд А) БНМАУ-ын АИХ Б) АИХ-ын Тэргүүлэгчид	19 (18-36)
Улсын Их Хурлын Тэргүүлэгчид*	5 (28-32)			4.	Төрийн захиргааны дээд ба төв байгууллагууд	9 (37-45)
БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл	10 (33-42)			5.	Орон нутгийн эрх барих ба захиргааны байгууллагууд	17 (46-62)
Төрийн эрх барих орон нутгийн байгууллагууд	16 (43-58)			6.	Шүүх, прокурорын байгууллага А) Шүүх Б) Прокурорын газар	13 (63-75)
Шүүх, прокурорын газар	13 (59-71)		III хэсэг БНМАУ-ын иргэдийн үндсэн эрх, үүрэг	7.	Иргэдийн үндсэн эрх ба түүнийг хянах баталгаа	13 (76-88)
БНМАУ-ын төсөв	8 (72-79)			8.	Иргэдийн үндсэн үүрэг	1 (89)
БНМАУ-ын сонгуулийн систем	8 (80-87)		IV хэсэг Бусад зүйл	9.	Сүлд, далбаа, нийслэл	3 (90-92)
Иргэдийн үндсэн эрх, уургууд	11 (88-104)			10.	БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлөх ба халах тухай	2 (93-94)
Сүлд, далбаа, нийслэл	3 (105-107)					
БНМАУ-ын Үндсэн хуулийг өөрчлөх журам	1					
Бүгд 12 бүлэг, 108 зүйл			Бүгд 4 хэсэг, 10 бүлэг, 94 зүйл			

3. 1992 оны Үндсэн хууль бол шинэ маягийн Үндсэн хууль
Монгол Улс өмнөх 3 Үндсэн хуулийг дагаж мөрдсөн 70 жилд тусгаар байдлаа бэхжүүлж, Зөвлөлтийг даган дэлхийн

хөгжлийн татах хүчний нөлөөн дор, ялангуяа нийгэм-соёлын амьдралын хувьд үлэмжхэн хөгжсөн нь маргашгүй юм. Нөгөөтэйгүүр тоталитар дэглэмд оршиж, нийгэм, эдийн засгийн

байгууллын буюу формацийн онол тэргүүтнийг баримталсны улмаас хүн төрөлхтний хөгжлийн жам ёсноос гажиж, улс төр, эдийн засгийн талаар дэлхийн хөгжлөөс дэндүү

*. 1949 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дараах бүтцээр нь авлаа-Зохиогч.

*. 1949 оны нэмэлт өөрчлөлт хүртэлх 1940 оны Үндсэн хуулийн 13-17 дугаар зүйлд Улсын Их Хурлын тухай, 18-26 дугаар зүйлд Улсын Их Хурлын чөлөөт цагт хууль тогтоох үүрэгтэй "Улсын Бага Хурал ба Улсын Бага Хурлын Тэргүүлэгчид"-ийн тухай заасан байв.

хоцорч, улмаар мухардалд орсон нь цаг улирах бүр тодрон мэдэгдэх болжээ.

Энэхүү мухардлаас гарахын тулд 1980-иад оны эцсээр Монголын ардчилсан хүчинийхэн хошуучилж, нэг нам ноёрхсон захиргаадалтын дэглэмийг халж, улс төр, эдийн засаг, нийгэмшил, оюуны шинэтгэл хийх хувьсгалт хөдөлгөөн өрнүүлсэн билээ. Үүний үр дүнд 1990 оны 3 дугаар сард нэг намын ноёрхлыг халж, 1990 оны дундуураас Монгол орны ардчилсан шинэтгэл юуны өмнө улс төрийн шилжилтийг эрслэн хийх хууль зүйн үндсийг мөн 1991 оны 5 дугаар сарын 12-нд Ардын Их Хурлаас баталсан "БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль"-аар тавьсан түүхтэй. Энэ нэмэлтийн хуулийг олонхи хуульч, улс төрчид дасал болсон хэллэгээр 1960 оны "Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт" л гэдэг. Хэрэг дээрээ тийм биш. Нэрнээсээ эхлээд агуулга нь хүртэл өөр хууль болох нь үзгэл илт, ойлгомжтой байхад ингэж загварчилсан хуучин сэтгэлгээгээр хандах нь хууль зүйн шийжлэх ухааны шинэтгэлд тээг болохоос тус хүргэхгүй. Ер нь Үндсэн хууль нэг оронд нэг л байдаг гэж төсөөлж болохгүй. Хэд хэдэн хуулиас бүрдэх нь бий. Швед улсын Үндсэн хуулийг үндсэн эрх, эрх чөлөө, төрийн байгууллагын тогтолцооны тухай, хаан ширээ залгамжлах тухай гурван хуулиас бүрддэг гэж ойлгох билээ¹.

Английн "холимог" хэлбэрийн Үндсэн хууль нь парламентын баталсан хууль, Үндсэн хуулийн заншил; Шүүхийн хэвшүүлсэн хэм хэмжээ; парламентын буюу эсвэл шүүхийн захиалгаар

ардэмтдийн бичсэн тайлбар (номлол) зэрэг дөрвөн зүйлийн эх сурвалжаас бүрдэнэ гэж үздэг.

Дээр дурдсан Үндсэн хуулийн нэмэлтийн хуулийн дагуу 1990 онд байгуулагдсан байнгын ажиллагаатай хууль тогтоох байгууллага болсон Улсын Бага Хурлаас 1990-1992 оны дунд үе хүртлэх хугацаанд Улсын Ерөнхийлөгч, Их Хурал, Засгийн газар, Улс төрийн намуудын тухай, өмчийн эрхийн болон төрийн өмч хувьчлах тухай, аж ахуйн нэгжийн тухай, боловсролын зэрэг Үндсэн хуульчилсан болон тийм хэм хэмжээ агуулсан бусад 30 гаруй хууль гаргаж Үндсэн хуулийн шинэтгэлийн эрх зүйн урьдач нөхцөлийг бүрдүүлжээ.

Эдгээр хуулийн үзэл баримтлал хийгээд богино хугацаанд дагаж мөрдсөн практикийг үндэслэн өмнөх үеийн сургамж, төр, нийгмийн хөгжлийн жам ёс, дэлхийн хөгжингүй орнуудын жишиг зэргийг харгалзан шинэ Үндсэн хуулиа боловсруулж баталсан. Өдгөө дагаж мөрдөж байгаа Үндсэн хууль нь оршил, 6 бүлэг, 70 зүйлтэй. Энэ хууль өмнөх хуулиуд шиг хөгжлийн зорилгыг хөтөлбөржүүлсэн, үзэл сурталжсан, ангичирхсан баримт бичиг биш, харин Монголын ардчилсан нийгмийн орчин хөгжих суурь, араг ясыг зангидаг бэхжүүлсэн, ардчилсан төрийн гол хууль юм.

Үндсэн хуулийн тухай янз янзын тодорхойлолт байдгийг бид мэднэ. Аль нэг намын үзлийг баримталсан биш, харин ямар нэг үндсэн хуулийг иш үндэс болгон тодорхойлох нь илүү үнэмшилтэй билээ. Жишээлбэл, XIX дүгээр зууны

нэрт судлаач, Английн эрдэмтэн, Оксфордын Их сургуулийн профессор агсан А.В.Дайси Үндсэн хууль бол төрийн эрх мэдлийг хуваарилсан хэм хэмжээгүүдийг агуулдаг гэсэн утгаар тодорхойлсон байдаг². Тэр үеэс, өөрөөр хэлбэл, АНУ-ын Үндсэн хуулийг баталсан цагаас хойш хоёр ч зуун хулжирч, дэлхийн улсууд Үндсэн хуулийн мөн хоёр гурван үеийг туулж, уг хуулиудын зохицуулах харилцаа хөгжин тэлж ирсэн байна. Тухайлбал, орчин цагийн Үндсэн хууль эрх мэдэл хуваарилахын зэрэгцээ хүний эрх, эрх чөлөөг хангахын үүднээс эдийн засаг, нийгмийн харилцааны үндэс тулгуур, өөрөө удирдах хийгээд Үндсэн хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх болжээ. АНУ ч Үндсэн хуульдаа энэ зүгт чиглэсэн шинэ шинэ нэмэлт хийж иржээ. Иймд сая дээр дурдсан хандлагыг баримталж Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн тухайд дараах тодорхойлолт өгч болно.

Шинэ Үндсэн хууль бол Монгол Улсын тусгаар тогтнол хийгээд нийгэм төрийн байгууллын ардчилсан үндэс тулгуурыг бататгаж, нийгэмд хүний эзлэх эрх зүйн байдал, төрийн байгууламж, засаг төрийн эрх мэдлийн хуваарилалт, түүний байгууллагын болон нутгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлж, Үндсэн хуулийг сахин хамгаалах хяналтыг тогтоосон төрийн гол хууль мөн. Үндсэн хууль ангич байр, үзэл суртлын аль нэг урсгал, хөгжлийн зорилгыг тодорхойлдоггүй, харин улс нийгэм өнө бат оршиж чинагшлах хөгжих анхдагч вөхцөл болсон төр, нийгмийн байгууллын араг ясыг зангидаг бэхжүүлсэн хууль зүйн

1. Конституционное (Государственное) право зарубежных стран. Т.1 Отв. Ред: Др. проф. В.А.Страшун. Изд-во "БЕК". 1993, ст.47

2. А.В.Дайси. Основы государственного права Англии (перевод с английского на русский язык) Издание второе. Москва. 1907.

тогтвортой суурь нь байх ёстой билээ. Өөрөөр хэлбэл, хэзээ, яаж хөгжих тухай биш, харин улс орон маань өнө бат оршихуйн улс төр, эдийн засаг, нийгэмшил, соёл, оюуны үндсийг бэхжүүлж хүнийг, түүний эрхийг дээдэлснээрээ өмнөх Үндсэн хуулиудаас үзэл баримтлал, суурь зарчмын ялгаатай. Үүнийг тодруулахын тулд өмнөхөө бас эргэн харьцуулж харууштай болдог.

• 1924 оны Үндсэн хуулиар: “Бүх дэлхийн жинхэнэ ард түмний зорилго нь одоогийн эзэрхэг хөрөнгөтний байдлыг үндсээр нь устгаж, нийгэм журам ба эв хамт ёс журмыг эрмэлзэх тул засгийн бодлогыг түүнтэй нийцүүлэн явуулах” гэх зэргээр заасан.

• 1940 оны Үндсэн хуулиар: “БНМАУ бол эзэрхэг түрэмгий ба феодальн дарлалыг устгасан цаашид нийгэм журамд дэвшин орохын учир улс орноо хөрөнгөтний биш замаар хөгжүүлэх явдлыг хангаж бүхий... улс мөн” (1 дүгээр зүйл).

• 1960 оны Үндсэн хуулиар: “БНМАУ-ын зорилго бол социализмыг төгөлдөр байгуулж, цаашдаа коммунист нийгэм байгуулах явдал мөн” (оршилд) гэж тус тус тусгасан нь эргээд шинжихэд хөтөлбөрийн чанартай заалт байжээ!

Бүхэлд нь үзвэл феодализмаас капитализмыг алгасан социализмд шилжиж, улмаар 1960 оны Үндсэн хуулийн сүүлчийн 94 дүгээр зүйлд зааснаар коммунизмын бүрэн ялалтыг хангаж төрийг “хөдөлмөрчдийн коммунист эвлэлээр солигдсон цагт БНМАУ-ын Үндсэн хууль халагдана” гэж төсөөлж байв.

Энэчлэн Үндсэн хуулийн үзэл сурталжсан заалтуудыг нэг намын мөрийн хөтөлбөрөөр дэмжүүлэн зорилгоо болгосноос Монгол орон хүн төрөлхтний жам ёсны хөгжлийн замаас гажсан хэрэг. Үүнийг бусдад, жишээлбэл, Зөвлөлтөд түлхэх хэрэггүй.

Чухам дээр дурсан зорилгод хөтөлгдөн “хувьсгалын ардчилсан шатны” Үндсэн хууль (1924 он); “Социализмын үндсийг байгуулах үеийн” Үндсэн хууль (1940 он); “Социализмын бүрэн ялалтыг хангах үеийн” Үндсэн хууль (1960 он) гэх нийтдээ социалист чиг баримжааны болон социалист нэгэн хэв маягт багтах гурван Үндсэн хууль дамжсан хэрэг.

Социалист маягийн хуулиудтай 1992 оны Үндсэн хуулийг жишвэл Монгол оронд ямар нэгэн нийгэм байгуулах, түүнээс өөр нийгэмд шилжих гэхчлэн стратегийн зорилгыг тодорхойлоогүй буюу хөтөлбөрийн шинж агуулаагүй юм. Харин Монголын ард түмний туйлын хүслэнг илэрхийлэх үндсэн дээр хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч хамгаалах, хангах баталгаа хийгээд төрийн байгууллагын ардчилсан үндсэн зарчим, түүний байгууламж, засаг төрийн байгууллагын хийгээд нутгийн удирдлагын тогтолцоог тус тус бэхжүүлж, Үндсэн хуулийн хяналтын арга хэрэглүүрийг тогтоосон юм. Өөрөөр хэлбэл, бүтээн байгуулах зорилгыг биш, харин түүний байнгын язгуур үндэс нь болсон Монгол нийгмийн жам ёсны суурь харилцааг бэхжүүлснээрээ төрийн гол хуулийн нийтлэг шинжийг олсон гэж болно. Энэ суурь дээр

Монгол Улс өнө мөнхөд оршин хөгжинө гэсэн утгатай. Ажиглалтаас үзэхэд “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно” гэснийг зааварчилсан хуучинсаг сэтгэлгээгээр ямар нэг “нийгэм байгуулах” юм гэж ойлгоод байх шиг. Энэ томъёолол тийм агуулгатай биш, харин социализмын үед хүлээн зөвшөөрөгдөөгүй, хэзээнээс байсан тэр иргэний нийгмийг шинэ тогтолцоонд оруулан төлөвшүүлж, төгөлдөржүүлэх гэсэн үзэл баримтлалтай гэж болно.

Зорилгын (гол үзэл баримтлалын) үүднээс харьцуулж үзсэнээр ардчилсан Үндсэн хууль нь нийгмийн байгууллын эзэн болсон хүний эрх чөлөөт байдал, бүх нийгмийн оршин хөгжих үндэс буюу яс, булчингийн тогтолцоог бэхжүүлж хамгаалдаг болохоос биш улс орны хөгжлийг хөтөлбөржүүлдэг ээлжит арга хэмжээний төлөвлөгөө биш гэдгийг ойлгож болно.

Үндсэн хууль зорилго, зорилтын хөтөлбөр биш гэдгийг иш үндэс болговол чухам юугаараа өмнө хуулиудаас ялгаатайг тус бүрт нь жишиж харуулах шаардлагатай билээ. Тийм нарийвчлалыг энд үзүүлэх боломж мөхсөйг бодолцон зөвхөн зарчмын ялгаатайг харуулах хэдэн гол шалгуурыг дурдъя. Шинэ үндсэн хууль нь Монгол Улсын төрийн бүрэн эрхт, тусгаар тогтносон байдлыг бататган бэхжүүлэх (нийтлэг)-ийн хамт: хүний эрх, эрх чөлөө, хуулийг дээдэлсэн;

- олон намт парламентад ёсонд үндэслэсэн улс төрийн хийгээд төрийн ардчилсан дэглэмтэй;

- нийтийн ба хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч хамгаалсан төрийн зохицуулалт бүхий зах зээлийн эдийн засагтай;

- анги, бүлгээр ялгаварлахыг хориглосон "ард түмэн" гэх нийгэмшлийн нэг үндэстэй;

- дангаар төвлөрсөн ёсыг халж, эрх мэдлийг засгийн гурван салаанд хуваасан засаг төрийн тогтолцоотой;

- олон ургалч үзлийг нийгмийн соёл оюуны үндэс болгосон;

- Үндсэн хуулиа дээдэлж, шүүхийн хяналт хамгаалалтад авсан тийм орон байх зарчмын үндсүүдийг тогтоосон нь түүний шинэ маяг, ардчилсан хууль болохыг харуулна. Зохиогчид хүү хураангуйлахдаа Үндсэн хуулийн үзэл баримтлалыг иш үндэс болгосноос бус түүний үндэслэл заалт хэрхэн хэрэгжиж байгаад үнэлэлт дүгнэлт өгөхийг санаархаагүй болно.

Эцэст нь уг Үндсэн хуулийг үндсэн хуульчилсан болон бусад хуулиар зөв дэлгэрүүлж, тогтвортой баримтлах нь Монголын нийгэм тогтвортой хөгжих үндэс, гол арга зам болохыг тэмдэглэе. Улс орон тогтвортой хөгжих үндэс нь "дарга тогтвортой байхад" бус, харин хууль тогтвортой "даргалахад" оршдогийг амьдрал хэдий нь харуулсан билээ.

Яагаад АНУ-ын 1787 оны Үндсэн хууль батлагдсаар 200 жил хол давсан агал өдгөө

мөрдөгдсөөр байна вэ? гэсэн асуулт байж болох. Эсвэл АНУ том орон болохоор Үндсэн хууль нь зуу зуун жилийн зорилго, зорилгыг багтаасан хосгүй хол ч хууль, Монгол буурай орон болохоор ахархан хугацаанд зорилго, төлөвлөгөөтэй байдгийг харуулаад байна уу? гэвэл нэн болхи асуулт болно. Гэвч энэ нь хариулахад нэлээд түвэгтэй асуулт юм.

Ардчилсан орны Үндсэн хуулийн "хол ч" байдаг нь, манай хуулиуд богинохон насалдаг юундаа байна вэ? гэвэл гүнзгий шалтгаантай юм шиг байна. Тоймлобол:

1) сонгосон зам, түүнд тохируулах гэсэн "нийгмийн байгуулал", улс төрийн дэглэмээс;

2) үндсэн хуулийн хэв маяг буюу ямар үзэл баримтлалд тулгуурласнаас;

3) тухайн орны нийгмийн ухамсар, ялангуяа улс төр, эрх зүйн ухамсар соёлын төвшингээс;

4) засаг төр барих арга ухаан, улс төрийн тууштай байдал, залгамжлал, тэвчээрээс ихээхэн шалтгаалдаг бололтой.

Үндсэн хуулиа дээдлэн түүний үзэл баримтлалыг гүнзгий ухаарч бусад хуулиар дэлгэрүүлэн хөгжүүлж эс чадваас тэвчээртэй бөгөөд тууштай баримтлахгүй, "өдөр бүр гоочлон" оролдоод байвал хэврэгхэн улс төр тогтворгүйтнэ гэдгийг дурдахад илүүдэхгүй биз ээ.

Улсын Анхдугаар Их Хуралд Үндсэн хуулийг хэлэлцэх үед Их Хурлын төлөөлөгч Лувсанчой:

- Энэхүү Үндсэн хуулийг үүрд журамлан дагаж явах буюу? гэж асуухад

Үндсэн хуулийн комиссын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд Б.Цэрэндорж:

- "Бид бодвоос үргэлжид дагаж явах Үндсэн хууль хэмээх бөгөөд хэд хэдэн арван мянган жил болоход үл болохоор үгүй" гээд улсаа тохинуулан буй цагт анхлан баталж байгаа болохоор "өөр орхигдсон зүйл байж болох тул өөрчлөгдөх нь болзошгүй ..." гэж хариулсан аж.

Үүнээс үзвэл "ороо бусгаа цаг" оюун сэтгэлийг нь зовоож байсан хэдий ч Үндсэн хууль тогтвортой байх ёстой гэдэг саруулхан санаа тэр үеийн Монголын төрийн зүтгэлтнүүдийн оюунд гийж шингэсэн байжээ. Харин хойч үе нь хэрхэн авч явсныг үнэлэхэд бэрх юм. Маргааш нь юу болохыг үл төсөөлөн өөрчлөхийн өвчин тусаад байвал өөд нар харахгүй гэдгийг анхны "халдлага" харуулсан биш үү?! Үндсэн хууль тогтвортой байх учиртай гэдэг бол түүнийг судлах, номлоход улмаар бусад хуулийг тодруулахад баримтлах бас нэг шинэ хандлага болно.



ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЪЁОГ ОНОВЧТОЙ БОЛГОХ, ЗӨВ ХЭРЭГЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ



ХЗҮТ-ийн секторын
эрхлэгч С.ГЭРЭЛМАА

Хуульч Та өөрийгөө барилгачин гэж төсөөлөд хууль гэдэг барилгыг барьж байна гэж бодъё. Тэгвэл Та хэр зэрэг тэгшхэн өрөлт хийж байгаа, тоосго бусад барилгын материал чинь хэр зэрэг чанартайгаас хамаарч таны ирээдүйн байшингийн дүр төрх нь тодорно. Таны зарим тоосго хэлэх гэж байгаа санааг чинь товч тодорхой, оновчтой илэрхийлсэн тун сайхан тоосго байж болно. Гэтэл зарим нь чанаргүй байдаг. Өөрөөр хэлбэл ямар барилгын материал хэрэглэж байгаа болон хэр зэрэг ур чадвартай инженер, мастер, барилгачин ажиллуулж байгаагаас хамаарч ирээдүйн байшингийн дүр төрх тодордог. Муу материалаар, чадваргүй хүн ажиллуулж барьсан

байшин хажуу тийшээ хазайсан ч юм уу, цонхгүй ч юм үү, хаалгагүй ч байшин болж болзошгүй, зарим нь бүр нурж унадаг. Гэтэл зарим байшин гаднаас нь харахад жигтэйхэн сайхан боловч дотор нь ороод амьдарч эхлэхээр ус байнга алддаг эсвэл цонхоороо сийгдэг эсвэл хаалга нь бариулгүй байдаг. Үүнийг хуультай адилтгавал ойлгомжгүй, цоорхойтой хууль гардаг гэсэн үг. Ийм нөхцөлд оршин суугч /шүүгч, өмгөөлөгч, прокурор бусад хууль хэрэглэгч/ тус бүр өөрийн төсөөллөөр, өөрт олдсон материалаар энэхүү цоорхойг бөглөж эхэлнэ гэсэн үг.

Ийм учраас хууль гэдэг барилгын "тоосго" нь болдог хууль зүйн нэр томъёог оновчтой болгож, зөв хэрэглэх нь ямар чухал ач холбогдолтой болохыг Та бүхэн надаар хэлүүлэлтгүй ойлгож байгаа гэдэгт найдаж байна.

Нэр томъёо гэдэг "тоосго"-той хамгийн түрүүнд хууль боловсруулагч учирч түүний найрлагыг тааруулдаг, дараа нь хууль тогтоогч олон талаас нь хэлэлцэж засаж залруулдаг, заримдаа өмнө байснаас нь бүр дордуулах

зэргээр хувь нэмрээ оруулдаг, дараа нь энэ байшинд хууль хэрэглэгчид орж амьдардаг. Оршин суугчид байранд орсноос хойш тэр байшингийн бүх дутагдал илэрч эхэлдэг. Тэгээд л хууль хэрэглэгчид зарим тохиолдолд өөрийн хүссэнээр нэр томъёог тайлбарлах эсвэл засаж залруулах ажлыг хийж эхэлдэг байна.

Нэр томъёог хууль боловсруулагчид хаанаас авч хэрэглэдэг вэ?

- **Нэгдүгээрт:** Хууль, эрх зүйн шинжлэх ухаан, мэргэжлийн хэвшсэн нийтлэг ойлголт, нэр томъёо байдаг. Үүнд Үндсэн хуулийн нэр томъёог нэрлэж болно. Монгол Улсын хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн байх ёстой, энэ нь нэн ялангуяа бусад хуулийн нэр томъёонд хамаарна. Гэтэл бусад хуулийн нэр томъёо Үндсэн хуультай нийцэхгүй байх нь элбэг тохиолддог төдийгүй иргэдэд эрх зүйн мэдлэг түгээх хамгийн өргөн арга хэрэгсэл болох хэвлэл мэдээллийн хэрэгсэл ч гэсэн буруу нэр томъёог хэрэглэх нь цөөнгүй тохиолддог. Энд би ганцхан жишээ дурдъя. Хууль

"Хууль бол ерөөсөө туйлын нарийн чанд томъёолсон хайрцагласан баримт бичиг. Цэг, таслал ч ач холбогдолтой байдаг."

Б.ЧИМИД

зүйн үндэсний төвийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, гавьяат хуульч Б. Чимид Үндсэн хуульд “эрх мэдэл” хуваарилах гэсэн зарчим орсон. Үүнийг “засаглал” /властвование/, “засаг” гэсэн нэр томъёоноос ялгаж ойлгох нь зүйтэй, тэгэхгүй бол Монгол Улс парламентын бүгд найрамдах нэг засагтай улс биш харин гурван засаглалтай улс болж хувирлаа гэж тайлбарлаж байсныг хэлмээр байна. Түүнчлэн “эрх мэдэл” /власть/, “эрх хэмжээ” /компетенция/, “бүрэн эрх” /полномочие/, “чиг үүрэг” /функция/, “үүрэг” /обязанности/, “журамт үүрэг” /долг/ гэх мэтийн ялгаатай нэр томъёог тоомсорлохгүй буюу буруу дутуу ухаарваас алдаа их гаргадаг гэж хэлснийг нь ч Та бүхэнд дахин нэг сануулмаар байна.

• **Хоёрдугаарт:** зарим тохиолдолд тодорхой асуудал хариуцсан яамдын мэргэжилтнүүд шинэ нэр томъёог санал болгодог. Тухайлбал, 1990 онд Тэтгэврийн хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт намайг ажиллаж байхад тухайн үеийн Хөдөлмөрийн яамны мэргэжилтнүүд “тахир дутуугийн” тэтгэвэр гэсэн нэр томъёо нь нь тахир дутуу хүмүүсийн хувьд их эмзэг тусдаг учраас үүнийг “хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр” гэж нэрлэе “өндөр насны тэтгэвэр” гэснийг “насны тэтгэвэр” гэж өөрчилье гэсэн санал оруулж ирж байсан. Гэтэл Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын конвенцод эдгээр нэр томъёог “пенсия по

старости”, “пенсия по инвалидности” гэж томъёолдог бөгөөд аль ч улсад энэ нь хэвшсэн нэр томъёо болж хувирсан байдаг. Гадаад хэл рүү хуулиа орчуулахаа бодсон ч, ОУХБ-ын конвенцын дагуу илтгэл бичихээ бодсон ч хуучин нэр томъёо нь илүү оновчтой байсан юм. Гэвч нэлээд маргалдсаны үр дүнд тахир дутуугийн тэтгэврийн нэр хэвээр үлдсэн боловч “насны тэтгэвэр” гэсэн шинэ томъёоллоор Улсын Бага хуралд төслийг оруулж хэлэлцүүлж батлуулсан. Уг утга нь бол хүн өндөр настай болсных нь хувьд тэтгэвэр олгож байгаа. Нэр томъёог буруу хэрэглэснээр ямар ч насны хүн өндөр насны тэтгэвэр авч болох мэт буруу төсөөлөл үүссэн. Дараа нь “өндөр насны тэтгэвэр” гэсэн нэр томъёог 1994 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд буцааж хэрэглэж эхэлсэн юм.

Энэ бүхнийг би ямар зорилгоор бичиж байна вэ гэвэл зарим тохиолдолд хуулийг хэрэгжүүлэх зорилгоор хүмүүсийн хэрэглэж дассан хэвшсэн нэр томъёог хэрэглэх нь илүү зохистой байдаг. Тухайлбал, “Хүний эрхийн түүгэмэл тунхаглал” гэдгийг орос хэл рүү орчуулбал “Общераспространённая декларация прав человека” болно. Гэтэл оросууд “Всеобщая декларация прав человека” өөрөөр хэлбэл “Хүний эрхийн бүх нийтийн тунхаглал” гэсэн нэр томъёог хэрэглэдэг. Гэвч энэ нэр томъёог засаад хэрэглээд

явъя гэж бодохоор хүмүүс анхнаасаа “Түүгэмэл тунхаглал” гэж хэрэглэж дассан учраас төөрөгдөлд орж болзошгүй бөгөөд хоёр өөр баримтын талаар ярьж байна ч гэж бодож магадгүй учраас практик талаасаа дассан нэр томъёог хэрэглэх нь заримдаа илүү зохистой байдаг.

Хуулийн нэр томъёог байсхийгээд сольж өөрчлөх нь хүмүүсийг төөрөгдөлд оруулахын зэрэгцээ, тэр салбарт гарсан бүх дүрэм, журмыг өөрчлөх нүсэр ажиллагааг шаардаж, хуульчдын цаг завьг үр ашиггүй зарцуулахад ч хүргэдэг. Тухайлбал, 1991 оны Хөдөлмөрийн хуульд “цалин хөлс” гэдэг бол хятад гаралтай үг, монголчлох нь зүйтэй гээд “хөдөлмөрийн хөлс” гэсэн нэр томъёог хэрэглэж байсан. Гэтэл 1999 онд баталсан Хөдөлмөрийн хуульд “цалин хөлс” гэсэн нэр томъёог буцааж оруулж ирсэн. Одоо Хөдөлмөрийн хуулийн зарим хуучин дүрэм, журам өөрчлөгдөөгүй байгаа бөгөөд “хөдөлмөрийн хөлс”, “цалин хөлс” гэсэн хоёр нэр томъёо зэрэг хэрэглэгдэж байгаа учраас эдгээр нь өөр утга санааг илэрхийлэх ялгаатай зүйл гэсэн маргаан ч гарч байгаа нь зохисгүй юм.

• **Гуравдугаарт:** Шинэ нэр томъёог бусад орны хуулийн заалтыг орчуулах явцад хуульд шинээр оруулж ирдэг. Хуульчид орчуулсан хууль гаргадаг гэсэн шүүмжлэлд их өртдөг. Гэтэл миний бодлоор бол нэгэнт нээчихсэн Америк

тивийг дахин дахин нээх гэж зовох хэрэггүй мэт санагддаг. Учир нь хэдэн зуун жил зах зээлийн харилцааг зохицуулсан, ус нь шахагдсан хуулийг манайх шиг энэ харилцааг зохицуулах талаар туршлагагүй орон шилжүүлэн суулгаж хэрэглэхэд буруу юм байхгүй. Харин В.Чимид багшийн хэлдгээр бүдүүвч орчуулгын алдаанаас болж ноцтой алдаа гардаг гэдэгтэй санал нэгтэй байдаг. Тухайлбал, 1995 онд баталсан Векселийн хуулийг энд жишээ болгож нэрлэж болно. Энэ хуулийг уншиж ойлгох, хэрэглэхэд тун төвөгтэй бөгөөд зарим нэн чухал ойлголтыг энэ хуульд орхигдуулсан байдаг. Жишээ нь, ямар этгээдийг векселийн зохих ёсоор эзэмшигчид /англиар holder in due course/ тоцоох асуудал хамаарна. Энэ нь Иргэний хуулийн шударга эзэмшигчээс өөр утгатай нэр томъёо юм. Харин Улсын Бага хурлын 1922 оны 31 дүгээр хурлын тогтоолоор баталсан Выкшилын дүрмийг уншихад вексель гэж юуг хэлээд байгаа нь илүү ойлгомжтой байдгийг хэлэх нь зүйтэй болов уу.

Нөгөөтэйгүүр гадаад нэр томъёог заавал монголчлох гэж муйхарлан зүтгэх нь төдийлэн үр ашиггүй байдаг. Тухайлбал, гэм буруугүйн презумпц, материаллаг эрх зүй, процессийн эрх зүй, монополия, компани гэсэн нэр томъёог дурдаж болно.

• Дөрөвдүгээрт: Хууль зүйн нэр томъёо Монгол Улсын нэгдэж орсон олон улсын

гэрээнээс бидний хэрэглээнд орж ирдэг. Гэтэл эдгээр гэрээний орчуулга заримдаа тааруухан байдаг.


Хуулийн орчуулгын талаар тэмдэглэж хэлэхэд хуулийн орчуулгыг янз бүрийн мэргэжлийн, янз бүрийн хэллэгт суралцсан хүмүүс хийдэг. Үүнээс болж нэг ойлголт өөр томъёоллоор хэрэглэгдэж байна. Миний ойлгож байгаагаар хуулийн орчуулгыг тухайн салбарт мэргэшсэн хуульч л хийх ёстой. Харин нь тодорхой мэргэжлийн хүмүүс, хуульчид нарийн мэргэшлийн нэр томъёог нь зааж өгөх нь зохистой. Орчуулга хийх гэдэг бол ердийн техник ажил биш нарийн төвөгтэй хөдөлмөр бөгөөд сайн орчуулгыг тухайн асуудлаа сайн мэддэг хүн л хийнэ. Учир нь энэ салбарын талаар сайн мэдлэгтэй байсан тохиолдолд хуулийн утгыг иж бүрэн, үнэн зөв илэрхийлж чадна.

Энэ бүхний эцэст тэмдэглэн хэлэхэд одоогоор бидний хувьд нэр томъёоны сурах бичгийн үүргийг 1978 онд БНМАУ-ын Шинжлэх ухааны Академаас эрхлэн гаргадаг Улсын нэр томъёоны комиссын мэдээ сэтгүүлд орсон "Хууль зүйн нэр томъёоны" тэргүүн дэвтэр гүйцэтгэж болох юм. Энэхүү тэргүүн дэвтэрт 3500 гаруй толгой үг, 10000 орчим хэллэг орсон бөгөөд эдгээрийг манай нэртэй эрдэмтэн Чой.Лувсанжав, Д.Пүрэв, Б.Чимид, дэд эрдэмтэн Д.Дариймаа, Д.

Дашдондог нар боловсруулж оноосон юм.

Цаашид эрх зүйн салбарын чиглэлээр зохих нэр томъёоны судалгааг хийж англи-орос-монгол нэр томъёог хадсан тайлбар толь хэвлүүлж гаргавал хууль боловсруулагч, хууль тогтоогч, шүүгч, их, дээд сургуулийн багш, оюутан сурагчид, сэтгүүлч зэрэг өргөн хүрээний хүмүүс хуулийг нэг мөр томъёолж, ойлгож, хэрэглэх олон талын ач холбогдолтой юм.

Хууль зүйн үндэсний төвөөс хууль зүйн нэр томъёоны нэгдсэн сантай болох зорилгоор хууль зүйн нэр томъёог судлах ажлыг хийж байгаатай холбогдуулан энэ салбарт судалгаа хийсэн, ном бичсэн эрдэмтэн мэргэд бидэнд өөрсдийн бичсэн ном болон үнэтэй саналаа өгвөл гүнээ талархах байна.



- 7574 -

ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх- шүүх эрх мэдлийн хамгийн дээд зэргэмжийн шүүх болох нь

Үндсэн хуулийн түүхэнд улс орнуудын Үндсэн хуулийн шүүхүүд нь хэлбэрийн хувьд ч, институтийн хувьд ч ХХ зууны хоёрдугаар хагаст буюу нэлээд хожуу төлөвшин хөгжжээ. Түүний нэг адил бие даасан Үндсэн хуулийн хяналтын байгууллагын анхдагчийн нэг болох Үндсэн хуулийн шүүхийг Германд 1949 онд буюу Гитлерийн дэглэмийн дараа байгуулсан түүхтэй.

1849 онд батлагдсан Германы Паулскирхийн Үндсэн хуульд Рейхийн шүүх байгуулах тухай заасан байдаг. Энэхүү Рейхийн шүүх нь төрийн байгууллагуудын хоорондын холбооны тогтолцооны тухай маргаан, хэм хэмжээний хяналтын тухай гомдлоос авахуулаад иргэдийн өргөдлийг ч шийдвэрлэх өргөн эрх хэмжээтэй байв. Гэхдээ Паулскирхийн Үндсэн хууль нь хэзээ ч хүчин төгөлдөр болж чадаагүй юм. Үүнээс хойш буюу 100 жилийн дараа 1949 онд Германы Үндсэн хуулийг тогтоочид бие даасан Үндсэн хуулийн шүүх болох Холбооны Үндсэн хуулийн шүүхэд төрийн байгууллага хоорондын эрх зүйн маргааныг шийдвэрлэхээс гадна хүн бүрт Үндсэн хуулиар олгогдсон эрх зүйн хамгаалалтыг тогтоосон юм. Тэрээр хамгийн өндөр зэрэглэлтэй шүүх ба Үндсэн хуулийн байгууллын давхар статустай. Энэ тухай Холбооны



Үндсэн хуулийн цэцийн ажилтан
Э.ЛХАГВАСҮРЭН

Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд тодорхой заасан байдаг.

Холбооны Үндсэн хуулийн шүүхийг төрийн дээд байгууллагын нэг гэж үздэг хүмүүс ч байдаг. Түүнчлэн Үндсэн хуулийн шүүх нь бүрэн гүйцэд тогтнож чадсан бол үндсэндээ парламентын 3 дахь танхим гэж үздэг хүмүүс ч бий. Харин ХБНГУ-ын Үндсэн хуулиар бол Үндсэн хуулийн шүүх нь цэвэр шүүх эрх мэдлийн байгууллага мөн гэсэн үзэл давамгайлдаг юм.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүх Карlsruэ хотноо байрлах бөгөөд шүүхийн үйл ажиллагаа ард түмэнд нээлттэй, ил тод байх зарчмыг бэлгэдэж битүү шилэн 2 цогцолбор байранд үйл ажиллагаагаа явуулж байна.

1.ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн бүтэц, бүрэлдэхүүн

Үндсэн хуулийн шүүх нь 2 сенаттай, Сенат бүр 8 гишүүнтэй, мөн 3 танхимтай. Танхим бүр 3 шүүгчтэй. Анх байгуулагдсан үедээ сенатын 2 танхим нь ажил үүргийн 2 өөр зохион байгуулалттай байв. Тухайлбал, 1 дүгээр сенат нь хүний үндсэн эрх, эрх чөлөөний тухай маргааныг хэлэлцэж шийдвэрлэдэг бол 2 дугаар сенат нь хэм хэмжээний маргаан буюу төрийн эрх бүхий байгууллага, тэдгээрийн албан тушаалтнуудын, Үндсэн хуулийн шүүхүүдийн, муж улсуудын хоорондын, мөн муж улс Холбооны улс хоорондын маргааныг хэлэлцэж шийдвэрлэдэг. Гаргаж буй шийдвэр, нийгэмд үзүүлэх нөлөөллөөс нь шалтгаалж 2 дугаар сенат нь тухайн үедээ Германы улс төрийн амьдралд чухал нөлөөтэй байв. Энэ байдлаас нь шалтгаалсан уу, ямартай ч Германы иргэдийн дунд 1 дүгээр сенатыг "Хүний эрхийн шүүх", 2 дугаар сенатыг "Төрийн шүүх" гэж нэрлэх, ойлгох явдал байдаг.

Хөгжлийн явцад 1 дүгээр сенатын ажлын ачаалал ихэсч улмаар 2 сенатын ажил үүргийг хуваарилах, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор эрүү, улс төрийн орогнол, гадаадын иргэд, төрийн албатай холбоотой хүний эрхийн тухай маргааныг 3 дугаар сенат хянан

шийдвэрлэж байхаар зохицуулсан бөгөөд одоо 2 сенат кобулаа хүний эрхийг Үндсэн хуулийн хүрээнд хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сенатад 6-аас доошгүй шүүгч бүрдсэн тохиолдолд асуудлыг шийдвэрлэх боломжтой болдог. Танхимын шүүгч тухайн танхимд 3 - аас доошгүй жил ажиллах шаардлагатай ба энэ хугацаа дуусгавар болсон тохиолдолд өөр танхимд шилжих эрх нь нээгдэнэ.

2. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилох, бүрэн эрхийн баталгаа

Үндсэн хуулийн шүүхтэй улс болгонд шүүгчийг томилох ажиллагаа маш чухал. Асуудлын гол нь Үндсэн хуулийн шүүх нь парламентаас хараат байж болохгүй гэдэгт оршиж байгаа бөгөөд эс тэргээс тэрбээр хууль тогтоогчийн үйл ажиллагаанд хяналт тавьж байх гол үүргээ биелүүлж чадахгүй болно гэсэн хэрэг. Үндсэн хуулийн шүүх нь улс төрийн туршлага хуримтдуулсан байх шаардлагатай боловч нөгөө талаас хяналт тавьж байх ёстой, мөн улс төрийн шийдвэр гаргадаг тул бүгдээс нь аль болох зай барьж байх ёстой байдаг.

Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хувьд 40 нас хүрсэн, Бундестагт сонгогдох эрхтэй, шүүгч болох шаардлагыг хангасан байх болзолтой. Мөн Үндсэн хуулийн шүүхийн шүүгч болохоо зөвшөөрснөө албан ёсоор бичгээр мэдэгдэх ёстой. Шүүгчийн болзлыг хангасан хүн нь Германы шүүхийн тухай хуулийн дагуу референдарын буюу ассессорын шалгалт өгсөн

хуульч, эсвэл германы аль нэг их, дээд сургуулийн хуулийн салбарын орон тооны профессор байдаг. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн сенат болгоны шүүгчдийн гурвыг Холбооны аль нэг өөр ердийн шүүхийн шүүгчдээс сонгох журамтай. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн аливаа маргааныг шийдвэрлэхэд шүүгчээр ажиллаж байсан хүний дадлага, туршлага зайлшгүй шаардлагатай гэж үздэг байна.

Холбооны Үндсэн хуулийн шүүхийн 2 сенатад хоёуланд нь холбоо болон муж улсуудын төлөөлөл 50:50 хувьтай байдаг. Сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь шууд сонгуулиар буюу Бундестаг, Холбооны зөвлөлөөс томилогдсон сонгуулийн хороогоор дамжин явагддаг. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр сонгогдохын тулд Холбооны зөвлөл болон Бундестагт, өөрөөр хэлбэл, сонгуулийн хорооны 2/3-ын саналыг авах ёстой. Мөн Сенат бүрийн 8 шүүгчийн 3 нь урьд өмнө нь Холбооны ердийн шүүхүүдэд ажиллаж байсан байх шаардлагатай байдаг ба ингэснээрээ дээр хэлсэнчлэн Холбооны шүүхүүдийн хуримтлуулсан туршлага тэдгээрээс Холбооны Үндсэн хуулийн шүүхтэй харилцах харьцааг бий болгох зорилготой гэж үздэг.

Шинжлэх ухааны уламжлал болон улс төрийн туршлагыг хадгалан үлдэхийн тулд сенат тус бүрийн бусад 5 шүүгч эрх зүйн шинжлэх ухааны салбараас болон улс төрийн хүрээнээс сонгогдож болдог байна. Шүүгчээр томилогдсон хүн Бундестаг, Бундесрат Холбооны

Засгийн газар болон тэдгээр харьяа байгууллагад ажиллахыг хориглох бөгөөд шүүгчээр томилогдохоос өмнө энэ байгууллагуудад ямар нэг албан тушаал хашиж байсан бол тэрхүү албан тушаалаасаа чөлөөлөгдөх үүрэгтэй. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид Германы аль нэг их, дээд сургуульд багшлахаас өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хуулиар хориглодог байна.

Хоёр сенатын шүүгчдийн хагасыг Бундестагаас, хагасыг нь Бундесратаас дахин томилогдох эрхгүйгээр 12 жилийн хугацаатай томилдог. Шүүгчээр ажиллах насны дээд хязгаар нь 68 нас байдаг. Нөхөн томилох шүүгчдийг өмнөх шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 3 сарын өмнө сонгосон байдаг. Тухайн үед Бундестаг завсарласан байвал ээлжит хуралдаан эхэлснээс сарын дараа тухайн шүүгчийн оронд ажиллах шүүгчийг томилдог байна. Бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө тухайн шүүгч өөрийн хүсэлтээр болон бусад байдлаар огцорсон байвал түүнийг томилсон байгууллагаас нь тухайн шүүгчийн оронд ажиллах шүүгчийг нөхөн томилдог.

Бундестаг нь Холбооны Үндсэн хуулийн шүүхийн бүрдэлдхүүнд багтах 12 гишүүнтэй. Будестагаас томилогдвол зохих шүүгчдийг шууд сонгууль явуулах замаар томилодог. Харин Бундесратын хувьд ба шууд бус сонгуулиар нийт гишүүдийн 2/3-ын саналыг авснаар Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр томилогдсонд тооцдог байна. Бундестаг болон Бундесратаас Холбооны Үндсэн хуулийн шүүхийн дарга, орлогч даргыг

нийт шүүгчийн дотроос ээлжлэн сонгодог. Өөрөөр хэлбэл, Бундестагаас Үндсэн хуулийн шүүхийн даргыг сонгож байхад, Бундесратаас орлогч даргыг сонгох жишээтэй. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр томилогдсон шүүгчид Үндсэн хуулийн шүүхийн ерөнхий шүүгчийн өмнө “Би шударга шүүгчийн ёсоор ХВНГУ-ын Үндсэн хуулийг үнэнчээр сахин хамгаалж, хэнийг ч үл ялгаварлан шүүгчийн албан үүргийг шударгаар биелүүлэхээ тангараглая” хэмээн тангараг өргөдөг журамтай.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, шүүгчээр ажилласан насны дээд хязгаарт хүрсэн болон бусад шалтгаанаар шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн тохиолдолд Холбооны Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн тэтгэвэр тогтоодог. Энэ хуулиар шүүгч нас барсан тохиолдолд түүний гэр бүлийн гишүүдэд тэтгэмж олгох заалт үйлчилдэг. Мөн Холбооны Үндсэн хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг зогсоовол тухайн шүүгч уг албан тушаалд 2-оос илүүгүй жил ажилласан бол нэг жилийн турш Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн цалингийн хэмжээтэй дүйцэхүйц хэмжээний тэтгэмж авдаг байна.

3. Үндсэн хуулийн шүүхийн эрх хэмжээ

Холбооны Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулиар харьяалуулсан бүх хэргийг хянан шийдвэрлэнэ. Үндсэн хуулийн шүүхээс гаргаж байгаа шийдвэрийн биелэлт

хэрэгжилтэд давхар хяналт тавьдаг. Дараах асуудлыг хянан шийдвэрлэнэ.

- Холбооны Үндсэн хуулийн 93 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын дагуу парламентаас гаргасан хууль, бусад шийдвэрийг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

- Холбооны Ерөнхийлөгч Үндсэн хууль зөрчсөн эсэх; /Холбооны Үндсэн хуульд заасны дагуу Бундестаг эсвэл Бундесрат нь Холбооны Ерөнхийлөгч Үндсэн хууль эсвэл Холбооны өөр нэг хуулийг санаатай зөрчсөн гэж үзвэл Холбооны Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байна. Парламентын аль нэг танхимаас Үндсэн хуулийн шүүхэд хандаж гаргасан дээрх хүсэлтийн агуулгад Ерөнхийлөгчийг буруутгах үндэслэл хангалттай байгаа тохиолдолд түүнийг Холбооны Үндсэн хуулийн шүүх албан тушаалаас нь огцруулах боломжтой хэмээн тооцдог байна./

- Улс төрийн намуудыг хориглох; /Тухайн нам, улс төрийн хүчний баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь ХВНГУ-ын бүрэн эрхт байдал, үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахаар байвал тэдгээр нам, эвслийн үйл ажиллагаанд хориг тавих эрхтэй. Гэхдээ дээрх шийдвэрийг гаргахаас өмнө уг нам, эвслээс явуулж буй улс төрийн үйл ажиллагаа болон түүний гишүүдэд ямар нэг саад хийх эрхгүй./

- Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарласан буюу зөрчсөн талаарх маргааныг хянан шийдвэрлэх; /Энэ талаарх гомдлыг эхлээд холбогдох ердийн шүүхэд хандаж

шийдвэрлүүлсний дараагаар Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх нь иргэдэд нээлттэй болдог./

- Холбооны улсын дээд байгууллагаас гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; /Үүнд Холбооны Ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллага болох Бундестаг, Бундесрат, Холбооны Засгийн газар зэрэг нь орно./

- Үндсэн хуулийн талаархи гомдол өргөдөл, маргаан;

- Газрын харилцаа дахь Үндсэн хуулийн маргаантай асуудлыг;

- Муж улсын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр Үндсэн хуульд нийцсэн эсэх;

- Үндсэн хуулийг тайлбарлах;

- Сонгуулийн ажиллагаа Үндсэн хуульд нийцсэн эсэх;

- Шүүхийн шүүгч Үндсэн хууль зөрчсөн эсэх;

- Олон улсын гэрээ, конвенц Үндсэн хуульд нийцсэн эсэх;

- Төрийн байгууллагын хооронд, эсвэл Төрийн байгууллага улс төрийн хүчнүүдийн хооронд үүссэн Үндсэн хуулийн маргаан.

Үндсэн хуулийн шүүх тогтоосон хэм хэмжээний хяналтыг хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, хууль тогтоох байгууллага эрх зүйн хэм хэмжээг батлан гаргахдаа Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлсэн эсэх мөн хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан болон зөрчсөн эсэхэд хяналт тавьдаг. Аливаа хууль тогтоомж материаллаг талаасаа ч, өөрийн агуулгаараа ч Үндсэн хуульд нийцсэн байх шаардлагын үүднээс энэхүү хяналтыг хэрэгжүүлдэг. Мөн хэм хэмжээний абстракт хяналтыг ч бас хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд

эрх зүйн тодорхой маргаанаас үл хамаарч Холбооны болон Зөвлөлийн эрх хэмжээ нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, түүнчлэн муж улсуудын эрх зүй нь холбооны өөр бусад муж улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцэж байгаа эсэх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг.

4. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог

Холбооны Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн хяналтын дээд байгууллага болохын хувьд Үндсэн хуулийн зөрчилтэй алив маргааныг хянан шийдвэрлэх эрх хэмжээтэй. Энэ ч утгаараа төрийн аль нэг байгууллагад харьяалагдахгүй, тэдгээрээс Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролдох, нөлөөлөхийг хуулиар хориглодог. Маргааныг хянан хэлэлцэхдээ юуны түрүүнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг аль сенатаар хэлэлцэх вэ гэдгийг эхлэн шийдвэрлэх нь маш чухал. Тиймээс энэ асуудлыг сенат бүрээс 3 шүүгч оролцсон тусгай хороогоор хэлэлцээд дүгнэлт гаргаж шийдвэрлэдэг журамтай.

Холбооны Үндсэн хуулийн шүүхээр жил дунджаар 4500 орчим гомдлыг хэлэлцэж шийдвэрлэдэг. Үүнээс гадна маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан 2500 гаруй өргөдөл байдаг гэсэн статистик тоо баримт бий. Энэ бүхнийг сенатаар шийдвэрлээд байвал цаг хугацааны хувьд ч тэр, шүүх бүрэлдэхүүнд орох гишүүдийн хувьд ч гэсэн хүндрэлтэй тул асуудлыг хөнгөвчлөх үүднээс танхим

байгуулсан гэж үздэг. Нийт өргөдлийн 95 орчим хувь нь иргэдийн үндсэн эрхтэй холбоотой маргаан байдаг. Үүнийг танхимаар шийдвэрлэдэг. Бүх шүүгч нийлээд буюу 2 сенат бүрэн бүрэлдэхүүнээрээ бүгд хуралдаанаар хэрэг шийдвэрлэх тохиолдол маш ховор. Гэхдээ 1 дүгээр сенатын гаргасан шийдвэрийг 2 дугаар сенат хүлээн зөвшөөрөхгүй, мөн танхимын аль нэг шүүгч гарсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тухайгаа албан ёсоор гаргасан бол 2 сенат нэгдэж хэлэлцээний эцэст тухайн маргаантай асуудлаар эцсийн шийдвэрийг гаргадаг. /Шүүгч дангаараа хэрэг шийдвэрлэдэггүй бөгөөд өөрийн үзэмжээр хэргийг шийдэх аюултай гэж үздэг.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь тухайн хэргийн оролцогч, өмнө нь оролцогч байсан, эсвэл талуудтай ажил үүргийн дагуу оролцож байсан зэрэг тохиолдолд тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй. /Энэ тохиолдолд өөр танхимын шүүгчдээс сугалааны үндсэн дээр тухайн шүүгчийг оронд ажиллах шүүгчийг томилдог. Харин өөрийн хувийн ашиг сонирхлын шалтгаанаар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзах санал гаргавал шүүхээс түүнийг эзгүйд тооцож шийдвэрээ гаргана.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гарах үед шүүгчдийн санал тэнцвэл шүүх хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ихэнх хуралдаан нь бичгэн хэлбэрээр явагддаг бөгөөд аман хуралдаан болох нь тун ховор. Жилдээ 10-15 удаа

аман хуралдаан болдог. Аман хуралдаанд шийдвэрийг аман байцаалтын үндсэн дээр тогтоолын хэлбэрээр, аман бус байцаалтын үндсэн дээр гаргасан шийдвэрийг магадлалын хэлбэрээр гаргана. Аман байцаалтын явцад протокол хөтлөх бөгөөд мөн техник хэрэгсэл ашиглаж болдог. Үндсэн хуулийн шүүх хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн ажиллах. Үндсэн хуулийн шүүхээс шаардсан аливаа баримт материалыг бусад байгууллага, албан тушаалтан гаргаж өгөх үүрэгтэй байдаг. Шүүх хуралдааны үед гэрч болон шинжээчийг оролцуулах, тэдгээрээс асуулт асуухад эрүүгийн болон иргэний хуулийн холбогдох заалтыг үндэслэнэ. Холбооны Үндсэн хуулийн шүүх шийдвэрээ Үндсэн хуулийн бус, ард түмний нэрийн өмнөөс гаргадаг. Уг шийдвэртээ шийдвэрийг хэрхэн гүйцэтгэхийг заасан байдаг. Шийдвэр гаргах товыг аман байцаалтын явцад зарлах, эсвэл шүүгчдийн зөвлөлгөөн дууссаны дараа тогтооно. Энэ тохиолдолд маргагч талуудад товыг нэн даруй мэдэгдэх ёстой. Нөгөөтэйгүүр шийдвэр уншиж сонсох товыг Үндсэн хуулийн шүүхээс магадлал гаргаж тодорхой хугацаагаар хойшлуулж болдог. Шийдвэрийг шүүгч өөрийн дотоод итгэлээр нотлох баримтад үндэслэн гаргах ба түүнийг бичгэн хэлбэрээр гаргаж, хуралдаанд оролцсон гишүүд гарын үсгээ зурж баталгаажуулна. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг маргагч талууд болон бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй хүргүүлэх ёстой. Мөн

шийдвэрийг Холбооны Хууль зүйн яамны нэгдсэн мэдээлэл албан ёсоор нийтэлж, нийтэд мэдээлнэ.

Маргагч талуудад хэргийн материалтай танилцах, хуулбарлан авах, нэмэлт тайлбар, материал гаргах болон эрхийг хэрэгжүүлэх боломжийг Үндсэн хуулийн шүүхээс бүрдүүлэх, мөн бүлэг иргэн хамтран өргөдөл, гомдол гаргасан тохиолдолд тэднээс төлөөлөгч томилуулахыг шаардах, туслах үүрэгтэй.

Шүүхийн захиргааны үйл ажиллагааг хуулиар зохицуулах боломжгүй тул Үндсэн хуулийн шүүх дэгээ өөрөө тогтоох шаардлагатай байдаг. Үүний нэг адил ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн бүгд хуралдаанаас Үндсэн хуулийн шүүхийн дэгийг баталсан бөгөөд тэрхүү дэгээр үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг боловсруулах, тус шүүхэд ажиллах эрдэм шинжилгээний ажилтныг сонгон шалгаруулах, шүүхийн дарга буюу ерөнхийлөгчөөс байгууллагыг гадагш нь төлөөлөх журам, шүүхийн захиргааны удирдах албан тушаалтны эрх хэмжээ, Үндсэн хуулийн шүүхээс зарлан дуудах бичгийг хүргүүлэх, хүлээн авсан, явуулсан албан бичгийг бүртгэх журам гэх мэт шүүхийн зохион байгуулалт, удирдлагын зарчмыг тодорхойлсон. Мөн илтгэгч гишүүнийг томилох журам, хуралдаан болох өдрүүд, хуралдааны үед шийдвэр гаргах журам, санал хураалт, шүүгчээс онцгой санал гаргах, шүүхийн шийдвэрийг эмхтгэх зэрэг процессын шинжтэй асуудлыг зохицуулсан байдаг.

5. Тамгын газрын бүтэц, зохион байгуулалт

Холбооны Үндсэн хуулийн шүүх захиргааны, төсвийн, тайлан бүртгэлийн, мэдээллийн гэсэн газар, хэлтсүүдтэй. Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхий шүүгч нь Захиргааны хэлтсийн даргын албыг давхар хашдаг. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн дэгээр Тамгын газрын зөвлөлийг байгуулсан. Тамгын газар нь Ерөнхий шүүгчид туслах үндсэн үүрэг, зорилготой. Холбооны Үндсэн хуулийн шүүхэд иргэд захидал, факс, цахилгаан шуудан, электрон шуудангаар өргөдөл, мэдээллийг ирүүлдэг бөгөөд Тамгын газар шууданг шалгах, ялгах ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг. Мөн Тамгын газрын Захиргааны зөвлөл нь өргөдөл, гомдол гаргасан хүмүүст харнуу өгөх, утсаар ярих, зөвлөгөө өгөх, материал шаардах зэрэг олон ажлыг эрхлэн хийдэг. Үүнийг Холбооны Үндсэн хуулийн шүүхийн дэгээр зохицуулсан байдаг. Үндсэн хуулийн шүүхийн шүүгч бүр туслах ажилтантай байдаг. Мөн эрдэм шинжилгээний 4 ажилтантай. Тухайн шүүгч өөрөө эрдэм шинжилгээний ажилтнаа сонгож авдаг. Эрдэм шинжилгээний ажилтан тухайн шүүгчид 3 жил хүртэл хугацаагаар ажиллах ёстой бөгөөд энэ хугацаа дуусвал өөр шүүгчийн эрдэм шинжилгээний ажилтан болох, эсвэл өөр албан тушаал хаших журамтай.

Тамгын газрын Захиргааны зөвлөл нь Үндсэн хуулийн шүүхэд иргэдээс шуудан, факс, электрон шуудангаар ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, гомдлыг шалгах үндсэн үүрэгтэй. Дараа

нь тэдгээрт дурдсан асуудал нь өмнө нь Үндсэн хуулийн шүүхэд ирсэн эсэх, тэр нь шүүхээр шийдвэрлүүлэх маргаан уу, эсвэл мэдээллийн чанартай зүйл үү гэдгийг тодорхойлж өгдөг. Ерөнхий бүртгэлийн хэлтэст иргэдээс ирүүлсэн асуулт, мэдээлэл, хянаж хэлэлцэх гэж буй маргааны талаархи хөндлөнгийн иргэдийн саналыг шилжүүлдэг. Харин өргөдлийн шаардлагыг хангаагүй, хугацаа хэтэрсэн, харьяаллын бус зэрэг Үндсэн хуулийн шүүхээр шийдвэрлэх боломжгүй маргаантай асуудлыг заавал Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид хуваарилахгүйгээр Захиргааны хэлтсийн дарга хүлээн авч тухайн иргэдэд өргөдлийн харнуу өгдөг. Захиргааны хэлтсийн даргад энэ үүргийг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор 10 туслах ажилтан ажилладаг бөгөөд тэдгээр нь заавал хуульч мэргэжилтэй байх шаардлагагүй, харин хуулийн байгууллагад тодорхой хугацаагаар ажилласан байх л шаардлагатай байдаг байна.



Монгол Улсын Газрын хууль тогтоомжийн ТҮҮХЭН ХӨГЖИЛ

ХЗҮТ-ийн ЭША, докторант Н.ОТГОНЧИМЭГ

Газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн өнөөгийн төлөв байдлыг бодитой үнэлж, дүгнэхэд “өнгөрсөн, одоо, ирээдүй” цагийн хэлхээнд асуудлыг авч үзэх шаардлагатай юм гэдэг бодол төрж улмаар 2002 онд “Газрын тухай” болон “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хууль батлагдахаас өмнө Монгол Улс энэ төрлийн харилцааг ямар хууль, эрх зүйн актаар зохицуулж байсныг судалсан юм.

Тэгээд ч одоо ярьж, бичиж буйгаар бол Монгол Улсад анх удаа иргэн газар өмчилж байна гэх бөгөөд үүнийг судалгааны хүрээнд магадлан тогтоох эрмэлзэл төрснийг дурдах хэрэгтэй. Монгол Улсад газар хувийн өмчлөлд байсан эсэх асуудлыг судалгаа, эрдэм шинжилгээний хувьд төдийгүй, газрыг өмчлөлдөө авч буй иргэдийн хувьд сонирхол татах зүйл юм.

Монголын нэгдсэн улс 1206 онд байгуулагдсан үеэс 2004 он хүртэлх хугацаанд газарт холбогдох нийт 40 гаруй хууль, дүрэм батлагдан гарчээ.

Чингисийн “Их засаг” хуулийн¹ (1206 он) 34 дүгээр зүйлд “Өвс ногоорсон хойно газрыг нүхэлсэн учир ба гал алдаж бэлчээрийг шатаагсдын вэген гэрийг ална” гэжээ. Энэ

нь газрын бүтэц, гадаад төлөв байдал, ургамлын бүрхэвч давхрааг онцгойлон анхаарч хамгаалж байсныг илтгэнэ. “Нэгэн гэр”-ийг гэдэг нь гэм буруутай хүний гэр бүл дэх бүх хүмүүсийг гэсэн бололтой. Газар бэлчээртэй холбоотой дээрх хуулийн заалт хэдий хатуу ч, ялын энэ бодлого нь хуулийг туйлбаргүй чанд мөрдүүлэх гэсэн зорилго агуулж байсан гэж үзэж байна. Чингисийн Их засаг хуулийн нэлээд олон заалт өнөөг хүртэл амьдралд хэрэглэгдсээр, төр нь заншлын шинжтэй болсон. Тухайлбал, газар нүхлэхгүй байх, бэлчээрийг хамгаалах, газар дэлхийгээ шүтэж өглөө бүр тайныхаа дээжийг өргөх гэх зэрэг ёс заншил амьдралд төлөвшин тогтсоныг үгүйсгэх аргагүй юм.

“Үйсэн дээр бичсэн 18 цаазын бичиг”-т газар бэлчээрийг хамгаалах олон зохицуулалт байсны дотор цаазын 11-т “Мод хатгасан газарт мэдэж байж бууваас “... рван ест буй. Эс мэдэж бууваас нэг морь ав.”² гэсэн нь газар эзэмших ашиглах харилцааг тодруулбал, эзэмшил давхардах харилцааг зохицуулж байсан жишээ болов уу.

1640 оны “Монгол Ойрадын цааз”-д хаад ноёдын ав хөмрөгөө хийх тусгайлан тогтоосон хориотой газарт орох эрхгүй анчин хүн ороход малаар торгож, нүүхдээ галаа унтраах, өвс ургамал, ойг хамгаалахыг заасан байв.³

1709 оны “Халх журам хууль”-д Хан-Уул, Хөгнө, Төхөм, Шивэрт, Онгон, Зоргол, Адаацаг, Улааннуур зэрэг газрыг онголон дархалж, газар эзэмших, бэлчээр хамгаалах, хүрээ хийдийн хуурай, нойтон мод огтлохгүй байх, зөрчвөл ямбатан сайдыг бод мал, энгийн хүнийг бог малаар торгохыг заажээ. Түүнчлэн “сүм хийдийн ...газар нутаг, ой модыг хуулиар дархалж халдашгүй болгосон байна.”⁴ Мөн “нүүсэн нутгаас хоногийн дотор түймэр гарваас ял хэлэлцэх, хөн хүн нүүсэн нутгийнхаа галыг унтраа, эс унтрааваас шүдлэн морь ав гэж”⁵ заажээ. Эдгээр заалт нь бэлчээр бүхий газрын үржил шимийг бууруулахгүй байх, олны хөл ихтэй сүм хийдийн газар хамгааллыг анхаарч байсныг харуулж байна.

1921 оны Ардын хувьсгалыг хүртэлх хугацаанд Монгол Улсад газрын харилцаа төдийлөн хөгжөөгүй талаар дээрх хууль цаазын бичгүүдийг нэгтгэн дүгнэлт хийж болно.

1. Г.Сайшаал. Чингис хааны товчоон. /Өвөр Монголын хэвлэлийн хороонд 1989 онд хэвлүүлсэн номноос монгол бичгээ буулган авав./

2. Т.Алтангэрэл. XVI-XVII зууны Монгол цаазын бичгүүд. УБ., 1999 он, 53 дахь тал.

3. Т.Сонгдорж. “Экологийн эрх зүйн уламжлал шинэчлэл” УБ., 1999 он, 32 дахь тал.

4. Э.Авирмэд, Д.Дашдэдэн, Г.Совд “Монгол хууль”. УБ., 1997 он, 76 дахь тал.

5. Мөн зохиол. 79 дэх тал.

Тухайн оны үеэс эхлэн төр засгийн байгууллагаас ард нийтийн газар тариалан эрхлэх явдлыг ихээхэн дэмжиж газар тариалангийн харилцааг хөгжүүлэхийг эрмэлзэж байсан. Энд зарим жишээ дурдъя.

БНМАУ-ын Анхдугаар Их хурлаас Засгийн газар ба олон яамдын илтгэлийг сонсоод 1924 оны 11 дүгээр сарын 8-нд гаргасан тогтоол¹-ын 5-д:

“1. Монголчуудыг тариалангийн ажилд боловсруулах явдлыг сайшаан хөгжүүлэх аргыг сүвэгчлэх;

2. Чухал хэрэглэгдэх тарианы зүйлийг бэлтгүүлэх ба тариалангийн явдлыг ард түмэнд өргөнөөр таниулахын учир ялангуяа улсын сангаас тариалангийн үйлдвэрийг байгуулан явуулах”... гэснийг анхааран үзвэл Монгол Улсад газрын харилцаа төдийлөн хөгжөөгүй ирсэн байна. Үүнийг дараахь хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно:

• Нүүдэллэн амьдрах хэв ёсноос үүдэн байнгын эзэмшлийн газар гэж байсангүй, мөн “Мод хатгасан газарт мэдэж байж бууваас...” гэсэн зохицуулалтаас үзвэл нүүдэллэн амьдрах газраа өөрсдөө сонгодог байсан;

• Газар тариалах хөгжих нэг үндэс нь суурин амьдрал бөгөөд суурин газар олноор бий болоход амьдралын хэв заншил нь саад болж байсан ажээ. Ийнхүү газар тариаланг хөгжүүлэх ажил Ардын хувьсгалын дараахь жилүүдэд эрчимтэй хийгдсэн нь тухайн үед гарч байсан тогтоол, дүрмүүдээс харагдаж байна²;

• Газрын үр шимийг тариалангийн замаар хүртээх төрийн гэсэн арга барил, мэдлэг дутагдаж байсан бололтой.

1921 оны 5 дугаар сарын 21-нд Ардын түр Засгийн газраас “Газрыг хувийн өмч болгохыг устгах тухай” тогтоол гарсан байх бөгөөд тогтоол нь нэг зүйлээс бүрдсэн, түүнд “Монгол ардын үндсэн хөрөнгө болох газрыг энгийн хүмүүст хувь хязгааргүй хэрэглүүлэх явдлыг устгавал зохино” гэсэн байдаг. Тогтоолыг өнгөц уншихад Монгол Улсад газар хувийн өмчид байсан мэт санагдах буй заа. Гэвч үүнийг “газар эдлэх харилцаа хэн хүний дураар хэрэгжиж байсныг зогсоон, улмаар газар бол тусгаар Монгол Улсын мэдлийн гэдгийг харуулсан тунхаглал байсан” хэмээн дүгнэж нь зүйтэй.

1924 оны БНМАУ-ын Анхдугаар Үндсэн хуулийн³ 3 дугаар зүйлийн 1-д “БНМАУ-ын хязгаарын дотор бүхий газар ба уурхай хийгээд ой мод, ус ба мөн тэдгээрийн баялгууд бол эрт цагаас нааш ард нийтийн хөрөнгө байсаар ирсэн зан суртал нь чухам одоогийн ард улсын ёсонд нийлэлцэх тул энэхүү хөрөнгө бүрнээ ардын мэдэлд байвал зохих бөгөөд энэ тухай хувийн өмч байгуулж үл болно” гэснээс гадна “Улсын дээд эрхийг барих газрын тухай” гэсэн II бүлгийн 10 дугаар зүйлд “Газар эдлэх нийтийн дүрмийг батлах, аймаг хошуудын нутгийн хил хязгаарыг байгуулах, дэлхийн баялгийг ашиглах, дүрэм зааврыг тогтоох” гэсэн бөгөөд

энэ нь газар өмчлөх, улмаар хамгаалах харилцааны эрх зүйн үндэс болсон.

Үндсэн хуулийн уг заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас 1926 онд “Газар бэлчээрийг эдлэх тухай” тогтоол гарчээ. Энэ тогтоол төрийн эрх баригчдаас бэлчээр нутгийг заан олгуулж байх анхны эрх зүйн акт болжээ.

Харин 1928 оны 6 дугаар сарын 29-нд батлагдсан “Монголчууд тус улсын хязгаарын дотор нутаг бэлчээрийг эдлэх түр дүрэм”-д хошуу нутаг нүүдэллэн бэлчээр эзэмшихийг хориглож⁴ байсан явдал нь Монгол Улсад бэлчээр ашиглах харилцаа хэдийнээс онцгой анхааралд байсан болохыг нотлоно.

1940 оны Үндсэн хуулийн⁵ 5 дугаар зүйлд “бүх газар, түүний хөрсөн дорхи баялаг, ой, мод, ус тэдгээрийн баялаг ... бол улсын өмч буюу ард нийтийн хөрөнгө мөн. Эдгээрийг хувьдаа өмчилж болохгүй”, 8 дугаар зүйлд “Газар бол улсын өмч буюу ард нийтийн хөрөнгө мөний тул бэлчээр буюу тариаланд ашиглуулахаар ард иргэн, түүнчлэн хөдөлмөрчдийн сайн дурын нэгдэлд үнэ төлбөргүйгээр олгогдоно.” мөн “Ард иргэний үндсэн эрх, үүргүүд” гэсэн 13 дугаар бүлгийн 88 дугаар зүйлд “... мал аж ахуйг аль болохоор өсгөн хөгжүүлэх зорилгоор бэлчээрийг үнэ төлбөргүй хэрэглэх...” хэмээн заасан нь Анхдугаар Үндсэн хуулийн заалтыг хэвээр бататгасан байна.

1. БНМАУ-ын Их, Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, Тунхгууд. УБ., 1956 он, 19 дэх тал.

2. 1921 оны 5 дугаар сарын 21-нд Ардын түр Засгийн газраас “Газрыг хувийн өмч болгохыг устгах тухай” тогтоол, 1922 оны 11 дүгээр сарын 5-нд “Гадаадын хүмүүсээс малын бэлчээрийн түрээс хураах дүрэм”, 1923 оны 11 дүгээр сарын 10-нд “Халдан хадах ба тариалан ногоо тарих тухай дүрэм” тус тус батлагдаж байжээ.

3. БНМАУ-ын Их, Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, Тунхгууд. УБ., 1956 он, 30, 32 дахь тал.

4. Т.Сэнгээрж. Монгол Улсын газрын эрх зүй. УБ., 1998 он, 13 дахь тал.

5. БНМАУ-ын Их, Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, Тунхгууд. УБ., 1956 он, 235, 236 дахь тал.

1942 онд батлагдсан “Газар эдэлбэрийн хууль”¹ нь иргэд, гэдний үйлдвэрийн нэгдэл ба соршоо, үйлдвэр зэрэг улсын бүх байгууллагад газар шороо, бэлчээр, өвс хадлан, тариалан зэргийн ажлуудад газрыг ямар

ч үнэ төлбөргүй, хугацаагүй ашиглуулах зорилготой гарсан байна.

Газар олгох ажиллагааг хуульд хэрхэн тусгасныг харьцуулан үзвэл:

Газрын төрөл	Ашиглах эрх олгож байсан байгууллага
Станц ба улсын аж ахуйнуудын ашиглах газар	Мал, газар тариалангийн яам
Улсын албан ба олон нийтийн байгууллагын туслах чанарын хадлан тариалангийн газар	
Үйлдвэрийн нэгдэл ба хоршоо худалдааны албан байгууллагуудын төрлө, ногоо төрх газар	Аймгийн мал, газар тариалангийн хэлтэс
Ой доторхи хадлангийн газар	
Хотын дотоод ба эргэн тойрны газар	Хотын захиргаа
Хотод, түүний орчмын газар ногоо төрх, хадлан хадах газар	
Ардын аж ахуйтнуудад олгох тариалан хадлангийн газар	Сумын захиргаа

Тухайн үед газартай холбоотой маргаан нэлээдгүй гарч байсны илрэл нь газрын маргааныг шийдвэрлэх асуудалд нэгэн бүлгийг зориулсан

явдлаар илэрч байна. “Газар эдэлбэртэй холбогдсон маргалдааныг таслах журам” гэсэн 7 дугаар бүлгийн зохицуулалтыг схемлэн үзүүлбэл:



1960 оны 7 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд “Бүх

газар түүний хөрсөн доорхи баялаг, ой мод, гол ус, тэдгээрийн баялаг, улсын

фабрик, завод, уурхай цахилгаан станц, төмөр зам, авто машин, усан ба агаарын тээвэр, засмал зам, холбооны хэрэгсэл, банк, улсын хөдөө аж ахуйн үйлдвэрийн газар (сангийн аж ахуй, мал аж ахуйн машинт станц зэрэг), улсын нийгэм ахуйн газар, хот суурин газрын орон сууцны улсын үндсэн фонд, улсын үйлдвэрүүдийн түүхий эд, материал, бүтээгдэхүүн, улсын худалдаа бэлтгэлийн ба соёл, шинжлэх ухааны газрууд, мөн улсын бүх байгууллагын эд хөрөнгө энэ бүхэн бол улсын өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө мөн.” гэжээ.

1971 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн Газар эдэлбэрийн хуулийн² зорилт нь газрыг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв зохистой эдлэх, хамгаалах явдлыг хангах, газрын үр ашгийг дээшлүүлэх нөхцөлийг бий болгоход оршиж байсан.

Газрыг ашиглах зориулалтаар нь ангилан хуваах зохицуулалт анх энэ хуулиас эхэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл энэ хуулиар газрын нэгдмэл санг анх удаа:

1. Хөдөө аж ахуйн эдэлбэр газар;
2. Хот суурины эдэлбэр газар;
3. Тусгай хэрэгцээний эдэлбэр газар;
4. Улсын ойн фондын газар;
5. Улсын нөөц газар;
6. Улсын усны фондын газар хэмээн ангилж байжээ.

Газар эзэмших, ашиглах эрхийг дараахь байдлаар олгож байв.

Газрын төрөл	Ашиглах эрх олгож байсан байгууллага
Хөдөө орон нутгийн иргэд эзэмших газар	Нэгдлийн зөвлөлийн шийдвэрийг баримтлав сумын АДХ олгоно
С.А.А. улсын байгууллагын ажилчдад болов иргэд ахуйн зориулалтаар эзэмших газар	Хот, сум хорооны АДХ
Аж ахуйн зориулалтын газар эзэмших газар	

1. Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1942 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 8 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлд баталсан. БНМАУ-ын Үндсэн хууль, түүнд холбогдох актын эмхтгэл. УБ., 1974 он, 33-39 дэх тал.
 *Төр үед станц ба улсын аж ахуйнууд гэдэгт хөдөө аж ахуйн байгууллагуудыг хамааруулан үзэж байжээ.
 2. БНМАУ, Хууль, дүрэм, тогтоолын эмхтгэл, 1971 он, № 11. СнЗ-ийн хэвлэл. УБ., 400-415 дахь тал.

1971 оны Газар эдэлбэрийн хуулийн бас нэгэн онцлог бол эдлүүлэх газрын хэмжээ нь хамтран эсвэл дангаар гэдгээс хамааран өөр байсанд оршино. Тухайлбал:

Газрын төрөл	Хамтран	Дангаараа
Хот сууринны, сумын төвийн иргэдийн эдлэх газар	0.04 га	0.03 га
Хөдөө орон нутгийн иргэдийн эдлэх газар	0.06 га	0.05 га

Газрын маргааныг шийдвэрлэх харьяаллыг нутаг дэвсгэрийн зарчмын дагуу зохицуулсан ба энэ нь 1942 оны Газар эдэлбэрийн хуульд газрын маргааныг эрх олгосон байгууллага нь харьяалан шийдвэрлэх зарчимтай байснаас ялгаатай байна. Тодруулбал:

Маргааны төрөл	Шийдвэрлэх субъект		
Сум, хорооны газрын маргаан	Сум, хорооны АДХГЗ	⇒ Дээд шатны байгууллага	⇒ Сайд нарын Зөвлөл
Аймаг, хот доторх газрын маргаан	Аймаг, хотын АДХГЗ		

Эрх зүйн тогтолцоо 1992 онд бүхэлдээ шинэчлэгдсэний дараа 1971 оны Газар эдэлбэрийн тухай хуулийг залгамжлан 1994 онд Газрын тухай хууль, 2002 оны 6 дугаар сарын 7-нд Газрын тухай хууль (шинэчилсэн найруулга), 2002 оны 6 дугаар сарын 28-нд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тус тус батлагдсан билээ.

1992 оны Үндсэн хуульд газар өмчлөх эрхийг тунхаглан зааснаас хойш 10 гаруй жил иргэд түүнийгээ эдлэх боломжгүй явсны эцэст Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлагдсан. Энэ хуулийг батлах хэлэлцүүлгийн явцад хуулийн гол мөн чанарыг газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж иргэдэд баялаг хүртээх явдал гэж тодорхойлж байсан нь бодит байдал дээр хэрэгжиж чадаагүй гэх үндэстэй. Хуульд иргэн өмчийн газраа хэрхэн барьцаалах, худалдаалах, түрээслэх, тухайн харилцаанд оролцогчдын эрх, үүргийн

байдал ямар байх гэх мэтчилэн эдийн засгийн буюу иргэний гүйлгээний асуудлыг хамруулаагүй тул газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилго энэ хуульд биелэгдээгүй юм. Үүний бас нэг нотолгоо бол УИХ-аас 1997 оны 7 дугаар сарын 9-ны өдөр баталсан “Намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” №70 дугаар тогтоолд Иргэний хувийн өмчийн газрын тухай болон Газар хувьчлах тухай хуулийн төсөл орсон байв. Тухайн төслүүдийг төвлөсөн ёсоор хэлэлцээгүй бөгөөд дараагийн 1998, 1999 оны хавар, намрын ээлжит чуулганаар¹ энэ хоёр хуулийн төслийг хэлэлцэхээр тогтоол гаргаж байжээ. Эдгээр тогтоолоос үзвэл Газар хувьчлах тухай хуулийн төсөл нь төрөөс эрх олгох ажиллагааг буюу газар өмчлүүлэх харилцааг, харин Иргэний хувийн өмчийн газрын тухай хуулийн төсөл нь газрыг эдийн засгийн эргэлтэд

оруулах харилцааг зохицуулах байжээ. УИХ-ын дараагийн тогтоолуудад² энэ хоёр хуулийг Газрын багц хуулийн төсөл гэсэн нэрэн дор хэлэлцэхээр төлөвлөж байв. Гэвч эдгээр төлөвлөсөн ажлууд цаг хугацаандаа хийгдэж чадаагүй бөгөөд УИХ-аас баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2003 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”³-д “газрын шинэтгэлийг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудын хэрэгжилтийг зохион байгуулан эрчимжүүлж, газрыг зурагжуулах, баталгаажуулах ажилд тэдхүү анхаарна” гэснээс үзвэл Иргэний хувийн өмчийн газрын тухай хууль орхигдсон байна. Үүгээр хэлэх гээд байгаа зүйл бол газрын шинэтгэлтэй холбогдсон УИХ-ын гол зорилт болсон газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах хууль батлагдсангүй, харин зөвхөн

1. УИХ-ын 1998 оны №24, №105, 1999 оны №10, №58 тогтоол.

2. УИХ-ын 2001 оны №24, №64, 2002 оны №07, №48 тогтоол.

3. УИХ-ын 2002 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн №80 тогтоол.

төрийн өмч (газар) хувьчлах хууль гарсан байна.

Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль" нь төрийн өмчийг нийтэд хэрхэн хувьчлах процессын асуудлыг хөндөж, харин иргэн маань цаашид түүний ашиг тусыг хэрхэн гаргаж өмчлөх харилцааг зохицуулж чадаагүй юм.

ОХУ-д гэхэд энэ талын харилцааг зохицуулсан **Ипотекний (үд хөдлөх хөрөнгийн барьцаа) тухай**¹ хууль үйлчилдэг ажээ. Энэ хуульд үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны нэг зүйл нь газар байхаар тусгаж, дараахь асуудлыг зохицуулсан байна. Үүнд:

- 1) Ерөнхий үндэслэл;
- 2) Ипотекний гэрээ байгуулах;
- 3) Ипотекний баримт;
- 4) Ипотекнийг улсад бүртгэх;
- 5) Ипотекний гэрээний зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангах;
- 6) Ипотекний гэрээгээр хангагдсан эрх өөр этгээдэд шилжих;
- 7) Дагалдах ипотек;
- 8) Ипотекний гэрээний эрхийг шилжүүлэх;
- 9) Ипотекний гэрээний зүйлийг хураан авахаар хандах;
- 10) Хураан авахаар хандсан эд хөрөнгийг худалдах;
- 11) Газрын ипотекний онцлог;
- 12) Аж ахуйн нэгж, барилга, байгууламж барьцаалах онцлог;
- 13) Хувийн болон нийтийн эзэмшлийн орон сууцны барьцааны онцлог;
- 14) Бусад зүйл. Энэ хуулийн газрын ипотекний харилцааг онцгойлсон 11 дүгээр бүлэгт дараах зүйлүүд багтсан байна:
 - Ипотекний зүйл байх газрын төрөл;
 - Ипотекний зүйл байж үл болох газрын төрөл;

- Барилга, байгууламж бүхий газрыг ипотекний зүйл болгох;

- Ипотекний зүйл дээр барьцаалагч барилга, байгууламж барих;

- Барилга, байгууламж нь гуравдагч этгээдийн эзэмшилд орших газрыг ипотекний зүйл болгох;

- Ипотекний газрыг үнэлэх;

- Ипотекний газрыг хураан авахаар хандах онцлог.

ОХУ-ын энэ хуулиас үзвэл газрын ипотекнийг нэлээд нарийвчлан зохицуулсан байна. Учир нь газрын Ипотект хамгийн их анхаарал татдаг "газрыг хэнд барьцаалж болох", "ипотекний газрыг хэрхэн үнэлэх", "ипотекний газар дээрх барилга, байгууламжийг хэрхэх", "ипотекний зүйл бусдад яаж шилжих" зэрэг асуудлыг зохицуулж чадсан юм.

Тэгвэл эдгээр асуудал Монгол Улсын хуулиудад хэрхэн зохицуулагдсаныг ОХУ-ын хуультай харьцуулан авч үзье.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 27.1.3-т "газар өмчлөгч өмчийн газрыг зохих журмын дагуу иргэнд худалдах, арилжих, өлгүүлэх, бэлэглэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах" гэсэнэс үзвэл банк болон бусад санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгжид газраа барьцаалаа зээл авах боломжгүй байгаа юм. Энэ заалт нь зөвхөн иргэнд хоорондын барьцааны харилцааг хүлээн зөвшөөрчээ. ОХУ-ын хувьд газрыг хэнд барьцаалж болохыг тухайлан заргаагүй бөгөөд газрыг барьцаалах этгээд нь иргэн болоод банк, бусад байгууллагууд байж болдог байна. Өөрөөр хэлбэл, газрыг өмчилж үл болох этгээдүүдэд газраа барьцаалж болдог ажээ. Мэдээх хэрэг эндээс нэг асуулт гарах юм. Энэ нь барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ

газрын эзэн биелүүлээгүй бол газар барьцаалагчид шилжих болно. Энэ тохиолдолд тэд газрыг өмчлөх эрхгүй шүү дээ? гэсэн асуулт. Үүнийг ОХУ-ын тус хуулийн 68 дугаар зүйлд "газрыг дуудлага худалдаагаар худалдах бөгөөд дуудлага худалдаанд газар өмчлөх эрх эдэлж болох этгээдүүд оролцоно" гэж заажээ.

Газрын барьцаатай холбогдох анхаарал татсан бас нэгэн асуудал бол ипотекний газрын үнэлгээ юм. Нийслэлийн дүүргүүдийн 250 иргэдийн дунд² явуулсан судалгаагаар "Та газар эзэмших, өмчлөх эрхийнхээ хүрээнд газраа эдийн засгийн эргэлтэд оруулах (тухайлбал, барьцаалах) боломжийг ашиглаж байсан уу?" гэсэн асуулдад

- 206 буюу 82.4% нь үгүй;

- 39 буюу 15.6% нь тийм;

- 4 буюу 0.2% нь огт дуулаагүй;

- 1 нь газаргүй гэсэн хариулт өгчээ. Иргэд хуулиар олгогдсон эрхээ төдийлэн хэрэгжүүлэх сонирхолгүй байгаа шалтгаан нь юуны өмнө тухайн хууль батлагдаад удаагүй байгаатай холбон тайлбарлаж болохын зэрэгцээ бас нэг гол шалтгаан нь барьцаалагч тал газрыг суурь үнэлгээнээс нь доогуур үнэлдэгт оршиж байна. Монгол Улсын Газрын тухай болон Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд газрыг барьцаалахдаа үнэлгээний ямар чиг баримжаатай байх талаар зохицуулалт хийгдээгүй нь энэ асуудлыг зах зээлийн зөнд нь орхисон хэрэг болжээ.

ОХУ-ын хувьд барьцааны гэрээний талууд газрыг үнэлэхдээ түүний суурь үнээс нь доогуур үнэлэхийг хориглосон байдаг байна.¹ Энэ зохицуулалтын сайн тал нь барьцаалагчид давуу эрхийг хязгаарлахад оршиж байгаа юм. Зах зээлд зээлдүүлэгч тал

1. Федеральный закон "Об ипотеке (залоге недвижимости)". 1998 оны 7 дугаар сарын 16.

2. Судалгаанд Нийслэлийн Ваянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Баянгол, Сонгино хайрхан, Сүхбаатар дүүргт газар эзэмшиж байгаа иргэд хамрагдсан юм.

нь өөрийн нөхцөлөө тогтоож тулгадг Монгол Улсын хувьд энэ заалт үлгэрлэн авбал зохих зүйл болох юм.

Газрын эдийн засгийн эргэлтийн тухай иргэдийн санаа бодол ямар байгааг асуулгын аргаар тандсан юм. (Судалгаанд нийт 250 иргэнийг хамруулсан юм.) "Та газрын барьцааны тухай хууль шинээр батлан гаргах шаардлагатай гэж боддог уу?" гэсэн асуултад:

- 190 буюу 76% нь газар эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээг барьцаалах асуудлыг нарийвчлан хуульчлах шаардлагатай;

- 32 буюу 12.8% нь иргэд газар эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээгээ төдийлөн барьцаалдаггүй тул ийм хууль шаардлагагүй;

- 28 буюу 11.2% нь хариулаагүй байна.

"Газрын эдийн засгийн эргэлтэд бодит утгаар оруулахад юу хийх шаардлагатай гэж үзэж байна вэ? гэсэн асуултад

а. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох 61 буюу 24.4%;

б. Төрийн байгууллагын үйл ажиллагааг одоогийн байгаа төвшнөөс идүү нээлттэй, үр нөлөөтэй болгох 31 буюу 12.4%;

в. Эрх зүйн зохицуулалт шаардлагагүй, харин зохион байгуулалтын арга хэмжээ авах хэрэгтэй 16 буюу 0.6%;

г. Банк, санхүүгийн бусад байгууллагад барьцааны асуудлаар зөвлөмж гаргах 45 буюу 1.8%;

д. Нэгэнт хуулиар зөвшөөрсөн тул иргэдэд энэ талаар сургалт, мэдээллийн ажил өрнүүлэх 118 буюу 47.2%;

е. Бусад-1.

Энэхүү асуулгыг дүгнэн үзвэл газрын хууль тогтоомжийн талаар иргэдэд мэдээлэл дутагдалтай байдаг байна. Түүнчлэн газрын барьцааны хууль тогтоомжийг боловсронгуй болгож, шинэ зохицуулалт хийх шаардлагыг иргэд тавьж байгаа юм.

Монгол Улсын газрын хууль тогтоомжийн түүхэн хөгжлийн талаар нэгтгэн дүгнэвэл:

1. Ардын хувьсгалаас өмнөх түүхийн үеүдэд газрын харилцаа нь гол төлөв хамгаалах чиглэлтэй буюу газрын хөрс, ургамлын бүрхэвч, бэлчээрийн үржил шимд онцгой анхаарч байжээ. Энэ нь өвч ногоорсон хойно газар нүхлэхгүй байх, нүүж, суухдаа газар орчноо цэвэрлэх, нүхлэсэн газрыг булах, бэлчээр шатаахыг хориглосон хэм хэмжээгээр илэрч байна.

2. Газрын эзэмшил тодорхой хэмээгээр оршиж байв. Эзэмшлийг засаг тайж, ноёд онцгойлон тогтоож байсны тод жишээ бол Монгол Ойрадын цаазад ноёдын ав хомрог хийх газрыг тусгайлж байсан явдал болно.

3. Дундад зууны үеийн хууль цаазын эх сурвалжуудыг харьцуулан үзэхэд газар өмчлөлтэй холбогдох заалт ажиглагдаагүй нь энэ үед газар өмчлөлийн харилцаа байгаагүй гэсэн дүгнэлтэд хүргэсэн. Харин эзэмшил газар гэх ойлголт байсан.

4. 1921 оны Ардын Хувьсгалын дараа үеийн газрын хууль, тогтоолын хамарч байсан асуудлаас үзэхэд Монгол Улсад газар тариалан тун муу хөгжиж байсан байна. Энэ нь мөн газар өмчлөлийн харилцаа монголд байгаагүй юм гэсэн дүгнэлтийг бататгана. 1924 оноос хойш 1992 он хүртэлх хугацаанд Үндсэн хуульд газрыг хувийн өмч болгохыг хориглож ирсэн.

5. Хувьсгалын дараах жилүүдэд суурин газар харьцангуй ихэсч газар ашиглах, эзэмших харилцаа шинэ шатанд гарчээ. Үүнийг 1942, 1971 оны Газар эдэлбэрийн хуулийн бүтэц, хамарсан харилцаа нотолно. Энэ хуулиар газрыг үнэ төлбөргүй, хугацаагүй эзэмшүүлэх зохицуулалттай

байв. Одоогийн хуулиас ялгаатай нэг зохицуулалт бол 1971 оны хуульд газрыг дангаар эсвэл хамтран эзэмшихээс хамаарч олгох хэмжээ нь ялгаатай байсан явдал юм.

6. Үндсэн хуульд газар өмчлөх эрхийг тунхаглан зааснаас хойш 10 гаруй жил түүнийгээ эдлэх боломжгүй явсны эцэст Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль батлагдсан боловч газрыг эдийн засгийн эргэлтэд бодит утгаар оруулж, үр ашгийг нь хүртэх эрх зүйн орчин өнөөг хүртэл үгүйлэгдэж байна. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль бол иргэдийн газар өмчлөлийн харилцааг зохицуулсан бус харин зөвхөн төрийн өмчийн хөрөнгийг хувьчлах асуудлыг хамарсан хууль болсон байна. Иймд газрыг иргэний эрх зүйн гүйцлэгэнд оруулсан харилцааг зохицуулсан Газрын барьцаа (ипотек), түрээсийн харилцааны тухай хууль батлан гаргах шаардлага тулгарч байна.

7. Иргэд эзэмших, ашиглах, өмчлөх, эрхийн хүрээнд газраа зөвхөн иргэдэд барьцаалах хуулийн зохицуулалтыг өөрчилж, банк, санхүүгийн бусад байгууллагад барьцаалах эрхийг олгосон зохицуулалт хийх шаардлагатай. Ингэхдээ банк, санхүүгийн байгууллага нь дуудлага худалдаа хийхэд хүрвэл газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхтэй этгээдийг л оролцуулах үүрэг хүлээлгэх нь зүйтэй байна.



1. Федеральный закон "Об ипотеке (залоге недвижимости)". 1998.7.16. Статья 67.

Зохиогчийн эрхийн ТЭМДЭГЛЭГЭЭ



ХЗУТ-ийн секторын эрхлэгч,
Удирдлагын Академийн ахлах
багш Д.ЦОЛМОН

Зохиогчийн эрхийн таних тэмдгийн талаар авч үзье. Үүнийг "Copyright notice" гэж англи хэл дээр бичдэг бөгөөд монголоор зохиогчийн эрхийн тэмдэглэгээ гэж хөрвөж болох боловч манай улсын зохиогчийн эрхийн тухай хуульд "бүтээлд хэрэглэх таних тэмдэг" гэж томъёолсон байна. Энэ нь цагираг доторх "С" үсэгтэй тэмдэг байдаг бөгөөд хэвлэгдсэн бүтээлийн он, сар, өдөр, зохиогчийн эрх эзэмшигчийн нэрийг заасан тэмдэглэгээ байдаг ба аливаа хэвлэл, нийтлэлд харагддаг билээ.

Энэхүү тэмдэглэгээ нь тухайн бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан болохыг олон нийтэд мэдэгдэх хэлбэр бөгөөд хэнд энэ бүтээлийн зохиогчийн эрх хадгалагдаж байгаа, хэдий үеэс эхлэн хамгаалагдсан талаар бусад этгээдэд мэдээлж байгаа ойлголт билээ. Зохиогчийн эрхийн тэмдэглэгээний талаар "Монгол Улсын Зохиогчийн

эрхийн тухай" хуулийн 10 дугаар зүйлд "Бүтээлд хэрэглэх таних тэмдэг" гэж оруулсан бөгөөд бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигч нь нийтийн хүртээл болгосон бүтээлийн зохиогчийн эрх нь хамгаалагдсаныг илэрхийлэх дугуй хүрээтэй "С" гэсэн латин үсэг бүхий таних тэмдэг хэрэглэж болно. Уг таних тэмдгийн хамт бүтээлийг анх нийтийн хүртээл болгосон он, бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигчийн нэрийг бичнэ, хэзээн зохицуулжээ.

Нэр томъёоны тухайд авч үзэхэд зохиогч миний бие "Зохиогчийн эрхийн тэмдэглэгээ" гэсэн үгийг сонгон хэрэглэж байгаагийн учир нь энэ ойлголтод зөвхөн "©" гэсэн тэмдгийг дангаар нь хэзээ ч хэрэглэдэггүй бөгөөд эрх эзэмшигчийн нэр, бүтээлийг анх хэвлэсэн он зэргийг тусгаж байж хүчин төгөлдөр байх шаардлага тавигддаг тул "таних тэмдэг" гэдэг үгийг хэрэглэхээс татгалзлаа. Хуулийн энэ зохицуулалт болон "Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн конвенц"-оос үзэхэд энэхүү тэмдэглэгээг "заавал" хэрэглэх тухай асуудал байх боломжгүй юм. Нөгөөтэйгүүр энэ талаар манай улсад уншиж судлах ном зохиол, шүүхийн практик хараахан хангалттай биш байна. Харин АНУ-д зохиогчийн эрхийн тэмдэглэгээний талаар нэлээд

сонирхолтой зохицуулалт хийгдэж байсныг энд авч үзье.

АНУ-д 1989 оны 3 дугаар сарын 1-нээс өмнө энэ тэмдэглэгээг хэвлэн нийтэлсэн бүх бүтээлд заавал тавих шаардлага тавьж, зохиогчийн эрхийг хамгаалах нөхцөл болдог байсан байна. Харин энэ хугацаанаас хойш хэвлүүлсэн бүтээлд энэ тэмдэглэгээг заавал тавихыг шаардлага болгохоо больсон байна. Гэлээ ч та өөрийн хэвлэн нийтлүүлж буй бүх бүтээл дээрээ энэхүү тэмдэглэгээг тавих нь зүйтэй билээ. Энэ тэмдэглэгээг ашиглах нь зохиогчийн өөрийн хариуцлага бөгөөд урьдчилан ямарваа нэгэн тусгайлсан байгууллага эсвэл зохиогчийн эрхийн газраас зөвшөөрөл авах буюу бүртгүүлэх шаардлагагүй ажээ. Энэ бүлэгт үзэх асуудал нь зарим нэг тодорхой байдал дээр хэрхэх вэ гэдэг тал дээр илүүтэй анхаарал хандуулах болно.

Хэвлэх үйлдвэрээр ном, бүтээлээ хэвлүүлэх. Энэ нөхцөлд зохиогч нь зохиогчийн эрхийн тэмдэглэгээг тавих талаар санаа зовох шаардлагагүй бөгөөд учир нь хэвлэх үйлдвэр зохиогчийн хэвлэн нийтлүүлж буй бүх ном, бүтээл дээр энэхүү тэмдэглэгээг тавьдаг байна. Харин зохиогч тэмдэглэгээнд орсон мэдээлэл үнэн зөв эсэхийг л шалгах шаардлагатай юм.

Чөлөөт хэвлэлд

нийтлэх. Аливаа сонин, сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх тохиолдолд сонин, сэтгүүлд нийтлүүлсэн бүх бүтээлд хамаарах тэмдэглэгээг хэвлэгч газар нь хариуцдаг. Гэлээ ч зарим зохиогч өөрийн бүтээлдээ зориулан тусгайлан зохиогчийн эрхийн тэмдэглэгээг сэтгүүлд дээр тавьж болдог ажээ.

Зохиогч бүтээлээ өөрөө хэвлэх. Энэ тохиолдолд бүтээлээ хэвлэж буй аливаа этгээд өөрөө зохиогчийн эрхийн тэмдэг-лэгээг өөрсдөө оруулах хариуцлагыг хүлээдэг байна.

Зохиогчийн эрхийн тэмдэглэгээ нь хэзээ хэвлэгдсэн бэ гэдэг цаг хугацаанаас шалтгаалан зарим бүтээлд заавал шаардлагатай байдаг байсан талаар АНУ-ын жишээг үргэлжлүүлэн авч үзье.

1. 1978 оноос өмнө АНУ-д хэвлэгдсэн бүх бүтээлд зохиогчийн эрхийн тэмдэглэгээг заавал тавих шаардлага тавьдаг байсан бөгөөд ингэснээр зохиогчийн эрхийн хамгаалалт үүсдэг байсан ажээ. Энэ тэмдэглэгээг тавиагүй бүтээл нь зохиогчийн эрхээ алдаж, олон нийт тухайн бүтээлийг чөлөөтэй ашиглах боломжтой байсан байна. Өөрөөр хэлбэл, дурын хэн ч гэсэн зохиогчийн тэмдэглэгээ тавиагүй бүтээлийг хуулбарлах буюу зохиогчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах боломжтой бий болгодог байв. Жишээ нь, *Берни өөрийн шүлгийн цомгоо 1967 онд өөрөө хэвлүүлдгээ. Зохиогчийн эрхийн хуулийн талаар ямар ч мэдлэг байхгүйн улмаас Зохиогчийн эрхийн тэмдэглэгээ өөрийн бүтээлдээ огт тавиагүй байна. Тээтэл Ширли энэхүү цомгийн нэг хувийг хуучин номын дэлгэцрээс 1988 онд олж, зарим шүлгүүдийг орчин үеийн Америкийн цуврал*

хэвлэлд оруулахаар шийджээ. Энэхүү номонд Зохиогчийн эрхийн тэмдэглэгээ байхгүй байсан учир олон нийтэд чөлөөтэй ашиглаж болох юм байна гэсэн үзэл бодлоор Бернигээ ямарваа зөвшөөрөл авалгүйгээр түүний бүтээлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хэвлэх бүрэн эрх Ширлид байна.

2. 1978 оны 1 дүгээр сарын 1-нээс 1989 оны 3 дугаар сарын 1-ний хооронд хэвлэсэн бүтээлийн хувьд дээрх жишээнээс үүдэн 1978 оноос өмнөх үед бүтээлээ хэвлүүлсэн зохиогчид зөвхөн техникийн бяцхан шаардлагыг үл тоомсорлосноос болж өөрсдийн зохиогчийн эрхээ алдах тохиолдол ихээхэн газар авсан байна. Энэхүү хохирлоос үүдэн АНУ 1976 онд **Зохиогчийн эрхийн хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулснаар 1978 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш хэвлэсэн бүтээл нь зохиогчийн эрхийн зохих тэмдэглэгээгүйгээр олон нийтэд түгээгдэхгүй бөгөөд бүтээлийг хэвлэсний дараахь 5 жилийн дотор Зохиогчийн эрхийн газарт бүртгүүлэн зохиогчийн эрхийн тэмдэглэгээ орхисон бүтээлд хүчин төгөлдөр тэмдэглэгээг оруулан залруулах боломжийг бий болгосон байна.**

Харин 1989 оны 3 дугаар сарын 1-нээс хойш хэвлэсэн бүтээлийн хувьд АНУ "Утга зохиол, урлагийн бүтээлийг хамгаалах тухай Бернийн Конвенц"-ын гишүүнээр элссэнээр хэвлэгдэх бүх бүтээлд зохиогчийн эрхийн тэмдэглэгээг тавих шаардлага төгсгөл болжээ. Тиймээс АНУ-д 1989 оны 3 дугаар сарын 1-нээс хойш энэхүү Зохиогчийн эрхийн тэмдэглэгээг хэвлүүлсэн бүтээлд заавал тавихаа больсон байна. Жишээ нь: *Жорж 1988*

онд бүтээлээ өөрөө хэвлүүлсэн байна. Энэхүү бүтээлээ зохиогчийн эрхээр хамгаалагдсаныг илтгэх зохиогчийн эрхийн тэмдэглэгээг хийж хэвлүүлсэн байна. Дараагийн хэвлэлээ 2000 онд хэвлүүлэх тохиолдолд энэхүү тэмдэглэгээг заавал оруулах шаардлага байхгүй байгаа боловч оруулаа гэхэд буруу байхгүй билээ.

Гадаадын иргэн, гадаадын оршин суугчийн бүтээлийг гадаад улсад зохиогчийн эрхийн тэмдэглэгээгүйгээр 1978 оны 1 дүгээр сарын 1-нээс 1989 оны 3 дугаар сарын 1-ний хооронд хэвлэсэн тохиолдолд нийтийн хүртээл болгоход хуулийн шаардлага бусад бүтээлийн адил байжээ. Гэлээ ч ГАТТ, олон улсын худалдааны бусад гэрээний гэрээний дагуу АНУ-ын зохиогчийн эрхийн хязгаартай зохицуулалтыг гадаадын иргэд болон оршин суугчдын бүтээлд 1996 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн үйлчлэл нь зогссон байна.

Манай Улсын тухайд зохиогчийн эрхийн тэмдэглэгээний асуудал төдийлөн нарийвчлагдан зохицуулагдаж байгаагүй хэдий ч зохиогчийн эрхийн хуульд анх тусгалаа олоходоо олон улсын жишигт нийцэхүйц хэмжээнд орсон байна.

Хэвлэгдмэл бүтээлд зохиогчийн эрхийн тэмдэглэгээг тавих учир нь

Түүхэн хөгжлийн явцад бий болж хөгжсөн зохиогчийн эрхийн тэмдэглэгээг хийх бусад шаардлага, хэрэгцээ байж болох уу гэдгийг сонирхон үзэх нь зүйтэй. Зохиогчийн эрхийн тэмдэглэгээг заавал оруулах шаардлага байхгүй боловч бүтээлээ хэвлэхдээ "хүчин төгөлдөр" зохиогчийн эрхийн тэмдэглэгээг оруулах нь зүйтэй билээ. Үүнд хэд хэдэн шалтгаан байдаг гэж үздэг. ¹

1. "Patent, Copyright and Trademark", NOLO., 4th edition, 2001., page.77.

Нэг. Зохиогчийн эрх зөрчигдсөн гэж үзээд маргаан цэцгэн зарга хийхэд зохиогчийн эрхийн тэмдэглэгээ нь эдийн засгийн хохирлоо гаргуулах чухал үндэслэл, нотолгоо болж өгдөг байна.

Зохиогч болон зохиогчийн эрх өмчлөгч нь өөрийнх зөвшөөрөлгүйгээр бүтээлийг хуулбарлах, олшруулах зэргээр зохиогчийн эрхийг нь зөрчсөн гэж үзвэл зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандаж зарга үүсгэх эрхтэй байдаг. Харамсалтай нь ийм төрлийн зарга хийх нь маш их үнэтэйд тооцогддог ажээ. *Жишээ нь, АНУ-д зохиогчийн эрхийн маргаанд өмгөөлөгч хөлслөхөд тус цагийн 150' доллараас доошгүй төлбөр нэхдэг байна.*

Тиймээс зохиогчийн эрхийг зөрчсөн маргаан нь хохирлоо тооцож, түүнийг эрх зөрчсөн этгээдээр нөхөн төлүүлж чадсан тохиолдолд л ашигтай байх нь ойлгомжтой. Ихээхэн хохирол учирсан гэдгээ шүүхэд нотлохдоо эрх зөрчигч этгээд нь санаатайгаар таны зохиогчийн эрхийг зөрчсөн гэдгийг батлах явдал юм. Өөрөөр хэлбэл, хуулиар хамгаалсан эрхийг зөрчиж байгаага мэдсээр байж тухайн үйлдлийг эрх зөрчигч шууд санаатайгаар хийсэн гэдгийг батлах хэрэгтэй гэсэн үг. Ингэснээр гэм буруугийн санаатай эсвэл болгоомжгүйн тухай асуудал яригдах бөгөөд мэдээж гэм буруугийн хэлбэрээс шалтгаалж эрх зөрчсөн этгээдэд ногдуулах хууль зүйн харууцлагын хүнд, хөнгөн байх эсэх нь шийдвэрлэгдэхэд нөлөө үзүүлэх юм.

Хэрэв бүтээлд хүчин төгөлдөр зохиогчийн эрхийн тэмдэглэгээ байхгүй байвал

эрхийг шууд санаатайгаар зөрчсөн гэдгийг батлах нь түвэгтэй байдаг ажээ. Үүний гол шалтгаан бол "гэм буруугүй" зөрчил гэсэн хамгаалалтыг бий болгох боломжтой оршино.

Хэрэв хэн нэгэн этгээд зохиогчийн эрхийн тэмдэглэгээ байхгүй бүтээлээс хуулбарласан тохиолдолд шүүхэд мэдүүлэг өгөхдөө өөрийгөө гэм буруугүй буюу энэхүү бүтээл зохиогчийн эрхээр хамгаалагдсан гэдгийг мэдээгүй гэж тайлбарлаж болох юм. Хэрэв шүүх энэ нотолгоог хүлээн авах тохиолдолд зохиогчийн эрх зөрчсөн тэр этгээдийг гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр зөрчил гаргасан гэж үзэхгүй байж болох бөгөөд тэр этгээдэд тодорхой хэмжээний торгууль (түүнчлэн хохирлын мөнгөн нөхөн олговор) ногдуулах боловч торгуулийн хэмжээ нь шууд санаатайгаар зөрчсөн гэсэн тохиолдолтой харьцуулахад нэлээдгүй хэмжээгээр бага байдаг байна². Нөгөөтэйгүүр хүчин төгөлдөр зохиогчийн эрхийн тэмдэглэгээ байсан тохиолдолд зохиогчийн эрхийг зөрчигч нь өөрийгөө гэм буруугүй буюу энэхүү үйлдлийг гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр хийгээгүй гэдгээ шүүх хуралд нотлох хэцүү бөгөөд энэ нь яах аргагүй санаатайгаар үйлдэгдсэн гэж үзэхээс өөр аргагүйд хүргэдэг ажээ.

Жишээ нь, Мэри өөрийн бүтээлээ ном болгон хэвлүүлэхдээ зохиогчийн эрхийн тэмдэглэгээ тавиагүй байна. Гэтэл Изи тэр номноос ихээхэн хэсгийг хуулбарлан ашигласан ажээ. Мэри Изи зохиогчийн эрх зөрчсөн хэргээр

шүүхэд гаргаж 25000 долларын хохирол учруулсан гэдгийг баталжээ. Тэгтэл Изи Мэригийн номноос хуулбар ласан гэдгээ хүлээн зөвшөөрсөн хэдий ч зохиогчийн эрхийн тэмдэглэгээ байхгүйн улмаас хууль зөрчиж байгаага мэдээгүй гэж тайлбарласан байна. Шүүх энэхүү Изигийн тайлбарыг хүлээн авч Мэрид хохирлыг 5000 доллараар барагдуулах шийдвэр гаргасан нь Мэригийн нэхэмжилсэн 25000 доллараас хавьгүй бага ажээ.³

Хэрэв Мэри өөрийн номондоо зохиогчийн эрхийн тэмдэглэгээ тавьсан бол Мэри Изи Зохиогчийн эрхийг зөрчсөн хэргээр шүүхэд мэдүүлсэн тохиолдолд Изи санамсаргүйгээр зохиогчийн эрхийг зөрчсөн гэсэн тайлбар тавих боломжгүй болох билээ. Иймээс Мэри нэхэмжилсэн 25000 долларын хохирлоо бүрэн барагдуулуулах боломжтой байжээ.

Хоёр. Зохиогчийн эрхийн тэмдэглэгээ нь эрхийг зөрчих тохиолдлоос — урьдчилан сэргийлэх боломжтой гэж үздэг.

Өөр нэгэн чухал шалтгаан бол зохиогчийн эрхийн тэмдэглэгээг хэвлэгдмэл бүтээлд оруулснаар зохиогчийн эрхийг зөрчих аливаа тохиолдлоос сэрэмжлүүлэх бололцоотой билээ. Зохиогчийн эрхийн энэхүү тэмдэглэгээ нь уншигчдад тухайн бүтээл зохиогчийн эрхээр хамгаалагдсан талаар мэдээлж, зохиогчоос зөвшөөрөл авахгүйгээр хуулбарлаж болохгүй гэдгийг анхааруулж байгаа хэрэг билээ. Түүнчлэн зохиогчийн эрхийн тэмдэглэгээ нь хэвлэгдсэн ном зохиолд ихэнхдээ тавигдсан байдаг учир

1. "The copyright handbook", NOLO., 5th edition, 2000., page.3/3

2. "The copyright handbook", NOLO., 5th edition, 2000., page.3/5

3. "The copyright handbook", NOLO., 5th edition, 2000., page.3/7

энэ тэмдэглэгээ байхгүй тохиолдолд уншигч нь зохиогчийн эрхээр хамгаалагдаагүй гэж ойлгон чөлөөтөйгөөр хуулбарлах бололцоотой гэж ойлгож болохоор байдаг байна.

Гурав. Зохиогчийн эрхийн тэмдэглэгээ нь Бернийн Конвенцод нэгдэж ороогүй улсад зохиогчийн эрхийг хамгаалах боломжтой.

Энэ конвенцод нэгдэж ороогүй арваад улс байдаг бөгөөд зохиогчийн эрхийн тэмдэглэгээг бүтээлдээ оруулснаар эдгээр улс оронд бүтээлийн зохиогчийн эрхийг хамгаалах нэг хэрэгсэл байх болно.

Зохиогчийн эрхийн тэмдэглэгээний хэлбэрүүд

Зохиогчийн эрхийн тэмдэглэгээг зохиогч өөрийн бүтээлдээ анх хэвлүүлэхдээ оруулах бөгөөд дараа дараагийн дахин хэвлэлтдээ оруулах хэрэгтэй юм. Бүтээлийг олон нийтэд гаргахдаа зохиогч өөрөө эсвэл зохиогчийн эрх өмчлөгч хэн нэгэн (тухайлбал, зохиогчид захиалга өгсөн хэвлэлийн газар) зохиогчийн эрхийн тэмдэглэгээг оруулах хэрэгтэй. Гэхдээ зохиогчийн эрхийн тэмдэглэгээг бүтээлийг нийтийн хүртээл болгон хэвлэх тохиолдолд л оруулах шаардлагатай ажээ. Хэрэв зохиогч нь өөрийн бүтээлдээ тодорхой тооны хүмүүсээс санал авахаар тарааж байгаа тохиолдолд олон нийтэд түгээсэн гэж тооцдоггүй ажээ.

Харин зохиогчийн эрхийн тэмдэглэгээг нийтийн хүртээл

болгох зорилгоор хэвлээгүй бүтээлд оруулах шаардлага ер байдаггүй байна. Гэлээ ч тодорхой тохиолдолд хэвлэгдээгүй бүтээлд зохиогчийн эрхийн тэмдэглэгээг оруулах хэрэгтэй байж болдог байна.

Зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд ямар зүйл орж байх талаар хатуу шаардлага тавигдсан байдаг. Эдгээр зүйлийг чанд мөрдсөнөөр зохиогч нь энэ тэмдэглэгээг хэрэглэсэн зорилгодоо хүрэх болно. Үүнд гурван элемент багтсан байна:

□ Зохиогчийн эрхийн таних тэмдэг;

□ Бүтээлийг хэвлүүлсэн он;

□ Зохиогчийн эрх эзэмшигчийн нэр;

Эдгээр элементийг ямар нэгэн тодорхой дарааллаар бичдэг гэсэн шаардлага байдаггүй боловч дээрх дарааллын дагуу ихэнх тэмдэглэгээг бичдэг. Эдгээр элемент тус бүрийг тодорхой авч үзье.

Зохиогчийн эрхийн таних тэмдэг

“©” буюу “с” үсгийг цагиргаар тойруулсан тэмдэг нь зохиогчийн эрхийн таних тэмдэг билээ. АНУ-д “зохиогчийн эрх” гэсэн бичиглэл хүлээн зөвшөөрөгдсөн боловч ихэнх оронд энэ нь түгээмэл бус билээ.

Хэвлүүлсэн он

Зохиогчийн эрхийн тэмдэглэгээг хэрэглэх тохиолдолд бүтээлийг хэвлүүлсэн оныг заавал харуулсан байхыг шаарддаг байна. Анх гарч буй бүтээлд үүнийг оруулахад хялбар байдаг. Харин дараа дараагийн хэвлэлд бүтээлийг хэвлүүлсэн жинхэнэ оныг тавих

хэрэгтэй байдаг. Энэ нь хугацааны зохицуулалтад мэдээлэл өгөх ач холбогдлыг агуулж болно.

Шинэ хувилбараар бүтээлээ дахин хэвлүүлэхэд зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд шинээр хэвлэж буй бүтээлийн огноог заавал оруулах хэрэгтэй. Тэмдэглэгээнд урьдах хэвлэлийн оныг заавал тавих шаардлагагүй боловч ихэнх тохиолдолд бүтээл хэвлэгдсэн он бүрийг тавьсан байдаг. Ингэснээр өмнө нь тухайн бүтээл хэвлэгдэж гарч байсан гэдгийг уншигчдад мэдээлэх нэг хэлбэр болж өгдөг.

Жишээ нь: С.Санчир ерөнхий боловсролын сургуулийн 5 дугаар ангийн сурагчдад зориулсан монгол хэлний сурах бичгээ анх 1995 онд нийтлүүлсэн байна. Зохиогчийн эрхийн тэмдэглэгээ нь “Зохиогчийн эрх © 1995, С.Санчир” гэж байна. 2000 онд тэрхүү сурах бичгийг дахин хянаж, хэвлүүлсэн байна. Тиймээс зохиогчийн эрхийн тэмдэглэгээ нь “Зохиогчийн эрх © 2000, С.Санчир” гэж шинээр хэвлэгдсэн гэж тодорхойлохдоо боловч Санчир өөрөө энэ удаагийн хэвлэлтэд цлэмж их өөрчлөлт хийсэн, шинэ хэвлэл гэж тодорхойлохдоо эргэлзээтэй байгаа учир “Зохиогчийн эрх © 1995, 2000 С.Санчир” гэж бичихээр шийдсэн байна.

Оны бичиглэлийг хийхдээ араб тоогоор бичнэ, тухайлбал “2000”. Гэхдээ зарим тохиолдолд товчилсон оноор бичиж болдог, тухайлбал “00” гэж, мөн ром тоогоор хүртэл бичиж болох юм. Жишээлбэл 2000 он гэхийг “ММ” гэж тэмдэглэсэн байх юм. Тэр ч байтугай үсгээр илэрхийлж ч

болдог байна. Жишээ нь: "Хоёр мянган он"

Зохиогчийн эрхийн оны бичиглэлийн тухай зөвлөмж

Зохиогчийн эрхийг эзэмшигч нь хэвлэгдсэн оныг ром тоогоор бичих нь уншигчдыг сүүлийн үеийн хэвлэл мөн үү биш үү гэх зэргээр төөрөгдүүлж болох ажээ. Зарим улсад зөвхөн араб тоогоор бичих шаардлагатай байдаг учир үүнийг анхаарах хэрэгтэй. Манай улсад л гэхэд хэвлэгдсэн оныг уйгаржин монгол бичиглэлийн тоогоор илэрхийлбэл яах вэ? гэсэн асуулт ч гарч ирж болох юм.

Зохиогчийн эрх өмчлөгчийн нэр

Зохиогчийн эрх өмчлөгчийн нэрийг зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд заавал оруулсан байх шаардлагыг тавьдаг байна. Энд хэний нэрийг тавьж болох вэ?

□ Бүтээлийг зохиогч эсвэл хамтран зохиогчид;

□ Тэрээгээр бүтээл туурвиулан зохиогчийн эд хөрөнгийн буюу ондгой эрхийг хууль зүйн дагуу өмчилж буй этгээд;

□ Зохиогчийн эд хөрөнгийн буюу ондгой эрхийг шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд;

Бүтээлийг гэрээний үндсэн дээр эрхээ шилжүүлэхээр тохирсноос бусад нөхцөлд жинхэнэ зохиогч буюу хамтран зохиогчид л зохиогчийн бүх эрхийг эдэлнэ. Эдгээр эрхийг өмчлөгчийн нэр нь зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд орох юм. Жишээ нь, *С.Санчир* нь *цэцэрлэгжүүлэлтийн тухай ном 2000 онд хэвлэцүлсэн байна. Зохиогч номоо өөрөө буюу хэн нэгэн этгээдийн захиалга,*

гэрээний үндсэн дээр бичээгүй тул зохиогчийн бүх эрхийг өөрөө өмчилнө. Тиймээс тэмдэглэгээ нь "Зохиогчийн эрх ©2000, С.Санчир" гэсэн байна.

Хэрэв хэд хэдэн зохиогч байгаа бол тэдний нэрс бүгд зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд дурын дарааллаар орох боломжтой. Жишээ нь: *С.Санчир, А.Ангараг нар нь цөмийн физикийн чиглэлээр ном бичиж хэвлэцүсэн бөгөөд зохиогчийн эрхийн тэмдэглэгээ нь "Зохиогчийн эрх ©2000, С.Санчир, А.Ангараг" гэх мэт.*

Бүтээлийг гэрээний үндсэн дээр эсвэл албан үүргээ гүйцэтгэх үндсэн үүргийнхээ хүрээнд туурвисан бол зохиогчийн эд хөрөнгийн буюу ондгой эрхийг ажил олгогч буюу гэрээг ажлыг захиалагч нь эдэлнэ¹. Иймээс зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд захиалагч буюу ажил олгогч этгээдийн нэр орох юм. Харин жинхэнэ зохиогчийн нэр **ЭНХ**үү тэмдэглэгээнд орохгүй хэдий ч түүний эд хөрөнгийн бус аминь эрх энд хязгаарлагдахгүй. Жишээ нь, *С.Санчир "LLM" ХХ компанид ажилладаг ба тэрээр технологийн зааварчилгааны гарын авлага гаргах цэрэг хүлээдэг бөгөөд энэ нь хөдөлмөрийн гэрээнийх нь үндсэн цэрэгт хамаарч байдаг. Тэрээр энэ цэргийнхээ дагуу гарын авлага гаргахад ажил олгогч байгууллагын нэр л зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд орох юм. Тиймээс тэмдэглэгээ нь "Зохиогчийн эрх © 2000, "LLM" ХХК гэсэн байна.*

Зохиогч эсвэл зохиогчийн эрх өмчлөгч нь зохиогчийн эрхээ өөр бусад этгээд болох хувь хүн, байгууллагад шилжүүлсэн тохиолдолд эрхийг шилжүүлэн авсан шинэ

эзэмшигчийн нэр энэ тэмдэглэгээнд орно. Гэсэн хэдий ч шилжүүлэн авахаас өмнөх үед хэвлэгдсэн бүтээлийг шинэчлэгдсэн нэрээр бус хуучин нэрээр борлуулж болно. Жишээ нь: *Санчир нь цэцэрлэгжүүлэлтийн тухай ном 2000 онд хэвлэцүлсэн байна. Зөвхөн түүний нэр л зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд орно. Тэр энэ номоо 1000 хувийг хэвлэцүлээд 2001 оны 1 дүгээр сард уг номоосоо 500 хувийг борлуулсан байв. Тэрээр 2001 оны 2 дугаар сард номын дэлцүрийн эзэн болох Ангарагт энэхүү номын зохиогчийн эрхээ шилжүлжээ. Тиймээс зохиогчийн эрхийг Ангараг эзэмших бөгөөд үлдсэн 500 ширхэг номыг зарахдаа анх тавигдсэн зохиогчийн эрхийн тэмдэглэгээг өөрчлөхгүйгээр борлуулах ба хэрэв Ангараг номыг шинээр хэвлэн борлуулах нөхцөлд зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд зөвхөн Ангараг нэрээ бичих эрхтэй болох юм.*

Зохиогчийн эрхийг шилжүүлж авдаг түгээмэл практик бол зохиогчоос хэвлэлийн газарт эрхээ шилжүүлэх явдал юм. Зохиогч нь өөрийн зохиогчийн эрхийг бүрнээр буюу хэсэгчлэн хэвлэлийн газарт шилжүүлж болох бөгөөд энэ нь хэлцлийн үндсэн дээр шийдвэрлэгдэнэ.

Борлуулалт, хэвлэлтийн хязгаарлагдмал эрхтэй гэрээ хийсэн тохиолдолд хэвлэлийн газар нь хэвлэлийн эрхийг эзэмшиж болохоос зохиогчийн эрхийг бүхэлд нь эдлэхгүй байна. Тиймээс зохиогчийн нэр нь зохиогчийн эрхийн тэмдэглэгээтэй хэвлэл бүрт орсон байна. Үүнд хэвлэлийн газрын нэр зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд ордоггүй бөгөөд учир нь зохиогч зохиогчийн

6. "Право интеллектуальной собственности", Издательство "ПРИОР", 2001., стр.18

эрхийнхээ зарим хэсгийг авч үлдсэн байдаг оршино. Бас нэг хандлага бол сурах бичгийн зохиогч нарт түгээмэл тохиолддог явдал билээ. Энэ нь зохиогч зохиогчийн эрхээ бүхэлд нь хэвлэлийн газарт шилжүүлдэг бөгөөд энэ тохиолдолд зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд зөвхөн хэвлэлийн газрын нэр орно.

Зохиогчийн эрхийг хэсэгчлэн хэд хэдэн этгээдэд шилжүүлсэн үед зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд хэний нэрээр орсон байх вэ? Энэ нь зохиогчийн эрхийг эзэмшигч нь зөвхөн өөрт нь байгаа эрхийг бүрнээр буюу хэсэгчлэн бусдад шилжүүлж болох эрхтэй холбоотой. Тухайлбал, зохиогчийн эрхийг эзэмшигч нь эрхийнхээ тодорхой хэсгийг өөртөө үлдээж бусдыг хэн нэгэнд шилжүүлж болно. Мөн тодорхой нэг эрхийг нэг хүнд шилжүүлэн бусдыг бас өөр хувь хүн буюу байгууллагад шилжүүлж болдог. Энэ тохиолдолд зохиогчийн эрхийг чухам хэн нь эзэмшиж байгааг зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд тодорхойлоход түвэгтэй байдаг.

Гэхдээ энэ тохиолдолд баримтлах ерөнхий зарчим нь бүтээлийг гэрээгээр эсвэл албан үүргээ гүйцэтгэх үндсэн үүргийнхээ хүрээнд хийснээс бусад тохиолдолд зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд зохиогчийн нэр л ордог байна¹. Жишээ нь, Луси тууж бичсэн байна. Тэрээр "Шульц" хэвлэлийн компанид уг номыг хатуу хавтастайгаар Хойд Америкийн улсуудад хэвлэн нийтэлж байх эрхийг худалдсан байна. Харин зөвхөн хавтастайгаар хэвлэх эрхийг "Пекуд Пресс"-д худалдсан байна. Эцэст нь Хойд Америкаас бусад

улсад уг номыг хэвлэх эрхийг "Линус Пабликейшн"-д худалдсан байна. Тиймээс Лусигийн нэр л дангаараа зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд орохоор байна. Харин "Шульц" хэвлэлийн компанид бүх эрхийг худалдсан тохиолдолд энэхүү компанийн нэр л зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд орсон байх учиртай гэжээ.²

Ерөнхий зарчмаас тусгаарлан авч үзэх нөхцөл бол өмнө байсан бүтээл дээр тулгуурлан бүтээсэн үүсмэл бүтээл болон эмхтгэлийн хувьд өөрөөр байж болох талаар дараагийн хэсэгт үзэх болно.

Нэрийг бичих хэлбэрийг хүртэл судалж үзсэн байна³. Ихэвчлэн зохиогчийн эрх өмчлөгчийн хууль ёсны нэрийг бүтнээр нь хэрэглэдэг ажээ. Гэсэн хэдий ч өмчлөгчийн товчилсон нэрийг буюу зөвхөн овгийг, худалдааны тэмдгийг, өөрчилж товчилсон буюу "хоч" нэрийг (nickname), хуурамч нэр түүнчлэн өөр ямар нэгэн нэрээр олонд танил болсон бол тэр нэрээрээ буюу үсгээр зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд оруулж болно. Тухайлбал, зохиогч Дэвид Корнвелл нь "John le Carre" нэрээр олонд танил болж энэ нэрийг ашигладаг бол энэ нэрийг зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд оруулна. Тэгвэл манай улсад "Баабар" гэдэг нэрийг зохиогч Б.Батбаяр хэрэглэвэл уншигчдад илүү тодорхой ойлгогдох байж болох бөгөөд ингэж хэрэглэсэн тохиолдол ч байдаг. Мөн International Business Machine Corporations нь IBM гэсэн товчлолыг хэрэглэж болно. Харин зохиогч нь өөрийн бүтэн нэрээр л алдаршсан бол тэр

нэрийг л зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд оруулах ёстой.

Хэрэв "Нууц ноёнтон" байхыг хүсвэл хэрхэх вэ? Энэ тохиолдолд "anonymous" буюу "нэр нь үл мэдэгдэх" гэсэн бичиглэл зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд орох ёсгүй. Учир нь энэ нэрээр зохиогч олон нийтэд алдаршаагүй нь лав. Тиймээс өөр нэгэн үл таних нэрээр ч зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд оруулах нь зохимжгүй. Харин өөрийн нэрийг нуух сонирхолтой байгаа бөгөөд зохиогчийн эрхийн хүчин төгөлдөр тэмдэглэгээтэй байхыг хүсвэл өөрийнхөө зохиогчийн эрхийг хэвлэлийн газартаа шилжүүлж болно. Түүнчлэн үүнтэй төстэй нэг арга нь ямар нэгэн байгууллагад эрхээ шилжүүлж тэр байгууллагын нэрийг зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд оруулж болно.

Хэрэв зохиогчийн эрхийг эзэмшигч нь байгууллага буюу хуулийн этгээд байгаа бол байгууллагын тодотгол болсон Inc буюу ХХК гэсэн үгсийг оруулах шаардлагагүй. Хэдийгээр албан ёсны нэрэнд энэхүү тодотгол үгс заавал ордог боловч зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд заавал оруулах шаардлага байхгүй юм.

Эмхтгэл ба түүврийг өмнө нь байсан бүтээлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн ашиглаж гаргадаг. Тиймээс зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд энэхүү ашигласан бүтээлийн зохиогчдын нэрийг оруулах шаардлагагүй байна. Эмхтгэл нь хамтын бүтээл байж болох бөгөөд энэ нь тус тусын бүтээлүүдийг нэгтгэн нэг болгохыг хэлнэ. Жишээ нь: *толь бичиг, судалгааны түүвэр болон сэтгүүл, эмхтгэл мэтийн цуврал*

1. The copyright handbook", NOLO., 5th edition, 2000., page.,3/7

2. The copyright handbook", NOLO., 5th edition, 2000., page.,3/7

3. The copyright handbook", NOLO., 5th edition, 2000., page.,3/8

хэвлэл. Түүнчлэн эмхтгэл нь өмнөх материалыг (ихэвчлэн төрөл бүрийн мэдээлэл) ашиглан сонгон зохион байгуулалтад оруулсны үндсэн дээр шинэ бүтээл бий болгохыг хэлнэ. Жишээ нь, каталог.

Зохиогчийн эрхийн хугацаа нь дууссан эсвэл нийтийн эзэмшилд байгаа бүтээлийг эмхтгэж байгаа л биш бол эмхтгэгч нь эмхтгэлд орох бүтээл, материалын өмчлөгч байх эсвэл жинхэнэ өмчлөгчөөс зөвшөөрөл авсан байхыг шаардлага болгоно. Жишээ нь, Санчир нь Монголын шилдэг туужаар цуврал ном хийхээр 2000 онд бүтээлцдийг эмхтгэж хэвлэжээ. Энэхүү бүтээлд 12 туужаар орсон бөгөөд тэдгээрийн зохиогчид нь Санчирт цуврал болгон хэвлэж зөвшөөрөл олгосон боловч өөрсдийн зохиогчийн эрхээ хадгалсан хэвээр байна. Тиймээс энэхүү цомжийн зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд зөвхөн Санчирын нэр орох юм. "Copyright © 2000 С.Санчир" гэх. Харин бусад 12 зохиогчийн эрхийг Санчирын нэрээс гадна оруулах шаардлага байхгүй ажээ.

Хэдийгээр хувь хүн эмхтгэл хийсэн тохиолдолд зохиогчийн эрхийн тэмдэглэгээг заавал тавих шаардлагагүй ч энэ эмхтгэлд орсон бүтээлүүдийн зохиогчийн эрх нь хүчинтэй, хэн нэгний эзэмшилд байгаа тохиолдолд тэмдэглэгээг хийх хэрэгтэй байдаг. Ингэснээр зөвшөөрөлгүйгээр, дураар хуулбарлах тохиолдлоос урьдчилан сэргийлж, зохиогчийн эрх энэхүү эмхтгэлийг хийсэн хүнд бус өөр хүнд байгааг анхааруулах хэлбэр билээ. Зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд зөвхөн эмхтгэлийг хэвлэсэн оныг л оруулахад хангалттай билээ. Харин эмхтгэлд орсон бүтээл, материалын хэвлэгдсэн оныг оруулах шаардлагагүй байна. Жишээ нь, Санчир өөрийн богино өгцлэлдэгчдийн цомжийг 2000 онд өөрөө эмхтгэж,

хэвлүүлсэн байна. Эдгээр өгцлэлэг нь 1990-2000 онд уран зохиолын олон сэтгэлд тус тус хэвлэгдсэн хэдий ч зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд цомог хэвлэсэн 2000 оныг л оруулна.

Урьд туурвисан бүтээлийг ашиглан түүний үндсэн дээр бий болгосон хялбаршуулсан бичвэр, орчуулга, хөгжмийн болон урлагийн бусад бүтээлийн зохиомж, найруулга зэрэг бүтээлийг үүсмэл бүтээл гэдэг. Үүсмэл бүтээл туурвигч нь эх бүтээлийн зохиогч болон зохиогчийн эрх өмчлөгчөөс заавал зөвшөөрөл авах шаардлагатай байдаг.

Эмхтгэлтэй нэгэн адил үүсмэл бүтээлийн зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд энэхүү үүсмэл бүтээлийг бий болгосон зохиогч буюу зохиогчийн эрх өмчлөгчийн нэр л орсон байх бөгөөд эх бүтээлийн зохиогчийн нэр тэмдэглэгээнд орохгүй. Жишээ нь, Санчир Ансарагийн бүтээлийг ашиглан кино зохиод бичихдээ түүний бүтээлийн зохиогчийн эрх эзэмшигчээс зөвшөөрөл авсан байна. Тиймээс кино зохиолын зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд зөвхөн Санчирын нэр л орох юм. Хэвлэлийн огнооны хувьд эмхтгэлтэй нэгэн адил байна.

Эмхтгэсэн болон үүсмэл бүтээлд зохиогчийн эрхийн дан тэмдэглэгээ байхад хангалттай гэсэн дүрэм нь АНУ-ын Засгийн газрын материалаас бүрдсэн бүтээлд хамаарахгүй болно. АНУ-ын Засгийн газрын хэвлэл нь олон нийтэд зориулсан байдаг ба зохиогчийн эрхээр хамгаалагдаагүй ба Засгийн газраас зөвшөөрөл авахгүйгээр хэн ч ашиглан хэрэглэж болно. Тиймээс зохиогч өөрөө АНУ-ын Засгийн газраас хэвлэн нийтэлсэн баримтыг давамгайлан ашиглах эсэхийг шийдэх зүйл билээ. Мэдээж, бүтээлийн тэн хагасаас илүү хэсгийг Засгийн газрын материал ашиглан туурвисан тохиолдолд ушингчдад аль хэсэг нь Засгийн

газраас гаргасан хэсгийг оруулсан гэдгийг харуулах нь зүйтэй. Жишээ нь: "Датабест Инкорпоратед" АНУ-ын хүн амын тооллогын статистикийн мэдээллийг шинжилсэн ном хэвлүүлсэн байна. Үүнд, АНУ-ын Тооллогын төвчөөны материалаас ашиглан хавсралт болгон оруулжээ. Энэ ном нь тус тусдаа бодовсруулсан олон хүмүүсийн хамтарсан бүтээл болж, харин хавсралтууд нь номны тэн хагасыг эзэлсэн байна. Үүнд зохиогчийн эрхийн тэмдэглэгээ нь дараах байдалтай байна. "Copyright © 2000 by Databest Incorporated. No protection is claimed in works of the United States government as set forth in Appendixes 1, 2, 4, 6. (Хавсралт 1, 2, 4, 6 нь АНУ-ын Засгийн газрын мэдээлэл бөгөөд зохиогчийн эрхээр хамгаалагддаггүй болно)" гэж зааж өгнө. Үүнтэй адебббббил номын аль хэсэг нь АНУ-ын Засгийн газрын мэдээлэл биш буюу зохиогчийн эрхээр хамгаалагдах хэсэг гэдгийг зааж өгнө. Жишээ нь, 1-10 дугаар бүлэгт ийнхүү Засгийн газрын материалыг ашиглаагүй тохиолдолд "Copyright © 2000 by Databest Incorporated. Copyright claimed in Chapters 1 through 10 (1-ээс 10 дугаар бүлэг хүртэл зохиогчийн эрхийг хамгаалсан)." гэсэн тэмдэглэгээг оруулдаг байна¹.

Мөн номын гаднах хавтсанд зохиогчийн эрхийн тэмдэглэгээг тусгайлан тавьж болдог байна. Тухайн номын зохиогчийн эрхийн тэмдэглэгээ нь уг номны гаднах хавтасны зохиогчийн эрхийг хамгаална гэсэн үг биш. Номны гаднах хавтас нь уг номтой хамт бүтээгдээгүй учир энэхүү хавтаст нийтэлсэн материалыг зөвшөөрөлгүйгээр хэвлүүлэхийг хүсэхгүй байгаа тохиолдолд зохиогч нь хавтсанд зориулсан зохиогчийн эрхийн тэмдэглэгээг тусгайлан оруулах шаардлагатай ажээ. Тэмдэглэгээг хавтасны хаана ч байрлуулж болох бөгөөд ихэнх тохиолдолд хавтасны ар талын нүүр буюу ар

1. "Patent, Copyright and Trademark", NOLO., 4th edition, 2000., page., 207

талыг дотоги нугалсан хэсэгт байрлуулдаг байна¹

Түүнчлэн мультимедиа бүтээл буюу электрон ном нь текст, дүрс бичлэг (хөдөлгөөнт болон хөдөлгөөнгүй дүрс, бичлэг), авиа (хөгжим, ердийн яриа, урлагийн тоглолт) зэргээс бүрдэнэ. Зарим электрон бүтээл нь хэвлэмэл текст болон CD-ROM диск буюу компьютерийн диск зэргээс бүрддэг бөгөөд мөн соронзон халстай байж болдог байна. Мөн зөвхөн CD-ROM буюу соронзон халс ч бас байж болох билээ. Хэрэв бүтээл нь ном ба дискээс бүрдсэн бол аль аль нь өөрийн зохиогчийн эрхийн тэмдэглэгээтэй байна. Компьютерийн диск дээр өөрт нь зохиогчийн эрхийн тэмдэглэгээ наалттай байдаг ч тохиолдол бий. Түүнчлэн дискийг компьютер дээр идэвхжүүлэх явцад дэлгэц дээр зохиогчийн эрхийн тэмдэглэгээг харуулах нь түгээмэл байхын зэрэгцээ программыг ажиллуулахад "Тухай" гэдэг команд гарах тохиолдолд зохиогчийн эрхийн тэмдэглэгээг оруулж болдог. Бас нэг хэлбэр бол дискийг ашиглах явцад дэлгэц дээр зохиогчийн эрхийн тэмдэглэгээ тогтмол гардаг байж болно².

Зохиогчийн эрхийн тэмдэглэгээг хаана байршуулах вэ? гэсэн асуулгачир ирж болох юм. Бүтээлийн бодит хэлбэрээс шалтгаалан зохиогчийн эрхийн тэмдэглэгээг хаана байршуулахыг тогтоож болно. Энд баримтлах хамгийн гол зарчим бол хүнд харагдахуйц (томруулдаг шил ашиглан унших хэмжээний байж болохгүй) ба тодорхой байх шаардлагатай. Зохиогчийн эрхийн тэмдэглэгээг уншигч харахад эрхийг хамгаалсан ба зохиогчийн эрхийг өмчлөгч хэн бэ гэдгийг мэдэгдэх нь хамгаас чухал гэдгийг санах хэрэгтэй ажээ.

Зохиогчийн эрхийн тэмдэглэгээний хамт нэмэлт мэдээллийг оруулж болох бөгөөд

түүнийг тухайн хуудас дээр байрлуулна. "All Rights Reserved" буюу "Бүх эрхийг хамгаалсан" гэсэн үгсийг зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд заавал оруулснаар Боливи, Гондурас зэрэг улсад эрхээ хамгаалуулах боломжтой байсан байна. Харин одоо энэ зохицуулалт өөрчлөгдсөн тул зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд эдгээр үгсийг заавал оруулах шаардлагагүй боловч ихэнх хүмүүс дассан зангаар буюу илүү сүр, хүч оруулах утгаар оруулдаг хэвээрээ байна.

Зохиогчийн эрх гэдэг нь ямар ойлголт байдгийг ихэнх хүмүүс сайн мэддэггүй учир зохиогч болох хэвлэх газрынхан зохиогчийн эрхийн тэмдэглэгээний хамт зарим анхааруулсан буюу тайбарласан мэдэгдэл оруулдаг ажээ. Ингэснээр уншигчдыг зөвшөөрөлгүй хуулбарлан ашиглахаас тодорхой хэмжээгээр сэргийлж, зохиогчийн эрхийг зохих хэмжээнд хамгаалах зорилгыг агуулдаг. Гэхдээ ингэж нэмэлт анхааруулга оруулсан хэдий ч энэ бүлгийн эхний хэсэгт үзсэнээр зохиогчийн эрхийн тэмдэглэгээнд байх ёстой хүчин төгөлдөр мэдээллийг эс оруулбал эрхийг хамгаалах үндэс байж чадахгүй гэж үздэг байна. Энэхүү бүтээлийн зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан бөгөөд зохиогч болон зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хувилах, хэсэгчлэн нийтлэх, дахин хэвлэх, электрон системд оруулахыг хориглоно гэх эсвэл энэхүү бүтээлийн зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан бөгөөд хувилах, хэсэгчлэн нийтлэх, дахин хэвлэх, электрон системд оруулах бүх тохиолдолд зохиогч болон зохиогчийн эрх эзэмшигчээс зөвшөөрөл авна гэж бичих нь түгээмэл байдаг. Зарим номонд "Зөвшөөрлийг дараах хаягаар авна уу. Хэвлэлийн газрын хаяг, нэр" гэсэн нэмэлт ч байдаг байна. Бас бүр их энгийн бичиглэл ч байж болно. Тухайлбал, 1993 оны Зохиогчийн эрхийн хуулийн дагуу энэ номыг бүхэлд нь буюу

хэсэгчлэн хуулбарлан авахыг хориглоно гэх мэт.

Книо, жүжгийн зохиолыг хэвлэсэн гаргасан тохиолдолд дараах анхааруулах мэдэгдэл байж болох жишээг харуулъя: *Сэрэмжлүүлэг: Энэхүү бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд зөвшөөрөл авч ашиглаж болно гэдгийг мэргэжлийн болон шинэ уран бүтээлч, жүжигчдэд анхааруулж байна. Энэ бүтээлийг тоглолтоор тайлалд тавих, хөдөлгөөнт дүрс, радио, телевиз, олон нийтийн уншлагад зориулан механик буюу электрон хэлбэр болон бусад хэлбэрээр зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлаж цл болно. Энэхүү бүтээлийн лиценз буюу найруулах зөвшөөрөл авах бол дараах хаягаар хандана уу" гэх жишээтэй байдаг байна.*

Иш татах зорилгоор зарим хэсгийг ашиглах зөвшөөрөл олгох нэмэлт бичиглэлийг хийж болдог³. Хэрэв бүтээлийн зарим хэсгийг хуулбарлан хэвлэхэд зохиогч нь татгалзах зүйлгүй бол зөвшөөрлийг албан ёсоор, тогтмол олгох хүнд суртлын оронд зохиогчийн эрхийн тэмдэглэгээний дараа тодорхой хэсэгт зөвшөөрөл олгож байгаа талаар нэмэлт мэдээлэл бичиж болно. Ийнхүү зөвшөөрөл олгох мэдэгдэл нь зохиогчийн хүслээс хамааран урт, богино ямар ч байж болно. Жишээ нь, Энэхүү бүтээлийн ___ (тоо) хүртэлх үгийг хуулбарлан ашиглах зөвшөөрлийг үүгээр олгож буй бөгөөд иш татаж ашиглахдаа үгийн дараалал болон үгсийг өөрчлөхгүйгээр хэрэглэх ба зохих ишлэл, тэмдэглэгээг оруулсан байна.

Уншигч авхай та ч гэсэн өөрийн бүтээлдээ энэхүү тэмдэглэгээг хэрхэх билээ гэдгээ бодох лавтай.

— © —

1. Patent, Copyright and Trademark. NOLO., 4th edition, 2000., page., 209

2. Patent, Copyright and Trademark. NOLO., 4th edition, 2000., page., 211

3. Patent, Copyright and Trademark. NOLO., 4th edition, 2000., page., 214

Өөртөө туслах эрхийн мөн чанар, онцлог

/Иргэний хуулийн 12 дугаар зүйл/



ХЗҮТ-ийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч, доктор
Т.МЭНДСАЙХАН

Аливаа хүний өөрийгөө хөгжүүлэх, амьдрал ахуй, мэдлэг боловсролоо дээшлүүлэх үндсэн нөхцөл бол эрх чөлөөтэй байх буюу нийгмийн амьдралын бүхий л харилцаанд идэвхтэй оролцох, хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэн тодорхой үйлдэл хийх, бусад этгээдтэй харилцах, хуулиар олгогдсон өөрийн субъектив эрхээ зөв хэрэгжүүлэх явдал юм. Эрхээ хэрэгжүүлэхдээ сайн санааны болон шударга ёсны зарчмыг мөрдөж, өөрийн хувийн зүй зохист сонирхолд захирагдан бусад этгээдийн эрхийг хүндэтгэн үзэх ёстой. Хэдийгээр өөрөө эрхтэй байгаа боловч түүнийгээ бусад, нийгэмд зохисгүйгээр ашиглах, илт

шударга бус, ёс суртахуунгүй нөхцөл байдлыг бий болгох нь эрх зүйн үндсэн зарчимд нийцэхгүй. Нөгөө талаар иргэний эрх зүйн эрхээ хэрэгжүүлэхэд бусдын зүгээс саад болох эсвэл эрхийг нь зөрчих, эрхэд нь бүдүүлгээр халдах явдал элбэг тохиолдоно. Ийм үед эрхээ хамгаалах, халдагчийг эсэргүүцэх, түүний эрхэд халдах шаардлага зүй ёсоор үүснэ. Түүнчлэн өмчлөгч этгээд өмчлөлийн зүйлээ хадгалж хамгаалах үүргээ гүйцэтгэх зорилгоор өөртөө туслах, бусдын эсрэг хүч хэрэглэх боломжтой байхыг хүлээн зөвшөөрдөг ажээ.

Иргэний эрх зүйн хамгаалалтыг хэрэгжүүлэх дараах үндсэн хоёр арга бий:

1.Өөрөө өөртөө туслах замаар. Энэ нь өөрийн дур зоргоор, өөрийн хүчээр ямар нэгэн эрх, шаардлагаа хангах үйлдэл буюу эрхээ хэрэгжүүлэх, хамгаалах анхдагч арга юм. Ямарваа нэг эсэргүүцэлтэй тулгарахгүй үед өөрөө өөрийн хүсэл зоригийн дагуу эрхээ хэрэгжүүлэх ба харин эсэргүүцэл саад байгаа үед өөртөө туслах явдал үүснэ.

Аливаа этгээд түүний эрхийг зөрчигч этгээдтэй өөрийн хүчээр тэмцэх замаар эрхээ хамгаалах нь бодит байдлын зайлшгүй илрэл юм. Гэвч хүн хүч мөхөсдөх эсвэл хүчтэй, давуу байдлаа үндэслэлгүй хэтрүүлэх магадлаа ихтэй байдаг байна. Аажмаар энэ аргаар төрийн хүчээр хамгаалуулах аргад шилжсэн ба өөрөө өөрийн хүчээр эрхээ хэрэгжүүлэх нь зөвхөн онцгой тохиолдолд зөвшөөрөгдөх болжээ.

Хууль бус халдлага, аяуулын үед эсвэл гарцаагүй хамгаалалтын байдалд өөрийн хүчээр хамгаалалтын үйлдэл хийх нь зохимжтой гэж үздэг. Хэрэв эд хөрөнгийг булаан авахад чиглэсэн халдлага болсон бол зөвхөн хамгаалаад зогсохгүй өөрийн хүчээр эд хөрөнгөө буцаан булаан авахыг зөвшөөрөх тохиолдол бий. Өөртөө туслах нь зарим сөрөг талтай: нэгд, хүчтэй нь дур зоргоор аашлах боломжтой бөгөөд эсрэг хүчирхийлэл, тэмцэл бий болгох; хоёрт, хэн нь зөв буруу нь тогтоогдоогүй, маргаантай байдаг; гуравт, төрийн үүрэг ролийг үгүйсгэх. Судлаач Б.Цогням "Иргэний эрх зүйн хамгаалалт"

1."Монголын төр, эрх зүй" сэтгүүл, 2002 он, №3 4 дэх тал.

2.Римское частное право. Под ред. И.В.Новицкого и И.С.Перетерского.М., 1994 г, стр.52

өгүүлэлдээ¹ 1820-1913 оны шүүхээр хэрэг маргаан шийдвэрлэсэн талаархи "Улаан хацарт" хэмээх түүвэр тэмдэглэлээс энэ үед өөрөө өөртөө туслахыг зөвшөөрдөггүй байсан тухай нэгэн жишээ татсан байна. Эртний Ромд үүргийн харилцаанд өөртөө туслахыг хориглох зохицуулалт байсан байдаг² ажээ. Харин ХВНГУ-ын 1900 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Иргэний хуулийн 229 дүгээр зүйлд өөртөө туслах /Selbthilfe/ ойлголтыг тусгасан байна.

2.Төрийн байгууллагын тусламжаар. Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага /цагдаа, прокурор, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх болон захиргааны холбогдох байгууллага/-д мэдэгдэн тэдний тусламжтайгаар эрхээ хамгаалж хэрэгжүүлнэ. Энэ арга зарим тохиолдолд удаашралтай, улмаар цаг алдах, эрхээ сэргээлгэхэд хүндрэл гарах, эсвэл бүр боломжгүй болох сөрөг талыг агуулж байдаг. Өөрөөр хэлбэл, цаг хугацааны болон эзэн холбогдогч, эд хөрөнгийн хувьд эрх, шаардлагаа хангуулах бодит боломж багасах аюул бий. Манай улсын хувьд 1926-1994 оны иргэний хууль тогтоомжийн зохицуулалтыг үзэхэд энэ аргад илүү ач холбогдол өгч ирсэн байна. Харин 2002 оны Иргэний хуульд зарим тохиолдолд аливаа этгээд өөрийн хүчээр эрхээ хэрэгжүүлэх боломжийг нээлттэй болгож, өөртөө туслах

тухай ойлголтыг шинээр оруулсан юм.

Монгол Улсын Иргэний хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Эрх бүхий байгууллагын тусламжийг шуурхай авах боломжгүй байсан болон цаг алдалгүй арга хэмжээ авахгүй бол эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох буюу эрхээ хэрэгжүүлэхэд ноцтой хүндрэл учрахаар байвал иргэний эрх зүйн харилцаанд оролцогч өөрийнхөө эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, өөртөө туслах зорилгоор эд юмсыг эзэмдэж авах, устгах буюу эвдэх, эсвэл зайлсхийж болзошгүй үүрэг гүйцэтгэгчийг саатуулах, үүрэг бүхий этгээдээс гүйцэтгэвэл зохих үйлдлийн эсрэг үйлдлийг таслан зогсоохоор тухайн нөхцөл байдалд тохируулан хийсэн үйлдэл"-ийг өөртөө туслах хэмээн тодорхойлсон байна. Энэхүү заалтаас гадна Иргэний хуулийн өмчлөх эрхийн тухай 101 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: "Өмчлөгч нь ... аливаа халдлагаас хамгаалах эрхтэй", уг зүйлийн 2 дахь хэсэгт: "Өмчлөгч бусдад гэм хор учруулах замаар өмчлөх эрхээ урвуулан ашиглахыг хориглоно. Харин ашиг сонирхлоо хамгаалахын тулд зайлшгүй шаардлагаар хийсэн үйлдэл хууль ёсны болох нь тогтоогдсон бол эрхээ урвуулан ашигласан гэж үзэхгүй" гэж заасан нь өмчлөгч, эзэмшигчийн өөртөө туслах эрх, түүнийг хэрэгжүүлэх талаар тодотгосон зохицуулалт болно.

Манай улсын Иргэний хуулийн дээрх зохицуулалт нь ХВНГУ-ын өмнө, дурдсан хуулийн холбогдох зохицуулалтыг үгчлэн хуулбарласан утгатай байгааг анхаарвал зохино. Хуулбарлах нь буруу гэдэг үүднээс бус, харин энэхүү зохицуулалт хаанаас эхтэй байв, цаашид хэрхэн ойлгож хэрэглэх вэ гэдэг асуултад хариу авах аргачлалыг тодруулах зорилгоор тэмдэглэсэн билээ. Өөрөөр хэлбэл, бид Германы хуулийн ойлголт, эрх зүйн практикийг цаашид илүү нарийвчлан судлах нь иргэний эрх зүйн шинэлэг зарим ойлголтыг зөв ойлгож хэрэглэхэд тустай.

Хуулийн дээрх тодорхойлолтоос үзэхэд иргэний эрх зүйн эрх, шаардлага хэрэгжүүлэх эсвэл баталгаажуулах /хамгаалах/ зорилгоор өөрийн хүчээр авч буй арга хэмжээ /үйлдэл/-г өөртөө туслах гэж ойлгоно. Профессор Т.Мөнхжаргал "Өөртөө туслах нь иргэний эрх зүйн хамгаалалтын арга болох тухай асуудалд" өгүүлэлдээ³ хуулийн заалтыг зөв тайлбарлан ойлгохын тулд "... ямар нөхцөлд, хэн, ямар үйлдлийг, яаж хийх вэ..." гэдэг арга зүй хэрэглэхийг санал болгосон байна. Өөртөө туслах үйлдлийг үүрэг гүйцэтгүүлэгч өөрөө, түүнчлэн түүний хууль ёсны төлөөлөгч, гуравдагч этгээд гүйцэтгэж болох тухай профессор Т.Мөнхжаргалын саналыг бүрэн дэмжиж байна. Энэ ойлголтыг зөв тодорхойлохын тулд "хэн"

1."Монголын төр, эрх зүй" сэтгүүл, 2003 он, 2 дахь тал.

2. Римское частное право, Под ред. И.Б.Новицкого и И.С.Перетерского, М., 1994 г, стр.52

3."Монголын төр, эрх зүй" сэтгүүл, 2003 он, 2 дахь тал.

гэдгээс гадна дараах дөрвөн чиглэлээр задлан үзэх нь зүйтэй болов уу. Үүнд:

А.Өөртөө туслах үйлдлийн урьдчилсан нөхцөл:

1.Хэрэгжүүлэх, хамгаалах гэж буй эрх, шаардлага нь иргэний эрх зүйн шинжтэй байх. Өөрөөр хэлбэл, эдийн ба эдийн бус баялагтай холбоотой харилцаа буюу өмчлөл, эзэмшил болон гэрээ, гэрээний бус үүргээс үүссэн эрх, шаардлага хэрэгжүүлэх үед өөртөө туслах аргыг хэрэглэнэ.

2.Энэхүү эрх шаардлага нь бодитой, хэрэгжүүлэх эрх зүйн үндэстэй байх. Жишээ нь, үүрэг үүсээгүй эсвэл дуусгавар болсон эсвэл гэрээний үүргийн шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн байвал өөртөө туслах үйлдэл хийх үндэслэл үүсэхгүй.

3.Хууль сахиулах байгууллагын туслалцааг зохих цаг хугацаанд авах боломжгүй байх. Хэрэв цагдаа дуудаж эрхээ хамгаалуулах боломжтой тохиолдолд өөртөө туслах үйлдэл хийхгүй. Түүнчлэн шүүхэд нэхэмжлэл гаргах журмаар эрхээ хамгаалуулах боломжтой үед ялангуяа гэрээний үүргийн харилцаанд өөртөө туслах үйлдлийг зөвшөөрөх нь зохимжгүй юм. Харин өмчлөх, эзэмших эрхэд халдсан тохиолдолд өөртөө туслах шаардлага элбэг тохиолдож болно.

4.Тэр даруй шуурхай арга хэмжээ авахгүй бол өөрийн эрх, шаардлага хэрэгжүүлэх боломжгүй болох эсвэл хүндрэх аюул бодитой байх. Гэм хор учруулагч, үүрэг гүйцэтгэгч оргож зугатах, дахин олдохгүй болох эсвэл хөрөнгө мөнгөө нуух, үүрэгдүүлэх магадлал өндөр байх зэрэг нөхцөлийг энд ойлгоно.

Б.Өөртөө туслах арга хэрэгсэл /хуульд тодорхойлон хязгаарлаж заасан/

1.Эд юмсыг эзэмдэж авах, устгах буюу эвдэх. Жишээ нь: ресторанд хоол идээд төлөх мөнгөгүй этгээдээс түүний зүүж явсан цагийг үйлчлэгч хүчээр эзэмдэн авах; зугтахаар завдаж буй гэм хор учруулагч, үүрэг гүйцэтгэгчийн эд зүйлсийг устгах, эвдэх замаар зугтах боломжгүй болгох.

2.Зайлсхийж болзошгүй үүрэг гүйцэтгэгчийг саатуулах. Жишээ нь хулгайч болон гэм хор учруулагчийг саатуулах.

3.Үүрэг гүйцэтгэгч этгээдийн зохих үйлдлийн эсрэг үйлдлийг таслан зогсоох. Жишээ нь, хулгайлах, дээдэмдэх, булаах оролдлого мөн хулгайчийн зугтах оролдлогыг хүчээр зогсоох; үүрэг гүйцэтгэгчийн үүргээ биелүүлэхгүй байгаа үйлдэл, эс үйлдэхгүйг хүчээр зогсоох.

В.Өөртөө туслах үйлдэлд тогтоосон хязгаарлалт:

1.Ийм үйлдэл нь тухайн нөхцөл байдалд тохирсон хэр хэмжээнээс хэтэрч болохгүй. Иргэний хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг.

2.Ийм үйлдэл хийсэн этгээд энэ тухай эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй. /Иргэний хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/

Г.Эрх зүйн үр дагавар:

1.Хэрэв өмнө дурдсан шаардлагыг хангасан бол ийм үйлдлийг эрх зүйн дагуух үйлдэл хэмээн үзэж, холбогдох хариуцлагаас /Иргэний хуулийн 497 дугаар зүйл/ чөлөөлнө.

2. Ийм үйлдлийн эсрэг аргагүй хамгаалалт хэрэглэж болохгүй.

3.Гэхдээ ийм үйлдлийг эндүүрч хийсэн буюу зохих хэмжээнээс хэтрүүлж хийсэн этгээд холбогдох хариуцлагыг хүлээх буюу учруулсан гэм хорыг арилгах үүрэгтэй /Иргэний хуулийн 12.4/ дахь хэсэг байхаар зохицуулжээ.



БУСДЫН ГАЗАР ДЭЭР БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

ХЗДХЯ-ны ахлах мэргэжилтэн Д.ОТГОНЧИМЭГ

Монгол Улсын шинэ Иргэний хуулийн дагуу аливаа этгээд өөрийн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой бусдын өмчлөх эрхийг хязгаарлах дараах төрлийн эрх эдэлдэг билээ. Үүнд:

- бусдын газар дээр барилга, байгууламж барих эрх;
- үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх /сервитут/;
- бусдын эд хөрөнгийг хязгаартайгаар эзэмших, ашиглах эрх /узуфрукт/;
- үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны /ипотека/ эрх багтан орно.

Эдгээр эрх нь газар өмчлөх эрхтэй салшгүй холбоотой бөгөөд тодорхой газар өмчлөх тохиолдолд л эдгээр эрх хэрэгжих бололцоотой юм. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх, бусдын эд хөрөнгийг хязгаартайгаар эзэмших, ашиглах эрх нь манай иргэний эрх зүйл урьд нь тусгалаа олсон боловч төдий л хэрэгжээгүй билээ. Энэ нь тухайн үед газар хувьчлагдаагүй, хувь хүн газар өмчлөх эрхийг эдэлдэггүй байсантай салшгүй холбоотой.

Бусдын өмчлөх эрхийг хязгаарлах эрх нь тухайн өмчлөгч этгээд, эд юмс хоёрын хооронд хууль зүйн холбоог бий

болгож буйгаар юуны өмнө нэгдүгээрт эд хөрөнгийн эрх болох бөгөөд жишээ нь бусдын газрын тодорхой хэсгээр явах эрхтэй этгээд нь тухайн газар өмчлөгч хэн байхаас үл шалтгаалан, газар өөр хүнд шилжсэн ч түүгээр дамжин явах эрхээ хэвээр хязгаарлалтгүй хэрэгжүүлдэг.

Дараа нь хоёрдугаарт энэхүү эрх нь бусдын өмчлөх эрхийг хязгаарлах эрх юм. Учир нь тухайн этгээдийн эрх байгаа эд зүйл – хөрөнгө нь өөр этгээдийн өмчлөх эрхийн зүйлс байдаг билээ.

Эдгээр эрх нь өөрийн агуулга, шалгавраас шалтгаалан дараах гурван төрөлд хуваагддаг.

Нэгдүгээр төрлийн дагуу эдгээр нь тухайн этгээдэд бусдын хөрөнгийг ашиглах эрхийг бий болгодог. Энэхүү ашиглалт нь хязгаарлагдмал /тухайн этгээд өөрийн хөршөөс нар, гэрэл, тодорхой зураглалыг хаахгүй байхыг шаардах эрхээр хязгаарлагдмал буюу өмчлөгчид зөвхөн "дан эрхийг"¹ римийн эрх зүйчдийн хэлдгээр *nudum jus*/ үлдээж харин нөгөө этгээд өмчлөх эрхийн² бүх агуулгыг өргөн утгаар хэрэгжүүлэх өргөн хүрээ бүхий байж болдог. Эдгээр төрлийн эрх нь бусдын ашиг сонирхлын үүднээс өмчлөгчийн эрхийг бага эсхүл өргөн хүрээгээр

хязгаарладаг. Энэ төрөлд бусдын эд хөрөнгийг хязгаартайгаар эзэмших, ашиглах эрх буюу узуфрукт² орно.

Хоёрдугаар төрөлд аливаа эд хөрөнгөөс тодорхой үнэ цэнэ олж авах эрх багтана. Энэ төрлийн үндсэн эрх нь барьцааны эрх юм - өмчлөгч тухайн барьцааны зүйл болох эд хөрөнгийн бүх эрх /эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрх/-ийг өөртөө хадгалан үлдэх, харин нөгөө этгээд болох үүрэг гүйцэтгүүлэгч тухайн эд хөрөнгийг тодорхой нөхцөлийн дагуу өөртөө тодорхой хэмжээний ашиг олох үүднээс борлуулна. Хэрэв нэгдүгээр төрлийн эд хөрөнгийн эрхэд тухайн эд хөрөнгийн ямарваа хэрэглээний үнэ цэнэ ач холбогдолтой байсан бол энэхүү хоёрдугаар төрлийн эрхэд тухайн эд хөрөнгийн арилжааны үнэ цэнэ түлхүү ач холбогдолтой юм.

Гуравдугаар төрөлд тодорхой эд хөрөнгийг буюу нэг төрлийн эд хөрөнгийг олж авах эрх багтан орно. Үүнд давуу эрхийн дагуу худалдан авах эрх, буцаан худалдан авах эрх, тодорхой эд хөрөнгө эзэмших тусгай эрх /бусдын газар дээр ан агнах, загасчлах эрх/ зэрэг эрх хамаарна.

Энэхүү эрх нь ХБНГУ-ын хууль тогтоомжид барилга

1.Покровский И.А."Основные проблемы гражданского права", М., 1998 , стр.207 тал

2.Васильев Е.А., "Гражданское и торговое право капиталистических государств", Москва., 1993 , стр.235

байгууламж барих өв залгамжлалын эрх /Наследственное право застройки, Erbbaurecht/¹ Гэж нэрлэгддэг ба түүнийг газрын хэсэг дэх хязгаарлагдмал эд хөрөнгийн эрх гэж тооцдог байна. Энэ асуудал нь эрт дээр үеэс хууль зүйн зохицуулалттай байсан бөгөөд анх 1896 онд батлагдан одоо хүртэл мөрдөгдөж буй ХБНГУ-ын Иргэний хуулийн 1012-1017 дугаар зүйлээр зохицуулагдаж байгаад хүчингүй болж, 1919 оны нэгдүгээр сарын 15-нд батлагдсан барилга байгууламж барих өв залгамжлалын тухай дүрмээр зохицуулагддаг. Хууль тогтоогч нь барилга байгууламж баригчийн зардлыг багасгах эдийн засгийн тооцооны үүднээс барилга, байгууламж барих тусгай эрхийг тогтоосон. Тухайн дүрмийн 1 дүгээр зүйлд хэний эрх ашгийн төлөө газрын хэсгийн хязгаарлалт хийгдсэн, түүнд тухайн газрын хэсгийн доор ба дээр барилга, байгууламж барих өв залгамжлах буюу шилжүүлэх эрх бий болно. Энэ эрх газрын хэсгийг өмчлөх эрх, тухайн хэсэг дээр баригдсан барилга, байгууламжийг өмчлөх гэсэн 2 эрхэд хуваагдана. Тухайн барилга байгууламж нь барих эрхийн хэсэг нь болдог. Барилга, байгууламж барих эрхийг бүртгэх, түүнийг өв залгамжлах эрхийн тусгай бүртгэлийн ном хөтлөгддөг. Ерөнхий журмын дагуу барилга, байгууламж барих эрх нь 66 эсвэл 99 жилийн хугацаанд хүчинтэй байдаг. Дүрмийн 9а дугаар зүйлийн дагуу барилга, байгууламж барих өв залгамжлах эрхийг өмчлөгчийн зөвшөөрлийн үндсэн дээр бусдад өв залгамжлах буюу шилжүүлж болдог.

Түүнчлэн дээр дурдсан тухайн дүрмийн 1 дүгээр

зүйлийн дагуу нэг талаас барилга, байгууламж барих эрхийг барилгын тодорхой нэг хэсэг, нэг давхар байх гэх мэт хязгаарлалттай, нөгөө талаас барилга байгууламж барих эрх нь өөрөө дуусгах нөхцөлөөр хязгаарлагдсан байж болохгүй.

Газрын хэсгийн өмчлөгч нь барилга байгууламж барих эрхийн эзэмшигчтэй тодорхой нөхцөл байдал бий болсны улмаас уг эрхээсээ татгалзах бөгөөд тусгай газрын эрхийн бүртгэлээс хасуулах тухай хэлцлийг байгуулж болохгүй. Энэ нь эрх эзэмшигчийн ашиг сонирхлыг хамгаалах хэрэгсэл болдог. Эрх эзэмшигч нь ямарваа нөхцөл байдлаас шалтгаалж өөрийн эрхээс үл татгалзах юм. Мөн түүнчлэн түүнээс уг эрхийг үл хасч болно.

Барилга, байгууламж барих эрхийн хүчинтэй байх бүх хугацаанд төлөх төлбөрийн хэмжээг гэрээгээр тодорхой хувьд хуваан тодорхойлдог.

Дүрмийн 9 дүгээр зүйлийн "а"-д заасны дагуу харэв барьсан барилга нь оршин суух зорилготой бол барилга байгууламж барих эрхийн төлбөрийн нэмэгдүүлэлтийг зөвхөн шударга тодорхой тохиолдлын нөхцөл байдлын тухай хэлцлийн дагуу хийгдэнэ.

Газрын харилцаатай холбогдон гарсан түүний үнэ өртгийн өөрчлөлт нь тэр болгон нь барилга байгууламж барих эрхийн төлбөрт нөлөөлөх ёсгүй билээ.²

Дээр заасны дагуу зөвхөн тодорхой шударга тохиолдолд гэдэг нь өмчлөгчийн гаргасан зардал буюу энэхүү зардлаас эрх эзэмшигчид бий болгож буй ашиг хоорондын ялгаанаас бий болох үнийн өсөлт гарах явдлыг хэлдэг байна. Төлбөрийг нэмэгдүүлэх шаардлага нь зөвхөн гэрээ байгуулснаас хойш

3 жил ба тусгай даалгавар өгснөөс хойш тус бүр 3 жилийн дараа үүснэ.

Барилга, байгууламж барих эрх нь хэлцлийн үндсэн дээр үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлснээр үүснэ. Энэ гэрээ нь үүргийн хэлцлийн хувьд заримдаа худалдах-худалдан авах гэрээтэй адил юм. Гэхдээ түүний төлбөрийг шууд бус хувиар хэсэгчлэн төлдөгт ялгаа нь оршино. Энэ гэрээг бичгээр үйлдэх ба ХБНГУ-ын Иргэний хуулийн 313 дугаар зүйлд зааснаар нотариатаар гэрчлүүлээгүй ч үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэсэнээр хүчин төгөлдөр болно³.

Дүрмийн 2 дугаар зүйлийн дагуу гэрээний агуулгад барилга, байгууламжийг барих, ашиглах, санхүүжүүлэх, даатгах, засварлах, нийтийн эрх зүйн болон иргэний эрх зүйн үүрэг, урт удаан хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд тухайн эрх өмчлөгчид шилжих, гэрээ дуусгавар болоход гэрээг шинэчлэх, барилга байгууламж барих эрх эзэмшигчид өмчлөгч тухайн газрын хэсгийг зарах үүрэг хүлээх зэрэг нөхцөлийг тусгасан байна.

Барилга, байгууламж барих эрх дуусгавар болоход Дүрмийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу тухайн эрхийн дагуу баригдсан барилга, байгууламж нь суурь хөнгөлдөлд бүрэлдэхүүн хэсэг болно. Барилга, байгууламж барих өв залгамжлалын эрхийн эзэмшигч нь өмчлөгчөөс тухайн барилга, байгууламжийг барихад зарцуулсан зардлаа нөхөн төлөхийг шаардах эрхтэй.

Монголын иргэний эрх зүйл цоо шинээр анх удаа тусгагдаж буй нэг эрх нь бусдын газар дээр барилга, байгууламж барих эрх юм.

1. Jaernig/Schlechtriem, Stuerner, Buergerliches Gesetzbuch, 7 Auflage, Muenchen, 1994, page. 1203.

2. Жалинский А., Рихт А., Введение в немецкое право. М., 2001., стр.429

3. Buergerliches Gesetzbuch, Deutscher Taschenbuch Verlag, 49. Auflage, 2001, p.54

Монгол Улсын 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан шинэ Иргэний хуулийн 150 дугаар зүйлд барилга, байгууламж барих эрхийн эрх зүйн зохицуулалт тусгагдсан билээ.

Бусдын өмчийн газар дээр барилга, байгууламж барих эрхтэй этгээд нь тухайн газрыг өөрийн эзэмшилд шилжүүлэн авна. Барилга, байгууламж барих эрхтэй этгээд нь түүнийгээ бусдад өв залгамжлах, барьцаалах, худалдах гэх мэт хэлбэрээр шилжүүлж болно.

Газар өмчлөгчийн өмчлөх эрхийг хязгаарлаж эрх эзэмшигч нь өөрт илүү зохистой ашиглах боломж олгож байгаа газрыг өөрийн эзэмшилд шилжүүлэн авах эрхтэй.

Барилга, байгууламж барих эрхийн хүчинтэй байх дээд хугацаа нь 99 хүртэл жил байх бөгөөд үүнээс өөр хугацаа тогтоогдсон тохиолдолд тэр нь заавал тодорхой байх ёстой. Мөн уг эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болохоор болзол тавьсан хэлцэл нь хүчин төгөлдөр бус байна.

Барилга, байгууламж барих эрх бүхий этгээд тухайн эрхийн төлбөрийг газар өмчлөгчид гэрээнд тохиролцсон ёсоор тогтмол төлөх ёстой ба тухайн жилийн төлбөрийг өмнөх жилд багтан урьдчилан төлөх үүргийг хүлээнэ. Хэрэв эрх эзэмшигч нь ийнхүү төлбөр төлөх үүргээ 2 жилийн турш төлөөгүй тохиолдолд газар өмчлөгч өөрийн, өөрөөр хэлбэл, гэрээг нэг талын санаачилгаар цуцлах тусгай эрхийг эдэлнэ. Энэхүү эрх нь газар өмчлөгчийн эрх зүйн хамгаалалтын хэрэгсэл болдог.

Барилга, байгууламж барих эрхийн төлбөрийн хэмжээг тухайн үеийн зах зээлийн үнэ ханшнаас шалтгаалж арван жил тутам шинэчлэн харилцан тогтоохоор талууд гэрээнд тусган тохиролцож болно.

Дээр зааснаас бусад тохиолдолд барилга, байгууламж барих эрхийг гэрээний аливаа нэг талын санаачилгаар дуусгавар болохыг хориглосон байдаг.

Бусдын өмчлөлийн газар дээр барилга, байгууламж барих эрхийн үндсэн дээр баригдсан барилга, байгууламж нь тухайн эрхийн гол бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд тэр нь нурсан, эвдэрсэн явдал нь уг эрх дуусгавар болох үндэслэл болохгүй.

Барилга, байгууламж барих эрхийн эзэмшигч нь түүнийгээ бусдад барьцаалах, худалдах ба бусад хэлбэрээр захиран зарцуулахад газар өмчлөгчийн зөвшөөрлийг заавал авна. Өмчлөгч нь ийнхүү зөвшөөрлийг эрх эзэмшигчид өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол ноцтойгоор зөрчлөхөөс бусад тохиолдолд өгөх үүрэгтэй юм.

Газар өмчлөгч нь өөрийн газар дээрх барилга, байгууламж барих эрхийн хугацаа дуусгавар болоход, хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол, тус газраас тухайн барилга, байгууламжийг зориулалтыг эвдэлгүйгээр салгаад авч явж чадахгүй тул түүний үнийг эрх эзэмшигчид нөхөн төлнө. Гэхдээ ийнхүү нөхөн төлбөрийн оронд газар өмчлөгч тухайн барилга, байгууламжийн эрхийг дууссан эрх эзэмшигчидтэй тохиролцон сунгаж болно. Ийнхүү сунгахдаа тухайн баригдсан барилга, байгууламжийн оршин байх ердийн хугацааг харгалзан үзнэ.

Барилга, байгууламж барих эрх бүхий этгээд нь нөхөн төлбөрийн оронд эрхийн хугацааг сунгахаас татгалзвал нөхөн төлбөр шаардах эрхээ алдана.

Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барилга, байгууламж барих зориулалтаар газар эзэмшиж байсан этгээд уг эрхийн хугацаа дуусгавар

болоход тухайн газар дээр барьсан барилга, байгууламж болон түүний бүрэлдэхүүн хэсгийг салган авч явах эрхгүй.

Барилга, байгууламж барих эрх эзэмшигчийн газар өмчлөгчөөс нөхөн төлбөр шаардах эрх нь барилга, байгууламж барих эрхтэй ижил дарааллаар хангагдах бөгөөд энэ дарааллыг талууд хэлэлцэн тохиролдож өөрчлөх эрхгүй байдаг. Хэрэв барилга, байгууламж барих эрхийн хугацаа дуусах үед уг эрх нь барьцаанд байгаа бол барьцаалагч нь барьцаагаар хангагдах үүргийн гүйцэтгэлийг мөн шаардах эрхтэй.

Барилга, байгууламж барих зориулалтаар газар эзэмших эрх дуусгавар болоход газар өмчлөгч нь барилга, байгууламж барих эрхтэй байсан этгээдийн гуравдагч этгээдтэй байгуулсан хөлслөх, түрээслэх гэрээний оролцогч болно.

Барилга, байгууламж барих эрх нь Иргэний хуулийн 150.13, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэнээр үүсэн баталгаажна. Тухайн эрх үүсэх, уг эрхийг олж авахтай холбогдсон харилцаанд үл хөдлөх эд хөрөнгө олж авах журам нэгэн адил үйлчилнэ.



Нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн хэргийг шүүхээр шийдвэрлэж байгаа нь

Нийслэлийн шүүхийн шүүгч Л.БЯМБАА

Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн /1992 оны/ Арванзургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 17 дахь заалтад “... Хүний эрх, нэр төр, алдар хүнд...”-ийг хуулиар хамгаалахаар заасны зэрэгцээ мөн Арвандолдугаар зүйлийн 1-ийн 2 дахь хэсэгт “Хүний нэр төр, алдар хүнд, эрх хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх” нь иргэний үндсэн үүргийн нэг болгон хуульчилсан. Энэхүү Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд “Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийг үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчилдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсвэл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ” гэж заасан. Энэхүү заалтыг өмнө нь үйлчилж байсан 1994 оны Иргэний хуулийн 7 дугаар зүйлд “Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах” талаар хуульчлан заасантай харьцуулан үзвэл “Хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэж үзвэл учирсан гэм хорыг арилгуулахыг шаардах эрх иргэнтэй нэгэн адил хамааралтай байсныг шинэ иргэний хууль “Хуулийн этгээд” гэсэн ойлголтыг хассан байна. Иймд нэр, нэр төр, алдар хүнд гутаагдсан гэж үзэх гэм

хорыг арилгахыг шаардах эрх зөвхөн иргэнд хамаарагдахаар хуульчилсныг анхаарах шаардлагатай. Өөрөөр хэлбэл хуулийн этгээдэд энэ заалт хамааралгүй болсон байна.

1994 оны Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Нэр, нэр төр, алдар хүнд ажил хэргийн нэр хүндийг гутааснаас учирсан гэм хорын хэмжээ, арилгах аргыг... шүүх тодорхойлно” гэж заасныг тухайн үед шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэлээд тулгамдсан асуудал болж байсан бөгөөд нэхэмжлэгч гэм хорын хохирлоо тооцон мөнгөөр илэрхийлсэн нөхцөлд шүүх яаж үнэлж дүгнэх вэ? гэдэг асуудалд нэгдсэн практик тогтоогүй байсантай холбоотой юм. Одоо ч гэсэн шүүхээс тогтоож буй гэм хорын хохирлыг хариуцагч тал хүлээн зөвшөөрдөггүй, ягаад шүүх ингэж үнэлэв гэдэгт итгэлгүй ханддагаас анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргах үндэслэл нь хохирлын хэмжээг зөвшөөрдөггүйтэй холбоотой байдаг.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь талуудын тэгш эрхийн үндсэн дээр мэтгэлцэх зарчмаар явагддаг учраас нэхэмжлэлийн шаардлага нотлох баримтаар нотлох, хариу тайлбар ч мөн адил нотлох баримтаар үгүйсгэх замаар мэтгэлцэж, шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтад

шүүх үндэслэлтэй дүгнэлт өгч зөвхөн иргэнд хамаарагдахаар хуульчилсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагатай байдаг. Сүүлийн 5 жилийн байдлаар шүүхэд гаргасан нэхэмжлэлийн 31.5 хувь нь нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэж үзэж гэм хорын хохирлыг мөнгөөр илэрхийлж гаргуулахыг, 68.5 хувь нь нэр төрөө сэргээлгэх, тухайн хэвлэлээр залруулга хийх, уучлалт гуйхыг тус тус хүсч байсан.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэж үзсэн маргаантай хэргийн дотор хэвлэл мэдээллийн үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэл 65.7 хувь, хуулийн этгээдэд холбогдуулан 9.2 хувь, иргэний үйл ажиллагаатай холбоотой нэхэмжлэл 31.5 хувийг эзэлж байна. Мөн нэхэмжлэлийн шаардлагаар гэм хорын хохиролд 1.4 тэрбум төгрөг нэхэмжилсэн 18,01 сая төгрөгийн буюу 1.2 хувийг шүүх хангаж, иргэн хуулийн этгээдэд учирсан хохирлыг арилгаж шийдвэрлэсэн байна.

Нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг судалж үзэхэд дараах 5 төрөлд хуваан үзэж болох юм. Үүнд:

- Нэр төрөө сэргээхийг хүссэн 50%;
- Ажил хэргийн нэр хүнд сэргээх 23,7%;
- Сэтгэл санааны хохирлоо арилгуулах 14,4%;

- Эрүүл мэндээр хохирсон 9,2%;
- Олох ёстой байсан орлогод нөлөөлсөн 2,7% байна гэж үзэж нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд гаргаж байгаа.

Нэр төр, алдар хүнд ажил хэргийн нэр хүндийг гутаагдсан гэж үзсэн нэхэмжлэлтэй хэргийг шийдвэрлэж байгаа байдлыг нийслэл, дүүргийн шүүхийн хэмжээгээр сүүлийн 3 жил хагасын хугацаагаар авч үзье. Дүүргийн шүүхүүд энэ хугацаанд 28269 иргэний хэрэг шийдвэрлэсний дотор нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэсэн нэхэмжлэлтэй 158 хэргийг хянан шийдвэрлэснээс 43 буюу 27,2 хувийн нэхэмжлэлийг бүрэн хангаж, 54 буюу 34,2 хувийн нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгож, 17 буюу 10,8 хувийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгожээ. Иймд шүүх нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаагдсан болон гэм хорын хохирол учирсан гэж үзсэн нэхэмжлэлийн шаардлагыг шүүх бүрэн хангадаггүй ялангуяа хэвлэлийн эрх чөлөөний талаар хуулиар олгогдсон хэм хэмжээний хүрээнд шүүх үнэлэлт, дүгнэлт өгч ирсэн гэж дүгнэх боломжтой байна.

Үндсэн хуулар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх талаар олгогдсон эрхийг шүүхээс хязгаарласан байдал дээрх дүн мэдээгээр харагдахгүй байна. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсанаас үүдсэн нэхэмжлэлтэй хэргийг шүүх шийдвэрлэж буй ажиллагаатай уялдан ялангуяа хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлалаа гэдэг шүүмжлэл зарим үед гардаг хэдий ч дээрх дүн мэдээнээс

үзвэл нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлага бүрийг шүүх хүлээн авдаггүй нь харагдаж байна.

Шинэ иргэний хуулиар нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах талаарх зарим асуудлыг эрх зүйн зохицуулалтаар улам нарийвчилж зааж өгсний дээр өмнө нь зохицуулагдаагүй маргаантай байсан зарим харилцаанууд тухайлбал, нас барсан этгээдийн нэр төр, алдар хүндийг гутаасан эсвэл түүний хувийн нууцтай холбоотой мэдээг өвлөгчийн зөвшөөрөлгүй олон нийтэд тараасан бол гэм хорыг эдийн хэлбэрээр нөхөн төлүүлэхийг шаардах эрхгүй харин нэр, нэр төр, алдар хүнд ажил хэргийн хүндийг хамгаалах эрх нь нээлттэй байх, иргэний өөрийн зөвшөөрөлгүй авсан, бодит баримтыг бүрэн гүйцэд мэдээлээгүйгээс нэр төрд халдах, хуулиар тогтоосон хуулийн нууцал хамаарах асуудлыг өөрийнх нь зөвшөөрөлгүй нийтэд мэдээлснээс гэм хор учирсан гэж үзвэл иргэн уг гэм хорын хохирлыг арилгахыг шаардах зэрэг асуудлуудыг нарийвчлан зохицуулж өгчээ. Жишээ нь Иргэн өөрийн өвчний талаар маш их эмзэглэж энэ тухайгаа нууцалж явдаг байжээ. Энэ талаар түүний зөвшөөрөлгүй олон нийтэд мэдээлбэл түүний нэр төрд халдсан гэж үзэх үндэслэлийг хуулиар тогтоосон байна.

Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан хохирлыг мөнгөөр тооцсон нөхцөлд яаж үнэлэх вэ? гэдэг асуудал одоо ч гэсэн бүрхэг хэвээр байна.

Шүүхийн практикаас үзвэл:

- Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан гэм

хорын хохирлыг мөнгөөр илэрхийлэн нэхэмжилсэн нэхэмжлэлээс 100000 төгрөгнөөс 5000000 төгрөгийн хэмжээнд нэхэмжлэлийн шаардлагыг хангадаг дундаж үнэлгээ тогтож байна.

Мөн нэхэмжлэгчийн нэр төр гутаасан тухай нийтлэл гарсан сонин, хэвлэлийн тэр өдрийн дугаараас олох ашгийн хэмжээгээр хохирлыг тооцон гаргаж байна.

Нэхэмжлэгчийн эрүүл мэндэд аохих хохирол учирснаас эмнэлэгт хэвтэх, даралт ихсэх, зүрх өвдөх зэрэг байдлаар өвчилсөн бол энэ талаар бичгэн нотлох баримтаар нэхэмжлэгч нотолсныг шүүх хэргийн бодит байдалтай харьцуулах байдлаар гэм хорын хохирлыг тогтоож байна. Энэхүү нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас учирсан гэм хорын хохирлын талаарх нэхэмжлэлтэй хэргийг шүүх шийдвэрлэхдээ гэм хорын хохирлыг туйлын зөв тооцсон гэж үзэхэд учир дутагдалтай байна.

Цаашид нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд учирсан гэм хорын хохирлыг яаж тооцох вэ? гэдэг талаар шүүхийн практикийг нэгтгэн нягтлан судалж, Улсын дээд шүүхээс нэгдсэн тайлбар гаргавал энэ төрлийн маргаантай хэргийн гэм хорын хохирлыг шүүх тооцох шалгуурыг нарийвчлан тогтооход чухал ач холбогдолтой болох юм.



Гаалийн хууль тогтоомжийг зөв хэрэглэх асуудал

УДШ-ийн шүүгч О.ЗАНДРАА

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжиж, дотоод, гадаад худалдааны эрэнхий орчин, бүтэц эерчлөгдөн, зах зээлийн харилцаа гүнзгийрэхийн хэрээр гаалийн хууль тогтоомжийг улам боловсронгуй болгож, олон улсын эрх зүйн нөхцөл байдалтай уялдуулан зохицуулах шаардлага зайлшгүй гарсны улмаас гаалийн эрх зүйн хэм хэмжээг нарийвчлан тусгасан, гаалийн эрх зүйн асуудлыг бүлэглэн эмхтгэж, төрөлжүүлсэн Гаалийн болон Гаалийн тарифын тухай хуулийг Улсын Их Хурлаас 1996 онд батлан гаргажээ.

Гаалийн хууль нь гаалийн байгууллагын зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тодорхойлсон, Монгол Улсын хилдээр нэвтрэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт шалгалт хийх, гаалийн бүрдүүлэлтийн горимыг тогтоох, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс гаалийн хууль тогтоомжийг сахин биелүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг бол Гаалийн тарифын тухай хууль нь бүх төрлийн бараанд ногдуулах татварын хэмжээг шууд өөрөө тогтоосон гаалийн тариф биш бөгөөд дотоодын зах зээл, худалдааны бодлогын чухал хэрэгсэл болох гаалийн

тарифыг тогтоох, түүнийг хэрэглэх аргыг зааж өгсөн хууль юм.

Гаалийн тарифын бодлого, гадаад худалдааны бодлого, барааны дотоодын зах зээлийн төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болно.

Түүнчлэн энэ хуулиар гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн болон бусад татварыг ногдуулах, гаалийн үнийг тогтоох арга, барааны гарал үүслийн гэрчилгээний тухай зэрэг асуудал тусгагджээ.

Гаалийн байгууллагын үйл ажиллагаа өргөн хүрээтэй байдаг онцлогоос шалтгаалан төрийн болон төрийн бус олон байгууллагатай хамтран ажиллаж, гаалийн тухай хууль тогтоомжоос гадна Төрийн албаны тухай болон Хөдөлмөрийн, Эрүүгийн, Валютын зохицуулалтын тухай, Эрдэнэсийн сангийн тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Амьтны аймгийн тухай зэрэг хуулиудын зүйл, хэсгийн заалтуудыг хэрэгжүүлэхэд гаалийн байгууллага оролцож байдаг.

Мөн Монгол Улсын татварын хуулиудыг хэрэгжүүлэхэд гаалийн байгууллагын оролцоо их юм.

Гаалийн байгууллага болон албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүүд гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх тухай олон асуудал Гаалийн тухай хуульд тусгалаа олсноос гадна тэдгээрийг шийдвэрлэх ажиллагааг ч мөн хуулиар зохицуулсан байна.

Гаалийн болон Гаалийн тарифын тухай хуулийн зүйл, заалт, Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийн заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Дээд шүүх 2001 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 436, 2003 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 24 дүгээр тогтоолуудыг гаргасан билээ.

Дээрх хуулиудын зүйл, заалтуудыг зөв хэрэглэх явдал хангалтгүй байгаагийн улмаас Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн болон иргэний хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж байгаа хэргийн шийтгэх тогтоол, шийдвэр, магадлалууд хүчингүй болох, өөрчлөгдөх байдал гарсаар байна.

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын хийсэн судалгаанаас үзэхэд Говь-Алтай, Увс, Дорнод, Ховд аймагт хилийн боомтгүй газраар хууль бусаар улсын хил зөрчих, хятад, тува

улсын иргэдтэй урьдчилан үгсэн тохирч эд зүйлийг хууль бусаар улсын хил нэвтрүүлж, чанар муутай спирт, тамхийг их хэмжээгээр оруулж ирэх, хил дамжин мал хулгайлах гэмт хэрэг гарсаар байна.

Өмнөговь аймгийн шүүхээр энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлэгсдийн байдлаас үзэхэд хилийн боомт нээгдэх үеэр зохих зөвшөөрөлгүй буюу боловсруулаагүй ноолуур, арьс шир, алт, мөнгийг хууль бусаар улсын хилээр нэвтрүүлж оронд нь хятад спирт авч спиртийг гаалийн мэдүүлэгт "химийн бодис" гэх мэтээр худал мэдүүлж оруулж ирэхийг завдсан, Дорноговь аймгийн шүүхээр ял шийтгүүлэгсдийн дотор Замын-Үүд боомтоор гардагтай холбогдон энэ боомтоор хил нэвтэрч байгаа хятад, монгол иргэд нь байгалийн түүхий эд, бугын чив, согооны сүүл, ангийн арьсыг нууцаар хил нэвтрүүлэх, хязгаарласан болон хориглосон барааг улсын хилээр нэвтрүүлдсэн, Говь-Алтай, Увс аймагт эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлэх хэргийг бүлэглэн үйлдэж, спиртийг хууль бусаар оруулахдаа машин, механизм, бусад тээврийн хэрэгслийг ашиглаж байгаа нь тогтоогдсон байна.

Дээрх аймгуудад гарч буй гэмт хэрэгт ял шийтгүүлэгсдэд ногдуулж байгаа ял харьцангуй хөнгөн байгаад дүгнэлт хийж, энэ төрлийн гэмт хэргийн нийгмийн хор аюулын

шинжийг харгалзан уг гэмт хэргийг давтан болон удаа дараа бүлэглэн үйлдсэн зэрэг хүндрүүлэн үзэх нөхцөл байдал байгаа тохиолдол бүрт ял шийтгэлийг зөв сонгон ногдуулж, ялын бодлогыг зохих төвшинд байлгах нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Иргэний хэргийн танхимын хийсэн судалгааны материалуудаас үзэхэд гаалийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан эрх зүйн акт хуульд нийцээгүй талаар иргэд, байгууллагаас гаргасан гомдлыг шийдвэрлэсэн хэргүүд зохигчдын гаргасан гомдлоор Улсын дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хянагджээ.

Хянагдсан хэргүүдийн дотор гаалийн албанаас үндэслэлгүй халагдсан ажилдаа эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах тухай иргэний хэрэг дийлэнх хувийг эзэлж байгаа боловч энэ төрлийн гомдолтой иргэний хэрэг жил дараалан буурсан үзүүлэлттэй байна.

Гаалийн улсын байцаагчийн ажлаас үндэслэлгүй халагдсан тухай гомдолтой иргэний хэргийг шийдвэрлэхдээ Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн "Энэ хуулийн 5.1.3-т заасан албан тушаалд тавих тусгай шаардлага болон ёс зүйн

хэм хэмжээг хууль тогтоомжоор тогтооно", 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсгийн "Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна" гэсэн заалтуудыг Гаалийн болон Гаалийн тарифын тухай, Хөдөлмөрийн тухай хуулиудын холбогдох зүйл, хэсгийн заалтуудтай уялдуулан ойлгож, зөв хэрэглээгүйн улмаас Гаалийн тухай хуулийн 68, 69, Хөдөлмөрийн тухай хуулийн 35, 40, 100, 129, Гаалийн тарифын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн, Улсын дээд шүүхийн 2000 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 259 дүгээр тогтоолын 21 дүгээр заалтыг буруу хэрэглэсэн, импортоор орж ирсэн бензиний үнийг тогтоохдоо хэлцлийн үнийг баримтлан итгэлцүүрийг хэрэглэн тодорхойлоогүй, жишиг үнэ, тооцооны үнийн зөрүүгээр тооцож үнийг тодорхойлон татвар ногдуулсан зэрэг үндэслэлүүдээр шүүхийн шийдвэр, магадлал өөрчлөгдөж, хүчингүй болжээ.

Цаашид эрүүгийн болон иргэний хэргийг шийдвэрлэхдээ дээрх зүйлүүдийг анхаарч алдаа зөрчил гаргахгүй ажиллах нь бидний гол зорилт болж байна.



Фидуцийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал

Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн судалгааны төвийн захирал П.ЦЭЦГЭЭ

Монгол Улсын Иргэний шинэ хуульд үүргийн гүйцэтгэлийг хангах аргын нэг төрөл болох үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ /фидуци/-ний асуудлыг шинээр оруулсан юм.

Ромын эрх зүйд фидуцийг үүргийн гүйцэтгэлийг хангах арга болох барьцааны нэгэн төрөл гэж үзэж байжээ. Үүргийн гүйцэтгэлийг хангах аргын эртний хэлбэрт фидуци, пигнус, ипотека хамаардаг бөгөөд эдгээр барьцааны үндсэн төрлөөс эх газрын эрх зүйн системд пигнус ипотекийн асуудал боловсронгуй болж хөгжсөн байна.

Үүргийн гүйцэтгэлийг хангах аргын нэг болох пигнусын онцлог нь үүрэг гүйцэтгэгч үүрэг гүйцэтгүүлэгчид эд хөрөнгөө шилжүүлдэг боловч уг эд хөрөнгийг ашиглах, эзэмших эрх шилждэггүй харин үүргийг хугацаанд нь гүйцэтгүүлэх шаардлагын үүднээс зөвхөн эд хөрөнгийг барьцаалж байдаг байна.

Ипотекийн хувьд үл хөдлөх эд хөрөнгө үүрэг гүйцэтгэгчийн өмчлөлд хэвээр хадгалагдах ба үүрэг гүйцэтгэгч уг хөрөнгийг

өөр өөр этгээдэд дахин барьцаалж болдог эрхтэй байдаг нь үүргийн гүйцэтгэлийг хангах арга болох фидуци, пигнус зэргээс давуу талтай.

Тайлбар тольд дурдсанаас үзвэл фидуцийг тодорхой бус нэр томъёо, янз бүрийн байдлаар илэрдэг гэсэн байх ба эрх зүйн талаас нь авч үзвэл олон улсын практикт эрхийн барьцаа гэсэн ойлголтоор авч үздэг байна. Олон улсын практикт үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээний зүйл нь материаллаг ба материаллаг бус хөрөнгө эзэмших эрхийн хамт, мөн шаардах эрх байж болдог ажээ.

Монгол Улсын Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцааж өгөх үүргийг тус тус хүлээнэ” гэжээ.

Хуулийн энэ заалтаас үзвэл:

А/ Үүрэг гүйцэтгэгч фидуцийн зүйлийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд заавал шилжүүлэх;

Б/ Үүрэг гүйцэтгэгч нь зөвхөн мөнгө төлөх үндсэн үүрэгтэй байх;

В/ Фидуцийн гэрээний зүйл нь зөвхөн хөдлөх эд хөрөнгө байх;

Г/ Үүрэг гүйцэтгэгч мөнгө төлөх үндсэн үүргээ хугацаанд нь гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн хөдлөх эд хөрөнгөө буцааж авах эрхтэй байдаг онцлог шинжийг агуулжээ.

Эдгээр гол шинжээс нь үзэхэд үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлснийг тухайн эд хөрөнгийн өмчлөх эрх, үүрэг гүйцэтгүүлэгчид шууд шилжсэн гэж ойлгож болохгүй бөгөөд үндсэн гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө уг хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулсан аливаа баримт бичгийг үүрэг гүйцэтгүүлэгч өөрийн нэр дээр шилжүүлэн авах явдал хязгаарлагдмал байх төдийгүй тухайн хөдлөх эд хөрөнгийн

хувьд захиран зарцуулах эрх бодит байдлаар хэрэгжих боломж нь хийсвэр шинжтэй байна.

Иймд Иргэний шинэ хуульд фидуцийг практикт хэрэгжүүлэхтэй холбоотой процессын шинжтэй зохицуулалт хомс байгаа тул өөрийн саналаа илэрхийлэхийг хүсч байна.

Жишээ нь: иргэн "А", "Эрхэс" банк бус санхүүгийн байгууллагатай зээлийн гэрээ байгуулж, түүнээс 5 сая төгрөгийн зээл авсан байна. Мөн өөрийн өмчлөлийн "Соната-3" маркийн автомашинаа үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ /фидуци/ байгуулж, зээлдүүлэгч банк бус санхүүгийн байгууллагад актаар хүлээлгэн өгчээ. Энэ тохиолдолд "Эрхэс" банк бус санхүүгийн байгууллага өмчлөгч юм бол гэрээний хугацаанд машиныг ашиглах эрхтэй. Ашиглахын тулд уг машиныг эзэмшихтэй холбоотой бичиг баримт заавал шаардлагатай болно.

Иймд дээрх гэрээг байгууллагц бичиг баримтыг зээлдүүлэгчийн нэр дээр шилжүүлэх үү? Эсвэл зөвхөн зээлдэгч зээлийн гэрээний мөнгө төлөх үндсэн үүргээ хугацаанд нь үүргээ биелүүлээгүй үед л Замын цагдаагийн газар гэрээг үндэслэн автомашин эзэмших /өмчлөх/ эрхтэй холбоотой техникийн бичиг баримтыг зээлдүүлэгчийн нэр дээр шилжүүлэх үү? наториатын юм

уу, шүүхийн шийдвэр гарсан байх шаардлагатай юу? гэдэг талаар саналаа хуваалцахыг та бүхнээс хүсч байна.

Миний үзэж байгаагаар гэрээгээр тохиролцсон бол үндсэн гэрээний хугацаанд машиныг итгэмжлэлээр ашиглах ба үндсэн үүрэг биелэгдээгүй тохиолдолд гэрээг үндэслэн эрх бүхий байгууллага өмчлөх эрхийг шилжүүлнэ гэж ойлгож байна.

Германы эрх зүйн толь бичигт "Фидуци гэдэг нь гаднаас нь харахад үүрэг гүйцэтгүүлэгчид өмчлөгчийн бүхий л эрх хэмжээг олгосон мэт боловч дотооддоо үүрэг гүйцэтгэгчийн зүгээс энэ эрх хэмжээг нэлээд хэмжээгээр хязгаарласан харилцаа байдаг" гэжээ. Фидуци нь зөвхөн талуудын харилцан итгэлцэл найдвартай байдалд үндэслэдэг тул аль нэг тал нь давуу эрх эдлэхгүй бөгөөд эдлэх эрхийнхээ хэмжээ хязгаарын талаар гэрээгээр хатуу тохиролцох ёстой.

Үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөлд шилжиж ирсэн эд хөрөнгийг үндсэн гэрээний хугацаанд сайн хамгаалах, түүнд нөлөөтэй байх, үүрэг гүйцэтгэгч нь өмчлөлд шилжүүлсэн эд хөрөнгийнхөө байдалд хяналт тавих, хариуцлага хүлээх үүрэг талуудад илүү тавигддаг байна.

Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө шилжүүлэх гэрээ нь үндсэн гэрээнээс хамаарал бүхий үүсмэл гэрээ байдаг тул үндсэн

үүргийн хугацааны асуудал хамгийн чухал байх нь мэдээж юм. Иймээс үүрэг гүйцэтгэгч үндсэн гэрээний үүрэг гүйцэтгэх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээний дагуу үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн хөдлөх эд хөрөнгөө буцааж авах эрхээ алдана.

Түүнчлэн "үүргийн гүйцэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээний дагуу шилжүүлсэн эд хөрөнгийг үүрэг хүлээгч ашиглах эрхтэй байхаар гэрээнд зааж болно" /Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/ гэсэн заалт практикт онцлог байдлаар хэрэгжинэ. Уг эд хөрөнгийг үүрэг гүйцэтгэгчид ашиглуулах эсэх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэл зоригоос хамаарах бөгөөд үүрэг гүйцэтгэгчийн тухайн эд хөрөнгийг ашиглах арга хэлбэрийн талаар тавьсан саналыг үүрэг гүйцэтгүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээний нөхцөл болгон заах ба ашиглуулах хэлбэрийн хувьд эд хөрөнгө хөлслөх, эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах, түрээслэх журмаар хэрэгжүүлж болох юм.



Захиргааны хэргийн шүүх: Харьцуулсан судалгаа



ХЗУТ-ийн ЭША
Н.ОТГОНЧИМЭГ

Монголчууд бид тун ойртож, дөхөж ирсэн зүйлээ "хаяанд ирсэн байна, хаалга тогшиж байна" гэгцгээдэг. Энэ үгийг захиргааны хэргийн шүүхийн хувьд одоо хэлбэл тун зохисон хэрэг болох биз. Захиргааны хэргийн шүүхийн талаар ярьж, бичиж буй зүйлд сүүлийн үед урьд урьдынхаас илүү анхаарал тавих болсныг судлаачийн хувьд ажигласныг бас өгүүлэх юун. Энэ мэт байдал нь захиргааны хэргийн шүүхийн харьцуулсан судалгаанд өөрийн хөрсөн дээрээс хандаж, дүгнэлт өгөх таатай нөхцөл бүрдүүлж байгаа юм.

Захиргааны хэргийн шүүхийн зохион байгуулалтын загвар

Захиргааны хэргийн шүүхийн зохион байгуулалтын үндсэн загварт:

1. Францын загвар;
2. Германы загвар;
3. Англи-саксоны загвар;
4. Ерөнхий хэргийн харьяалалтай шүүх дэх захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхий загвар багтдаг.

1. Францын загварын үндэс нь эрх мэдэл хуваарилах зарчим буюу хууль тогтоох гүйцэтгэх шүүх, эрх мэдлийн байгууллага бие биенийхээ хөрөгт хөндлөнгөөс үл оролцох зарчим байдаг. Эндээс гарах дүгнэлт гэвэл, нийтийн захиргааны актыг ердийн шүүх биш харин тусгайлан байгуулагдсан захиргааны трибунал буюу гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаа явуулах шүүх хянах ёстой байна. Францад захиргааны шүүх (трибунал) нь хоёр төрөлд хуваагддаг:

□ Хэргийн ерөнхий харьяалалтай захиргааны шүүх (трибунал);

□ Хэргийн онцгой харьяалалтай захиргааны шүүх (трибунал).

Тэдний зохион байгуулалт, үйл ажиллагааг Захиргааны

шүүх (трибунал)-ийн тухай 1973 оны хуулиар зохицуулдаг. Хэргийн ерөнхий харьяалалтай захиргааны шүүх нь 3 шаттай. Үүнд:

- Орон нутгийн шүүх (трибунал): Анхан шатны ийм шүүх 26 байдаг. Шүүх бүр тамгын газартай байхаас гадна харьяалагдах нутаг дэвсгэрийн нэгж бүрт орон нутгийн товчоотой, тэдгээр нь нэхэмжлэлийг хүлээн авах боломжтой байдаг*. Хэргийг танхимуудад хянан шийдвэрлэх бөгөөд орон нутгийн нэг шүүх 7 хүртэл танхимтай байдаг;

- Давж заалдах шатны 5 шүүх бий: Энэ шатны шүүх 1-3 танхимтай, хэрэг, маргааны дийлэнх хэсгийг харьяалан шийдвэрлэнэ;

- Төрийн зөвлөл. Төрийн зөвлөл 6 хэлтэсээс бүрдэх ба 4 хэлтэс нь Засгийн газарт зөвлөх, 1 нь мэдээллийн, харин нөгөө нь захиргааны маргаан таслах чиг үүрэгтэй. Захиргааны маргаан таслах хэлтэс 10 дэд хэлтэстэй. Маргааныг анхан, давж заалдах, хяналтын шатаар маргааныг хянан шийдвэрлэнэ. Тэгэхлээр Францад захиргааны хэргийн дээд шатны шүүх нь чухамдаа Төрийн зөвлөлийн Захиргааны маргаан таслах хэлтэс (section du contentieux) болох юм.

Захиргааны хэргийн ерөнхий харьяалалтай дээрх шүүхтэй зэрэгцэн хэргийн

*. Манай улсын хувьд аймагт захиргааны хэргийн анхан шатны зөвхөн нэг шүүх ажиллах бөгөөд энэ нь аймгийн төвөөс алслагдсан сумын оршин суугч нэхэмжлэл гаргахад борхшээл үүсгэх талтай. Францын загварын энэ жишээг өөрийн орнон олонцогт тохируулан хэрэглэх асуудлыг судалж үзэх нь зүйтэй.

онцгой харьяалал бүхий шүүх 50 шүүхтэй. Тэдний бүрэн эрх нь захиргааны тодорхой нэг салбарт үүссэн маргаан хянан шийдвэрлэх байдлаар хяз-гаарлагдсан байна. Жишээ нь: төсөв-санхүүгийн, сахилгын шүүх.

2. Германы загвар бүхий захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо нь дараахь үндсэн 2 зарчмаас үүдэлтэй.¹

• Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаанд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас саад болохоос сэргийлэх. Энэ нь захиргааны хэргийн шүүхийг шүүх эрх мэдлийн байгууллагын бүрэлдэхүүн байгуулахад хүргэсэн;

• Нийтийн ба хувийн ашиг сонирхлын илрэх хүрээг ангилан авч үзсэн нь захиргааны хэргийн шүүхийг ердийн шүүхээс бие даасан байдалтай байгуулах үндэс болсон.

Германы захиргааны хэргийн шүүхийг хэргийн харьяаллаар ерөнхий ба төрөлжсөн харьяалалтай гэж ангилж болно.

Хэргийн ерөнхий харьяалалтай захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааг "Захиргааны хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх тухай хууль" (1960 он)-аар зохицуулдаг. Захиргааны хэргийн шүүх нь гурван шаттай:

I. Мужийн захиргааны хэргийн шүүх (3=1+2);

II. Мужийн захиргааны хэргийн дээд шатны шүүх (5=3+2);

III. Холбооны захиргааны хэргийн шүүх (11 мэргэжлийн шүүгч).

Захиргааны хэргийн төрөлжсөн харьяалалтай

шүүхэд нийгмийн халамжийн, санхүүгийн, сахилгын (хөдөлмөрийн) хэргийн шүүхүүд хамаарна.²

Монгол Улсын захиргааны хэргийн шүүх нь шүүх эрх мэдлийн тогтолцоондоо багтаж байгаа гэдэг утгаараа германы загварт илүү дөхүү юм. (Эрх зүйн зохицуулалтын агуулга руу нарийвчлан орохгүйгээр өгүүлж байгаа нь энэ юм.) Дөхүү гэдгийн учир нь шүүхийн бүтэц, шүүх бүрэлдэхүүн, зохион байгуулалт, харьяалан шийдвэрлэх маргаан зэрэг зарчмын олон асуудлаар германы захиргааны хэргийн шүүхээс ялгаатай байгаа.

3. Англи-саксоны эрх зүйн тогтолцоотой улсын захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаа явуулдаг байгууллага нь зохион байгуулалт болон яам, ердийн шүүхтэй харилцах байдлаараа өвөрмөц ялгаатай. "Англи-саксоны улсууд захиргааны байгууллага өөрөө өөрсдийгээ шүүдэг францын загварт шүүмжлэлтэй хандаж, тэрхүү загварыг "өөрийн хэрэгт хэн ч шүүгч байж болохгүй" гэсэн шүүх ажиллагааны зарчимд харшилж байна гэж үзсэн юм"³. Гэвч 1930-аад оноос эхлэн Их Британид захиргааны хэргийн шүүн таслах байгууллагууд аяндаа бий болсон байна. 1970-аад оны үед ийм байгууллага 2000 орчимд (30 салбараар дагнасан) хүрсэн байв. Ийнхүү байгуулагдах болсон шалтгаанд:

- ердийн шүүхүүд ачаалал ихтэй болсон;
- ердийн шүүх дэх шүүхийн зардал өндөр;
- хугацаа их шаарддаг;
- харьяаллын бус болон техник ажиллагааны хувьд

бэрхшээлтэй гэсний үндсэн дээр ердийн шүүх хэргийг буцаах болсон.

Ийнгэхдээ шүүх маягийн байгууллагын давуу талыг зардал хямд, хугацаа богино, маргааныг хянан шийдвэрлэх арга зам нь хялбар гэдгээр тодорхойлдог. Тэдгээрийг комисс, зөвлөл, агентлаг, товчоо, трибунал гэх мэтээр нэрлэх нь бий.

Англи-саксоны улс дахь захиргааны хэргийн трибунал улс орны хэмжээний, бүс нутгийн, орон нутгийн байдлаар зохион байгуулагдсан нийтлэг шинжтэй. Тухайлан үзвэл, Их Британид трибуналыг 3 бүлэгт хуваадаг:

- улс орны хэмжээний: даатгалын үндэсний комисс, цагаачлалын давж заалдах трибунал;

- бүс нутгийн: газрын маргааны трибунал, татварын тусгай комисс, тээврийн трибунал;

- орон нутгийн: нутгийн удирдлагын байгууллагаас олгосон бүрэн эрхийг хэрэгжүүлдэг захиргааны трибунал; орон нутгийн даатгалын трибунал, орлогын албан татварын ерөнхий хороо г.м.

4. Ерөнхий харьяалалтай шүүх дэх захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. Ердийн шүүхийн хүрээнд иргэний хэрэг хянан шийдвэрлэх хэм хэмжээг хэрэглэн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд гаргасан гомдлыг хянан шийдвэрлэдэг. Энэ загвар Монгол Улсад 2004 оны 6 сарын 1 хүртэл хэрэгжих юм.

1.Ред. А.Н.Козырин, М.А.Шталина. Административное право зарубежных стран. М., Спарк. 2003 г. стр.194.

*.Шүүх нь танхимын зохион байгуулалттай бөгөөд нэг танхимд багтах 3 шүүгчийн 1 нь мэргэжлийн (хуульч) шүүгч, үлдэх хоёр нь олон нийтийн хүндэт шүүгч байна.

2.Ред. А.Я.Сухарев. Правовые системы стран мира. М., 2001 г. стр.168-174.

3.Ред. А.Н.Козырин, М.А.Шталина. Административное право зарубежных стран. М., Спарк. 2003г. стр.195.

онцгой харьяалал бүхий шүүх 50 шүүхтэй. Тэдний бүрэн эрх нь захиргааны готорхой нэг салбарт үүссэн маргаан хянан шийдвэрлэх байдлаар хяз- гаарлагдсан байна. Жишээ нь: төсөв- санхүүгийн, сахилгын шүүх.

2. Германы загвар бүхий захиргааны хэргийн шүүхийн тогтолцоо нь дараахь үндсэн 2 зарчмаас үүдэлтэй.¹

- Захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаанд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас саад болохоос сэргийлэх. Энэ нь захиргааны хэргийн шүүхийг шүүх эрх мэдлийн байгууллагын бүрэлдэхүүн байгуулахад хүргэсэн;

- Нийтийн ба хувийн ашиг сонирхлын илрэх хүрээг ангилан авч үзсэн нь захиргааны хэргийн шүүхийг ердийн шүүхээс бие даасан байдалтай байгуулах үндэс болсон.

Германы захиргааны хэргийн шүүхийг хэргийн харьяаллаар ерөнхий ба төрөлжсөн харьяалалтай гэж ангилж болно.

Хэргийн ерөнхий харьяалалтай захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааг “Захиргааны хэргийг шүүхээс хянан шийдвэрлэх тухай хууль” (1960 он)-аар зохицуулдаг. Захиргааны хэргийн шүүх нь гурван шаттай:

I. Мужийн захиргааны хэргийн шүүх (3=1+2);

II. Мужийн захиргааны хэргийн дээд шатны шүүх (5=3+2);

III. Холбооны захиргааны хэргийн шүүх (11 мэргэжлийн шүүгч).

Захиргааны хэргийн төрөлжсөн харьяалалтай

шүүхэд нийгмийн халамжийн, санхүүгийн, сахилгын (хөдөлмөрийн) хэргийн шүүхүүд хамаарна.²

Монгол Улсын захиргааны хэргийн шүүх нь шүүх эрх мэдлийн тогтолцоондоо багтаж байгаа гэдэг утгаараа германы загварт илүү дөхүү юм. (Эрх зүйн зохицуулалтын агуулга руу нарийвчлан орохгүйгээр өгүүлж байгаа нь энэ юм.) Дөхүү гэдгийн учир нь шүүхийн бүтэц, шүүх бүрэлдэхүүн, зохион байгуулалт, харьяалан шийдвэрлэх маргаан зэрэг зарчмын олон асуудлаар германы захиргааны хэргийн шүүхээс ялгаатай байгаа.

3. Англи-саксоны эрх зүйн тогтолцоотой улсын захиргааны хэргийн шүүн таслах ажиллагаа явуулдаг байгууллага нь зохион байгуулалт болон яам, ердийн шүүхтэй харилцах байдлаараа өвөрмөц ялгаатай. “Англи-саксоны улсууд захиргааны байгууллага өөрөө өөрсдийгээ шүүдэг францын загварт шүүмжлэлтэй хандаж, тэрхүү загварыг “өөрийн хэрэгт хэн ч шүүгч байж болохгүй” гэсэн шүүх ажиллагааны зарчимд харшилж байна гэж үзсэн юм”³.

Гэвч 1930-аад оноос эхлэн Их Британид захиргааны хэргийн шүүн таслах байгууллагууд аяндаа бий болсон байна. 1970-аад оны үед ийм байгууллага 2000 орчимд (30 салбараар дагнасан) хүрсэн байв. Ийнхүү байгуулагдах болсон шалтгаанд:

- ердийн шүүхүүд ачаалал ихтэй болсон;
- ердийн шүүх дэх шүүхийн зардал өндөр;
- хугацаа их шаарддаг;
- харьяаллын бус болон техник ажиллагааны хувьд

бэрхшээлтэй гэсний үндсэн дээр ердийн шүүх хэргийг буцаах болсон.

Ингэхдээ шүүх маягийн байгууллагын давуу талыг зардал хямд, хугацаа богино, маргааныг хянан шийдвэрлэх арга зам нь хялбар гэдгээр тодорхойлдог. Тэдгээрийг комисс, зөвлөл, агентлаг, товчоо, трибунал гэх мэтээр нэрлэх нь бий.

Англи-саксоны улс дахь захиргааны хэргийн трибунал улс орны хэмжээний, бүс нутгийн, орон нутгийн байдлаар зохион байгуулагдсан нийтлэг шинжтэй. Тухайлан үзвэл, Их Британид трибуналыг 3 бүлэгт хуваадаг:

- улс орны хэмжээний: даатгалын үндэсний комисс, цагаачлалын давж заалдах трибунал;

- бүс нутгийн: газрын маргааны трибунал, татварын тусгай комисс, тэврийн трибунал;

- орон нутгийн: нутгийн удирдлагын байгууллагаас олгосон бүрэн эрхийн хэрэгжүүлдэг захиргааны трибунал; орон нутгийн даатгалын трибунал, орлогын албан татварын ерөнхий хороо г.м.

4. Ерөнхий харьяалалтай шүүх дэх захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа. Ердийн шүүхийн хүрээнд иргэний хэрэг хянан шийдвэрлэх хэм хэмжээг хэрэглэн захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд гаргасан гомдлыг хянан шийдвэрлэдэг. Энэ загвар Монгол Улсад 2004 оны 6 сарын 1 хүртэл хэрэгжих юм.

1. Ред. А.Н.Козырин, М.А.Штагина. Административное право зарубежных стран. М., Спарк, 2003 г., стр.194.

* Шүүх нь танхимын зохион байгуулалттай бөгөөд нэг танхимд багтах 3 шүүгчийн 1 нь мэргэжлийн (хуульч) шүүгч, үлдэх хоёр нь олон нийтийн хүндэт шүүгч байна.

2. Ред. А.Я.Сухарев. Правовые системы стран мира. М., 2001 г., стр.168-174.

3. Ред. А.Н.Козырин, М.А.Штагина. Административное право зарубежных стран. М., Спарк, 2003г., стр.195.

нэхэмжлэлээ ямар хугацааны дотор гаргах ёстойг иргэдэд таниулан ойлгуулж байх нь зохих хугацаанд эрхээ хамгаалахад чухал нөлөөтэйг энд дурдах нь зүйтэй.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журмын тухай хууль 1962 онд батлагдахаас өмнө Японд үйлчилж байсан журмаар бол шүүхэд нэхэмжлэл гарган хандахдаа урьдчилж захиргааны байгууллагад гомдлоо гарган шийдвэрлэх ёстой байв. Энэ журмын гол зорилго нь шүүхийн ачааллыг хөнгөлөхөд оршиж байсан. Одоо энэ журам хүчингүй болсон боловч гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад гомдол гарган асуудлаа шийдвэрлүүлэх эрх нээлттэй, гагцхүү энэ нь шүүхэд нэхэмжлэл гарган хандах зайлшгүй нөхцөл болдоггүй.

Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар захиргааны хэргийн шүүхэд хандах урьдчилсан нөхцөлийн нэг нь урьдчилан хянан шийдвэрлэх ажиллагааг явуулсан байх шаардлага юм. (Энэ шаардлага харьяалах дээд шатны байгууллага байхгүй тохиолдолд хэрэгжижгүй байж болно.) Энэ нь шүүхэд хэт ачаалал үүсгэхгүй байх, захиргааны байгууллага алдаа гаргасан байвал өөрсдөө түүнийгээ засах боломж олгох утгаараа ашигтай зохицуулалт юм.

Гомдол гаргах тусгай журмыг 1999 онд батлагдсан Захиргааны байгууллагын мэдээллийг нийтлэх тухай хуулиар жишээлэн авч үзье. Захиргааны мэдээллийг дэлгэхтэй холбоотой шийдвэрт гомдлоо "Мэдээллийг нийтлэх асуудал эрхэлсэн Хяналт шалгалтын зөвлөлд гаргана" гэж хуулийн 18 дугаар зүйлд заажээ. Энэ Зөвлөл нь

Засгийн газрын танхимын Тамгын газрын дэргэд байх бөгөөд 9 гишүүнээс бүрдэнэ. Гомдлыг 3 эсвэл 9 гишүүний бүрэлдэхүүнтэй шийдвэрлэнэ.

Хяналт шалгалтын зөвлөл гомдлыг хянан шийдвэрлэхдээ мэдээллийн янз бүрийн эх сурвалжийг ашиглаж болдог. Үүнд: холбогдох захиргааны актыг эрх бүхий этгээдээс шаардан авах, акттай холбоотой тайлбар авах, гомдол гаргагч болон хэрэгт холбогдох бусад этгээдээс санал бодлыг авах бүрэн эрхтэй. Мөн гомдол гаргагч болон түүний төлөөлөгчид Хяналт шалгалтын Зөвлөлийн өмнө үг хэлэх боломж олгох эрхтэй юм, зөвлөл шийдвэрээ бичгээр гаргана. Хуулийн 36 дугаар зүйлд мэдээллийг дэлгэх талаар гаргасан захиргааны байгууллагын шийдвэрийг шүүхэд хандан давж заалдах эрхтэйг заасан. Шүүхэд нэхэмжлэлээр хандахын тулд Хяналт шалгалтын зөвлөлд заавал урьдчилан хандсан байх шаардлагагүй юм. Тухайн хэргийг Хяналт шалгалтын Зөвлөлд болон шүүхэд нэгэн зэрэг хэлэлцэж болдог.

Японы нийтийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих шүүхийн хяналт

Нийтийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд тавих шүүхийн хяналтын механизмийг Японд Дэлхийн II дайны дараа шинэчлэн байгуулсан юм. Үүнээс өмнө энэ улсад Мэйжийн Үндсэн хуулиар тогтоосон ром-германы процессын эрх зүйгээс эхтэй захиргааны шүүхийн тогтолцоо үйлчилж байв.

1947 оны Үндсэн хуулийн 76 дугаар зүйлд "Шүүх засаглал бүхэлдээ Дээд шүүх, мөн хуульд заасны дагуу байгуулагдах түүний доод шатны шүүхүүдэд хадгалагдана. Ямар нэгэн

онцгой шүүх байгуулахыг хориглоно. Захиргааны байгууллага эцсийн шийдвэрийг гаргах бүрэн эрхээрээ шүүх засаглалыг хэрэгжүүлэхгүй" гэж заасан юм.

Дайны дараах Японд гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаанд тавих шүүхийн хяналтын онол нь үндсэн хуульд ёс, эрх зүйт төр, легализм, эрх зүйн ноёрхол зэрэг эрх зүйн үзэл баримтлалын үндсэн шинж, агуулгыг тусган авсан байна. Профессор Сигүэки Суто "нийтийн захиргааны үйл ажиллагаанд тавих шүүхийн хяналтын онол нь эрх зүйн орчин үеийн янз бүрийн үзэл баримтлалын онолыг өөртөө шингээн тусгаснаар шинэ өнгө аястай болж байна. Өөрөөр хэлбэл, "үйл ажиллагаа нь хууль тогтоомжид тулгуурласан байх гүйцэтгэх эрх мэдлийн онол юм."¹ Хууль дээдлэх ёс бол энэ онолын нэг чухал элемент болох бөгөөд түүний дагуу хуультай зөрчилдсөн аливаа бүхэн анхнаасаа хүчин чадлаа алдах, эсвэл хүчингүй болох ёстой болно" гэж тэмдэглэжээ.

Удирдлагын хүрээнд үүссэн маргааныг ерөнхий харьяалалтай шүүхэд шилжүүлэх нь хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагааг үүсгэсэн байна.

1948 онд батлагдсан

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх журмын тухай хууль нь захиргааны хэргийг хянан шийдвэрлэхдээ иргэний процессын хэм хэмжээнд тулгуурлахыг зэрэгцээ тодорхой хэргийн онцлогтой холбогдсон зарим өвөрмөц журмыг тусгасан байв. Энэ хуулийг баталсны дараа тун удалгүй сонгосон загвар нь амьдрах чадвар муутай болох нь хардагд болсон байна. Ингээд 1962 онд Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх журмын

1. Япон дахь "хууль дээдлэх ёс": орчин үеийн асуудлууд. // Вест. Моск. ун-та Сер.11. Право. 1996. 54 дэх тал.

тухай шинэ хууль батлагджээ. Энэ хууль өнөөг хүртэл захиргааны хэрэг хянан шийдвэрлэх гол эх сурвалж болж байна.

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх журмын тухай хуульд зааснаар захиргааны байгууллагаас гаргасан актыг хүчингүй болгуулах нэхэмжлэл гарган шүүхэд хандах эрх бүхий этгээдийн хүрээг зөвхөн эрх нь зөрчигдсөн гэх этгээдээр хязгаарлаагүй байна. Ийм эрхтэй этгээдийн тоонд тухайн арга хэмжээг хүчингүй болгосноор “хууль ёсны ашиг, үр нөлөө” олж авах этгээд ордог. Орчин үеийн төрийн удирдлага олон хүний ашиг сонирхлыг хөндөх болсонтой холбогдож энэ зохицуулалт хийгджээ. Шүүхийн практикийн хувьд “хууль ёсны ашиг, үр нөлөө” хүртэх этгээдийн хүрээг өргөжүүлэх байдлаар өрнөж байна.¹ Тухайлбал, орон нутгийн зарим шүүх автобусанд зорчих тасалбарын үнийг нэмэгдүүлэхийг захиргааны байгууллагад зөвшөөрсөн шийдвэрийн талаарх нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэжээ нэхэмжлэл гаргах эрхтэй этгээдэд автобусны чиглэл дагуу амьдрах иргэдийг хүлээн зөвшөөрч байна.

Захиргааны маргаантай холбоотой 4 төрлийн нэхэмжлэлийг гаргаж болохоор хуульчилжээ. (Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх журмын тухай хуулийн 2 дугаар зүйл.)

- 1) “кококу” нэхэмжлэл;
- 2) “тоджиша” нэхэмжлэл;
- 3) actio popularis;
- 4) байгууллага ба газруудын хоорондын маргаантай холбоотой нэхэмжлэл.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай Монгол Улсын хуульд нэхэмжлэлийг хүрэх зорилго буюу тавьж буй шаардлагаар ангилсан байх бөгөөд Японы хувьд хүрэх зорилгоос гадна нэхэмжлэлийг гаргах эрхтэй субъектээр нь ийнхүү ангилж байна.

Японы захиргааны эрх зүйн онолд эхний хоёр нэхэмжлэлийг эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үндсэн зорилготой субъектив нэхэмжлэл гэж нэрлэдэг. Дараагийн 2 нь объектив нэхэмжлэл буюу хуульчлан тогтоосон хэм хэмжээг биелүүлэх зорилготой байна. Объектив нэхэмжлэлийг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд хүлээн авч шийдвэрлэнэ.

“Кококу” нэхэмжлэлд дараах төрлийн нэхэмжлэл багтана:

- тогтоол, заавар, тушаалыг хүчингүй болгох;

- захиргааны актыг илт хууль бус гэж үзэн хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрөх;

- **З а х и р г а а н ы** байгууллагын эс үйлдэхүйг хууль бус гэж хүлээн зөвшөөрөх.

Тогтоол, заавар, тушаалыг хүчингүй болгох нэхэмжлэлийг тухайн акт гарсан өдрөөс хойш 3 сарын дотор гаргаж болно.

“Тоджиша” нэхэмжлэлийг талуудын хооронд нийтийн эрх зүйн үндсэн дээр үүссэн маргаантай холбогдуулж гаргана. Энэ шинж нь түүнийг иргэний эрх зүйн нэхэмжлэлээс ялгаж байдаг. (Жишээ нь, нийгмийн тустай ажил хийх, төрийн болон хувийн өмчийн газрын хилийн заагтай холбоотой маргаан гэх мэт.)

Ард нийтийн нэхэмжлэл (actio popularis)-ийг зөвхөн хуульд заасан

тохиолдолд гаргаж болно. Энэ нэхэмжлэл нь захиргааны хууль бус актыг өөрчлөх тухай нэхэмжлэлийг эрх зүйн хувьд түүнд шууд холбогдолгүй этгээд гаргахад яригддаг. Сонгуулийн тухай хуулийн 203, 204, 207, 208 дугаар зүйлд зааснаар захиргаа сонгуулийн журмыг зөрчсөн тухай нэхэмжлэлийг сонгогч шүүхэд гаргаж болно.

Байгууллага ба газруудын хоорондын маргаантай холбоотой нэхэмжлэлийн жишээ: Нутгийн удирдлагын тухай хуульд (176 дугаар зүйл) зааснаар префект (хотын захирагч ба ахлагч) ба тухайн төвшний нутгийн иргэдийн хурлын хооронд үүссэн маргаан болох юм.

Захиргааны хэргийг хянан шийдвэрлэх журмын тухай хуульд захиргааны байгууллагыг хариуцагчаар тодорхойлсон хэдий ч захиргааны шийдвэрийн биелэлтийг зогсоох нэхэмжлэл үндэслэлтэй байсан хэдий ч актын биелэлтийг зогсоох нь нийтийн ашиг сонирхолд ноцтой нөлөөлөх, эсвэл аюул учруулах бол шүүх нэхэмжлэлийг хангахаас татгалзах бүрэн эрхтэйг заажээ. Түүнчлэн захиргааны шийдвэрийн биелэлтийг зогсоох шүүхийн шийдвэрт Ерөнхий сайд эсэргүүцэл гаргавал шүүх шийдвэрээ хүчингүй болгох үүргийг хуульчилсан байна.

Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн шийдвэр нь тухайн асуудлаар эцсийн байх бөгөөд аль нэгэн албан тушаалтны эсэргүүцэл, татгалзал нь шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох шууд үндэслэл болохгүйгээр ялгаатай.



Шүүгчийн ёс зүйн байдлын судалгаа

ШУА-философи социологи эрх зүйн хүрээлэн,
Хууль зүйн судалгааны төв ЭША Д.ЗОЛЗАЯА

Хууль зүйн үндэсний төвөөс ШУА, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүйн судалгааны төв, Нийслэлийн шүүхтэй хамтран Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн хөтөлбөрийн санхүүжилтээр шүүхийн шүүгчийн ёс зүйн байдлыг судлах төслийг 2004 оны 4 дүгээр сарын 1-нээс 5 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлсэн юм.

Монгол Улсад шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг төлөвшүүлэх, шүүх эрх мэдлийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх нэг нөхцөл нь шүүгчдээс ёс зүйн хэм хэмжээгээ сахиж явдал билээ. Энэ асуудлаар өмнө нь бие даасан иж бүрэн судалгаа хийгдээгүй тул шүүгчийн ёс зүйн өнөөгийн байдал бодит дүгнэлт хийж, ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох талаар санал боловсруулахад энэхүү судалгаа ач холбогдолтой байлаа.

Төслөөр дараах зорилтыг тавьсан:

1. Шүүгчийн ёс зүйн дүрэм болон энэ асуудлын хүрээнд гарсан бусад актад дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох талаар санал бэлтгэх;

2. Шүүгчээс ёс зүйн хэм хэмжээгээ сахиж буй байдал, Сахилгын хорооноос шүүгчийн ёс зүйн зөрчилтэй холбогдсон гомдол, хүсэлтийг хянан

шийдвэрлэсэн байдлыг судлаж дүгнэлт хийх.

Нэгдүгээр зорилтын хүрээнд шүүгчийн ёс зүйн дүрмийн ойлгомжгүй, тодорхойгүй, хэрэгжүүлэх боломжгүй заалтыг илрүүлэх, бусад орны шүүгчийн ёс зүйн дүрэм болон өөрийн орны бусад хуульчдын мэргэжлийн дүрмээс одоогийн дүрэмд тусгах боломжтой заалтыг илрүүлэх; хоёрдугаар зорилтын хүрээнд шүүгчийн ёс зүйн хамгийн түгээмэл зөрчлийг илрүүлэх, хот, хөдөөгийн шүүгчдийн ёс зүйн зөрчлийн ялгаатай болон нийтлэг талыг судлахад анхаарлаа хандуулсан юм.

Нэг. Монгол Улсын шүүхийн шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсронгуй болгох талаар

Монгол Улсын Үндсэн хуульд "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана", "... шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй" гэж заасан нь шүүгчийн ёс зүйн үндсэн шаардлагын эрх зүйн тулгуур болдог. Мөн Шүүхийн тухай хуульд "...шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана. ...ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ" гэж заасан байдаг.

Монгол Улсын шүүхийн Шүүгчийн ёс зүйн дүрэм /цаашид "Дүрэм" гэх/ нь Шүүгчдийн зөвлөлийн 2003 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд 4 бүлэг, 20 зүйлтэй. Уг дүрэмд шүүгчийн мөрдөх ёс зүй, зан үйлийг тогтоон хэвшүүлэх, бие даасан, хараат бус, шударга шүүх эрх мэдлийг төлөвшүүлэн бэхжүүлэх, хамгаалах зорилго дэвшүүлсэн байна. Дүрмийн:

- Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэл;
- Хоёрдугаар бүлэгт шүүгчийн биеэ авч явах ёс зүй;
- Гуравдугаар бүлэгт шүүгчийн мэргэжлийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд тавигдах ёс зүйн шаардлага;
- Дөрөвдүгээр бүлэгт шүүгчийн шүүн таслах ажиллагаанаас бусад үйл ажиллагаанд тавигдах ёс зүйн шаардлагыг тус тус тогтоожээ.

Дээрх зорилтын хүрээнд шүүгчийн ёс зүйн дүрмийн ойлгомжгүй, тодорхойгүй, хэрэгжүүлэх боломжгүй заалтыг илрүүлэх зорилгоор бүх шатны шүүхийн шүүгч, прокурор болон өмгөөлөгч, нотариатчдын дунд социологийн судалгаа явуулав. Мөн шүүгчийн ёс зүйн эх сурвалжийг задлан шинжилж, шүүгчийн ёс зүйн дүрмийг а/ өөрийн орны бусад хуульчид /прокурор, өмгөөлөгч, нотариатч/-ын ёс зүйн дүрэмтэй; б/ АНУ, ОХУ, Франц, Япон зэрэг улсын ёс зүйн хэм

хэмжээтэй тус тус харьцуулан судаллаа.

Шүүгчийн ёс зүйн дүрэм нь мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээний хувьд заавал биелэгдэх, зөрчөөс хариуцлага хүлээлгэх тул түүнийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн байнга өөрчилж шинэчилж байх нь зүйтэй юм.

Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухайд

Хуульчид/шүүгч, прокурор, өмгөөлөгч/-ын дунд явуулсан санал асуулга болон олон улсын баримт бичиг, гадаадын орны туршлагатай харьцуулсан судалгааг үндэслэн шүүгчийн ёс зүйн дүрэмд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

1. Дүрэмд ёс зүй болон холбогдох бусад нэр томъёог тодорхойлох;

2. Шүүгчийн ёс зүйн дүрмийг уншихад гадаад улсын ёс зүйн дүрмийн орчуулга мэт зэтгэгдэл төрж байгаа бөгөөд ойлгомж, найруулга муутай болсныг сайжруулах;

3. Х а р и у ц л а г ы г ялгавартай тогтоох; Жишээ нь, Ажлын цагаар, ажлын байранд архиан согтуурах явдлыг бусад үеэр архиан согтуурах явдлаас зааглаж хариуцлагыг ялгавартай тогтоох.

4. Гарч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс дүрэмд шинэ заалт нэмэх; Жишээ нь, Шүүгч өөртэйгөө хэт дотноссон харьцаанд оруулахаар өмгөөлөгч, прокурор, зохигчийг өдөөн хатгахгүй байх тухай, ажил үүргээ цалгардуулж бусдыг удаан хугацаанд чирэгдүүлсэн бол хариуцлага хүлээх, мэргэжлийн алдаанаас үүдсэн гэм хорыг арилгах, бусдын нөлөөнд автахгүй байх гэх мэт.

Ойлгомжгүй, хэрэгжих боломжгүй заалтын тухайд

Дүрмийн 7.1-д "Шүүгч бүр олон нийтийн анхаарлын төвд, байнгын хараа хяналтад байгаа

гэдгээ ухамсарлан жирийн иргэдийн хувьд хязгаарладаггүй ч, шүүгчийн хувьд мөрдвөл зохих зарим эрхийн хязгаарлалтыг сахин биелүүлэх үүрэгтэй." гэж заасныг судалгаанд оролцсон шүүгчдийн 17.5% нь ойлгомжгүй гэж тодорхойлсон байхад 2.5% нь бүр хасах санал тавьжээ. Энэ нь шүүгч ажилдаа болон хувийн амьдралдаа шүүгчийн ёс зүйг сахих үүрэгтэйг тайлбарласан сургалт явуулах хэрэгцээ байгааг харуулж байна.

- Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд оролцохгүй байх үндэслэл (7.2.2), хэргийн оролцогчид, тэдгээрийн өмгөөлөгч, найз нөхөд, садан төрлийн хүмүүстэй хувийн харьцаанд орохгүй байх (7.2.3), хувийн аливаа үйл ажиллагаандаа шүүх, шүүгчийн нэр хүндийг ашиглахгүй байх (7.2.4), их дээд сургууль, коллежийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орохыг хориглох (13.1.3), шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгохоос бусад асуудлаар байгуулсан аливаа хороо, комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцохыг хориглох (13.1.4) заалтууд нь хүн ам цөөтэй орон нутгийн хувьд хэрэгжихэд хүндрэлтэй байж болох талтай боловч социологийн судалгаанд оролцсон шүүгчдийн 80% нь хэрэгжих боломжтой гэж үзсэн байна. Харин найз нөхөд (сургууль хамт төгссөн хүнийг энд хамруулах уу), садан төрлийн хүмүүс гэдэгт хэнийг хамруулах, хувийн харьцаа гэдэгт юуг ойлгох нь тодорхойгүй байна.

- Шүүгч улс төрийн үйл ажиллагаанд оролцож ажлаас чөлөөлөгдсөний дараа дахин шүүгч болохын тулд шүүгчийн сонгон шалгаруулалтад орно (18.2) гэсэн заалтыг санал асуулгад оролцогчдын 7.5% нь,

Бие хамгаалах тусгай хэрэгсэл ашиглах журам зөрчих (19), Шүүгчийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдэх (20) заалтыг 2.5% нь хасах нь зүйтэй гэж үзжээ.

- Дүрэмд эсрэг утгаар ойлгогдохоор туегагдсан заалтууд цөөнгүй байгааг залруулах, тухайлбал: 6 дугаар зүйлийн тайдбар, 7.2.1, 7.2.5, 13.1.2, 14.1.3 заалтыг эргэж хянах шаардлагатай юм.

Хоёр. Шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж буй байдал

Энэ хүрээнд шүүгчийн ёс зүйтэй холбоотой сонин, хэвлэлийн нийтлэлийг түүвэрлэж дүн шинжилгээ хийх, иргэд, хуульчдын дунд социологийн судалгаа явуулах, сахилгын хорооноос шүүгчийн ёс зүйтэй холбоотой гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэсэн байдлыг судлах зэрэг ажлыг хийсэн юм.

Шүүгчийн ёс зүйн хамгийн нийтлэг зөрчлийг илрүүлэх

Шүүгчдийн дунд гардаг нийтлэг зөрчлийг илрүүлэх зорилгоор төслийн баг хэд хэдэн чиглэлээр судалгаа хийлээ.

Сүүлийн 3 жилийн хугацаанд Өдрийн сонин, Өнөөдөр, Монголын мэдээ, Зууны мэдээ, Үнэн зэрэг өдөр тутмын сонинд шүүгчийн ёс зүй, шүүхийн ажил байдлын талаар гарсан бүх нийтлэл, мэдээ баримтыг түүвэрлэж, дүн шинжилгээ хийгээд хамгийн нийтлэг дараах зөрчлийг илрүүдэв:

- харилцааны соёл хэт доогуур;
- маргагч талууд болон шүүх хуралдаанд оролцогчидтой хувийн харьцаа тогтоодог;
- эд материалын болон хувийн нөлөөнд автамтгай;
- шүүх хуралдаанд хайхрамжгүй ханддаг;
- хүнд сурталтай;
- архинд дуртай.

Шүүгчдийн дунд гардаг нийтлэг зөрчлийн талаарх социологийн судалгаанд оролцогчдын санаа бодлыг харьцуулан хүснэгтээр илэрхийлье.

№	Судалгааны асуулт	Шүүгч	Хуульч	Иргэд
1	Хүнд суртал, чирэгдүүлэлт	66,8%	36,9%	43,9%
2	Гар хардаг, дайллага, урилгаас татгалздаггүй	13,5%	16,0%	29,3%
3	Тал тохой татдаг	11,1%	15,7%	0,6%
4	Харилцааны соёл муу	88,5%	31,5%	26,2%

Шүүгчдийн дунд хүнд суртал чирэгдүүлэлт, харилцааны соёл муу зэрэг зөрчил хамгийн түгээмэл байдаг болохыг судалгаанд оролцогчид бүгд санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн байна.

Иргэдийн дунд явуулсан социологийн судалгаанд оролцогчид /шүүхээр хэрэг маргаан шийдвэрлүүлж байсан/-ын 23.4% нь шүүгч хатуу ширүүн харьцаатай байсан, 17.2% нь буруутгаж гэмт хэрэгтэнтэй адил үзсэн, 31.3% нь үл тоомсорлож хайхрамжгүй хандсан гэсэн дүгнэлтэд хүрсэн бол зөвхөн 0.7% нь ёс журмын дагуу зөв харьцсан гэж хариулжээ.

АНУ-ын шүүгчийн ёс зүйн загвар дүрэм, ОХУ-ын шүүгчийн ёс зүйн дүрэмд бусадтай харилцахдаа эн тэргүүнд төвчээртэй, эелдэг байхыг шүүгчээс шаарддаг байна.

Сахилгын хорооноос шүүгчийн ёс зүйтэй холбоотой гомдол, хүсэлтийг хянан шийдвэрлэсэн байдал

Тус судалгаанд 1992 оны Үндсэн хууль батлагдсанаас хойшхи хугацааг хамруулсан бөгөөд энэ хугацаанд улсын хэмжээнд нийт 292 шүүгчид сахилгын хэрэг үүсгэснээс 77 хэргийг хэрэгсэхгүй болгож, 215 шүүгчид арга хэмжээ авсан байна. 2003 оноос мөрдөгдөж байгаа ёс зүйн дүрмийн дагуу сахилгын хэрэг үүсгэсэн үндэслэлийг нь авч үзвэл 12.9% нь холбогдох хууль зөрчсөн, 3.2% нь зохисгүй байдал гаргасан, 25.8% нь биеэ авч явах байдлыг зөрчсөн, 16.1% нь шүүн таслах ажиллагаанд тавигдах шаардлага хангаагүй, 16.1% нь хэргийн оролцогчидтой зохистой харилцаагүй, 25.8% нь хэрэг маргааныг хуулийн хугацаанд

шийдвэрлээгүй байна. Энэ судалгаа нь иргэд, хуульчдаас авсан социологийн судалгааны дүнгээр илэрсэн түгээмэл зөрчлийг давхар нотолж байгаа юм.

Сахилгын хорооноос дээр дурдсан зөрчлийн 25.8 хувьд нь сануулах, 9.7 хувьд нь зэрэг дэв бууруулах, 25.8 хувьд нь огцруулах санал гаргаж шийдвэрлэжээ.

Иргэдээс “Шүүгчээс ёс зүйгээ зөрчих явдалтай та тулгардаг уу?” гэсэн асуултад 77.5% нь байнга буюу заримдаа тулгардаг, 22.5% нь огт тулгардаггүй гэжээ. Дээрх 77.5 хувийг эзэлсэн “Та амар арга хэмжээ авсан бэ?” гэж асуухад 47.1% нь дуугүй өнгөрсөн, 38.0% нь өөрт нь, 3.3% нь Сахилгын хороонд, 11.7% нь Ерөнхий шүүгчид нь хандсан гэжээ. Үүнээс үзэхэд шүүгчийн ёс зүйн зөрчил ихэнхдээ хариуцлагын гадна үлддэг байж болзошгүй, прокурор, өмгөөлөгч нар ч хуулинд заасны дагуу зөрчлийг шийдвэрлүүлэх арга хэмжээ авах санаачилга төдийлөн гаргадаггүй гэхээр байна.

Харин “Та шүүгчийн ёс зүйн талаар хаана хандах вэ?” гэсэн асуултад судалгаанд хамрагдсан иргэдийн 8.9% нь Ерөнхийлөгчид, 27.5% нь Дээд шүүхэд, 42.5% нь Шүүхийн сахилгын хороонд, 21.0% нь хаана хандахаа мэдэхгүй гэж хариулснаас үзэхэд энэ талаарх иргэдийн мэдлэг хангалтгүй гэж хэлж болохоор байна.

Судалгааны эцэст төслийн баг дараах дүгнэлтэд хүлээ. Үүнд:

1. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, иргэдийн дунд явуулсан социологийн судалгааны дүнгээс үзэхэд

ерөнхийдөө “Шүүгчийн ёс зүйн дүрэм”-ийн талаарх тэдний мэдлэг хангалтгүй байгаа нь харгадлаа. Иймд уг дүрмийг сурталчлах, энэ талаар сургалт зохион байгуулах шаардлагатай юм.

2. Дүрэмд ойлгомжгүй, тодорхой бус зүйл заалтууд нэлээд байгаа учраас судалгаагаар илэрсэн нийтлэг зөрчил, бусад улсын баримт бичиг, туршлагыг харгалзан өөрийн орны өвөрмөц онцлогт нийцүүлэн өөрчлөх нь зүйтэй.

3. Шүүгчийн ёс зүйн түгээмэл зөрчил нь хүнд суртал, чирэгдүүлэлт, харилцааны соёл муу, авилгалд автсан байдалтай холбоотой байна. Иймд цаашид эдгээрээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар бодлого боловсруулж, хэрэгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

4. Шүүхийн нэр хүнд иргэдийн дунд харьцангуй өндөр байгаа нь судалгаанд оролцогчдын 54.2% нь шүүхэд хүндэтгэлтэй ханддаг гэж хариулснаас харгагдаж байхад судалгаанд хамрагдсан шүүгчдийн зөвхөн 17.7%, хуульчдын 9.9% нь шүүгчийн нэр хүндийг сайн гэж үнэлсэн нь сонирхол татаж байгаа юм.

5. Хот, хөдөөгийн шүүгчдийн ёс зүйн хандлагад онцны ялгаа ажиглагдаагүй болно.



МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНД ТАВИХ ПРОКУРОРЫН ХЯНАЛТЫН ЧИГ ҮҮРЭГ, БҮРЭН ЭРХ

Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрүүгийн хэргийн мөрдөн байцаах ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих нь прокурорын байгууллагын үндсэн чиг үүргийн нэг юм.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны гол зорилт болох гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох нь мөрдөн байцаах байгууллагын үүрэг бөгөөд прокуророос энэхүү ажиллагаанд тавих хяналт нь мөрдөн байцаалтын явцад хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хууль бусаар хязгаарлах явдлыг гаргуулахгүй байхад чиглэгдэнэ.

Эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хуулийн байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн үндэс болсон Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэргийг шүүхэд янан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2002 онд шинэчлэгдэн батлагдсанаар байцаан шийтгэх ажиллагаанд оролцох прокурорын эрх



УЕП-ын туслах, мөрдөн байцаах ажиллагаанд тавих хэлтсийн дарга Т.СҮХБААТАР

хэмжээ өргөжиж, шинэ чиг үүрэг нэмэгдсэн нь голлон эрүүгийн хэргийн талаар шүүхийн өмнөх шатанд прокурор хууль зүйн үндэслэл бүхий шийдвэр гаргадаг болсонтой холбоотой юм. Эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд прокуророос тавих хяналт нь прокурорын байгууллагын үндсэн чиг үүрэгт ажлын хамгийн гол, нэн хариуцлагатай үйл ажиллагаа тул мөрдөн байцаах ажиллагаанд прокуророос тавих хяналтын чиг үүрэг, бүрэн эрхийг онол, арга зүйн хувьд нарийвчлан ойлгож, хэрэгжүүлж ажиллах нь чухал ач холбогдолтой юм.

Мөрдөн байцаах ажиллагаанд прокуророос тавих хяналтын үндсэн чиглэл

Монгол Улсын шинээр батлагдсан Прокурорын

байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу прокурор эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын дараах ажиллагаанд хяналт тавина. Үүнд:

- Мөрдөн байцаах байгууллагад ирсэн гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;

- Мөрдөн байцаалтын ажиллагаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

- Мөрдөн байцаалтын ажиллагаанд Эрүүгийн хуулийг зөв хэрэглэж байгаа эсэх;

- Сэжигтнийг баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ болон байцаан шийтгэх албадлагын бусад арга хэмжээний хууль зүйн үндэслэлийг хянах;

- Сэжигтнийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, журамд нийцэж байгаа эсэхэд тус тус хяналт тавина.

Өмнө нь мөрдөгдөж байсан Прокурорын байгууллагын тухай хуульд заасан мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналтын чиг үүрэгтэй харьцуулахад шинээр батлагдан мөрдөгдөж

буй Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулиар прокуророос мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хяналтын чиг үүрэгт:

- Мөрдөн байцаалт явуулах байгууллагад ирсэн гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;

- Албадлагын бусад арга хэмжээний хууль зүйн үндэслэлийг хянах гэсэн хоёр шинэ чиг үүрэг нэмэгдсэн байна. Эдгээр чиг үүрэг нь эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бие даасан үе шат болон хуульчлагдсаны гадна албадлагын арга хэмжээг прокурорын зөвшөөрлөөр авч хэрэгжүүлэх болсонтой холбоотой юм.

Прокурор эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавихдаа Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын байгууллагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан дараах зарчим хэрэгжиж буйд хяналт тавина. Үүнд:

- Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх;

- Гадны нөлөөнд үл автах;
- Хуулийг нэг мөр хэрэглэх;

- Прокурорын хяналт тасралтгүй, идэвхтэй байх;

- Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангах;

- Иргэний орон байрны халдашгүй байдлыг хангах;

- Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууцыг хамгаалах;

- Гэм буруугийд тооцох;

- Хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор тогтоох;

- Сэжигтэн, яллагдагч, хохирогчийн өмгөөлүүлэх эрхийг хангах зарчим хамаарах бөгөөд эдгээр зарчим мөрдөн байцаалтын явцад болон прокурорын хяналтын шатанд хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах талаар хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Хоёр. Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих прокурорын бүрэн эрх

Прокурор эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавихдаа Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 12.2, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193.1-д заасан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгаж, шийдвэрлэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих эрхтэй.

Мөрдөн байцаах албаны дарга, мөрдөн байцаагч гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг Эрүүгийн, байцаан шийтгэх хуулийн зүйл 170.1 –т заасны дагуу заавал хүлээж авах үүрэгтэй бөгөөд тухайн хүлээн авсан гомдол, мэдээллийг 5 хоногт багтаан хянаж эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Нэмэлт тайлбар, бичиг баримт, бусад материал гаргуулж авах, хэргийн газарт үзлэг хийх шаардлагатай бол дээрх хугацааг мөрдөн байцаах албаны дарга 14 хүртэл хоногоор сунгаж болно. Мөрдөн байцаагч гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэл хүлээж аваад Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172.1.1-172.1.3-т заасан шийдвэрийн аль нэгийг

гаргаж байгаа эсэхэд прокурор хяналт тавина. Мөрдөн байцаагч гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг шалгах явцад эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэхийн тулд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172.3-т заасан х о й ш д у у л ш г ү й ажиллагаануудыг хийж байгаа эсэхэд прокурор нэгэн адил хяналт тавина. Прокурор гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгах ажиллагаанд хяналт тавихдаа бүртгэлээр хяналт тавина. Монгол Улсын Ерөнхий прокурорын 2002 оны 260 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд прокуророос тавих хяналтын ажилд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан заавар”-ын 11 -г заасны дагуу Мөрдөн байцаах албаны хүлээн авсан гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэлтэй прокурор өдөр бүр танилцаж, бүртгэлд тусгаж, хяналтдаа авна. Мөрдөн байцаах албаны хүлээн авсан гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийн шийдвэрлэлтэд прокурор хяналт тавьж энэ тухай мэдээ тайланг тогтоосон хугацаанд гаргаж, Улсын Ерөнхий прокурорын газарт ирүүлнэ.

Мөрдөн байцаах алба гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хэрхэн хүлээн авч, бүртгэн шалган шийдвэрлэж байгаа, энэ үйл ажиллагаанд хуулийн заалтыг хэрхэн хангаж байгааг харьяа прокурорын газрууд зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах эрхтэй.

2. Эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих эрхтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 166 дугаар зүйлд заасан үндэслэл байвал мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж энэ тухай тогтоол гаргаж, тогтоолыг 72 цагийн дотор прокурорт танилцуулах бөгөөд тогтоолыг хүлээн авсан тэр үеэс эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэхэд прокурор хяналт тавина. Мөрдөн байцаагч хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн бол прокурор хэргийн материалтай танилцсаны эцэст эрүүгийн хэргийн дугаар олгож, тухайн хэргийг нэгдсэн бүртгэлд бүртгэн авч мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавина.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2002 оны 223 дугаар тушаалаар “Эрүүгийн хэргийг бүртгэх дугаар олгох заавар”-ыг баталж гаргасан бөгөөд энэхүү зааврыг харьяа прокурорын газрууд хэрэгжүүлж ажилладаг. Мөрдөн байцаагч хуульд заасан үндэслэл, баримтгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэсэн бол прокурор эрүүгийн хэрэг үүсгэсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгох, хэрэв эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдсэн бол хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлд заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, энэ тухай тогтоол гаргана. Мөрдөн байцаагч гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэл хүлээж аваад эрүүгийн хэрэг үүсгэх хуульд заасан үндэслэл байхгүй, эсвэл байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй нөхцөл байдал тогтоогдсон бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 175 дугаар зүйлийн 175.2-т заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай саналаа бичгээр гаргаж

хэргийн материалын хамт 3 хоногийн дотор прокурорт ирүүлнэ. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах талаар мөрдөн байцаагчаас тавьсан санал үндэслэлтэй бол прокурор энэ тухай тогтоол гаргана. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг гомдол, мэдээлэл гаргагч эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт гомдол гаргах эрхтэй. Ийнхүү эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаанд прокуророос тавих хяналтыг хэрэгжүүлэх журмыг Улсын Ерөнхий прокурорын 2002 оны 260 дугаар тушаалаар баталсан аргачилсан зааварт тодорхой заажээ.

3. Мөрдөн байцаалтын ажиллагаанд биеллэн оролцох, хэргийн материалтай танилцах, хэргийг хянах, байцаан шийтгэх тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр даалгавар бичих эрхтэй

Прокурор мөрдөн байцаах ажиллагаанд биеллэн оролцох, хэргийн материалтай танилцах, хэргийг хянах, байцаан шийтгэх тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр даалгавар бичих нь прокурорын хяналт тасралтгүй, идэвхтэй байх зарчим хэрэгжих гол нөхцөл юм. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 127 дугаар зүйлийн 127.2-т заасны дагуу онц хүнд гэмт хэргийн хэргийн газрын үзлэгт прокурор заавал оролцоно.

Түүнчлэн прокурор шаардлагатай гэж үзсэн хэргийн газрын үзлэгт өөрийн санаачилгаар эсвэл мөрдөн байцаагчийн хүсэлтээр оролцох эрхтэй. Прокурор өөрийн санаачилгаар буюу мөрдөн байцаагчийн хүсэлтээр үзлэг нэгжлэг хийх, хэрэгт ач холбогдолтой эд зүйл, бичиг баримт хураан авах, хөрөнгө бүтээмжлэх зэрэг ажиллагаанд оролцоно. Улсын Ерөнхий

прокурорын 2002 оны 260 дугаар тушаалаар баталсан аргачилсан зааврын 28 дугаар зүйлд “Мөрдөн байцаагч мөрдөн байцаалтын явцад нүүрэлдүүлэн байцаах, таньж олуулах, мэдүүлгийг газар дээр нь шалгах, шинжээчид асуулт тавих, туршидт хийх зэрэг шийдвэр гаргасан тохиолдолд прокурор эдгээр байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхтэй”-г заажээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 139 дүгээр зүйлд заасны дагуу дипломат төлөөлөгчийн албан болон орон байранд нэгжлэг хийх, хураан авах ажиллагаанд зөвшөөрөл өгөх эсэх асуудлыг зөвхөн Улсын Ерөнхий прокурорын газар хянаж шийдвэрлэнэ. Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, шүүгч, прокурор зэрэг тусгай субьектын албан тасалгаа, орон байранд нэгжлэг хийхэд прокурор заавал оролцоно.

Прокурор мөрдөн байцаалтын ажиллагаанд биеллэн оролцох нь тухайн байцаан шийтгэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхийг шууд хянах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Байцаан шийтгэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэхийг хянахын тулд прокурор өөрийн санаачилга болон мөрдөн байцаагчийн хүсэлтээр хэргийн материалтай танилцах эрхтэй. Хэргийн материалтай прокурор ийнхүү танилцах, мөрдөн байцаалтыг шуурхай, бүрэн гүйцэд, бүх талаас нь, бодитой явуулах талаар мөрдөн байцаагчид даалгавар өгч, хэрэгт цугларсан цагаатгах болон ялах нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлж тухайн эрүүгийн хэргийн

талаар зохих шийдвэр гаргана. Хэргийн сэжигтэн, яллагдагч болон байцаан шийтгэх ажиллагааны бусад оролцогчдын санал хүсэлт, өргөдөл, гомдлыг үндэслэн прокурор хэргийн материалыг уншиж хянан, мөрдөн байцаалтыг шуурхай явуулах, хуулийн заалт зөрчсөн зөрчлийг арилгуулах талаар холбогдох арга хэмжээ авна. Мөрдөн байцаалтын ажиллагаанд хуулийн заалтыг хангуулах, хуулийг зөв хэрэглэх, зайлшгүй ажиллагааг цаг тухайд нь бүрэн, бодитой явуулах зорилгоор прокурор мөрдөн байцаагчид даалгавар бичнэ. Прокурорын даалгавар нь Прокурорын байгууллагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн шаардлага хангасан, хугацаа тогтоосон, бичгэн хэлбэртэй байна. Прокурор өөрийн болон дээд шатны прокурорын бичсэн даалгаврын биелэлтэд хяналт тавьж, даалгаврын заалтыг хангуулах арга хэмжээ авна.

4. Мөрдөн байцаалтын явцад байцаан шийтгэх зарим ажиллагаа явуулахад прокурор зөвшөөрөл өгөх эрхтэй.

Мөрдөн байцаалтын явцад хүний эрх, эрх чөлөө, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн ажиллагаа явуулах тохиолдолд зөвшөөрөл өгөх асуудлыг прокурор хянан шийдвэрлэнэ. Хэрэгт ач холбогдолтой эд зүйл, бичиг баримт хураан авах, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх, хураан авах, үзлэг хийх, цогцсыг оршуулсан газраас нь гаргаж авах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, сэжигтэн, яллагдагчийг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт шилжүүлэх, хэргийн материалыг нийтэд мэдээлэх,

албан үүргээ гүйцэтгэхийг түр түдгэлзүүлэх, эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг хязгаарлах зэрэг ажиллагаа явуулахад прокурор зөвшөөрөл өгнө.

Прокурорын зөвшөөрөл нь мөрдөн байцаагчийн тогтоолыг батлах хэлбэрээр хэрэгжинэ. Прокуророос олгосон зөвшөөрөл нь хууль зүйн үндэслэлгүй бол дээд шатны прокурор тухайн зөвшөөрлийг хүчингүй болгох бөгөөд ийнхүү хүчингүй болгохдоо тогтоол үйлдэнэ.

5. Мөрдөн байцаагчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг хянан шийдвэрлэх, хэргийг өөр мөрдөн байцаагчид шилжүүлэх эрхтэй.

Прокурорын байгууллагын тухай хуулийн 12.2.4 болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193.1.19-д заасан энэхүү бүрэн эрхийг прокурор хэрэгжүүлэхэд дор дурдсан нөхцөл байдал тогтоогдсон байх ёстой. Үүнд:

- Мөрдөн байцаагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн;

- Тухайн хэрэгт хувийн сонирхолтой болох нь тогтоогдсон байх явдал юм.

Прокурор мөрдөн байцаалтын ажилд хяналт тавих явцад мөрдөн байцаагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн нь илэрч тогтоогдовол тухайн хэргийг өөр мөрдөн байцаагчид шилжүүлнэ. Хэргийг ийнхүү шилжүүлэхэд прокурор мөрдөн байцаагчийн үйлдсэн хууль бус, үндэслэлгүй тогтоолыг хүчингүй болгох буюу өөрчлөх эрхтэй. Прокурор энэхүү эрхээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193.1.13-т заасны дагуу хуулийн шаардлагыг хангуулах талаар бичгээр заалт өгөх замаар хэрэгжүүлнэ. Мөрдөн байцаагчийг татгалзан гаргах

тухай хүсэлтийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 54.3-т зааснаар прокурор хянан шийдвэрлэх бөгөөд мөн хуулийн 49 дүгээр зүйлд заасан үндэслэлийн аль нэг байвал хэргийг өөр мөрдөн байцаагчид шилжүүлнэ. Мөрдөн байцаагч тухайн хэрэгт хувийн сонирхолтой болох нь тогтоогдовол прокурор хэргийг өөр мөрдөн байцаагчид шилжүүлэх талаар байгууллагын захиргаанд мэдэгдэж шийдвэрлүүлнэ. Мөрдөн байцаагч хэрэгт хувийн сонирхолтой болохыг прокурор өөрийн санаачилгаар болон зохих гомдол, мэдээллийн дагуу шалгаж тогтоосон байвал зохино.

6. Гэмт хэргийн шинж тэмдгийг хяналтаараа илрүүлсэн бол эрүүгийн хэрэг үүсгэн, харьяаллын дагуу шалгуулахаар шилжүүлэх эрхтэй.

Прокурор гэмт хэргийн шинж тэмдгийг хяналтаараа илрүүлсэн бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 166.1.4-ийг үндэс болгон эрүүгийн хэрэг үүсгэж харьяаллын дагуу шалгуулахаар зохих мөрдөн байцаах албанд шилжүүлнэ. Прокурор ийнхүү эрүүгийн хэрэг үүсгэж, харьяаллын дагуу шалгуулахаар шилжүүлэхэд үндэслэл бүхий тогтоол үйлдэж, хэргийн дугаар авна.

Прокурор эрүүгийн хэрэг үүсгэн харьяаллын дагуу шалгуулахаар шилжүүлсэн тохиолдолд тухайн хэргийн мөрдөн байцаалтад хяналт тавих прокурорт мэдэгдэж, хэргийг эрүүгийн хэргийн нэгдсэн бүртгэлд авахуулахын зэрэгцээ хэргийн эд мөрийн баримтыг хэргийн хамт шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

7. Хэрэг шалгах харьяаллыг тогтоох эрхтэй.

Мөрдөн байцаах ажиллагаанд тавих прокурорын хяналт нь Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 180 дугаар зүйлд заасны дагуу эрүүгийн хэрэг гарсан нутаг дэвсгэрийн зарчмаар хэрэгжинэ. Мөрдөн байцаалтыг түргэн шуурхай, бүрэн гүйцэд хийхийн тулд гэмт хэрэг илэрсэн буюу сэжигтэн, ялагдагч болон гэрч, хохирогчийн олонхи байгаа газарт мөрдөн байцаалт явуулж болно. Ийнхүү мөрдөн байцаалтын харьяаллыг өөрчлөн тогтоох асуудлыг тухайн хэргийн мөрдөн байцаалт эхэлсэн газрын прокурор Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 180.4 заасны дагуу шийдвэрлэнэ.

Нийслэлийн дүүргүүд дамжсан үйлдэлтэй хэргийн мөрдөн байцаалтын харьяаллыг Нийслэлийн прокурорын газар, аймаг хооронд дамжсан үйлдэлтэй, эсвэл аймаг, нийслэл, дүүрэг дамжсан үйлдэлтэй хэрэг, гадаад улсаас шилжүүлэн ирүүлсэн хэрэг, Монгол Улсын хилийн гадна байгаа тус улсын төрийн далбаа мандуудсан усан онгоц болон гадаад улсад суугаа дипломат төдөөлөгчийн газрын эзэмшил нутагт гарсан хэргийн харьяаллыг Улсын Ерөнхий прокурорын газрын Мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтэс тогтооно.

Мөрдөн байцаалтын ажиллагаа хийгдэж байсан эрүүгийн хэрэг нь хэрэг бүртгэлтийн харьяалалтай хөнгөн, хүндвэрт хэрэг болох нь тогтоогдвол хэрэг бүртгэх байгууллагад харьяалал тогтоон шилжүүднэ. Прокурор эрүүгийн хэргийг шалгах мөрдөн байцаалтын харьяаллыг тогтоохын зэрэгцээ тухайн

хэргийн хяналтын харьяаллыг нэгэн адил тогтооно. Хэргийн мөрдөн байцаалтын болон хяналтын харьяаллыг тогтооходоо эрх бүхий прокурор тогтоол үйлдэнэ. Монгол Улсын Ерөнхий прокурор гэмт хэрэг үйлдэгдсэн нутаг дэвсгэр, гэмт этгээдийн хувийн байдал, эрхэлж буй ажил, албан тушаал, гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэр, гэмт хэргийн нийгмийн хор аюулын онцгой шинж чанар, учирсан хохирлын хэмжээ зэргийг харгалзан үзэж, эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын болон хяналтын харьяаллыг тусгайлан тогтоож болно.

8. Мөрдөн байцаалтын ажиллагааг шалгах, хэргийн материалыг хянах явцад илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах эрхтэй.

Мөрдөн байцаах ажиллагаанд хуулийн заалтыг хэрхэн хангаж байгааг тодорхой эсдэв, чиглэлээр төдөвлөгөө, удирдамжийн дагуу мөрдөн байцаах хэлтэс, тасгуудад шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах нь мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх нэг арга юм. Прокурор шалгалтыг хийхдээ хяналт шалгалтын ил тод байх зарчмыг баримтлахын зэрэгцээ иргэд байгууллага, албан тушаалтын гомдол мэдээллийг үндэслэн тодорхой асуудлыг шалгаж болно. Прокурор мөрдөн байцаах ажиллагааг шалгахын зэрэгцээ зохих чиглэлээр судалгаа хийж, хуулийн хэрэгжилтийн талаар үнэлэлт дүгнэлт гаргаж болно. Прокурор шалгалтын явцад илэрсэн зөрчлийг холбогдох хүмүүсээс тайлбар, тодорхойлолт авах зэрэг байдалар бэхжүүлж, зөрчлийг арилгуулахаар хуульд заасан арга хэлбэрээр авч, гэм

буруутай хүмүүс зохих хариуцлага тооцуулж, шалгалтын дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, зөрчлийг арилгуулахаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг тооцох зэргээр энэхүү бүрэн эрхээ идэвхтэй байдалар хэрэгжүүлднэ.

9. Мөрдөн байцаагчийн үйл ажиллагаа, шийдвэрийн талаар гарсан гомдлыг шалгаж шийдвэрлэх эрхтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 112 дугаар зүйлд заасны дагуу мөрдөн байцаагчийн шийдвэр, үйл ажиллагааны талаарх гомдлыг тухайн мөрдөн байцаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа прокурор хянан шийдвэрлэнэ. Гомдлыг хүлээн авсан прокурор 72 цагийн дотор нэмэлт материал шалгах буюу бусад арга хэмжээ авах бол ажлын 7 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Хэргийн талаар мөрдөн байцаагчийн гаргасан шийдвэр, үйл ажиллагаа нь хууль зөрчсөн бол прокурор мөрдөн байцаагчийн шийдвэрийг хүчингүй болгох буюу өөрчлөх арга хэмжээ авна. Прокуророос гаргах шийдвэр нь үндэслэл бүхий тогтоол хэлбэртэй байна. Мөрдөн байцаагчийн үйл ажиллагаа, шийдвэр нь хууль зөрчөөгүй бол прокурор энэ талаар гарсан гомдлыг хүлээн авахаас татгалзсан тухай үндэслэл бүхий харууг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 112.3-ыг удирдлага болгон гомдол гаргагчид өгч уг шийдвэрт дахин гомдол гаргах эрхтэйг тайлбарлан өгнө. Прокурорын шийдвэр, үйл ажиллагааны талаарх гомдлыг зохих шатны болон дээд шатны прокурорт гаргаж болно. Зохих болон дээд шатны прокурор гэдгийг Улсын Ерөнхий

прокурорын 2002 оны 260 дугаар тушаалаар баталсан зааврын нэгийн 6-д зааснаар ойлгоно.

10. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, хэргийг хэрэгсэхгүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх, хэргийг шүүхэд шилжүүлэх эрхтэй.

Шинэ Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, хэргийг хэрэгсэхгүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх шүүхэд шилжүүлэх эрхийг прокурорт олгосон нь зарчмын чухал ач холбогдолтой заалт юм.

Шүүхийн өмнөх шатанд эрүүгийн зарга буюу гэмт хэргийн тухай гомдол мэдээллийг мөрдөн байцаагч хүлээн авч, эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг зөвхөн прокурорын хяналтын дор шийдвэрлэх нь олон улсын нийтлэг жишиг төдийгүй, хууль, эрх зүйн ач холбогдол, үр дагавартай тул энэхүү эрхийг хуулийн хүрээнд бүрэн хэмжээгээр хэрэгжүүлж ажиллах нь чухал.

Монгол Улсын Ерөнхий прокурорын 2002 оны 260 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд прокуророос тавих хяналтын ажилд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтыг дагаж мөрдөх аргачилсан заавар"-т эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, хэргийг хэрэгсэхгүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх, шүүхэд шилжүүлэх журмыг нарийвчлан заасан тул энэхүү журмыг мөрдөж ажиллах шаардлагатай.

11. Прокурор мөрдөн байцаалтын хугацаа сунгах эрхтэй

Мөрдөн байцаалт явуулах үндсэн хугацаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 182

дугаар зүйлийн 182.1 дүгээр зүйлд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэнээс хойш 2 сар байна. Прокурор эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавихдаа хэргийг аль болохоор богино хугацаанд шалгаж шийдвэрлэхэд хяналт тавина. Тухайн хэрэг нь олон сэжигтэн, яллагдагчтай буюу олон үйлдэлтэй эсвэл алслагдсан газарт шалгалт хийх шаардлагатай, түүнчлэн шүүх нягтлан бодох бүртгэлийн болон бусад нарийн төвөгтэй шинжилгээ хийх, дахин болон нэмэлт шинжилгээ хийлгүүлэх зэрэг зайлшгүй шаардлагатай тохиолдолд мөрдөн байцаалт явуулах хугацааг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 182 дугаар зүйлийн 182.4 дүгээр зүйлд заасан журам болон Улсын Ерөнхий прокурорын 2002 оны 260 тоот тушаалаар баталсан аргачилсан зааврын 7-9-д зааснаар сунгана.

12. Сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих буюу хорьж мөрдөх хугацааг сунгах, өөрчлөх, хүчингүй болгох, баривчлах болон энэ тухай тогтоолыг хүчингүй болгуулах тухай саналыг шүүхэд гаргах эрхтэй

Хүний эрх, эрх чөлөөг зөрчих, хууль бусаар хязгаарлах явдлыг гаргуулахгүй байх, хуулийг чанд сахиулах зорилгоор сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих буюу хорьж мөрдөх хугацааг сунгах, өөрчлөх, хүчингүй болгох, баривчлах болон энэ тухай тогтоолыг хүчингүй болгуулах тухай саналыг прокурор шүүхэд гаргах эрхтэй байхаар Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Прокурорын байгууллагын тухай хуульд заасан нь олон улсын жишигт нийцсэн чухал ач холбогдолтой заалт юм.

Прокурор сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих талаар мөрдөн байцаагчаас тавьсан саналыг зөвшөөрсөн тохиолдолд мөрдөн байцаагчийн тогтоолд зөвшөөрсөн тухай тэмдэглэл хийж тогтоол болон шаардлагатай гэж үзвэл хэргийн материалыг шүүхэд өөрийн саналын хамт танилцуулж сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих зөвшөөрлийг авна. Хэрвээ прокурор сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шаардлагагүй гэж үзвэл мөрдөн байцаагчаас тавьсан саналыг татгалзсан тухайгаа мөрдөн байцаагчийн тогтоолд тэмдэглэж, тогтоолыг буцаах эрхтэй.

13. Мөрдөн байцаалт явуулсан хэрэгт яллах дүгнэлт үйлдэх хэргийг шүүхэд шилжүүлэх эрхтэй.

Мөрдөн байцаалт явуулсан тусгай харьяалалтай хүндэтгэр, хүнд, онц хүнд хэргийг прокурор Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 215.1-т заасан 14 хоногийн дотор хянах ба нийнхүү хянахдаа мөн хуулийн 214 дүгээр зүйлд заасан 10 асуудлыг заавал хянаж үзнэ. Прокурор хэргийг хянаад мөрдөн байцаалтын ажиллагаа бүрэн гүйцэд хийгдсэн гэж үзвэл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 215.2.2-т заасны дагуу тусгай харьяалалтай хүндэтгэр болон хүнд, онц хүнд гэмт хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлнэ.

Яллах дүгнэлт үйлдэх үед прокурор урьд сонгосон ялын заримыг хүчингүй болгох түүнчлэн хөнгөн ялтай хууль хэрэглэх эрхтэй. Яллагч хүндрүүлэх буюу жинхэнэ бодит байдлаараа урьд сонгосон ялаас онцын ялгаатай болгож өөрчлөх шаардлагатай бол прокурор хэргийг мөрдөн

байцаалтад буцаахгүйгээр шинээр ял сонгож байцаалгах эрхтэй. Прокурорын яллах дүгнэлт нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 218 дугаар зүйлийн шаардлагыг хангасан байна.

Прокурор яллах дүгнэлт үйлдэж хэргийг харьяаллын дагуу шүүхэд шилжүүлж, энэ тухай яллагдагчид мэдэгдэнэ. Хэргийг шүүхэд шилжүүлсний дараа хэргийн талаар гарсан хүсэлт гомдлыг прокурор шүүхэд шууд шилжүүлнэ.

14. Прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй.

Мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан эсэхийг тогтоох хамгийн хүчтэй арга нь прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх юм.

Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 12.3, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 195.1-т прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулах дор дурдсан үндэслэлүүдийг заасан. Үүнд:

- Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 357.1.1, 357.1.2-т заасан нөхцөл байдал илэрсэн;

- Хохирогч, гэрч, яллагдагчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй;

- Мөрдөн байцаалтын тодорхой ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаагүй гэж прокурор үзсэн.

Прокурор мөрдөн шалгах ажиллагааг өөрийн санаачилгаар болон зохих гомдол, мэдээллийг үндэслэн явуулна. Прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа үндэслэл бүхий тогтоол гаргана. Прокурорын тогтоол нэгдсэн дугаартай байна. Прокурор мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа:

а/ гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагчийг биечлэн байцаах;
б/ шинжээч дахин томилж дүгнэлт гаргуулах;

в/ үзлэг, нэгжлэг, туршилт хийх зэрэг ажиллагаа хийж гүйцэтгэнэ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 195.5-т заасны дагуу прокурор мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан бүхий л нотлох баримтыг хэрэгт хавсаргана. Мөрдөн шалгах ажиллагааны явцад хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдаагүй, хуулийг ноцтойгоор зөрчсөн нь тогтоогдвол прокурор:

- Тухайн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар хэргийг цаашид мөрдүүлэхийг зогсоох;

- Хэргийг өөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид шилжүүлэхийг хэрэг бүртгэлт мөрдөн байцаалт явуулах байгууллагад даалгах;

- Үндэслэлгүйгээр түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээж, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагад шилжүүлэх зэрэг арга хэмжээ авна.

Монгол Улсын Ерөнхий

прокурорын 2002 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 261 дүгээр тушаалаар батлан гаргасан “Эрүүгийн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах аргачилсан заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

15. Прокурор эрүүгийн хэргийн дугаар олгох эрхтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 166 дугаар зүйлд заасан эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл байвал хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор эрүүгийн хэрэг үүсгэж, энэ тухай тогтоол гаргана. Хэрэг

бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэсэн бол Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 173.3-т заасны дагуу 72 цагийн дотор прокурорт танилцуулж, эрүүгийн хэргийн дугаар авна. Прокурор эрүүгийн хэргийн дугаар олгохдоо хэргийн материалтай танилцаж, эрүүгийн хэрэг үүсгэсэн нь үндэслэлтэй эсэхийг хянаж шийдвэрлэнэ. Мөрдөн байцаагч үндэслэлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэсэн гэж үзвэл прокурор мөрдөн байцаагчийн тогтоолыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193.1.1, Прокурорын байгууллагын тухай хуулийн 12.2.5-ыг баримтлан тогтоолыг хүчингүй болгоно. Энэ тохиолдолд прокурор эрүүгийн хэргийн дугаар олгохгүй. Прокурор эрүүгийн хэрэгт дугаар олгож байгаа нь тухайн хэргийн шийдвэрлэлт хяналт тавих үр дүнтэй арга юм. Прокурор эрүүгийн хэрэгт олгосон дугаараа эрүүгийн хэргийн нэгдсэн бүртгэлд тэмдэглэж, тухайн хэргийг хэрэгсэхгүй болгосон, түдгэлзүүлсэн, нэгтгэсэн, тусгаарласан, харьяаллаар шилжүүлсэн тохиолдол бүрт тухайн хэргийн дугаараар нь давхар хяналт тавина.

16. Хэргийг вэмэлт мөрдөн байцаалтад буцаах эрхтэй.

Мөрдөн байцаагч мөрдөн байцаалтын бүх ажиллагааг хийж дууссан, хэргийг шийдвэрлэхэд хангалттай нотлох баримт бүрдсэн гэж үзвэл яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгч, төлөөлөгчид хэргийн материалыг танилцуулж хэргийг прокурорт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 213.1-т заасны дагуу шилжүүлнэ. Мөрдөн байцаагчаас шилжүүлж ирүүлсэн хэргийн талаар

прокурор Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 214.1-т заасан асуудлыг хянаж, мөрдөн байцаалтын ажиллагаа дутуу хийгдсэн, хэргийг бүрэн гүйцэд шалгаагүй, хэргийг шүүхэд шилжүүлэх хангалттай нотлох баримт бүрдээгүй гэж үзвэл хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаана. Прокурор хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахдаа үндэслэл бүхий тогтоол үйлдэнэ. Хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахдаа тухайн хэрэгт нэмж хийх ажиллагаа, шалгах зүйлийн талаар мөрдөн байцаагчид бичгээр даалгавар, заалт өгнө. Прокуророос өгсөн даалгаврын заалтыг мөрдөн байцаагч заавал хангах үүрэгтэй. Хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахдаа прокурор мөрдөн байцаалтын хугацааг сунгах бөгөөд яллагдагчийг цагдан хорих хугацааг сунгах эсэх асуудлыг шүүхэд тавьж шийдвэрлүүлнэ.

17. Прокурор эрүүгийн хэргийг үндэслэлгүйгээр нэгтгэсэн, тусгаарласан, мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгох эрхтэй.

Прокурор хэргийн материалыг хянаад мөрдөн байцаагч эрүүгийн хэргийг үндэслэлгүйгээр нэгтгэсэн, тусгаарласан бол мөрдөн байцаагчийн тогтоолыг өөрийн тогтоолоор хүчингүй болгож хэргийг зохих журмын дагуу шалгуулахаар даалгавар бичнэ. Прокурор үндэслэлгүйгээр нэгтгэсэн хэргийг тусгаарлан шалгуулах бөгөөд үндэслэлгүйгээр тусгаарласан хэргийг нэгтгэн шалгуулах арга хэмжээ авна. Энэ талаар прокуророос өгсөн даалгаврыг мөрдөн байцаагч заавал биелүүлэх үүрэгтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 369 дүгээр зүйлд заасны дагуу насанд хүрээгүй этгээд насанд хүрсэн этгээдийн

хамт гэмт хэрэгт хамтран оролцсон тохиолдолд бололцоотой гэж үзвэл мөрдөн байцаалтын шатанд хэргийг нь тусгаарлан шийдвэрлүүлэх арга хэмжээг авсан эсэхэе прокурор хяналт тавина.

Эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 124, 125 дугаар зүйлээр тогтоосон журмыг мөрдөн байцаагч хэрхэн мөрдөж ажилласныг прокурор хянаана.

18. Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох зорилгоор хийгдэж байгаа гүйцэтгэх ажилд хяналт тавих эрхтэй.

Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Ерөнхий прокурор, түүний тусгайлан эрх олгосон прокурор гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох зорилгоор гүйцэтгэх ажилд хяналт тавина.

19. Мөрдөн байцаалтын хэвийн ажиллагааг хангах, илэрсэн нийтлэг зөрчлийг арилгуулахаар мөрдөн байцаах байгууллагын захиргаанд шаардлага тавих эрхтэй.

Мөрдөн байцаах ажиллагаанд хуулийн заалт хэрхэн хэрэгжиж байгааг прокурор шалган, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар мөрдөн байцаах байгууллагын захиргаанд шаардлага өгнө. Прокурорын шаардлага нь Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу зохих мөрдөн байцаах байгууллага албан тушаалтанд өгөгдөнө. Прокурорын шаардлагыг хүлээн авсан мөрдөн байцаах байгууллагын захиргаа 14 хоногийн дотор шаардлага бичсэн прокурорт

бичгээр хариу өгнө. Прокурор шаардлага өгсөн мөрдөн байцаах байгууллагад мөрдөн байцаалтын ажиллагааг хэвийн явуулах, хуулийн заалтыг хангах талаар удирдлага зохион байгуулалтын ямар арга хэмжээ авч хэрэгжүүлснийг давтан шалгаж болно.

Прокуророос ийнхүү хийх шалгалт нь прокурорын өөрийн санаачилгаар буюу иргэдийн гомдол мэдээллээр зохих төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийгдэнэ.

20. Мөрдөн байцаах ажиллагааны талаар гаргасан тушаал, шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг хянах, хуульд зөрчсөн тушаал шийдвэрт эсэргүүцэл бичих эрхтэй.

Тагнуулын Ерөнхий газрын мөрдөн байцаах хэлтэс, Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба, Мөрдөн байцаах байгууллага мөрдөн байцаах ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг хангах, тодорхой хэргийг шалгаж шийдвэрлэх, гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох, мөрдөн байцаах ажиллагаанд хуулийн заалтыг хангуулах, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтыг хэрэгжүүлэх талаар тушаал, шийдвэр гаргах эрхтэй. Эдгээр тушаал, шийдвэр нь хуульд нийцэж байгаа эсэхийг прокурор хянаж, хуульд зөрчсөн тушаал, шийдвэрийг хүчингүй болгох буюу өөрчлүүлэхээр эсэргүүцэл бичнэ.



Гадаадын хөрөнгө оруулалтын тухай олон улсын эрх зүй ба Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хууль



ХЗҮТ-ийн ЭША
Ч.НАРАНТУЯА

“Хөрөнгө оруулах нь ирээдүйд илүү их мөнгө олохын тулд өнөөдөр мөнгөнөөсөө салах гэсэн үг юм”.¹ Түүхээс харвал, олон улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүй нь хоёр хүчин зүйлийн үр дүнд үүссэн байна.

Нэг талаас, гадаад улсын иргэдэд холбогдох дэглэм тогтоож байсан эрх зүйн үргэлжлэл юм. Энэ нь тодорхой хэмжээнд ёс зүйн шинж чанарыг агуулж байсан. Учир нь ёс заншлын дагуу сайн хүний хувьд хилийн чанадаас ирсэн хүнийг ивээн тэтгэх үүрэгтэй ажээ. Урт удаан хугацааны турш гадаадын иргэдэд холбогдох эрх зүй нь хувь хүний эрхтэй холбоотой байсан боловч эдгээр эрхийн дунд эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй хүмүүст эдлэх эрх бас байжээ. Энэ талаархи эрхийг хамгаалах нь зарим улсын хувьд гадаадад хуримтлагдсан эдийн засгийн туршлагыг нь

ашиглах бодлоготой нь нийцэж байсан тул өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулахыг зөвшөөрдөг байжээ. Иймээс зөвхөн гадаадын иргэнийг бус түүний өмчийг ч мөн хамгаалах эрх зүйн хэм хэмжээг өргөтгөх шаардлага гарсан. Энэхүү шаардлага нь юуны түрүүнд төрөөс гадаадын иргэдэд хандах хандлагыг төлөвшүүлэх зорилго бүхий олон улсын эрх зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрснөөр хэрэгжиж эхэлсэн байна. Эдгээр хэм хэмжээ, юуны түрүүнд шударга болон эрх тэгш дэглэмийн хэм хэмжээ нь гадаадын иргэдийн аюулгүй байдлыг тодорхой хэмжээнд хамгаалдаг байв. Гэвч улс хоорондын эдийн засгийн харилцаа өргөжин хөгжсөн орчин үеийн нөхцөлд дээрх хэм хэмжээ нь хамгаалалтын аргын хувьд бүрэн дүүрэн биш болсон тул гэрээ, хэлэлцээр хийх замаар асуудлыг шийдвэрлэж эхэлсэн. Удаан хугацааны турш эв найрамдалтай харилцаа тогтоох, худалдаа хийх болон усан замын аялалтай холбогдолтой гэрээ, хэлэлцээрүүд агуулга, тооны хувьд чухал байв. Аажимдаа хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих болон хамгаалах хоёр талт гэрээ, хэлэлцээрүүд дээрх гэрээ, хэлэлцээрүүдийн оронд хэрэглэгдэх болжээ.

Нөгөө талаас, сүүлийн жилүүдэд ёс зүйн бус эдийн засгийн шинж чанар

бүхий асуудлыг шийдвэрлэх шаардлага гарч байна. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчийн аюулгүй байдал, хөрөнгө оруулалтын баталгаанд бус үндэстний нийгмийн халамжийг хангах механизмын чухал хэсэг болох үйлдвэрлэлийн хүчин зүйлүүдийн хөдөлгөөнд анхаарлаа хандуулах болсон.

Дээрх асуудлыг хууль зүйн талаас шийдвэрлэх хоёр арга байна. Олон улсын байгууллагуудын тогтоолууд, тухайлбал, эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллагын (OECD)² үйл ажиллагааны хүрээнд боловсруулсан Хөрөнгийн чөлөөт хөдөлгөөний тухай кодекс, Гадаадын хөрөнгө оруулалтын дэглэмийн талаархи Дэлхийн банкны удирдлага болгох зарчмууд чухал ач холбогдолтой юм. Нөгөөтэйгүүр, гэрээ, хэлэлцээр байгуулах явдал улам эрчимтэй болж байгаа нь АНУ-ын байгуулж буй хоёр талт болон Америкчуудын санаачилгаар үүссэн чөлөөт худалдааны талаарх гэрээ, хэлэлцээрт нэн тэргүүнд үндэсний дэглэмийн зарчмыг хөрөнгө оруулалтын өмнөх шатанд тавьж эхэлсэнээс харагдаж байна.

Олон улсын гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүй нь ийнхүү хоёрдмол эх үүсвэртэй байгаа нь түүний эх сурвалж болон агуулгад нөлөөлөх хүчин зүйл болдог. Хөрөнгө

1. Шарп У.Ф., Александер Г.Дж.В., Инвестиции. М., 1999, стр. 1.
2. OECD - Organization for Economic Co-operation and Development.

оруулалтыг баталгаажуулах хүчин зүйл болохын хувьд олон улсын шинжтэй эрх зүйн заншлыг нэн тэргүүнд тавьдаг хэдий ч хөрөнгө оруулалтын хөдөлгөөнийг зохицуулагч хүчин зүйлийн хувьд гэрээ, хэлэлцээр хийх, ялангуяа олон талт конвенц байгуулах арга замыг сонгодог. Иймээс ч хөрөнгө оруулалтын тухай олон талт гэрээг байгуулах нь чухал ач холбогдолтой бөгөөд нарийн асуудал юм.

Олон улсын эрх зүй дэх хөрөнгө оруулалтын тухай ойлголт

Олон улсын эрх зүйд хөрөнгө оруулалтын тухай нэгдмэл ойлголт үгүй юм. Хөрөнгө оруулалт нь эдийн засгийн шинжлэх ухаантай салшгүй холбоотой тул эрх зүйн талаас нь тодорхойлохдоо эдийн засгийн ойлголтыг харгалзан үзэх нь нэгдмэл байдлыг төлөвшүүлэхэд хэрэгтэй мэт. Гэсэн хэдий ч хөрөнгө оруулалтын эрх зүйн харилцаанд оролцогчид мөн л тусгай хууль тогтоомжоор зохицуулагдах эрх, үүрэгтэй учир эдгээр эрх зүйн хэм хэмжээний агуулга болон зорилтоос шалтгаалан хөрөнгө оруулалтын тухай ухагдахуун мөн л өөрчлөгдөх болно. Иймээс ч нэгдмэл ойлголтод хүрэх боломж бага юм.

Хөрөнгө оруулалтын харилцааны хүрээнд үүсэх гэрээг өөр өөр аспектаас харж үзвээс хөрөнгө оруулалтыг гурван төрөлд ангилж болно. Үүнд:

- хөгжингүй улс орнуудын хооронд үүсдэг хөрөнгө оруулалтын эрх чөлөөний тухай гэрээ, хэлэлцээрт хөрөнгө оруулалтыг хэрхэн ойлгодог тухай;

- хөгжингүй болон хөгжиж буй, мөн хөгжингүй улсуудын өөр хооронд үүсэх хөрөнгө оруулалтыг хамгаалах талаарх гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хэрхэн тодорхойлж буй;

- хөгжингүй болон хөгжиж буй улс хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу үүсэх хөрөнгө экспортолж буй улсаас хөрөнгө импортолж буй улс руу үүсэх хөрөнгө оруулалтыг авч үзэж болох юм.

Хөрөнгө оруулалтын эрх чөлөөний тухай актууд дахь хөрөнгө оруулалтын тухай ойлголт

Хөгжингүй улс орнууд хоорондын хөрөнгийн чөлөөт хөдөлгөөнийг зохицуулах зорилго бүхий баримтыг хоёр төрөл болгон ангилдаг байна. Эхний төрөлд нь OECD-гийн үйл ажиллагааны хүрээнд боловсруулсан "Хөрөнгийн хөдөлгөөнийг либералчлах тухай кодекс", хоёр дахь төрөлд нь Европын актууд: "Ромын гэрээ"-ний 67 – 73 дугаар зүйлүүд, 67 болон 70 дугаар зүйлүүдийг хэрэглэх тухай удирдамж, Маастрихтын гэрээгээр оруулсан өөрчлөлтийг харгалзан үзсэн "Европын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр"-ийн 73В – 73Н дугаар зүйлүүд орно.

Эдгээр акт нь хөрөнгөөс гадна бараа болон ажиллах хүчний татваргүй, чөлөөтэй хөдөлгөөнийг зөвшөөрснөөр тус гэрээ, хэлэлцээрт нэгдэн орсон улс орнуудын эдийн засаг хөгжих нэгэн нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Үйлдвэрлэлийг чөлөөтэйгээр санхүүжүүлэхэд хөрөнгө оруулалтын салшгүй хэсэг болох хөрөнгө болон ажиллах хүчний чөлөөт хөдөлгөөн зайлшгүй шаардлагатай юм. Иймээс ч

хөрөнгө болон ажиллах хүчний чөлөөт хөдөлгөөн ба хөрөнгө оруулалтын эрх чөлөөний хооронд шууд холбоо үүсдэг.

OECD-гийн кодекс болон 1988 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 88 – 361 дүгээр удирдамжид хавсаргасан жагсаалтыг үндэслэн дараахь шинж чанарыг агуулсан үйлдлийг хөрөнгө оруулалт гэнэ:

- Ямарваа нэгэн хандив нэмэр байх;

- Энэхүү хандив нэмэр нь хөрөнгийн хэлбэрээр илэрхийлэгдэх;

- Энэхүү хандив нэмэр нь удаан үргэлжлэх харилцаа холбоо (заавал эрх зүйн биш) үүсэхэд дөхөм болох;

- Энэхүү удаан үргэлжлэх харилцаа холбоо нь хөрөнгө оруулагч болон тухайн үйлдвэрлэгч, өөрөөр хэлбэл, эдийн засгийн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй байгууллагын хооронд үүсэх;

- Хөрөнгө оруулагч энэхүү харилцаа холбооны улмаас хөрөнгө оруулсан үйлдвэрлэлийн удирдлагад мэдэгдэхүйц нөлөө үзүүлж чадах ёстой байх.

Сүүлийн шинж чанарыг агуулсан хөрөнгө оруулалтыг шууд хөрөнгө оруулалт хэмээн нэрлэдэг.

Хөрөнгө оруулалтыг хамгаалах талаарх актууд дахь хөрөнгө оруулалтын тухай ойлголт

Хөгжингүй болон хөгжиж буй улс орнууд хоорондын хөрөнгө оруулалтын талаархи чухал актуудын нэг нь 1965 оны Хөрөнгө оруулалттай холбоотойгоор үүссэн маргааныг шийдвэрлэх журмын тухай

Вашингтоны конвенц¹ юм. Дээрх конвенцын дагуу маргааныг шийдэх үүрэг бүхий Төв байгуулагдсан байна. 1960 – 1990 оны хооронд хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих ба харилцан хамгаалах тухай хоёр талт хэлэлцээр хийх практик тогтож эхэлжээ². Харин 1995 оноос өнөө хүртэл үргэлжилж буй үйл явц бол OECD-гийн хүрээнд хийгдэх Хөрөнгө оруулалтын тухай олон талт хэлэлцээр (MAI)³-ээс эхэлж буй хөрөнгө оруулалттай холбоотой актуудыг төрөлжүүлэн эмхтгэх ажил юм.

Энэ актууд хөрөнгө оруулалтыг хамгаалах талаар нэгдмэл үзэл баримтлалтай бөгөөд харилцан тохиролцсоны үндсэн дээр л хөрөнгө оруулалтыг хамгаалах зорилтдоо хүрнэ. Гэвч энэ нь тохиолдол бүрт хамаарахгүй, тухайлбал, Вашингтоны конвенц хөрөнгө оруулалтыг хамгаалах тухай олон талт хэлэлцээр болох хэдий ч түүнийг соёрхон баталсан улс орнууд “хөрөнгө оруулалт” хэмээх ойлголтыг тодорхойлоход бэрхшээл их гарахыг ухамсарласны улмаас тодорхойлолт хийхээсээ зайлсхийсэн байна. Ямар ч тодорхойлолт гаргасан бэрхшээл үүсэх ба арбитрын шүүхүүд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд маргааныг хөрөнгө оруулалттай холбоотой эсэхийг хэрэг болгоны дээр нөхцөл байдлыг харгалзан байж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзжээ. Арбитрын шүүхэд ийнхүү эрх мэдэл олгосноор хөрөнгө оруулалт хэмээх ойлголт нь эд хөрөнгийн ойлголтод, хөрөнгө оруулалтын харилцаа нь гэрээний харилцаанд шингэх эрсдэл бий

анхаарах нь чухал. Ингэснээр хөрөнгө оруулалтыг хамгаалах үүрэг нь зөвхөн хөрөнгө оруулалтын хувьд бас гадаадын иргэдийн ямар ч эд хөрөнгөд учирч болох эрсдэлийн даатгал болон хувирах бөгөөд хамгаалах үүргийг нэн тэргүүнд тавьснаараа уг Конвенцын бүтцийг ганхуулж болзошгүй юм. Хоёр талт хэлэлцээрүүд дэх хөрөнгө оруулалтын ойлголт дээрх бэрхшээлийг үүсгэхгүй, учир нь уг хэлэлцээрүүд нь нэг талаас нууцлагдмал байдаг ба нөгөө талаас хөгжингүй орноос хөгжиж буй орон руу хөрөнгө оруулж буй этгээдийг хамгаалдгаас гадна бусад хөгжингүй улс оронд үүсч болох эрх ашгийг хөнддөггүй. MAI нь OECD-гийн хүрээнд явагдаж буй учир юуны түрүүнд хөгжингүй улс орон хоорондын харилцааг зохицуулна. Тухайлбал, Монгол Улс дахь Францын хөрөнгө оруулалтын бус харин Франц Улс дахь Америкийн хөрөнгө оруулалтын дүрэм журам болон хамгаалалтын тухай яригдах юм.

MAI-г хийх явцад оюуны өмчийн хувьд мөн маргаан үүссэн байна. Үүнийг шийдвэрлэх хоёр арга зам байна. Үүнд:

Нэгт, олон талт конвенцод хөрөнгө оруулалтыг тодорхойлохдоо оюуны өмчийн эрхийг оруулахгүй байх тухай юм. Гэвч хоёр талт хэлэлцээрүүд дэх хөрөнгө оруулалтын тодорхойлолтод оюуны өмчийн эрх ордог тул энэ нь олон талт гэрээ, хэлэлцээрийг хэрэглэх хүрээг багасгах магадлалтай юм.

Хоёрт, оюуны өмчийн эрхийг хөрөнгө оруулалтын тодорхойлолтод оруулах боловч

улс орнууд олон талт хэлэлцээрийг хэрэглэх хүрээнд дуу, дүрс бичлэгийн бүтээгдэхүүнийг оруулахгүй байх тухай заалтыг өөр хоорондоо хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр оруулж болохыг зөвшөөрөх тухай юм. Одоогийн байдлаар сүүлийн шийдвэр нь зохимжтой гэж үзэх хандлага давамгайлж байна.

Сүүлийн үед эрх зүйн аюулгүй байдлын үүднээс хэлэлцээр болгон тайлбар заалттай байх ба тус заалтын дагуу тухайн хэлэлцээрийн хувьд хөрөнгө оруулалт хэмээх ойлголт нь хоёр шинж чанарыг агуулах ёстой. Үүнд, хөрөнгийн болон хөрөнгийн бус хэлбэрээр илэрхийлэгдэх хандив нэмэр байх болон уг хандив нэмрийг ашиглахад хөрөнгө оруулагч ямар нэгэн байдлаар оролцсон байх шаардлагатай (үйл ажиллагааных нь үр дүнгээс үл шалтгаалан, ашигтай ч, ашиггүй ч) гэжээ.

Хөгжлийг дэмжих хэлэлцээрүүд дэх хөрөнгө оруулалтын тухай ойлголт

Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих болон харилцан хамгаалах талаархи хоёр талт хэлэлцээрүүд хамгаалалтыг нэн тэргүүнд тавьдагт хөгжиж буй улсууд сэтгэл дундуур байдаг нь энэхүү бодлого хөгжингүй улс орнуудад илүү ашигтай хэмээн үздэгт оршино. Тэгэхдээ хамгаалалт болон түүний баталгаа нь хөхиүлэн дэмжих бодлого үүсэх нөхцөлийг мөн бүрдүүлж өгдөг.

Баталгаа гаргах нь ерөнхийдөө улс орнуудын,

1. Монгол Улс тус конвенцод 1996 онд нэгдэн орсон.

2. 2002 оны байдлаар Монгол Улс 34 улстай хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих ба харилцан хамгаалах тухай хоёр талт хэлэлцээрийг байгуулавч байна.

3. Multilateral Agreement on Investment

ялангуяа хөгжингүй орнуудын хувьд дотоодын эрх зүйн асуудал болдог ба тус зохицуулалтаараа дотоодынхоо үйлдвэрлэл эрхлэгчдийг дэлхийн зах зээлд оролцохыг хөхиүлэн дэмждэг байна. Байдал хэдий ийм боловч хөрөнгө оруулалтын баталгааны талаарх олон улсын механизм үгүй хэмээн хэлж болохгүй юм. Тухайлбал, Олон талт хөрөнгө оруулалтыг баталгаажуулах агентлагийг (AMGI¹) үүсгэн байгуулах тухай 1985 оны "Сөүлийн олон талт конвенц"-ыг дурдах хэрэгтэй². Энэхүү конвенц нь "А" жагсаалтад багтах хөгжингүй орнуудаас "Б" жагсаалтад орох хөгжиж буй орнуудын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтыг тухайн улсын үйлдэл болон эс үлдэхгүйгээс үүсч болзошгүй улс төрийн эрсдэлээс хамгаалах зорилттой юм. Тэгэхдээ аль ч улсад үүсч болзошгүй, аливаа эрсдэлээс бус, харин хөрөнгө оруулалтын сонгосон хэлбэрийн хувьд, тухайн улсад буй эрсдэлийг судалсны үр дүнд баталгаагаа гаргадаг.

Дээрх зүйлийг харгалзан үзсэний үндсэн дээр "Сөүлийн конвенц"-д хөрөнгө оруулалтыг баталгаа гарган шууд болон шууд бусаар хамгаалах хоёр төрөлд ангилсан³ ба зөвхөн эхний тохиолдолд хамаарагдах хөрөнгө оруулалт л эрх зүйн үүднээс тодорхойлолт хийхэд чухал юм. Үүний дагуу өрнөгө оруулалт нь дараах үндсэн шинжүүдийг агуулна. Үүнд:

- Хөрөнгө оруулалт нь хандив нэмрээр илэрхийлэгдсэн байх шаардлагатай. Уг хандив нэмэр нь мөнгөн буюу бодит байдлаар байх ба сүүлийн тохиолдолд материаллаг буюу материаллаг бус хандив байж

болох боловч үйлчилгээ үзүүлэх нь үүнд багтахгүй юм.

- Энэхүү хандив нэмэр нь удаан хугацаагаар хийгдсэн байх ёстой. Иймээс "Сөүлийн конвенц" нь зөвхөн дунд болон урт хугацаат хөрөнгө оруулалтад баталгаа гаргадаг.

- Хөрөнгө оруулагч ямар нэгэн хэмжээгээр үйлдвэрлэлийн эрсдэл буйг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд хөрөнгө оруулалт хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагч түүний хандив нэмрийг ашигласны улмаас гарсан үр дүнгээс (ашиг орлого ч бай, алдагдал ч бай) хүртэх ёстой байна.

Сүүлийн шинж чанар нь хамгийн чухал бөгөөд тухайн үйлдлийг хөрөнгө оруулалтын хэсэг мөн эсэх болон түүний үүрэг, ач холбогдлыг ялган салгахад дөхөм болдог байна. Үүний нэгэн сонгодог жишээ бол тоног төхөөрөмжийн худалдаа юм. Зарим хүний үзэж байгаагаар худалдан авч буй улсын эдийн засагт үзүүлэх чанарын болон хэмжээний ач холбогдлыг нь харгалзан үзвэл тоног төхөөрөмж худалдах зарим үйлдлийг хөрөнгө оруулалтын үйлдэл хэмээн үзэж болох юм. "Сөүлийн конвенц"-д тухайн тохиолдлын нөхцөл байдлаас шалтгаалан тоног төхөөрөмж худалдах үйлдэл хөрөнгө оруулалт мөн эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй гэжээ. Хэрэв хөрөнгө оруулагчийн орлого зөвхөн худалдааны үнэ (хэсэгчлэн төлсөн тохиолдолд ч мөн адил) бол энэхүү үйлдэл нь хөрөнгө оруулалт биш юм.

Харин хөрөнгө оруулагчийн орлогын нэг хэсэг нь худалдааны үнэ, нөгөө хэсэг нь тоног төхөөрөмжийг ашигласны

үр дүнд олсон орлогын тодорхой хэмжээ бол хөрөнгө оруулалтын шинж чанартай гэж хэлж болох байна. Иймээс хөрөнгө оруулалтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хөрөнгө оруулагч зөвхөн хөрөнгө оруулах бус, уг хөрөнгөтэйгээ холбоотой байх шаардлагатай.

Ийнхүү хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлж буй зорилтоос шалтгаалан олон улсын актууд дахь хөрөнгө оруулалтын тухай ойлголт өөр өөр байна.

Улс орны бүрэн эрхт байдлын зарчим гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйд нөлөөлөх асуудал ба Гадаадын хөрөнгө оруулалтын дэглэмийн талаарх Дэлхийн банкны удирдлага болгох зарчим.

Хөрөнгө оруулалтын чөлөөтэй хөдөлгөөнийг дэмжих тухай үзэл бодол үүсээд удаагүй хэдий ч нэлээн хурдацтай хөгжиж байна. Зарим улс орон хөрөнгө оруулалтын чөлөөт хөдөлгөөнийг улс орныхоо бүрэн эрхт байдлын зарчимтай холбож үзэж байгаа нь тус үйл явцыг удаашруулах хүчин зүйл болж байна. Дээрх байдлаас гарахын тулд хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын хооронд компромисс байгуулах шаардлагатай болсон. Хөгжиж буй улсуудын хувьд энэхүү асуудлыг хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих болон харилцан хамгаалах хоёр талын конвенцууд ба гадаадын хөрөнгө оруулалтын дэглэмийн талаарх Дэлхийн банкны удирдах зарчим гэсэн хоёр аргаар шийдвэрлэх боломжтой.

Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалтын ерөнхий

1. Agency on Multilateral Guaranties on Investment

2. Монгол Улс 1998 онд тус конвенцод нэгдэн орсон.

3. Сөүлийн конвенцын 12 дугаар зүйл

хүрээг тодорхойлох зорилгоор Хөрөнгө оруулалтын дэглэмийн талаарх Дэлхийн банкны удирдах зарчим боловсруулах санаачилгыг анх Франц Улс гаргажээ. Тус зарчим нь одоогийн байдлаар заавал мөрдөн биелүүлэх шинж чанар үгүй бөгөөд дараахь зөвлөмжийг агуулсан байна:

- Аливаа улс хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих өөрийн гэсэн бодлоготой байна. Тус бодлого нь тухайн улс орны нутаг дэвсгэр дээрх хөрөнгө оруулах явцыг хялбар болгох ба түүний хэрэгжилттэй холбоотой үүсэх ажиллагааг зөөлрүүлэхэд чиглэгдэнэ.

- Гэхдээ улс болгон өөрийн нутаг дэвсгэр дээр гадаадын хөрөнгө оруулах явцыг зохицуулах эрхийг өөртөө хадгалан үлдээдэг. Энэ нь ихэвчлэн гадаадын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих хандлагатай байдаг.

- Дээр дурдсанаас үзвэл гадаадын хөрөнгө оруулалтын хувьд нээлттэй бодлого баримтлахыг зөвлүүштэй байна. Өөрөөр хэлбэл, зөвхөн өөрийн улсын иргэдийн хэрэгжүүлэх зарим нэгэн эдийн засгийн үйл ажиллагаанаас бусад салбарт гадаадаас хөрөнгө оруулалтыг чөлөөтэй оруулах нь нээлттэй. Үйл ажиллагааны дээрх төрлийн жагсаалтын талаар гадаадын хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх шаардлагатай (restrictive list system). Энэхүү систем нь үндэсний аюулгүй байдлыг хөндөх салбаруудын хувьд хэргэглэгдэг.

- Гадаадын хөрөнгө оруулалтыг зөвшөөрөхдөө тусгайлсан үүрэг (performance requirements) өгөхгүй байхыг зөвлөсөн байна. Учир нь үндэсний болон гадаадын үйлдвэрлэгчдийн хооронд үүсэх шударга өрсөлдөөнд саад болох

хүчин зүйл юм. Ер нь ямар нэгэн байдлаар хязгаарлалт тогтоох нь хөрөнгө оруулагчид ажил хэргээ явуулахад бэрхшээл болох тул улс орнууд хязгаарлалт тогтоохоос татгалзах нь зөв юм. Учир нь энэ нь урт хугацаанд гадаадын хөрөнгө оруулалтыг үргээх тул ашгаас илүү хор хөнөөл учруулах болно.

Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль

1993 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хууль батлагдаж, түүнд 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн, 2002 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн хуулиар тус тус нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Уг хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт :

“Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг гадаадын хөрөнгө оруулалт гэж хэлнэ.” гэж заажээ.

Дээрх тодорхойлолт болон уг хуулийн зорилтыг Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулан дэмжих, хөрөнгө оруулагчийн эрх, эд хөрөнгийг хамгаалах болон гадаадын хөрөнгө оруулалтын холбогдолтой харилцааг зохицуулахад оршино хэмээн тодорхойлсон нь хөрөнгө оруулалтыг хамгаалах талаарх олон улсын актад заасны дагуу байх ёстой 2 шинж чанарт нийцсэн байна. Нэгд, эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийн хэлбэрээр илэрхийлэгдсэн хандив нэмэр байна; хоёрт, аж ахуйн нэгж

байгуулах болон Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах учраас уг хандив нэмрийг ашиглахад хөрөнгө оруулагч оролцсон байна.

Гадаадын хөрөнгө оруулагчийн эрх зүйн байдал ба хамгаалалт

Олон улсын эрх зүйд хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулагчийн иргэний харьяалал дээр үндэслэн дотоодын болон гадаадын хэмээн ялгах зарчмыг баримталдаг. Үүний дагуу хэрэв хөрөнгө оруулагч тухайн улсын иргэн бол дотоодын, харин гадаад улсын иргэн тухайн улсад эсвэл тухайн улсын иргэн өөр улсын нутаг дэвсгэр дээр хөрөнгө оруулалт хийвэл гадаадын хөрөнгө оруулалт гэдэг. Гэвч зарим улсад (жишээлбэл, Франц Улс, ОХУ, Монгол Улс) байнгын оршин суугаа газрыг шалгуур болгодог.

Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж буй гадаадын хуулийн этгээд, Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаадад байнга оршин суудаг Монгол Улсын иргэнийг гадаадын хөрөнгө оруулагч гэнэ. Гадаадад байнга оршин суугаа Монгол Улсын иргэд Монголд хөрөнгө оруулж, манай эрх ашигт нийцсэн үйл ажиллагаа явуулбал төрөөс бүх талын дэмжлэг үзүүлнэ гэдгийг хуульчлав.

Хөрөнгө оруулагч нь эрхийн чадвар, чадамжтай, байнга оршин суух нутаг, оронтой, тэндээ албан ёсны бүртгэлтэй, өөрийн гэсэн эд хөрөнгөтэй, түүнийгээ захиран зарцуулах эрхтэй байх шаардлагатай.

Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн ба өмчийн баталгааг хангах хэд хэдэн

аргыг Монгол Улс хууль тогтоомждоо тусгасан болно. Гадаадын хөрөнгө оруулалт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Үндсэн хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хамгаалагдана. Ингэснээр Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг улсын өмчлөлд авахгүй гэсэн ерөнхий заалт эрх зүйн хамгаалалттай болж байна. Эрх зүйн хамгаалалт гэсэн ойлголтод хуулийн хамгаалалтаас гадна Монгол Улсын шүүхийн бие даасан байдал, зөвхөн хуульд захирагдан ажиллах, шүүхийн шударга үйл ажиллагаа, Арбитрын эрх орно. Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн дайчлан гаргуулж болно. Чингэхдээ зөвхөн хууль журмын дагуу, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын үндсэн дээр, бүрэн нөхөн төлөх нөхцлөөр эд хөрөнгийг нь дайчилна.

Гадаадын хөрөнгө оруулагчид хамгийн таатай нөхцөл олгоно гэдэг бол тухайн орон өөрийн иргэд, хуулийн этгээдэд олгодог үндэсний нөхцөлийг түүнд олгох явдал гэдгийг дэлхий нийтэд хүлээн зөвшөөрдөг. Монгол Улс олон улсын жишгээс үл хазайн гадаадын хөрөнгө оруулагчдад "үндэсний нөхцөлөөс дутуугүй тааламжтай нөхцөл" олгоно¹ хэмээн Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульдаа хуульчилсан.

Гадаадын хөрөнгө оруулагчдад эд хөрөнгөө үр ашигтай захиран зарцуулах, олсон орлогоо гадаадад саадгүй гуйвуулах, шаардлага гарвал эд хөрөнгөө буцаан гаргах эрхтэй байх явдал чухал байдаг. Харин орлогыг нь "хөрөнгө оруулалтын үр дүнд олсон" гэж хязгаарласан байсныг нь 2002 оны уг хуулиар хүчингүй болгожээ.

Гадаадын хөрөнгө оруулагчдыг татвараар урамшуулах бодлогыг мөн хуульчилсан байна. Тухайлбал, тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл явуулахдаа технологийн зориулалтаар ашиглах, угсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизмыг нэмүү өртгийн албан татвараас чөлөөлнө. Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарын жагсаалтыг Засгийн газар батлан гаргана². аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын тухай Монгол Улсын хуульд зааснаар дараахь салбарт үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай Аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн өдрөөс орлогын албан татварын дор дурдсан хөнгөлөлт үзүүлнэ:

1/ цахилгаан, дулааны станц; цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ; авто, төмөр зам; агаарын тээврийн болон инженерийн барилга, байгууламж; телекоммуникацийн үндсэн сүлжээний салбарт 10 жилийн

хугацаанд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө;

2/ нефть, хатуу түлш олборлох, боловсруулах, металлург, хими, төмөрлөг, машины үйлдвэрлэл, электроникийн салбарт 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.

Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг³ зааснаас бусад салбарт байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 50-аас дээш хувийг экспортолж байвал тухайн аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас эхний 3 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө. Энэ нь ноос, ноолуур угаах, самнах, арьс ширний анхан шатны боловсруулалт хийдэг үйлдвэрт хамаарахгүй. Уг асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тухай бүр шийдвэрлэнэ.

Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагч өөрт ногдох орлогоос тухайн аж ахуйн нэгжид дахин хөрөнгө оруулалт хийвэл оруулсан хөрөнгийн хэмжээгээр тухайн аж ахуйн нэгжийн албан татвар ногдуулах орлогыг багасгаж тооцно. Эдгээр нь урамшуулал болох хэдий ч НҮБ-ын зөвлөх, Колорадогийн Их сургуулийн профессор Жеймс М. Оттогийн Монгол Улсын ашигт малтмалын салбарын татварын тогтолцооны талаар хийсэн судалгаанаас иш татваас: "Төсөл хэрэгжилтийн эхэн үед татвараас чөлөөлдөг өнөөгийн тогтолцоо нь хөрөнгө оруулагчийн ашгийн хувьд бараг ямар ч нөлөөгүй. Учир нь

1. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйл

2. Тус жагсаалтыг Засгийн газрын 2001 оны 140 дүгээр тогтоолын хавсралтаас үзнэ үү.

3. Олон улсын, улсын, орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан, засвар, арчлалт хийсэн аж ахуйн нэгжийн уг ажил зарцуулсан хөрөнгийг албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцно. /энэ хэсгийг 1998 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар нэмсэн. Авто замын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан./

төлөөлөх хугацаанд гарах их зардлын улмаас тэртээ тэргүй энэ хугацаанд төлөх татвар бараг гардаггүй"¹ гэжээ.

Татварын дээрх хөнгөлөлтүүдээс гадна гадаадын хөрөнгө оруулагчдыг эрсдэлээс хамгаалах үүднээс тэдгээртэй тогтвортой байдлын гэрээ байгуулах заалтыг Ашигт малтмалын тухай хууль, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, Татварын ерөнхий хуульд оруулсан байна. Тус гэрээ нь төслийг хэрэгжүүлэх тодорхой хугацаанд аж ахуйн нэгжийн татвар, бусад шууд татвар болон импортын татварыг тогтвортой байлгах хууль ёсны баталгаа болно. Хөрөнгө оруулалтын хэмжээнээс шалтгаалан тогтвортой байдлын гэрээг 10-15 жилээр байгуулж байна².

Эдийн засгийн, худалдааны чөлөөт бүсүүд Монгол Улсад байгуулагдсанаар тус бүсүүдэд хөрөнгө оруулагчдад аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, гаалийн албан татвар, бусад татвар хураамжийн хөнгөлөлттэй нөхцөл, хилийн шалган нэвтрүүлэх хялбарчилсан горим, гаалийн бүрдүүлэлт, аж ахуйн нэгжийн болон бусад бүртгэлийн хөнгөвчилсөн журам үйлчилнэ. Мөн Монгол Улс давхар татвараас чөлөөлөх тухай хоёр талт хэлэлцээрийг дэлхийн 30-аад улс оронтой байгуулсан нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах нэгэн арга юм.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хууль батлагдсанаар аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон лицензийн тоо эрс багассан бөгөөд тус тусдаа үйл ажиллагаагаа явуулдаг байсан хяналтын байгууллагууд нэгдсэн удирдлагатай болсноор гадаадын хөрөнгө оруулалттай

аж ахуйн нэгжийг зөвшөөрөх, бүртгэх үйл ажиллагаа хялбар боллоо.

Гадаадын хөрөнгө оруулалтын төрөл ба түүнийг хэрэгжүүлэх хэлбэр

Монгол Улсад гадаадаас хөрөнгө оруулж болох эдийн засгийн хүрээг тодорхойлохдоо Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар хориглосноос бусад бүх салбарт; үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглосноос бусад нутаг дэвсгэрт гадаадын иргэн, хуулийн этгээд нь Монголын Улсын иргэд, байгууллагатай нэгэн адил хөрөнгө оруулах эрхтэй байдаг гэжээ. Энэ нь Монгол Улсын төрийн эдийн засгийн нээлттэй бодлого, хүний эрхийг хүндэтгэн хамгаалах тухай Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцэж байна.

Гадаадын хөрөнгө оруулалтыг эдийн засгийн үр дүн өгөх ямар ч хэлбэрээр оруулж болно. Гэвч Монголын талын эрх ашгийг илэрхийлсэн хэд хэдэн хязгаарлалт байгаа болно. Тухайлбал, валютын хувьд зөвхөн чөлөөтэй хөрвөх валют, төгрөгөөр хөрөнгө оруулалт хийхийг зөвшөөрөх, хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн хувьд газар, байгалийн баялгийг ашиглах, боловсруулах эрхийн асуудал Үндсэн хуулийн заалтын хүрээнд тус тусын хууль тогтоомжоор, тухайлбал Газрын тухай хууль, Уул уурхайн тухай хууль, концессын эрхийн тухай Улсын Их Хурлын шийдвэрээр зохицуулагдана.

Монгол Улсад гаднаас шашны хэрэг хөтлөх, гадаадын ажиллах хүч оруулах зэргээр хөрөнгө оруулалт шууд хийгдэхгүй.

Гадаадын хөрөнгө оруулалт нь Монгол Улсад зохион байгуулалтын тодорхой хэлбэрээр, тухайлбал дангаараа аж ахуйн нэгж байгуулах, салбар нэгжээ нээн ажиллуулах, гадаадын хөрөнгө оруулагч Монголын хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах, байгалийн баялгийг ашиглах, боловсруулах талаар хууль тогтоомж, концесс, бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу эрх олж авах; маркетинг, менежментийн гэрээ байгуулах, санхүүгийн түрээсийн болон франчайзын хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх хэлбэрээр хийгдэнэ. Гадаадын хөрөнгө оруулагчид Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах эрх олгосон нь шууд хөрөнгө оруулалтын нэгэн хэлбэр болсон байна.

Ийнхүү гадаадын хөрөнгө оруулалтын тухай дэлхий нийтийн чиг хандлагыг Монгол Улс өөрийн орны хэмжээнд тодорхой хэмжээгээр буулгаж, холбогдох хуулиудаараа хамгаалсан нь сайшаалтай. Харин гадаадын хөрөнгө оруулалтын талаарх үндэсний зохицуулалтыг өөрийн орны онцлогт тохируулан улам боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага судлаачдын өмнө тавигдаж байна.



1. James M. Otto "Competitive Position of Mongolia's Mineral Sector Fiscal System: the Case of a Model Copper Mine" Ulaanbaatar, 2003

2. Гэрээний хүрээнд тогтвортой байдлын хугацааны аль нэгэн үед тогтвортой байдлын гэрээг цуцалж, түүнээс хойш ердийн тогтворгүй тогтолцоогоор татвар төлөх нэг удаагийн эрхийг олгож байхыг профессор Жеймс М. Отто мөн зөвлөсөн болно.

Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц ба Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хууль



ХЗУТ-ийн ЭША С.ДОЛЖИН

Энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэх, улс гүрний хоорондын найрамдалт харилцаа, бүхий л салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд олон улсын гэрээ хамгийн нөлөөтэй хэрэглүүр нь болж байдаг.

“Олон улсын эрх зүйн субъектүүд нийтлэг ашиг совирилхынхоо асуудлаар олон улсын эрх зүйд нийцсэн бөгөөд заавал биелэгдэх эрх үүрэг үүсгэсэн харилцаа тогтоох шийдвэрээ илтгэн нотолсон, талууд өөрийн хүсэл зоригийг чөлөөтэй илэрхийлсэн тохиролцоог олон улсын гэрээ гэвэ” хэмээн нийтээр хүлээн зөвшөөрсөн байдаг. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Олон улсын эрх зүйн комисс олон улсын гэрээний эрх зүйг өргөжүүлэн хөгжүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт тавьж байсан бөгөөд 1969 онд Вена хотод болсон олон улсын

дипломат бага хурлаар Олон улсын гэрээний эрх зүйн тухай конвенцыг баталсан билээ. Энэхүү конвенц нь 1980 оноос эхлэн өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Ийнхүү хожим хүчин төгөлдөр болсон учир нь тус конвенцын 84 дүгээр зүйлд заасан “энэхүү конвенц нь 35 дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орох тухай гучин тав дахь баримт бичгийг хадгалуулахаар тушааснаас хойш гуч дахь батламж жуух бичиг буюу нэгдэн орох тухай гучин тав дахь баримт бичгийг хадгалуулахаар тушааснаас хойш гуч дахь өдрөөс хүчин төгөлдөр болно” гэсэнтэй холбоотой юм. Венийн конвенцоор нэр томъёоны асуудлууд, гэрээ байгуулах үе шат, гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл, гэрээнд тайлбар хийх, ямар нөхцөлд тайлбар хийхийг хориглодог тухай, гэрээг түр хугацаагаар хэрэглэх, гэрээний хувьд гуравдагч орны эдлэх эрх зэргийг тодорхой зохицуулж өгсөн байдаг. Энэхүү конвенцоос гадна улс гүрэн болон олон улсын байгууллагын хооронд, засгийн газар хооронд, мөн энэ байгууллагууд өөр хоорондоо гэрээ байгуулах эрх зүйн тухай конвенцыг дээрх комиссоос боловсруулан 1986 онд баталсан. Энэ конвенц нь одоогоор хүчин төгөлдөр болоогүй ч дээр дурдсан субъектүүдийн хооронд гэрээ байгуулахад заншлын хэм хэмжээ болгон хэрэглэж байна.

Олон улсын гэрээг дотор нь олон улсын нийтийн эрх зүйн гэрээ ба олон улсын хувийн эрх зүйн гэрээ гэж ангилж болно. Ингэж ангилахын гол ач холбогдол нь олон улсын нийтийн эрх зүйн гэрээ болон олон улсын хувийн эрх зүйн асуудлыг зохицуулсан олон улсын гэрээний аль алиныг байгуулахдаа “Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хууль”-ийг баримтална. Харин эдгээрийн үйлчлэх хүрээ, бий болгох эрх үүргийн хувьд зарим талаар ялгаатай байдаг.

Олон улсын нийтийн эрх зүйн гэрээ гэдэг нь нэгдүгээрт, сонирхогч улсуудын хүсэл зоригийн зөвшилцөл буюу олон улсын эрх зүйг бүтээх үйл ажиллагааны үр дүн; хоёрдугаарт, оролцогч улсуудын эрх үүргийг тогтоох замаар улс хоорондын харилцааг зохицуулж буй олон улсын эрх зүйн хэм хэмжээ юм. Олон улсын нийтийн эрх зүйн гэрээний гол онцлог нь аливаа улсын дотоод харилцааг ерөнхийд нь зохицуулдаг. Өөрөөр хэлбэл, гэрээнд оролцогч улсын төрд шууд үүрэг бий болгодог бөгөөд тухайн улсын иргэд, хуулийн этгээдэд шууд эрх үүрэг бий болгодоггүй байна. Харин аливаа улсын иргэд, хуулийн этгээдэд эрх үүрэг бий болгоход чиглэгдсэн гэрээ нь олон улсын хувийн эрх зүйн гэрээ юм. Гэхдээ олон улсын хувийн эрх зүйн гэрээ тухайн улсын дотоодод үйлчлэхийн тулд үндэсний эрх зүйн хэм хэмжээ болон хувирсан байх

шаардлагатай гэж олон улсын эрх зүй судлаачид үздэг. Үүнийг *трансформацийн онол* гэж нэрлэдэг. Энэ нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг дотоодын хууль тогтоомж болгож хувиргах үйл явцыг хэлнэ. Ингэж хувиргах үйл явц нь тухайн олон улсын гэрээг соёрхон батлах, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хууль гаргах зэрэг хэлбэрээр илэрдэг.

Аливаа олон улсын гэрээг Эрх зүйн эх сурвалжийн хувьд хэрэглэхийн өмнө үндэсний эрх зүйд шилжүүлсэн эсэхийг шалган үзэх хэрэгтэй. Энэ үед олон улсын нийтийн эрх зүйн болон тухайн улсын Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт шаардагдана¹. Олон улсын гэрээ байгуулах нь ихэвчлэн дараах үе шатаар хэрэгждэг. Үүнд:

- Хэлэлцээр хийх;
- Үзэглэх; Хэлэлцээр хийгч талуудын төлөөлөгчид гэрээний тодорхой төслийн талаар тохиролцоно. Гэхдээ уг бичвэрт хэлэлцээрт оролцогч улсууд эрх үүргийн хувьд үл холбогдоно. Энэ нь шинээр хэлэлцээр хийх үед өөрчлөгдөж болно.

- Гарын үсэг зурах; Гэрээнд оролцогч талын итгэмжлэгдсэн төлөөлөгч гэрээний эх бичвэрт гарын үсэг зурснаар гэрээ эцсийн байдлаар бэлэн болно. Түүнчлэн оролцогч улсууд өөрийн улс оронд хүлээн зөвшөөрүүлэх боломжийг хайх үүрэг хүлээнэ.

- Хүлээн зөвшөөрүүлэх үйл ажиллагаа; Олон улсын гэрээг соёрхон батлах эсвэл нэгдэн орох тухай сонирхогч улсын эрх бүхий байгууллагаас шийдвэр гаргах шаардлагатай. Энэхүү шийдвэр нь ОУЭЗ дагуу хүчин төгөлдөр болохын /ратификац/ хамт олон улсын гэрээг дотоодын эрх зүйд шилжүүлэх /трансформац/ үйл явцыг бүрдүүлнэ.

- Ратификац; Олон улсын эрх зүйн дагуу ратификац хийлгэснээр буюу гэрээнд оролцогч улсын эрх мэдэл бүхий байгууллага батламж бичиг гардуулснаар олон улсын гэрээнд оролцогчид эрх, үүргийн хувьд уг гэрээнд олон улсын эрх зүйн үүднээс холбогдоно. Энд болон үүний өмнө дурдсан үе шатыг хамтад нь ратификац гэж нэрлэнэ. Олон улсын гэрээ байгуулах нь зөвхөн гарын үсэг зурснаар дуусахгүй, гэрээг хүлээн зөвшөөрч ратификац хийх хүртэл үргэлжлэх шат дараалсан нарийн үйл ажиллагаа юм.

- Хүчин төгөлдөр болох, Олон улсын гэрээ нь ратификац хийснээр тухайн улсын хувьд хүчин төгөлдөр болно. Олон улсын олон талт зарим гэрээ тодорхой тооны улс хүлээн зөвшөөрсөн, түүнчлэн зарим олон улсын гэрээ нь ратификац хийгдсэнээс хойш тодорхой хугацааны дараа хүчин төгөлдөр болно.

- Хэвлэн нийтлэх; Олон улсын гэрээ нь дотоодын хуулийн нэгэн адил хүчин чадалтай болдог учраас албан ёсоор хэвлэн нийтлэх журмыг ихэнх улс мөрддөг. Олон улсын гэрээ хүчин төгөлдөр болсон цаг хугацаа, хожим нэгдэн орсон бусад улс орны тухай мэдээлэх нь чухал. Албан ёсоор хэвлэн нийтлэгдэхгүйгээр аливаа хууль болон олон улсын гэрээ хуулийн хүчин чадал олж авч чадахгүйд эрх зүйн гол үр дагавар нь оршино.

Монгол Улс 1980 онд Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцод нэгдэн орсон билээ. Ингэснээр Монгол Улс нь нэгдэн орсон болон баталсан гэрээгээ биелүүлэхээ хүлээн зөвшөөрч буйгаа тод томруун илэрхийлсэн. Энэ нь тус

конвенцын 11 дүгээр зүйлд гэрээг заавал биелүүлэхээ хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлэх арга гэдэгт гэрээнд гарын үсэг зурах, гэрээг бүрдүүлэгч баримт бичгүүдийг солилцох, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох буюу тохиролцсон бусад аргыг хэлнэ гэж заасан байдаггаас тод харагдана.

Тус конвенцод нэгдэн орсны дараагаар 1985, 1993 онд Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийг тус тус батлан гаргаж байсан. Сүүлд батлагдсан хуулийн өмнөх хуулиас ялгарах шинж нь:

1. Олон улсын нийтийн эрх зүйн гэрээ ба олон улсын хувийн эрх зүйн гэрээг дотоодын хуулийн хүрээнд ялгаж өгсөн.

2. Ойлголт, нэр томъёог тодорхойлон цэгцлэхийн хамт гэрээ байгуулах, бүртгэх, хадгалах, биелэлтэд нь хяналт тавих, нэмэлт, өөрчлөлт оруулах, тайлбарлах, үйлчилгээг түр зогсоох зэрэг процедурын шинэтэй заалтыг оруулж өгсөн.

3. Эрх зүйт төрийн онол болон Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн гэрээ байгуулах, гарын үсэг зурахад засаглах эрх мэдлийг хэрэгжүүлэх субъектүүдийн эрх хэмжээний заагийг нарийн тогтоож өгсөн байна.

Олон улсын гэрээ гэж юу вэ?

Үүнийг Венийн конвенцод: "Олон улсын гэрээ гэж нэг буюу хоёр эсвэл өөр хоорондоо холбоотой хэд хэдэн баримт бичигт агуулагдаж байгаа бөгөөд түүний тодорхой нэрээс хамаарахгүйгээр улсуудын хооронд байгуулсан, олон улсын эрх зүйгээр зохицуулагдаж байгаа олон улсын хэлэлцээрийг хэлнэ" гэж заасан. Харин Олон

1. Ж.Амарсанаа. "Хуний эрх: Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал", УБ., 2000 он, 31-45 дахь тал.

улсын гэрээний тухай Монгол Улсын хууль "Олон улсын гэрээ гэж Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, үүргийг тодорхойлон тогтоосон, олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр болон олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ"² гэжээ. Гол ялгаа нь Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хууль нь зөвхөн Их Хурал болон Улсын Засгийн газраас байгуулсан гэрээ л Олон улсын гэрээний тухай хуулиар зохицуулахаар заасан байна.

Монгол Улсын яам, агентлаг болон тухайн гэрээгээр зохицуулж байгаа асуудлын хүрээнд хамаарагдах бусад байгууллага Монголын талын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангана. Монгол Улсын Их Хурал нь соёрхон баталсан олон улсын гэрээ болон шаардлагатай гэж үзсэн Монгол Улсын олон улсын аливаа гэрээний хэрэгжилтэд хуулиар тогтоосон журмын дагуу хяналт тавина.

Олон улсын гэрээний биелэлтийг хангахын хувд ийм арга хэмжээг авч хэрэгжүүлдэг олон улсын хэмжээний байгууллага байдаггүй учир түүний биелэлтийг хангах тал дээр талууд өөрсдөө л анхаарал тавих шаардлагатай байдаг. Ийм учраас гэрээний хэрэгжилтийн гол нөхцөл нь "pacta sunt servanda" зарчим болдог. /гэрээ зөрчигдөшгүй бөгөөд заавал биелэгдэх/

Олон улсын харилцаанд олон улсын гэрээний биелэлтийг хангах хэд хэдэн арга механизм байдаг. Үүнд:

а/ олон улсын баталгаа бий болгох; Гэрээний биелэлтийг хангахын тулд шаардлагатай

арга хэмжээ авахаар хөндлөнгийн нэг буюу хэд хэдэн улс үүрэг авахыг хэлнэ.

б/ олон улсын хяналт бий болгох: Энд дэлхийн худалдааны байгууллагыг жишээ татаж болно. Энэ байгууллагын үндэс 1945 онд байгуулагдсан "Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр"-ээр тавигдсан. Байгуулсан гол зорилго нь ТХЕХ-ийн биелэлтийг хангах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах явдал юм.

УИХ, Засгийн газраас бусад төрийн байгууллага гадаадын засгийн газрын байгууллагууд, олон улсын байгууллагатай хоёр талт болон олон талт гэрээ байгуулах явдал маш элбэг байдаг. Эдгээр гэрээг Засгийн газрын 1994 оны 201 дүгээр тогтоолоор баталсан байгууллага хоорондын гэрээ байгуулах журмаар зохицуулсан байна. Гэхдээ ийм гэрээний асуудлыг тусгайд нь зохицуулах ямар шаардлага байна вэ? гэдэг асуулт гарч ирнэ.

Практикт олон улсын гэрээний эрх зүйгээр улс хоорондын, яамд хооронд болон төрийн байгууллагуудаас байгуулсан буюу локаль гэрээг олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцээр зохицуулахыг үгүйсгээгүй байдаг.

Гэрээ байгуулах

а/ Монгол Улсын эрх бүхий байгууллагууд олон улсын гэрээний төслийн талаар хэлэлцээ хийж, эх бичвэрийг тохирсны үндсэн дээр түүнд гарын үсэг зурах, нэгдэн орох, соёрхон батлах, батлах замаар гэрээг байгуулна.

б/ Гэрээ байгуулах гэсэн нэр бүхий конвенцын 2 дугаар хэсгийн нэгдүгээр бүлгийг үзвэл гэрээнд гарын үсэг зурах,

нэгдэн орох, соёрхон батлах, батлах замаар гэрээг байгуулна гэсэн байна. Энэхүү конвенцын 11 дүгээр зүйлд зааснаар дээрх арга замууд нь гэрээг заавал биелүүлэхээ хүлээн зөвшөөрч буй хэрэг болно гэсэн байна.

Гэрээг хэрэглэх

Хэрэв өөр хандлага байгаа нь гэрээнээс илрээгүй буюу өөр хэлбэрээр тогтоогдоогүй бол оролцогч бүрийн хувьд түүнийг бүх нутаг дэвсгэрийн хувьд гэрээ заавал биелэгдэнэ.

Гэрээний хэрэгжилт, биелэлтэд нь хяналт тавих

Гэрээний хэрэгжилт, биелэлтэд нь тавих хяналтын талаар конвенцод тусгайлсан заалт байхгүй, гэхдээ нэгэнт улс гүрэн гэрээ заавал биелүүлэхээ дээр дурдсан арга замуудын аль нэгийг сонгон илэрхийлсэн тохиолдолд тухайн олон улсын гэрээ нь ямар ч маргаангүйгээр биелэгдэх ёстой нь ойлгомжтой юм. Өөрөөр хэлбэл конвенцын 11 дүгээр зүйлийг гэрээг хэрэгжүүлэх, биелүүлэх нэг нөхцөл нь болно гэж ойлгож болно.

Ийнхүү Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцыг Монгол улсад хэрэгжүүлэхэд "Олон улсын гэрээний тухай Монгол Улсын" хууль чухал суурь болж байгаа билээ.



1. Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц. 1969 он, 1 дүгээр зүйл

2. Олон улсын гэрээний тухай Монгол Улсын хууль. 1993 он, 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг.

Монгол Улсын Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэтгэлийн зарим асуудал



ХЗУТ-ийн секторын эрхлэгч,
доктор, профессор
Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ

Нэг. Эрүүгийн ба Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэтгэлийн үзэл баримтлал

Манай улсад одоогийн мөрдөгдөж байгаа хуулийн өмнө Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль 1960-аад оноос 2002 оны 9 дүгээр сарын 1-нийг хүртэл үйлчилсэн билээ. Эдгээр хуулийг манай улс социалист хамтын нийгэмлэгийн идэвхтэй гишүүн байсан, эрх зүйн тогтолцооны хувьд социалист эрх зүйн бүлд хамаарч байсан түүхэн цаг үед тухайн үеийн улс төрийн бодлого, чиглэл, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүтээж, дагаж мөрдөж иржээ. Эдгээр хууль нь ЗХУ-ын /гэр үеийн нэрээр/ эрүүгийн хууль тогтоомжийг агуулга, хэлбэрийн хувьд

загварчлан хуулбарласан байсан ба зарчмын ялгаатай зүйл ховор байв. Тэдгээрт социалист эрх зүйн бүлийн нийтлэг шинж болох "эрх зүйн үзэл баримтлалыг коммунист нийгэм байгуулахад тус дөхөм үзүүлэх хүч хэмжээн үздэг"¹ шинж тод тусгагдаж, тухайн нийгэмд хүрэх эрх зүйн арга хэрэгсэл болж байлаа.

1990 онд Монгол Улсад ардчилсан хувьсгал ялж, 1992 онд нийгмийн энэ чухал өөрчлөлтийн үр дүнг баталгаажуулсан шинэ Үндсэн хууль батлагдсан нь тус улс цаашид ардчилсан хөгжлийн замыг тууштай баримтлах үндсийг тавьсан бөгөөд үүгээрээ тухайн нийгмийн харицаанд нийцсэн шинэ зохицуулалтын эрэлт шаардлагыг буй болгосон юм. Үүний дагуу УИХ-ын 1998 оны 18 дугаар тогтоолоор "Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг баталсан бөгөөд түүнд:

- Прокурорын үйл ажиллагааг шүүх эрх мэдлийг зөв хэрэгжүүлэхэд идэвхтэй нөлөөлөх чиглэлээр боловсронгуй болгоно²;

- Хэрэг бүртгэх мөрдөн байцаах байгууллагуаг шинэчлэн зохион байгуулна³;

- Эрүү, иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журмыг Үндсэн хуулийн агуулгад нийцүүлэн шинэчлэхэд чиглэгдсэн хуулиудыг батлан

мөрдүүлнэ. Ингэхдээ шүүгчийн ёс суртахууны болон хуулийн өмнө хүлээх хариуцлагыг өндөржүүлж, шүүн таслах ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг бүх шатанд жигд баримтлах, энэ ажиллагааны явцад хүний эрхийг дээдлэн хангах, аливаа чирэгдэл, хүнд суртлыг арилгах, шударга ёсыг чанд сахиу зарчмыг удирдлага болгоно⁴;

- Эрүү, иргэний хэрэг, захиргааны эерчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд явагдах өмгөөллийн үйл ажиллагааны... талаархи эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно⁵ хэмээн заажээ. Мөн Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн "Хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах талаар" гэсэн хэсэгт хамааруулан тусгаан 14 хуулийн жагсаалтад Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль багтсан юм.⁶

Эндээс харахад дээрх хөтөлбөрт хүний эрхийг хангах асуудалд гол ач холбогдол өгч, түүнтэй уялдуулан шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгчийн эрх зүйн байдал, тэдгээрийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг боловсронгуй болгох асуудлыг бодлого болгон тусгажээ.

1. С.Нарангэрэл, "Монголын ба Дэлхийн эрх зүйн тогтолцоо", 2001 он, УБ., 267 дахь тал.

2. Тус хөтөлбөрийн 28 дүгээр зүйлд

3. Тус хөтөлбөрийн 29 дүгээр зүйлд

4. Тус хөтөлбөрийн 30 дугаар зүйлд

5. Тус хөтөлбөрийн 34 дүгээр зүйлд

6. УИХ-ийн 1998 оны 18 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

2002 оны 1 дүгээр сарын 3-нд Эрүүгийн, мөн оны 1 дүгээр сарын 10-нд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн баталсан бөгөөд эдгээр хууль 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хуулийн хүчин төгөлдөр болж үйлчилснээр дээрх хөтөлбөрийн цаашалт үндсэндээ хангагдсан гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл Эрүүгийн эрх зүйн салбар дахь хууль тогтоомжийн шинэчлэлийн гол ажил үүгээр хийгдсэн бөгөөд одоо түүнийг практикт зөв хэрэгжүүлэх, мөн онол,

Практикийн хувьд зайлшгүй авч үзээр асуудлуудыг цаашид үргэлжлүүлэн судалж уг хуулиудыг чанаржуулахад чиглэгдсэн арга хэмжээнд анхаарал төвлөрч байна. Тухайлбал, эдгээр хуулийг дагаж мөрдсөнөөс хойшхи хугацаанд уг хуулиудын хэрэгжилтэн байдлаа үргэлжилсэн судалгаа хийгдэж байгаа бөгөөд үүнд Хууль зүйн үндсийн төв судалгааны байгууллагын хувьд идэвхтэй оролцож өөрийн хувь нэмрийг оруулж байгаа. Үүнд үндэслэн Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, санал боловсруулах ажлын хэсэг томилогдон ажиллаж байна.

Шинэ хуулиудыг дагаж мөрдөөд удаагүй байгаа, мөн тэдгээрийг чанаржуулан сайжруулах чиглэлийн судалгаа эрчимтэй хийгдэж байгаа цаг үед энэхүү олон улсын бага хурал зохион байгуулагдаж байгаа нь бидэнд уг асуудлыг улам өргөн хүрээтэй, илүү харьцуулалттай авч үзэх боломжийг олгож байна.

Хэдийгээр Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэтгэлд манай хууль цаазны үе үеийн түүх, уламжлал хамааралтай, үүнтэй холбогдуулан ихээхэн өргөн хүрээтэй асуудлуудыг хөндөж болох боловч энэхүү илтгэлд зөвхөн тухайн шинэтгэлийн өнөөгийн хөгжлийн үе шатны

гол гэж үзсэн зарим асуудлуудыг товч тусгахыг зорилго.

Хоёр. Эрүүгийн хуулийн шинэтгэлийн талаар

Үүний өмнөх Эрүүгийн хуулийг БНМАУ-ын АИХ-аас 1961 оны 1 дүгээр сарын 31-нд баталсан бөгөөд мөн оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс хуулийн хүчин төгөлдөр болж үйлчилсэн байна. Үүнээс хойш социализмын үед энэ чиглэлээр хийгдсэн томоохон шинэтгэл нь тус хуулийг шинэчлэн найруулж БНМАУ-ын АИХ-аас 1986 оны 12 дугаар сарын 5-ны өдөр батлан 1987 оны 7 дугаар сарын 1-нээс дагаж мөрдүүлсэн явдал бөгөөд энэ хууль одоогийн шинэ хууль үйлчилж эхэлсэн өдөр хүчингүй болсон юм. 40 гаруй жил тогтвортой дагаж мөрдөгдсөн энэ хууль түүхэн үүргээ гүйцэтгэсэн бөгөөд түүнийг шинэ хуулиар халах үндэслэл нь:

- нийгмийн шударга ёс, тэгш байдлын талаарх ардчиллын зарчимд тус хуулийн үзэл баримтлалыг нийцүүлэх;

- хүний эрх, үүрэг, хариуцлагын асуудалд анги, нам, өмчийн ялгавартай байдлын үүднээс хандах бодлого чиглэлийг өөрчлөх;

- эрүүжүүлэх, эс эрүүжүүлэх бодлогыг өнөөгийн дэлхий нийтийн болон үндэсний эрүүгийн нөхцөл байдалтай уялдуулах шаардлагатай нэн тэргүүнд холбоотой байв.

Тухайлбал, 1961 оны Эрүүгийн хуулийн 4 дүгээр зүйлд "БНМАУ-ын тусгаар тогтнол, нийгмийн ба төрийн байгууламж, социалист өмч, иргэдийн амь бие, улс төр, хөдөлмөр, эд хөрөнгийн болон бусад эрх, түүнчлэн хуулиар тогтоосон социалист хэв журамд хор хүргэсэн бөгөөд эрүүгийн хуульд заасан нийгэмд аюултай хэргийг гэмт хэрэг гэж үзнэ." хэмээсэн гэмт хэргийн ойлголтын тодорхойлолтод байгаа "социалист өмч", "социалист хэв журам" зэрэг

тодотголуудад ихээхэн өндөр ач холбогдол өгч, ялын бодлогын хувьд ч ялгавартай хандаж ирсэн юм. Үүнийг одоогийн хуулиар "Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүй гэмт хэрэг гэнэ." гэж хялбар энгийн томъёолсон нь гэмт хэргийн тухай социалист эрх зүйн тогтоолдооноос татгалзсан бодлого илэрхийлэл юм.

Хуучин Эрүүгийн хуульд нэг хэм хэмжээнд багтаан тоочсон хэлбэрээр тусгаж байсныг ихээхэн далгэрэнгүй болгож, зарчим болгоныг бие даасан заалт болгон түүнд хамаарах ойлголтуудыг тодорхойлж, тэдгээр:

- эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй байх /Здугаар зүйлийн 2 дахь хэсэг/;

- хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх /3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг/;

- гэм буруугүйгээр энэ хуульд заасан хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх /4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг/;

- гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэх /6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг/ зэрэг орчин үеийн эрүүгийн эрх зүйн ололтод үзэл баримтлалуудыг ихээхэн тодорхой болгож хуульчилсан нь эрүүгийн шинэ хуулийг нэг мөр дагаж мөрдөхөд ихээхэн дэвшилтэй алхам болсон гэж үзэж байна.

Эрүүгийн хариуцлагын хувьд шинэ хуульд өмнөх хуулиас хөнгөн ба хүндэвтэр гэмт хэргийн хувьд харьцангуй хөнгөн, хүнд ба онц хүнд гэмт хэргийн хувьд харьцангуй хүнд байх бодлогоыг барьсан бөгөөд албадан ажил хийлгэх, баривчлах гэсэн 2 төрлийн алыг шинээр нэмж тусгасан байна. Энэ нь шинэ хуулийн ялын

бодлогыг туйлшруулахгүй байх, мөн хорих ялын оронд сонгон хэрэглэх ялын төрлийг нэмэгдүүлэх зорилгоор хийсэн шинэчлэлт юм. Тухайлбал, цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд бүх насаар нь хорих ялаар сольдог байсныг өөрчилж 30 жилийн хугацаагаар гянданд хорихоор зааснаас гадна хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн гэм буруутай этгээд хохирогчтой сайн дураараа эвлэрсэн бөгөөд учруулсан хохирлоо бүрэн төлсөн, гэм хорыг арилгасан бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болохоор хуульчилснаас эрүүгийн хариуцлагыг уян хатан байлгах бодлого барьсныг харж болно. Эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, ялыг тэнсэх зэрэг тохиолдолд хохирогчид учруулсан хохирлыг төлсөн, гэм хорыг арилгасан байхыг зайлшгүй шаардахаар шинэ хуульд тусгасан нь ялын бодлогыг хохирогчийн хөндөгдсөн эрхийг сэргээх асуудалтай холбосон шинэлэг заалт болсон юм.

Хохирол болон торгуулийн хэмжээг өмнөх хуульд тодорхой мөнгөний дүнгээр илэрхийлдэг байсан нь мөнгөний ханш, амьжиргааны төвшин, хөдөлмөрийн хөлсний хэлбэлдээл зохицон уян хатан байж чаддаггүй дутагдлыг гэтлэхийн тулд тэдгээрийн хэмжээг тодорхойлох тусгай нэгж буй болгон түүнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр орлуулан тухайн нэгжийг нэмэгдүүлж хорогдуулах замаар тогтоодог болсон нь амьдралд илүү нийцтэй болжээ. Харин хохирол болон торгуулийн нийт хэмжээтэй холбоотой цаашид боловсронгуй болгох асуудал байхыг үгүйсгэхгүй.

Өмнөх хуульд захиргааны шийтгэл хүлээсний дараа дахин тийм зөрчил гаргавал эрүүгийн

хариуцлага хүлээлгэдэг байсныг больж шинэ хуулиар захиргааны зөрчлийг ямар ч тохиолдолд эрүүгийн гэмт хэрэг гэж үзэхгүй байхаар шийдвэрлэсэн нь онолын хувьд зүйтэй шийдэл болсон гэж үзэж байна.

Шинэ Эрүүгийн хуульд гэмт хэргийн нийгмийн хор аюулыг үгүйсгэх нөхцөл байдлуудын тохиолдлуудыг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийн дотор ихээхэн маргаан үүсгэж байж шийдвэрлэгдсэн асуудал бол аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлсэн тохиолдолд гэм буруутай гэж үзэж, эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байсан хуучин уламжлалыг эвдэж, хэр хэмжээ болон түүнийг хэтрүүлсэн гэсэн ойлголтыг үгүй болгосон явдал юм. Энэ нь өөрийгөө хамгаалах, аюулгүй байдлаа хангах үний эрхийг баталгаажуулахад дөхөм үзүүлсэн зоримог өөрчлөлт болсон билээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн тухайд:

- Алах, хүнд гэмтэл учруулахаар заналхийлэх;
- Виае үнэлэх;
- Эрчим хүч ашиглах журам зөрчих;
- Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчих;
- Цэргийн үүрэгтэн, цэргийн тоо бүртгэлээс зайлсхийх;
- Гэрлэлтээ бүртгүүлэхдээ гэрлэхэд харшлах шалтгааныг нуух буюу худал мэдэгдэх зэрэг 50 гаруй зүйлийг үл эрүүжүүлэх бодлогын хүрээнд хасч дийлэнхдээ эдийн засаг, бизнесийн салбарын ашиг сонирхол, татварын бодлого, төсвийн бүрдүүлэлт, ашигдалтын эрх ашгийг хамгаалах, зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын хууль бус эргэлт, хүн худалдаалах, мөнгө угаах зэрэг шинэ төрлийн гэмт хэрэгтэй

тэмцэхэд чиглэгдсэн агуулгатай 40 орчим зүйлийг шинээр нэмж тусгасан байна. Мөн “Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг” гэсэн бүлгийг шинээр нэмсэн нь даяаршиж байгаа дэлхий нийт, хүн төрөлхтний аюулгүй байдлыг хамгаалахад үндэсний хууль тогтоомжоороо дэм үзүүлж олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө энэ талаар худалдсан үүргээ биелүүлэхэд чиглэгдсэн чухал алхам, шинэчлэл болсон юм.

Олзуурхан тэмдэглүүштэй Энэ мэт олон чухал ололтын зэрэгцээ цаашид дахин хянаж үзэж улам боловсронгуй болгох хэрэгтэй асуудлууд ч нэлээд байгаа нь судалгаанаас харгалдаж байна. Тухайлбал, хуульд заасан ялын доод хэмжээнээс доош татаж ял ногдуулах боломжтой байсан хуучин хуулийн уламжлалыг өөрчилж ийм боломжийг огт үгүйсгэсэн нь шүүгчээс хэргийн онцлог нөхцөл байдлыг харгалзан ялыг уян хатан хэрэглэх эрх хэмжээг нь хязгаарласан бөгөөд цаашид үүнийг дагасан сөрөг үр дагавар үүсгэж болзошгүй юм. Мөн гэмт хэргийг гэм буруугийн хэлбэр болон ялын хэмжээг харгалзан ангилдаг байсныг өөрчилж зөвхөн ялын хэмжээг харгалздаг болсныг онол, практикийн хувьд дэвшил биш ухралт болсон гэж үзмээр байгаа юм. Энэ хоёр асуудалд анхаарал хандуулж, ямар байвал зохистойг ултай суурьтай авч үзэх нь уг хуулийн мөн чанар, хэрэгжилт, үр нөлөөнд ихээхэн чухал ач холбогдолтой байх болно. Энэ талаар ХБНГУ-ын мэргэжилтэн “Ял ногдуулах тухайд Европын ажиглагчийн хувьд анхаарал татсан зүйл бол ялын хэмжээг тогтоох шүүгчийн эрх мэдлийг тун бага байхаар хуульд заасан явдал юм” гээд энэ нь Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэхэд төвөгтэй байдал

үүсгэж болошгүй¹ гэсэн дүгнэлт хийсэнтэй санал нэг байна. Эрүүгийн хуульд шинээр тусгагдсан баривчлах ял нь хорих ялын оронд сонгон ногдуулах ялын оновчтой хувилбар мөн эсэх нь эргэлзээтэй бөгөөд үүний оронд ганцаарчлан хорихоос өөр төрлийн сонгох ялуудын хувилбаруудыг эрэлхийлэх нь илүү үр нөлөөтэй байж мэдэх юм.

Гурав. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэтгэлийн талаар

Үүний өмнөх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг БНМАУ-ын АИХ-аас 1963 оны 12 дугаар сарын 24-нд баталсан бөгөөд 1964 оны 6 дугаар сарын 1-нээс хуулийн хүчин төгөлдөр болж үйлчилсэн байна. Үүнээс хойш тус хуульд нийт 12 удаа нэмэлт өөрчлөлт оруулж байсны сүүлчийн нь буюу 1994 оны өөрчлөлт тус хуулийг 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэхэд чиглэгдсэн томоохон өөрчлөлт байсан юм. Гэвч уг хуулийн хуучин хэм хэмжээ нь агуулгын хувьд шинэтэйгээ зөрчилдөх нь их болсон тул Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хуулийг боловсруулан батлах зайлшгүй шаардлага үүссэн байна.

Энэхүү шинэтгэлийн гол агуулга нь:

- Байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын чиг үүргийг хяналт ба хариуцлагын оновчтой хэлбэрийг сонгон онолын үүднээс зөв хуваарилах,
- Байцаан шийтгэх ажиллагааны хүнд суртлыг аль болох багасгаж илүү шуурхай болгох,

- Байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах баталгааг сайжруулж бодитой болгоход чиглэгдсэн болно.

Шүүхийн өмнөх хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт нь дотроо шаталсан бүтэцтэй нэг үе

шат байсныг гэмт хэргийн ангиллаар харьяалан тус тусдаа хэрэг мөрдлөг зэрэгцэн бие даасан үе шат болгон өөрчлөв. Энэ тогтолцоогоор хэрэг бүртгэлтэд хөнгөн хүндэтгэр гэмт хэрэг, мөрдөн байцаалтад хүнд, онц хүнд гэмт хэрэг харьяалахаар болсон ба хэрэг бүртгэлт явуулах хугацааг мөрдөн байцаалтынхаас харьцангуй богино тогтоосон байна.

Эрүүгийн байцаах ажиллагаанд дахь прокурорын эрх хэмжээ нэмэгдэж эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, хэргийг хэрэгсэхгүй болгох, түдгэлзүүлэх зэрэг шүүхийн өмнөх үе шатны гол шийдвэрүүдийг гаргадаг болсон нь түүний яллах, хяналт тавих чиг үүрэгт нийцүүлэн хийсэн өөрчлөлт юм.

Баривчлах, цагдан хорих арга хэмжээ авах зөвшөөрлийг прокурор өгдөг байсан өмнөх уламжлалыг өөрчилж энэ зөвшөөрлийг шүүгч өгдөг болсон нь байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах баталгааг нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болсон бөгөөд манай нэгдэн орсон олон улсын гэрээний үзэл санаанд нийцсэн, орчин үеийн байцаан шийтгэх ажиллагааны чиг хандлагыг харгалзан чухал алхам болсон билээ. Одоо үүнийг практикт хэрэгжүүлэх тогтолцоо, зохион байгуулалтын асуудалд онцгой анхаарах хэрэгтэй байгаа юм. Мөн яллагдагчийг цагдан хорих хугацааны цаад хязгаарыг дөрүй 12 сараар хорогдуулсныг мөн энд олзуурхан тэмдэглэж байна.

Эрүүгийн шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмаар явуулах тухай 1994 онд тус хуульд орсон нэмэлтийг 2002 оны шинэ хуульд ихээхэн дэлгэрэнгүй болгож тусгасан бөгөөд мэтгэлцүүлэн шүүх

болон байцаан шүүх тогтолцооны холимог хувилбарыг сонгож авсан нь онолын хувьд ихээхэн сонирхол татаж байна. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хавтаст хэргийг шүүгч шүүн таслах ажиллагааны өмнө бүрэн уншиж судалдаг, шүүхээс хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаадаг, шүүгчийн зүгээс шүүхийн хэлэлцүүлгийн аль ч үед асуулт тавьж болдог зэрэг хуучин уламжлал хадгалгдсан хэдий ч яллах ба өмгөөлөх талууд шүүхэд мэтгэлцэх өргөн бололцоог хангасан заалтууд тусгагдсан юм.

Мөн шүүхийн ажиллагаанд оруулсан ихээхэн том өөрчлөлт нь шүүхийн харьяалал юм. Өмнө нь онц хүнд гэмт хэргийг аймаг, нийслэлийн шүүх, бусад хэргийг сум болон сум дундын, дүүргийн шүүх анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг байсан бол одоогийн хуулиар эрүүгийн бүх ангиллын хэргүүд сум, сум дундын, дүүргийн шүүхээр анхан шатны журмаар хянан шийдвэрлэгддэг болов. Харин аймаг, нийслэлийн шүүх давж заалдах шатны гомдол, эсэргүүцэлтэй хэргийг, Улсын дээд шүүх хяналтын шатны гомдол, эсэргүүцэлтэй хэргийг хянан шийдвэрлэх юм. Шинэ хуулиар ийнхүү анхан шат, давж заалдах шат, хяналтын шатны харьяаллыг хооронд нь тодорхой заатай болгож өглөө. Энэ нь шүүх шат шатандаа өөрт нэгдсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, анхан шатны шүүхийн эрх хэмжээ, хариуцлагыг нэмэгдүүлэх, ингэснээр шүүн таслах ажлын чанар, хяналтын тогтолцоо сайжрах боломж бүрдэнэ гэж тооцоолж байгаа юм.

Одоогийн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд:

- Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хэрэг бүртгэгч, мөрдөн

байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэнд учирсан хохирлыг арилгах;

Монгол Улсын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, прокурор, шүүхийн байгууллага болон гадаад улсын холбогдох байгууллагын эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх ажиллагаа гэсэн хоёр бүлгийг шинээр тусгасан ба энэ нь хүний хөндөгдсөн эрхийг сэргээх ба гадаад орнуудтай байцаан шийтгэх ажиллагааны чиглэлээр хамтран ажиллах явдлыг хуульчилсан анхдагч тохиолдол болж байгаагаараа онцлогтой.

Манай шинэ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг гадаадын судлаачид ч сонирхон судалж өөрсдийн байр суурийг илэрхийлж байна. Тухайлбал, ХБНГУ-ын профессор Кают "2002 оны 9 дүгээр сарын 1-нд хүчин төгөлдөр болсон Эрүүгийн байцаан шийтгэх хууль нь дийлэнх талаараа олон улсын стандартад нийцэж байгаа бөгөөд зарим талаараа бүр давж гарсан байна" гээд давж гарсан гэж үзсэн зарим заалтын хэрэгжих боломжид эргэлтээ төрж байгаагаа илэрхийлжээ¹. Мөн ХБНГУ-ын профессор Бернд Шюемани "Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг Европын орнуудын Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудтай эрх зүйн баталгааны хувьд харьцуулан үзэхэд нийтлэг хэв шалгуураас нь хооронд зүйл цөөн, харин ч зарим талаар боловсролгүй болжээ"² гэж дүгнээд зарим хэм хэмжээ тодорхой бус байгаагаас хийдэл үүсч болзошгүйг тэмдэглэсэн байна. Мөн тэрээр "Монголын энэ зохицуулалтаар өмгөөлөгч Америкийн ч тэр, эх газрын ч тэр эрүүгийн байцаан шийтгэх

ажиллагаанд өмгөөлөгчийн оролцох эрхээс хавьгүй давуу эрх эдэлж байна... Европын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд өмгөөлөгчийн оролцох байр суурь сул байгаа нь дараах байдлаар тайлбарлагддаг. Байцаан шийтгэх ажиллагаа үр дүнд хүрэх нь эхний шатандаа магадлал багатай байдаг. Учир нь яллагдагч этгээд тодорхой шалтгаанаар байцаан шийтгэх ажиллагаанд саад учруулахыг эрмэлздэг ба мөрдөн байцаалтыг үр дүнгүй болгох олон боломж түүнд байдаг бөгөөд үүнийг мөрдөн байцаах байгууллагууд тэр бүр мэдэх боломжгүй. Германы Эрүүгийн байцаан шийтгэх хуульд үүнийг "мөрдөн байцаалтын зоригдод" саад учруулах" хэмээн тодорхойлдог³ гэжээ.

Гадаадын судлаачид мэргэжилтнүүдийн олж хараад Европын жишгээс давсан, түүнээс илүү боловсролгүй болсон гэж үнэлж байгаа зүйлүүдээр бид бахархаж болох боловч онолын хувьд энэ асуудалд нухацтай хандах, үнэхээр бид дөвшил хийсэн үү, эсвэл байцаан шийтгэх ажиллагаанд яллагдагч, хохирогч талуудын эрх ангийг тэнцүү анхаарах зарчмыг анхааралгүй нэг талд нь хэт давуу байдал үүсгээд байна уу гэдэгтэй дүгнэлт хийх хэрэгтэй юм. Тухайлбал, хэрэг бүртгэлтийн хугацаанд тодорхой хязгаар тавьж цаашид сунгагдах боломжгүйгээр хуульчилснаас болж хөндөгдсөн эрхээ сэргээлгэж чалахгүй үлдэж байна хохирогчийн тоо, ял завшиж байгаа хүмүүсийн ч тоо аль аль тогтвортой өсч байгааг бид анзаарахгүй байх аргагүй. Энэ мэтээр уян хатан бус, ямар ч гарцгүйгээр хуульчилсан хэм хэмжээнүүд шинэ хуульд нэлээд байгаа.

Мөн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг зэрэгцсэн институтууд болгосныг миний хувьд онол, практикийн аль ч үүднээс зөвтгөх үндэслэлийг олж харахгүй байгаа бөгөөд ялангуяа орон нутагт энэ тогтолцоо хэрэгжихэд ихээхэн бэрхшээл учирч, хөрсгө санхүүгийн үргүй зардал, байцаан шийтгэх ажиллагааны давхардал, харьяаллын маргаан үүсэх нөхцөлийг бүрдүүлж байгаад хууль тогтоох байгууллагын анхаарлыг зориуд хандуулахыг хүсч байна.

Дөрөв. Дүгнэлт

Эрүүгийн бодон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинэтгэлийн үндсэн зорилго эдгээр хуулийг шинээр баталж мөрдүүдснээр үндсэндээ хангагдсан бөгөөд энэхүү зорилгод хүрэхийн тулд өмнөө тавьсан зорилтуудыг өмнөх уламжлал, олон улсын болон бусад улс орны эрх зүйн жишиг хандлагад тулгуурлан амжилттай шийдвэрлэсэн гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Харин үг шинэтгэлийн хоёр дахь үе шатны ажил буюу тэдгээрийн хэрэгжилтийг хангах, цаашид сайжруулан төгөлдөржүүлэх ихээхэн хариуцлагатай ажил эхлээд төдийлэн удаагүй байна. Үүнд л бид шинжлэх ухаанч, бодитой бөгөөд улс төрийн болон байгууллагын элдэв туйлширсан ашиг сонирхлоос ангид хандаж чадвал шинэтгэлийн энэ үе шатны зорилтыг амжилттай биелүүлж чадна гэдэгт эргэлзэх явдалгүй юм.



1.Еоахим Кают, "Эрүүгийн эрх зүйд өгөх зөвлөмж, Монголын эрх зүйн шинэтгэл-8 жил", УБ., 33 дахь тал

2.Бернд Шюемани нар, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинжлэх ухааны тайлбар, УБ., 30 дахь тал

3.Мөн бүтээл, 39-40 дэх тал

Эрүүгийн шүүн таслах ажиллагаанд ӨМГӨӨЛӨГЧ МЭТГЭЛЦЭЭНИЙ НЭГ ТАЛ БОЛОХ НЬ



МӨХ-ны гишүүн,
өмгөөлөгч Я.НИЯМЖАВ

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд мэтгэлцэх зарчим тусгагдсан байдал

Манай улсын ЭВШ хуульд анх удаа 1994 онд “Эрүүгийн хэргийг анхан шатны болон давж заалдах шатны журмаар хянан хэлэлцэх шүүх хуралдаан мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явагдана” гэсэн томъёоллоор мэтгэлцэх зарчим тусгагдсан билээ.

2002 онд шинээр батлагдан мөрдөгдсөн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд мэтгэлцэх зарчмын тухай ойлголтыг тодотгоод зогсохгүй, үүнтэй холбогдох ойлголтуудыг

ялдуулан мэтгэлцэх зарчимд нийцүүлэх байдлаар мэтгэлцэх тогтолцоог хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хэд хэдэн хэм хэмжээг тусгасан юм. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлд “Шүүн таслах ажиллагаа нь тэгш эрх бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явагдана. Шүүгдэгчид сонгосон ялыг нотлох үүргийг прокурор хүлээнэ. Өмгөөлөгч нь шүүгдэгчийг өмгөөлөхийн тулд хуульд заасан бүхий л арга хэрэгслээр хууль зүйн туслалцаа үзүүлнэ. Талууд шүүх хуралдааны үед нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох хүсэлт гаргах, хэрэгт ач холбогдол бүхий ямар ч асуудлаар саналаа илэрхийлэх талаар эрх тэгш байна гэж заасан.

ЭВШ хуулийн 5.1.7-д тодорхойлсноор “яллах тал” гэж прокурорыг, мөн хуулийн 5.1.8-д тодорхойлсноор “өмгөөлөх тал” гэдэгт шүүгдэгч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, иргэний хариуцагч, түүний төлөөлөгчийг хэлжээ. Ийнхүү Эрүүгийн байцаан шийтгэх хуульд мэтгэлцээний талуудыг тодорхой болгож, тэдгээрийн гүйцэтгэх чиг үүргийг зааглаж өгсөнд эдгээр хэм хэмжээнүүдийн ололттой

тал оршино. Гэхдээ манай ЭВШ хуульд заагдсан хэм хэмжээнүүд нь мэтгэлцээний сонгодог уламжлалтай харьцуулбал эрс ялгаатай, онцлогтой байгаа болно. Талууд шүүхэд яллах ба өмгөөлөх үндэслэлээ өрсөлдөн нотлох ба шүүх төвийг сахисан байр сууринаас мэтгэлцээний үр дүнг дүгнэж шийдвэр гаргах нь мэтгэлцээний үндсэн шинж бөгөөд англи-саксоны эрх зүйгээс гаралтай ийнхүү мэтгэлцүүлэн шүүх хэлбэр нь шүүх нотлох үүрэг хүлээхгүй, бодитой байх нөхцөлийг хангана. Англи, Америк болон тэдгээртэй нэг эрх зүйн бүлд багтдаг орнуудын хувьд мэтгэлцэх тогтолцоо нь түүхэн уламжлалтай, эх газрын эрх зүйн тогтолцооноос эрс ялгаатай байдаг. Тухайлбал шүүхийн хэлэлцүүлэгт яллах, өмгөөлөх талуудын эрх тэгш оролцоог хангах боломжийг бүрдүүлэхэд илүү их анхаарч мэтгэлцээний тогтолцоог тогтоосныг манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалттай харьцуулан харж болно.

Мэтгэлцээний уламжлалаар бол:

Мэтгэлцээний эхлэл буюу гараа нь талуудад адил байх боломжийг олгож яллах ба өмгөөлөх талууд шүүхийн

хэлэлцүүлгийн эхэнд эхлэлийн үг ээлжлэн хэлж яллах, өмгөөлөх чиглэлээ танилцуулдаг байна. Тэгвэл манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар өмгөөлөгчид нийм боломж олгогдоогүй.

- Шүүгдэгчийн мэдүүлэг нь цагаатгах нотлох баримтад хамаардаг бөгөөд шүүгдэгч өөрөө өмгөөлөх талд багтдаг учир шүүгдэгчийг өмгөөлөгч эхэлж байцаадаг байна. Тэгвэл манай Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар шүүгдэгчээс шүүгч эхэлж мэдүүлэг авсны дараа түүнд эхэлж улсын яллагч асуулт тавих ба дараа нь өмгөөлөгч асуулт тавина.

- Талууд төгсгөлийн үг хэлснээр шүүхийн мэтгэлцээн дуусдаг, шүүгдэгч эцсийн үг хэлдэггүй.

Тэгвэл шүүх хуралдааны шүүмжлэл дууссаны дараа шүүгдэгч эцсийн үг хэлэх боломжийг өдгөдөг ба шүүгдэгчээс хэлэх эцсийн үгийг цагаар хязгаарлаж болохгүй. /Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 280 дугаар зүйл/ Хэдийгээр шүүхийн хэлэлцүүлэг ялагчийн давуу байдлаар эхлэх боловч шүүмжлэлийн дараа шүүгдэгч эцсийн үг хэлж байгаа нь өмгөөлөх талд бас илүү боломж олгож байгаа ололттой явдал юм. Ийнхүү мэтгэлцээн явагддаг сонгодог уламжлалтай харьцуулахад манай Эрүүгийн байцаан шийтгэх хуульд мэтгэлцээний талаар тусгагдсан хэм хэмжээнүүд зөрөөтэй байгаа боловч Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд мэтгэлцэх зарчмыг бүхэлд нь үгүйсгэж болохгүй. Учир нь

Манай Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгагдсан мэтгэлцээн бол уламжлалт хэлбэрийг баримтлаагүй, харин холимог хувилбарыг сонгосон учраас дээрх зөрөөнүүд гарч байгаа юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгагдсан хэм хэмжээнүүдийн дагуу мэтгэлцээнийг явуулах боломжтой гэж үзнэ.

Шүүх мэтгэлцэх нөхцөлийг хангах үүрэгтэй бөгөөд яллах, өмгөөлөх талуудыг шүүхийн хэлэлцүүлэгт тэгш эрхтэйгээр оролцуулна. Мэтгэлцээн бол үнэнийг эрэлхийлэх, шүүхээс шударга шийдвэр гаргах хамгийн тааламжтай нөхцөлийг буй болгодог ардчилсан зохион байгуулалт ба байцаан шийтгэх ажиллагааны үндсийг нэгтгэсэн шүүн таслах ажиллагааны нэн чухал зарчим юм.

Өмгөөлөгч мэтгэлцээнд оролцох бэлтгэл хангах нь

Шүүх хуралдаанд оролцох үүрэг хүлээж томилолт, хүсэлт хүлээж авсан өмгөөлөгч мэтгэлцээнд оролцох бэлтгэл хангах ажилд орно. Үүнд:

1. Хавтаст хэргийн материалыг танилцах;
2. Өмгөөлөгч үйлчлүүлэгчтэйгээ уулзаж ярилцах;
3. Өмгөөлөгч байр суурь, хэргийн онолыг тодорхойлох яедал юм.

Өмгөөлөгч хавтаст хэргийн материалыг хэрхэн уншиж танилцах арга барилаа өөрөө сонгоно.

Өмгөөлөгчийн сонголт нь шүүгдэгчийн гэм буруу,

үйлдлийн олон цөөн, хэргийн зүйлчлэл, ангилал, шүүгдэгчдийн тоо, ээдрээ маргаан зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж янз бүрийн байх ба тэмдэглэл, түүвэр заавал хийх хэрэгтэй. Тухайдбал олон үйлдэлтэй хэргийг уншаад хэргийн зүйлчлэл, ангиллаар түүвэрлэж бодох ба харин олон холбогдогчтой хэргийг хүн тус бүрээр түүвэрлэж, нотлох баримтыг зэрэгцүүлэн тэмдэглэх жишээтэй. Өмгөөлөгч хавтаст хэргийн материалтай хэр зэрэг нарийвчлан бүрэн гүйцэд танилцах байдлаас өмгөөллийн ажлын үр дүн шууд хамаарах бөгөөд өмгөөлөгчөөс ихээхэн хөдөлмөр цаг, төвчээр, хариуцлага шаардана.

Хавтаст хэргийн материалыг сайн уншиж танилцаад тэмдэглэл түүврийг эмх цэгцтэй хийж авсан тохиолдолд өмгөөлөгч нь мэтгэлцээнд оролцох үүргээ амжилттай биелүүлэх үндэс бүрдэнэ. Хэрэв хавтаст хэргийг уншиж танилцахгүйгээр өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцвол "хүний эрхийн манаанд сумгүй буутай зогсохтой" нэгэн адил болно. Хавтаст хэргийн материалыг уншиж танилцсаныхаа дараа өмгөөлөгч нь шүүгдэгчтэй уулзах нь ач холбогдлоор илүү байдаг. Өмгөөлөгч нь өмгөөлүүлэгчтэйгээ уулзаж эрхтэй гэж /Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41.3.1/ заасан бөгөөд өмгөөлүүлэгчтэйгээ илэн далангүй ярилцах нь хэргийн учир шалтгаан, үнэн мөнийг олж тогтооход ихээхэн түлхэц болох бөгөөд өмгөөлөгчид ашиг тустай олон мэдээ, мэдээлэл өгөгдөнө. Шүүгдэгчийн гэмт хэрэгт

холбогдох болсон нөхцөл шалтгаан, гэм буруугийн байдал, хувийн зан чанар, амьдрал ахуйн түүхэн замналыг хавтаст хэргээс тэр бүр нарийвчлан ойлгож мэдэх боломжгүй байдаг. Гагцхүү өмгөөлөгч нь өмгөөлүүлэгчийнхээ байгаа газарт чөлөөтэй нэвтрэн орж, ганцаарчлан уулзаж, илэн далангүй ярилцсанаар түүнийг таньж мэдэх боломжтой болдог ба өмгөөллийн үйл ажиллагааны чиглэл, байр суурь, үзэл бодлоо харилцан солилцох, зөвлөлдөх, шүүх хуралдаанд эрхээ чөлөөтэй эдэлж оролцох боломжийг олгоно. Мөн өмгөөлөгчөөс өмгөөллийн байр сууриа хэрхэн тодорхойлохоо сонгох ач холбогдолтой болдог. Өмгөөлөгч нь өмгөөлүүлэгчийнхээ итгэмжлэн ярьсан зүйлийг задруулах эрхгүй бөгөөд эрх зүйн туслалцаатай холбоотой бүхий л мэдээлэл өмгөөллийн нууцад хамаарна.¹

Өмгөөллийн нууцыг хуулиар хамгаалж, хугацаагүй хадгална. Аливаа этгээдээс өмгөөлөгчид эрх зүйн туслалцаа хүсч хандсан болон үйлчлүүлэгчид эрх зүйн туслалцаа үзүүлэх явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан өмгөөлөгчийг гэрчээр болон бусад байдлаар байцаах, нөхцөл байдлыг тодруулах зорилгоор асууыг хориглодог.

Өмгөөлөгчөөс өмгөөлөх чиглэл, байр сууриа тодорхойлох нь ихээхэн бүтээлч ажиллагаа шаарддаг. Өмгөөлөгч өмгөөлүүлэгчтэй уулзаж ярилцсаны дараагаар өмгөөллийн байр суурийг тодорхой болгох ёстой.

"Өмгөөллийн байр суурь"-ийн сонголт хийхдээ хууль зүйн үнэлгээний хувилбар гарна.

Эвэ хувилбар нь:

1. Буруутай гэдгийг бүрэн үгүйсгэх-гэм буруугүй;

2. Гэм буруугаа хэсэгчлэн хүлээх-хэсэгчилсэн гэм буруутай;

3. Гэм буруугаа бүрэн хүлээх-бүрэн гэм буруутай;

4. Яллагаанд хандаж байгаа илэрхийлэхээс татгалзах-дуугүй байх байр суурь байна.

Үүнээс үндэслэн өмгөөлөх байр суурь тогтох² учиртайг тодорхой тайлбарлан бичсэн бий.

Өмгөөлөгчөөс байр сууриа хууль зүйн үүднээс зөв тодорхойлон мэтгэлцээнд оролцох нь түүний мэдлэг чадвар, дадлага, туршлагаас ихээхэн шалтгаална.

Мэтгэлцэгч талууд мэтгэлцээн ий бэлтгэлийн үе шатанд хэргийнхээ онолыг хэрхэн оновчтой тодорхойлж чадсан эсэхээс өмгөөлөл эсвэл яллагааны эцсийн хувь заяа шалтгаалдаг тухай мэтгэлцээний талаар туршлага хуримтлуулсан хуульчид, судлаачид чухалчлан тэмдэглэсэн байдаг.

Мэтгэлцээний уламжлалтай орнуудад "хэргийн онол" гэж тухайн хэргийн нөхцөл байдал, баримтууд тэдгээрт хамаарах хуулийн холбогдох заалтуудыг сайтар судалж үзсэн үндсэн дээр өөрийн үйлчлүүлэгчийн талд шүүхээр ашигтай шийдвэр

гаргуулахын тулд сонгож авсан, цаашид өмгөөлөлдөө баримтлах үндсэн чиглэлийн хамгийн оновчтой хувилбарыг хэлдэг байна. Хэргийн онолыг оновчтой байдлаар тодорхойлоход ихээхэн шаргуу нямбай ажиллагаа, энэ талын арга зүйн мэдлэг, дадлага шаардана.

Хэргийн онолыг тодорхойлох арга зүй нь хэд хэдэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

1. Хуулийн холбогдох хэм хэмжээнүүдийг судалж нотлогдвол зохих зүйлүүдийг тоймлох;

2. Өөрийн талд ашигтай буюу эерэг нотлох баримтуудын жагсаалтыг түүвэрлэн гаргах;

3. Сөрөг нотлох баримтын жагсаалтыг гаргах;

4. Эерэг, сөрөг нотлох баримтуудыг харьцуулан судалсны үндсэн дээр онолын бүх хувилбарыг гаргах;

5. Харьцуулсан судалгаанд тулгуурлан нотлох баримтуудыг нэг бүрчлэн үнэлж үзээд нотлогдох боломж, үгүйсгэгдэх эрсдэл, мэтгэлцээнд амжилт гаргах магадлалаар нь зэрэглэх;

6. Өөрийн талын амжилтанд хүрэх хамгийн магадлалтай онолын хувилбарыг сонгож авах.

Сонгож авсан онолоо үндэслэн өмгөөлөх чиг баримтлалыг тодорхойлох нь мэтгэлцээнд амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлнэ³ гэжээ.

Шүүхийн хэлэлцүүлгийн шатанд өмгөөлөгч оролцох нь

Өмгөөлөгч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 41.2,

1.Өмгөөллийн тухай хууль, 2002 он, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

2.С.Нарангэрэл. "Амьд эрх зүй". 97 дахь тал.

3."Мэтгэлцэх ур чадвар" гарын авлага,

41.3-д заагдсан эрх эдэлж үүрэг хүлээж, шүүгдэгчийн өмгөөлүүлэх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, хууль болон нотлох баримтад тулгуурлан түүний гэм буруу, ял хариуцлагыг хөнгөрүүлэх, цагаатгах үндэслэлийг шүүхийн өмнө илэрхийлэх байдлаар мэтгэлцээнд оролцоно. Яллах ба өмгөөлөх талууд шүүх хуралдааны үед нотлох баримтыг шинжлэн судлахад оролцох, хүсэлт гаргах, хэрэгт ач холбогдол бүхий ямар ч асуудлаар саналаа илэрхийлэх талаар эрх тэгш байх ёстой.

Шүүхийн хэлэлцүүлэгт нотлох баримтыг шинжлэхдээ эхлээд яллах, дараа нь цагаатгах болон бусад баримтыг шинжлэх дарааллыг баримтална. /Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 261.1 дэх хэсэг/

Ийнхүү нотлох баримтыг шинжлэн судлах дарааллыг талууд өөрсдөө тогтоох бөгөөд шүүх сонгосон дарааллыг өөрчлөх эрхгүй. Өмгөөлөгч энэ тохиолдолд идэвхитэй байр суурь эзэлж, аль болох баримтаас эхлэн хэргийг хэлэлцвэл мэтгэлцээн үр дүнтэй, ашигтай болохыг сайтар тунгаан бодсоны үндсэн дээр саналаа шүүхэд тавих нь чухал ач холбогдолтой. Өмгөөлөгч нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоохдоо тухайн хэргийн сэдэлт, онцлог, шүүгдэгчийн гэм буруугийн байдал, үйлдлийн дараалал, хэргийн зүйлчлэл, ангилал зэргийг харгалзан үзвэл зохино.

Шүүхийн хэлэлцүүлэг улсын яллагч яллах дүгнэлт уншиж

сонсогхоос эхэлдэг./Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 262.2/

Улсын яллагч яллах дүгнэлт сонгосны дараа шүүх хуралдаан даргалагч нь шүүгдэгч хэргийн талаар мэдүүлэг өгөх эсэхийг асууж хэрэв зөвшөөрвөл түүний мэдүүлгийг авах ёстой. Мэдүүлгийг авна гэдэг нь тухайн хэрэгт хамааралтай үйл явдлыг шүүгдэгчээр яриулна гэсэн үг бөгөөд шүүгдэгчийг шүүгч эхэлж байцаах эрхтэй байгаа юм. Хэдийгээр шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч болон хохирогч, гэрч, шинжээчийг байцаах журам мэтгэлцээний тогтсон жишгээр явагдах учиртай боловч ЭБШ хуульд шүүгдэгчээс шүүгч эхэлж мэдүүлэг авах, гэрч, хохирогч, шинжээчийг яллах, өмгөөлөх талууд эхэлж байцаахаар тусгасан нь мэтгэлцээний холимог хэлбэрийг агуулж байгаа гэдгээр тайлбарлаж болох боловч шүүгдэгчийг шүүх эхэлж байцаахын эрх зүйн учир холбогдол нь төдийлөн ойлгомжтой биш санагдана. /Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 263.1, 265.1, 267.2, 272.2 дахь хэсэг/

Хэрэв шүүгч хэлэлцүүлгийн үед идэвхитэй байдлаар оролцож, асуулт олныг тавибал мэтгэлцээний мөн чанар алдагдаж болзошгүй байдалд хүрч болох юм. Харин шүүхийн хэлэлцүүлгийн үед өмгөөлөгч нь шүүгдэгч, хохирогч, гэрчийн мэдүүлгийг анхааралтайгаар сонсож, тэдэнд асуултыг оновчтой тавьж, бусад нотлох баримтыг шинжлэн судлах ажиллагаанд хуулиар олгогдсон эрхээ эдэлж, санал

санаачилгатайгаар оролцох ёстой. Өмгөөлөгч нь хэдийгээр шүүх хуралдаан даргалагчийн зөвшөөрөлтэйгээр асуулт тавих боловч шүүх хуралдааны хэлэлцүүлэг Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар тогтоогдсон журмын дагуу явагдаж буй эсэхэд анхаарч, хууль зөрчигдөхөөс сэргийлэн тэмцэж, хүсэлт саналаа чөлөөтэй илэрхийлбэл зохино.

Шүүх хуралдааны шүүмжлэлийн шатанд өмгөөлөгч оролцох нь

Шүүх хуралдааны хэлэлцүүлэг дууссаны дараа талуудын шүүмжлэлийг сонсоно./Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 279 дүгээр зүйл/ Шүүх хуралдааны шүүмжлэл нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор дүгнэсний үндсэн дээр шүүгчийн дотоод итгэлийг бүрэлдүүлэхэд ач холбогдолтой мэтгэлцэн явагдах ёстой. Шүүмжлэл эхлэхийн өмнө шүүмжлэлд оролцогчид шүүх хуралдааныг түр завсарлуулах тухай хүсэлт тавих эрхтэй. Ийм шаардлага ээдрээ төвөгтэй, олон үйлдэлтэй хэрэгт ихэвчлэн гарна. Шүүх үг хүсэлтийг хангасан тохиолдолд хуралдаан даргалагч шүүмжлэл явагдах өдөр, цагийг зарлана. Шүүмжлэлд оролцохдоо шүүгдэгчийн зан төлөв, гэмт хэргийн нөхцөл байдал, үйл явдлын талаархи өөрийн тайлбарт шүүхийн анхаарлыг хандуулж, хэлэх үгэндээ шүүхийн хэлэлцүүлгийн үр дүнг юу гэж дүгнэж байгаагаа тусгана. Шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдээгүй нотлох баримтыг шүүмжлэлд иш татах эрхгүй. Шүүмжлэл нь талуудын

хувьд чухал ач холбогдолтой зүйл юм. Мэтгэлцээнд оролцогч өмгөөлөгч тал /өмгөөлөгч/ байр сууриа хэргийн талаархи үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, яллах тал /прокурор/-тай мэтгэлцээнд оролцохдоо хэргийн болсон нөхцөл байдлыг сэргээн тогтоож өмгөөлөх байр сууринаас тодорхойлох явдал мөн. Өмгөөлөх болон яллах талууд бүгд л өөр өөрийнхөөрөө болсон хэрэг явдлыг сэргээн босгох, үнэлэхийг оролддог. Мэтгэлцэх зарчим нь яллах, өмгөөлөх 2 талаас хэргийн талаар босгосон дүр зургийг хэр зэрэг итгэл үнэмшилтэйгээр шүүгчийн өмнө дүрслэн харуулах байдлаар илэрхийлэгдэж, талууд өөр өөрсдийн байр суурийг нотолж, эсрэг талтайгаа мэтгэлцэх байдлаас хэргийн жинхэнэ үнэмшилтэй дүр зураг босох боломжтой.

Шүүмжлэлд оролцогчдын байр суурь өөр хэдий ч тэдний хэлсэн үгнээс шүүмжлэлийн явцад шинжлэн дүгнэж буй асуултын тодорхой хүрээг тодорхойлж болно. Үүнд:

Гэмт хэргийн нийгмийн хор аюул, гэмт хэрэг үйлдэх болсон бодит нөхцөл байдал, бий болсон үр дагавар /оюун санаа, бие махбодийн болон эд хөрөнгийн гэм хор/, хэргийн зүйлчлэл /Эрүүгийн хуулийн ерөнхий болон тусгай ангийн хэм хэмжээг хэрэглэх/, ялыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдал, шүүгдэгч, хохирогчийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан нөхцөл зэргийг хамарна. Мөн шүүмжлэлийн үгэнд шүүгдэгчийг гэм буруутгайд тооцох эсэх, гэмт хэргийн зүйлчлэл, ялын төрөл, хэмжээ, ялаас чөлөөлөх болон

цагаатгах үндэслэл, иргэний нэхэмжлэлийг хэрхэх, мөн хэргээс үүдэн гарсан бусад шийдвэрлэгдвэл зохих асуудлууд тусгагдсан байвал зохино. Улсын яллагч, өмгөөлөгч шүүх хуралдааны шүүмжлэлд заавал оролцох үүрэгтэй. Тэд шүүмжлэлд оролцож үг хэлэхээс татгалзах эрхгүй. Шүүх хуралдааны шүүмжлэлийг цагаар хягаарлаж болохгүй боловч хэрэгт холбогдолгүй зүйл яривал хуралдаан даргалагч зогсоох эрхтэй. Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд шүүгдэгч ямар нэгэн шалтгаанаар өмгөөлөгчөөс татгалзаж болох бөгөөд харин өмгөөлөгч өмгөөлөхөөс татгалзах эрхгүй. Шүүх хуралдаанд шүүгдэгч ямар шалтгаанаар өмгөөлөгчөөс татгалзсанаас үл хамаарч тэрээр өөрийгөө өмгөөлж үг хэлэх эрхтэй. Шүүмжлэлийн шатанд улсын яллагчийн үгийг эхлэн сонсдог нь шүүгдэгч, түүний өмгөөлөгч нар өөрийн байр суурийг илүү тодорхой илэрхийлэх боломжийг олгож байгаа явдал мөн. Шүүх хуралдааны шүүмжлэлд хохирогч оролцож байгаа бол тэрээр шүүгдэгчийн өмгөөлөгчийн өмнө үг хэлнэ. Шүүмжлэл нь шүүх хуралдаанд байлцсан иргэдэд хүмүүжлийн үр нөлөө ч үзүүлнэ. Шүүмжлэлээс иргэд тухайн хэргийн мөн чанар, үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, хор аюул, үр дагаврыг ойлгож авна. Өмгөөлөгч ямар ч тохиолдолд үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийн эсрэг яллах, нотлох байр сууринаас үйл ажиллагаа явуулж хэрхэвч болохгүй. Өмгөөлөгч хуулиар олгосон эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ямар

ч тохиолдол, ямар ч нөхцөл байдал үүссэн өөрийн үйл ажиллагаагаар шүүгдэгчийн байдлыг дордуулахгүй байх талаар байнга санаж байх учиртайг юм.

Шүүх хуралдаанд өмгөөлөгч ирээгүй бөгөөд түүнийг солих боломжгүй бол хэрэг хэлэлцэх ажиллагааг хойшлуулах ба солих асуудлыг ЭБШ хуулийн 39 дүгээр зүйлд зааснаар зөвхөн шүүгдэгчийн зөвшөөрлөөр шийдвэрлэнэ. Шүүн таслах ажиллагааг эрх тэгш бүхий яллах, өмгөөлөх талын мэтгэлцээний үндсэн дээр явуулах зарчмыг хэрэгжүүлэх үүднээс шүүх хуралдаанд прокурор өмгөөлөгч ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болох талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 242 дугаар зүйлийн 242.1-д зааж өгсөн. Шүүгдэгчийн сонгож авсан өмгөөлөгч үг хэрэгт цаашид оролцох боломжгүй болсон, өмгөөлөгчөөсөө татгалзсан бол шүүгдэгч өмгөөлөгчөө өөрөө сонгон авах эрхтэй. Өмгөөлөгчийг хуульд заасан үндэслэлээр сольсон бол хэрэг хэлэлцэх ажиллагааг эхнээс нь явуулах ба өмгөөлөгч нь хэргийн бүх материалтай танилцах бололцоог шүүх олгоно. Ингэснээр мэтгэлцэх зарчим хэрэгжих боломж хангагдана.



Хуулийн зөвлөгчийн эрх зүйн байдлын зарим асуудал



ХЗУТ-ийн ЭША
П.БАТТОГТОХ

Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн хоёр дугаар бүлгийн арван гуравдугаар дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалтад: “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар ... хууль зүйн туслалцаа авах ... эрхтэй” хэмээн заасан байдаг билээ. Аливаа хүн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн буюу зөрчигдөж болзошгүй тохиолдолд тэрхүү хууль зүйн туслалцааг холбогдох этгээд авах эрхтэй байдаг. Хууль зүйн туслалцааг үзүүлэх субъектэд өмгөөлөгч, хуулийн зөвлөгч¹ нар голлох байр суурь эзэлдэг билээ.

Хууль зүйн дээд боловсрол эзэмшсэн тохиолдолд ажиллаж болох ажил, албан тушаал байдаг бөгөөд үүнд шүүгч, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, нотариатч, мөн хуулийн зөвлөгч багтдаг.

Эдгээр ажил, албан тушаалыг ангилж, зохицуулах нэг том алхам хийгдсэн нь Улсын Их Хурлаас 2003 оны 5 дугаар сарын 22-ны өдөр “Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль”-ийг баталсан явдал юм. Уг хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад: **хуульчдын сонгон шалгаруулалт гэж шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаал эрхлэх сонгон шалгаруулалтад оролцох, өмгөөллийн болон нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар ажиллах хуульчдаас мэргэжлийн хангалттай мэдлэг, чадварыг эзэмшсэн эсэхийг шалгаж, гэрчилгээ олгох ажиллагааг хэлнэ.** гэж заажээ. Мөн Орон тооны бус зөвлөл сонгон шалгаруулалтад тэнцсэн этгээдэд гэрчилгээ олгох бөгөөд гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, өмгөөлөгч, нотариатч, шийдвэр гүйцэтгэгчээр, гадаадын иргэн, харьяалаггүй хүн өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй бөгөөд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу мэргэшлийн шалгалт өгөх тухай тус хуульд тусгасан байна.

Ийнхүү дээр дурдсан ажил, албан тушаалд ажиллах боловсон хүчнийг зохих шалгаруулалтад оруулж үнэлэх болсон нь нэг талаараа хуульч боловсон хүчний мэргэжлийн мэдлэг, чадварыг

үнэлэх, нөгөө талаараа тухайн ажил, албан тушаалын үнэ цэн, өндөр шалгуурыг илэрхийлэх чухал ач холбогдолтой зүйл болсон билээ.

“Төрийн албаны тухай хууль”-ийн 17 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсэгт: “хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтад орж тэнцэн гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчийн албан тушаалд ороход төрийн албаны мэргэшлийн шалгалтаас чөлөөлөгдөнө. Дээр дурдсан албан тушаалд ажиллаж байгаа этгээд төрийн жинхэнэ албаны өөр албан тушаалд шилжиж ажиллахад төрийн албаны мэргэшлийн шалгалт өгнө.” гэж заасан байдаг.

Одоо хууль зүйн дээд боловсрол эзэмшсэний дараа ажиллаж болох ажил, албан тушаалын хууль зүйн шаардлагуудыг тус бүрт нь авч үзье.

“Шүүхийн тухай хууль”-ийн 28 дугаар зүйлд “хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, хорин таван нас хүрсэн, ял шийтгүүлж байгаагүй, хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан Монгол Улсын иргэнийг шүүгчээр томилж болно.” гэж заасан.

1. Бид уг нэр томъёог үйл үгийн хэлбэрээр буруу хэлж хэвшсэн бөгөөд зүй нь эзэн биетэй нэр үгээр хэлж дуудах ёстой билээ.

"Прокурорын байгууллагын тухай хууль"-ийн 39 дүгээр зүйлд: "хууль зүйн бакалаврын боловсролтой, мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвараар шаардлага хангасан, хуульчийн мэргэжлээр гурваас доошгүй, эсхүл прокурорын туслах ажилтнаар хоёроос доошгүй жил ажилласан, ял шийтгэлгүй байгаагүй, хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан хорин гурван нас хүрсэн Монгол Улсын иргэнийг прокуророор томилно." гэж заасан.

"Цагдаагийн байгууллагын тухай хууль"-ийн 29 дүгээр зүйлд: "цагдаагийн албанд 18 нас хүрсэн, ял шийтгэлгүй, Монгол Улсын иргэнийг хүсэлтээр нь авч ажиллуулна. Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан иргэнийг цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар томилно." гэж, мөн "Тагнуулын байгууллагын тухай хууль"-ийн 17 дугаар зүйлд "хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан иргэнийг тагнуулын байгууллагын хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар томилно." гэжээ.

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль"-ийн 132 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: "шийдвэр гүйцэтгэгч нь хууль зүйн дээд боловсролтой, хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан ял шийтгэлгүй, шийдвэр гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтаар тэнцсэн Монгол Улсын иргэн байна." гэж "Нотариатын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлд "хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд

заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан иргэн тусгай зөвшөөрөл авахаар мэргэшлийн шалгалт өгөх эрхтэй." гэж заасан байна.

"Өмгөөллийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлд "хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнийг өмгөөлөгч гэнэ.", 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: "хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан этгээд тусгай зөвшөөрөл авахаар мэргэшлийн шалгалт өгөх эрхтэй.", мөн зүйлийн 4 дэх хэсэгт "Монгол хэл мэддэг, хуульчдаас сонгон шалгаруулах тухай хуульд заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан харьяалалгүй хүн, гадаадын иргэн хуульч Монгол Улсын нутаг дэвсгэрт өмгөөллийн үйл ажиллагаа явуулахыг хүсвэл мэргэшлийн шалгалт өгсний үндсэн дээр тусгай зөвшөөрөл авна." гэж тус тус заасан байдаг.

Харин хууль зүйн дээд боловсрол эзэмшсэн хүмүүсээс хуулийн зөвлөгчийн ажил, албан тушаалыг эрхлэхэд хуулиар болон бусад байдлаар ямар нэгэн шаардлага, шалгуур тавиагүй байна. Өнөөгийн байдлаар хууль зүйн дээд боловсрол эзэмшсэн хүмүүс аж ахуйн нэгж, байгууллагатай хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр уг байгууллагын орон тооны үндсэн ажилтнаар ажиллах, эсвэл аж ахуйн нэгж болон иргэдтэй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх тухай гэрээний үндсэн дээр тэдэнд хуулийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг эрхэлж байгаа билээ.

Хуулийн зөвлөгч нь ажил олгогч болон үйлчлүүлэгч нартаа хууль тогтоомжийн талаар ерөнхий мэдлэг, мэдээлэл өгөх, эсвэл тодорхой салбар эрх зүйн чиглэлээр мэргэшсэн зөвлөгөө өгөх хэлбэрээр ажиллаж болдог.

Хуулийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа нь дараах үндсэн хэлбэрүүдтэй байж болдог:

□ Зөвлөгөө авч буй этгээдэд холбогдох хууль тогтоомжийг ойлгуулан таниулах,

□ Зөвлөгөө авч буй этгээдийн эрх ашигт нийцүүлж холбогдох гэрээ болон бусад баримт бичгийг мэргэжлийн өндөр түвшинд боловсруулж өгөх;

□ Зөвлөгөө авч буй этгээдийн ашиг сонирхлыг хамгаалж, түүнийг төлөөлж эрх зүйн харилцаанд оролцох.

Хуулийн зөвлөгч нь өмгөөлөгчтэй нийтлэг болон түүнээс ялгаатай шинжтэй байдаг.

1. Нийтлэг шинж:

□ Хүний зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй эрх, эрх чөлөөг хамгаалахын тулд хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг;

□ Хууль зүйн дээд боловсролтой байх ёстой байдаг;

□ Салбар эрх зүйн чиглэлээр мэргэшсэн байж болдог;

□ Үйлчлүүлэгчээ итгэмжлэл болон холбогдох баримт бичгийн үндсэн дээр төлөөлөх эрхтэй байдаг;

□ Үзүүлж буй хууль зүйн үйлчилгээ нь байнгын, үргэлжилсэн шинжтэй байдаг;

□ Эдгээр ажил, албан тушаалыг төрийн зарим тусгай албан хаагч тухайн албаа гүйцэтгэж байх хугацаандаа давхар хашиж болдоггүй;

□ Ганцаараа болон багаар ажиллаж болдог.

1. Ялгаатай шинж:

Эдгээр ажил, албан тушаалын онцлог, чиг үүрэг, мөн чанарыг үндэслэн доорхи шинжүүдийг тодорхойлсон бөгөөд харин Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгосонгүй.

№	Шинжүүд	Өмгөөлөгч	Хуулийн зөвлөгч
1.	Үйл ажиллагаа нь хамаарах үндсэн статусын хувьд:	Төрийн албан хаагч биш байдаг.	Төрийн болон төрийн өмчийн бус байгууллагын ажилтан, албан хаагч байж болдог.
2.	Үйл ажиллагаа явуулах эрхийн хувьд:	Зохих шалгаруулалтад орж тэнцэн тусгай зөвшөөрөл авдаг.	Зохих шалгаруулалтад орж тэнцэн тусгай зөвшөөрөл авахыг шаарддаггүй боловч зохих сургалтад хамрагдах, дүгнүүлэх ёстой байдаг.
3.	Үндсэн үйл ажиллагаа нь хамрагдах хүрээний хувьд:	Гол төлөв үйлчлүүлэгчийнхээ зөрчигдөж байгаа болон зөрчигдсөн эрх ашгийг хамгаалахад чиглэдэг.	Гол төлөв үйлчлүүлэгчийнхээ эрх ашгийг зөрчигдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэхэд чиглэдэг.
4.	Шүүхэд болон холбогдох байгууллагад үйлчлүүлэгчээ төлөөлөх үед эдлэх эрхийн хувьд:	Төлөөлөгчийн болон өмгөөлөгчийн эрхийг давхар эдлэх боломжтой байдаг.	Зөвхөн төлөөлөгчийн эрхийг эдэлдэг.
5.	Үйлчлүүлэгчтэйгээ хийх гэрээний төрлийн хувьд:	Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн дээр ажилладаг.	Хууль зүйн үйлчилгээ үзүүлэх болон хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр /ажил олгогчтой/ ажилладаг.
6.	Бие даасан байдлын хувьд:	Үйлчилгээ үзүүлэх гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа өмгөөлөгч харьцангуй бие даасан байдалтай байдаг.	Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа хуулийн зөвлөгч ажил олгогчоос харьцангуй хараат байдалтай байдаг.
7.	Бусад субъектээс тухайн үйл ажиллагааг эрхлэх хууль зүйн боломжийн хувьд:	Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш тодорхой хугацаа өнгөрч байж /3 жилийн дараа/ өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй болдог.	Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч ажлаасаа өлөөлөгдсөнөөс хойш хэзээ ч хуулийн зөвлөгчийн ажил, албан тушаалыг эрхлэх боломжтой байдаг.
8.	Тухайн ажил, албан тушаалуудыг харилцан сольж эрхлэх боломжийг хувьд:	Өмгөөллийн үйл ажиллагаагаа эрхлэхээ больсноос хойш хуулийн зөвлөгчийн ажил, албан тушаалыг эрхэлж болдог.	Хуулийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаагаа эрхлэхээ больсноос хойш зохих шалгаруулалтад орж тэнцэн тусгай зөвшөөрөл авч байж өмгөөллийн үйл ажиллагааг эрхэлж болдог.
9.	Тухайн үйл ажиллагааг эрхлэхэд олгогдсон хууль зүйн боломжийн хувьд:	Эрх зүйн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь холбогдох хуулиудаар харьцангуй баталгаажсан байдаг.	Эрх зүйн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь хуулиар төдийлэн баталгаажаагүй байдаг.
10.	Харьяаллын хувьд:	Тодорхой байгууллага, холбоонд харьяалалтай байдаг.	Ажил олгогчид харьяалагдахаас бусад байдлаар заавал харьяалалтай байхыг шаарддаггүй.
11.	Сахилгын зөрчил гаргасан үед хүлээх хариуцлагын хувьд:	Сахилгын зөрчлийг тухайн харьяалагддаг байгууллага, холбооны Сахилгын дүрмээр шийдвэрлэдэг.	Ажил олгогчид харьяалагдаж байгаа бол сахилгын зөрчлийг түүний дотоод журам, хөдөлмөрийн гэрээг үндэслэн шийдвэрлэдэг. Хэрэв хөдөлмөрийн гэрээг бус өөр төрлийн гэрээний
12.	Үйл ажиллагааны зорилгын хувьд:	Ашгийн бус шинжтэй	Ашгийн шинжтэй

Өмгөөллийн үндсэн үйл ажиллагааг өнөөгийн байдлаар Үндсэн хууль /1992 он/, Өмгөөллийн тухай хууль /2002 он/, Эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002 он/, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /2002 он/, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2002 он/, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль /1999 он/ зэрэг эрх зүйн актуудаар голлон зохицуулж байна.

Өмгөөлөгчид нь заавал нэгдсэн нэг байгууллагад харьяалагдах ёстой гэсэн шаардлагын дагуу өмгөөлөгчдийг нэгтгэсэн Монголын өмгөөлөгчдийн холбоо хэмээх байгууллага ажиллаж байгаа бөгөөд уг байгууллагын статусыг "Өмгөөллийн тухай хууль"-ийн 6 дугаар зүйлд: "Монголын өмгөөлөгчдийн холбоо /цаашид "Холбоо" гэх/ нь өмгөөлөгчдийг эгнээн дээ нэгтгэсэн, тэдний эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус, мэргэжлийн байгууллага байна." гэж заажээ.

Одоо тэгвэл "Төрийн бус байгууллагын тухай хууль /1997 он/"-аас иш татъя.

Уг хуулийн 4 дүгээр зүйлд: "Төрийн бус байгууллага" гэж иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, цээл бодлын үндэнээ сайн дурын үндсэн дээр байгуулагдан цйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус

байгууллагыг хэлнэ," гэж заасан байдаг.

Иймээс дээрх хуулиудын холбогдох заалтуудаас үзвэл Монголын өмгөөлөгчдын холбоо бол төрийн бус байгууллага мөн бөгөөд төрийн бус байгууллага нь ашгийн төлөө бус байна гэсэн бодомж гарч ирж байна.

Энэ бодомжоос дүгнэлт хийж үзвэл өмгөөллийн үйл ажиллагаа бол ашгийн төлөө бус шинжтэй байна гэсэн логик дүгнэлт хийж болно.

Өмгөөллийн үйл ажиллагаатай холбогдон бүлгээр хамтран эвсэж өмгөөллийн үйл ажиллагаа явуулж буй нэгдлийн /хууль зүйн товчоо гэж нэрлэдэг/ тухай асуудал өнөөдөр сөхөгдөн тавигдаж байгаа билээ. Энэхүү нэгдэл нь ямар статустай байх талаар өнөөдөр нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй байна.

Өөрөөр хэлбэл ийм нэгдэл байх шаардлагатай юу, үгүй юу. Хэрэв байх хэрэгтэй бол хуулийн этгээдийн хэлбэртэй байх уу, эсвэл хуулийн этгээдийн эрхгүй нэгдэл байх уу гэдэг асуудлыг хөндөх хэрэгтэй болж байна.

Хэрэв өмгөөлөгчдийн тэрхүү нэгдэл байх шаардлагатай гэвэл хуулийн этгээдийн эрхтэй байх ёстой бөгөөд тэр дундаа ашгийн төлөө бус хуулийн этгээд болох төрийн бус байгууллагын статустай байх ёстой. Гэхдээ тухайн нэгдэл бүхий тэрхүү төрийн бус байгууллага нь Монголын өмгөөлөгчдийн холбоондоо харьяалагддаг байх учиртай.

Иргэний хуулийн /2002 он/ 25 дугаар зүйлд "өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, цэрэг хүлээдэг, цйл ажиллагаанаасаа бий болох цр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцэгч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой цйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ. Хуулийн этгээд нь ашиг олох зорилготой ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан зорилготой, ашгийн төлөө бус байж болно." гэж хуулийн этгээдийг тодорхойлон байдаг.

2003 оны 5 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хурлаас "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль"-ийг баталж гаргасан бөгөөд уг хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад "холбоо, сан, шашны байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэнэ" гэж тусгасан.

Мөн хуулийн 28 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэгт "Энэ хууль батлагдахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан уг хууль хүчин төгөлдөр болсноос хойш зургаан сарын дотор холбогдох баримт бичгийг харьяалан бүртгэх байгууллагад ирцүллэнэ. Холбогдох баримт бичгийг тогтоосон хугацаанд бүртгэх байгууллагад ирцүллэггүй бол тухайн хуулийн этгээдийг бүртгэх байгууллагын саналыг үндэслэн шүүх татан буулгана". 29 дүгээр зүйлд "Энэ

хууль 2003 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн $\delta\zeta\epsilon\grave{\epsilon}\grave{\iota}\ \circ\ \circ\ \text{Э}\grave{\epsilon}\grave{\alpha}\ \delta\ \acute{\alpha}\grave{\iota}\ \acute{\epsilon}\ \acute{\iota}\ .$ гэж тус тус заасан байдаг.

Иймд “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль” хүчин төгөлдөр болсон огноо болох нь 2003 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хойш зургаан сарын дотор буюу тодруулбал, 2004 оны 4 дүгээр сарын 1-ний дотор уг хууль хүчин төгөлдөр болохоос өмнө холбогдох бүртгэлд бүртгүүлсэн өмгөөллийн үйл ажиллагаа явуулж буй нэгдэл /хууль зүйн товчоо/-ийн эрх бүхий албан тушаалтан тухайн нэгдлээ хуулийн этгээд, тэр тусмаа төрийн бус байгууллагын хэлбэрээр зохион байгуулж харъяалан бүртгэх байгууллагад бүртгүүлэх үүрэгтэй болж байна.

Харин дээр дурдсан хуулиар өнөөдөр өмгөөлөгчдийн тэрхүү нэгдлийг хуульд заасан хугацаанд Хууль зүй, дотоод хэргийн яамд бүртгүүлээгүй бол тэднийг шүүхээр татан буулгуулах тухай эрх зүйн үр дагавар бий болж байна.

Тиймээс хэрэв өмгөөлөгчид нэгдэн тодорхой нэгдэл бий болгохыг хүсвэл уг нэгдлээ төрийн бус байгууллагын хэлбэрээр байгуулж, харъяалах газарт нь бүртгүүлэх бөгөөд үүний үндсэн дээр уг нэгдэл бүхий төрийн бус байгууллагуудыг Монголын өмгөөлөгчдийн холбоо өөрийн харъяандаа байлгаж, тэднийг хянаж, чиглүүлж байх үүрэг гарч ирж байгаа учир холбогдох зохицуулалтыг хийх хэрэгтэй байна.

Харин өмгөөллийн үйл ажиллагаа явуулах тэрхүү нэгдлийг аж ахуйн нэгжийн хэлбэрээр үүсгэн байгуулж болохгүй юм. Учир нь нөхөрлөл болон компани нь ашгийн төлөө хуулийн этгээд билээ. Тодруулбал, “Иргэний хууль /2002 он/”, “Компанийн тухай хууль” /1999 он/, “Нөхөрлөлийн тухай хууль /1995 он/”-уудад нөхөрлөл, компанийг ашгийн төлөө хуулийн этгээд гэсэн хэлбэрээр тусгасан. Харин хоршоог “Иргэний хууль”-д ашгийн төлөө бус гэж зааж өгсөн боловч хоршоо нь дундын эд хөрөнгө дээр үндэслэсэн бөгөөд гишүүдийн эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор байгуулагддаг учир нийгмийн төлөө үйл ажиллагаа нь чиглэгддэг өмгөөллийн үйл ажиллагааны мөн чанарт нийцэхгүй билээ.

Ийнхүү өмгөөллийн үйл ажиллагаатай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг дээр дурдсан байдлаар буюу тодруулбал, өмгөөлөгчдийн нэгдлийг төрийн бус байгууллагын хэлбэрт оруулан Монголын өмгөөлөгчдийн холбоонд харьяалуулах замаар шийдвэрлэж болох боловч хуулийн зөвлөгөө өгөх үйлчилгээтэй холбогдсон харилцаа нь нарийвчилсан зохицуулалтад орж хараахан чадаагүй л байна.

Зах зээлийн харилцаа өдрөөс өдөрт хөгжиж, эдийн болон эдийн бус баялаг нийгмийн харилцааны эргэлтэд ихээр орж

буй өнөө үед хуулийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа ихээхэн чухал үүрэгтэй байдаг.

Хуулийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа нь тухайн хуулийн зөвлөгч үйлчлүүлэгчтэйгээ тохиролцож гэрээ байгуулсны үндсэн дээр явагддаг учир мөн чанараараа ашгийн төлөө шинжийг өөртөө агуулсан байдаг.

Нийгмийн харилцаа хуулиар зохицуулагдаж байдаг билээ. Тиймээс хуулийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүж буй хуулийн зөвлөгч нар мэдлэг, чадварын хувьд өндөр төвшинд, өмгөөлөгчөөс дутуугүй хэмжээнд байх ёстой байдаг.

Зах зээл өндөр хөгжсөн улс орнуудад хуулийн зөвлөгч нарыг бизнесийн харилцаанд ихээхэн чухал үүрэгтэй байдаг гэж үздэг учир тэднийг тодорхой сургалтад хамруулж, зохих гэрчилгээг олгож, тэдний мэдлэг, чадварыг үнэлдэг байна.

Харин хуулийн зөвлөгч нарын мэдлэг, чадварыг үнэлэх үнэлэмж Монгол Улсад одоогийн байдлаар хараахан бий болоогүй байгаа нь үнэн юм.

Тиймээс хуулийн зөвлөгч нарын мэдлэг, үр чадварыг үнэлсэн тодорхой шалгуур байх нь зүйтэй билээ.

Энэ шалгуурыг бий болгох дараах үндсэн арга зам байж болох юм.

Үүнд:

1. “Хуульчдаас сонгон шалгаруулах тухай хууль”-д заасан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан этгээдийг хуулийн зөвлөгч өөрөө сонгон авч, түүнээс хууль

зүйн туслалцаа, үйлчилгээ авдаг байх жишиг тогтоож болох юм. Өөрөөр хэлбэл, хууль зүйн туслалцаа, үйлчилгээ авахыг хүссэн үйлчлүүлэгч буюу ажил олгогч хуульчдын сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрчилгээ авсан этгээдийг сонгон түүгээр үйлчлүүлэх буюу түүнийг ажилд авч байх жишгийг нийтэд тогтоох явдал юм.

Ийм жишиг тогтсон тохиолдолд хуулийн зөвлөгч нар бусдад хүлээн зөвшөөрөгдөхийн тулд хуульчдын сонгон шалгаруулалтад орж тэнцэн гэрчилгээ авсан байхыг эрмэлзэх бөгөөд үүний тулд өөрийн мэдлэг, чадвараа шалгуулах шаардлагатай болно.

Ингэж хуулийн зөвлөгч нарыг шалгаруулалтад хамруулж чаддаг жишиг тогтоож чадсанаар тэдний мэдлэг, чадварыг үнэлэх механизмтай болох боломжтой гэж бодож байна. Харин гагцхүү нийгэмд тийм жишиг тогтооход хөрөнгө хүч болон нийгмийн сэтгэл зүй, цаг хугацааны хувьд тодорхой хэмжээний бэрхшээлтэй байж магадгүй юм.

2. Хуулийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх сонирхол бүхий хүмүүсийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, бататгах үүднээс тэдэнд сургалт явуулах, улмаар уг сургалтын эцэст авах шалгалтыг амжилттай өгч чадсан хүмүүсийг хуулийн зөвлөгөө өгөх мэдлэг, чадвартай боллоо гэж үзэх агуулга бүхий сургалтын механизмыг бий болгох явдал юм.

Энэ асуудлыг дараах байдлаар зохицуулах боломжтой гэж үзэж байна. Үүнд:

“Боловсролын тухай хууль /2002 он/-ийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: *“Сургуулиас гадуурх сургалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлээр нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, хууль зүй, байгаль орчин, гоо зүй, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, гэр бидлийн болон ахуйн хирээний асуудлаар тусгай хөтөлбөрийн дагуу хичээх, насанд хирэгчдэд боловсрол эзэмшүүлэх, боловсрол, мэргэшлээ дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлж болно.”* гэж заасан байдаг.

Хууль зүйн үндэсний төвийн эрхлэх үндсэн нэг чиг үүрэг бол хууль сургалт явуулах үйл ажиллагаа бөгөөд тус байгууллагын бүрэлдэхүүнд сургалтын асуудал хариуцсан “сургалтын төв” хэмээх нэгж байдаг билээ.

Тус төвийн сургалтын үйл ажиллагааны үндсэн чиглэлд *“хуульч /шүүгч, прокурор, өмгөөлөгч, хуулийн зөвлөгч, нотариатч/-дад ажил хэргийн мэдлэг олгох, мэргэжил дээшлүүлэх, дахин мэргэшилүүлэх чиглэлээр сургалт хийх, хууль зүйн клиник сургалт зохион байгуулах”* тухай тусгасан байдаг.

Хууль зүйн үндэсний төв өнгөрсөн хугацаанд хуульчдад буюу хуулийн ажилтан, албан тушаалтнуудад, бизнес

эрхлэгчдэд болон хуулийн зөвлөгчдэд зориулж эрх зүйн тодорхой салбар бүрээр олон удаагийн сургалтыг амжилттай зохион явуулсан бөгөөд одоо ч холбогдох сургалтыг зохион явуулж байгаа билээ.

Тус төвийг энэ талаар хангалттай туршлага хуримтлуулсан байгууллага гэж хэлж болно.

Иймд “Боловсролын тухай хууль”-ийг болон Хууль зүйн үндэсний төвийн дүрмийг удирдлага болгон хуулийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой хүмүүсийг зохих сургалтад хамруулан тэдний мэдлэг, чадварыг үнэлэх асуудлыг Хууль зүйн үндэсний төв хариуцан хийх боломжтой гэж бодож байна.

Харин гагцхүү эдийн засгийн болон эрх зүйн зохих хэмжээний дэмжлэг, зохицуулалт хэрэгтэй болох нь гарцаагүй ээ.



Нотариатчдад өгөх зөвлөмж



Монголын Нотариатчдын
танхимын ажилтан П.УЯНГА

Төрийн чиг үүргийн тодорхой нэг хэсгийг гүйцэтгэдэг нотариатын байгууллага өнөөгийн нийгмийн хэрэгцээнд нийцэн ажиллаж чадаж байгаа эсэх, цаашид нотариатын байгууллага юуг анхааран ажиллах, нотариатын байгууллагын гол цөм болсон нотариатчийн мэргэжлийн төвшин, ёс зүйн талаар анхаарвал зохих мэдээллүүд иргэд, байгууллагаас ирж байгааг газар дээр нь тухай бүрт нь шийдвэрлэж байх нэгдсэн системтэй болох, нотариатын үйл ажиллагааг явуулахад ямар бэрхшээлтэй тал гарч байгаа, цаашид юуг анхааран ажиллах, Нотариатын тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хуульчилсан актуудад нэмэлт, өөрчлөлт оруулбал зохих санал, дүгнэлтийг холбогдох эрх бүхий удирдлагын сонорт хүргэх үүднээс Монголын нотариатчдын танхимын Мэдээллийн албанаас сар тутам заавар зөвлөгөө, мэдээллийг гаргадаг.

БНМАУ-ын Засгийн газрын 1925 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 30 дугаар хурлын 3 дугаар тогтоолоор Шүүх явдлын яамны Ерөнхий хэлтсийн харьяанд “Гэрээ зэргийг гэрчлэн батлах хэргийг эрхлэх салаа” байгуулагдсанаар тус улсад Нотариатын байгууллагын үндэс суурь тавигдсан юм.

Монгол Улсад 1990-ээд оноос эхэлсэн өөрчлөлт шинэчлэлт, ялангуяа 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн дагуу хэрэгжүүлж буй эрх зүйн шинэтгэлийн хүрээнд 1997 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Нотариатын тухай Монгол Улсын хууль батлагдан гарснаар нотариатын байгууллагын тогтолцоо бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, үйл ажиллагааны хүрээ, үйлдлийн төрөл өргөжсөн юм.

2002 онд Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Нотариатын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль зэрэг шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон олон хууль шинээр батлагдан 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлснээр нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэчийн эрх хэмжээ, ажлын ачаалал, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ өргөжиж,

нотариатын байгууллагын ач холбогдол өссөөр байна.

Өнөөдөр нотариатч нь дараах баримт бичгийг гэрчлэх үйлдэл хийж байна. Үүнд:

1. Бичиг баримтын хуулбар, орчуулга;
2. Гэрээ хэлцэл, хуулийн этгээд үүсгэн байгуулах бичиг баримт;
3. Итгэмжлэл;
4. Бичиг баримтад зурсан гарын үсгийн үнэн зөв эсэх;
5. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой бичиг баримт;
6. Өв залгамжлах эрхийн гэрчилгээ;
7. Гэрээслэл.

2003 онд нийт нотариатчдийг Монголын Нотариатчдын танхимаас нэгдсэн шаардлагын дагуу ажиллаж буй эсэх, тэдний мэргэжлийн ур чадвар ямар төвшинд байгааг дараах үзүүлэлтээр шалгасан юм. Үүнд:

1. Шаардлагад нийцсэн, нууцлал хангаж чадахуйц ажлын байртай эсэх, ажлын байрны хаяг, утас тодорхой эсэх;
2. Зөвшөөрөл олгосон тойрогт тогтмол үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг эсэх;
3. Үйлчилгээний хөлсийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 192 дугаар тушаалаар баталсан “Нотариатын үйлчилгээний хөлс, зардлын жишиг”-ийн дагуу авч байгаа эсэх;

4. Гишүүний татвар, хариуцлагын даатгалын төлөлтийг цаг хугацаанд нь тушааж, тооцоо хийдэг эсэх;

5. Улирал тутам тухайн татварын албатай зохих тооцоог хийдэг эсэх;

6. Нотариатын бүх төрлийн үйлдлийг мэргэжлийн өндөр төвшинд, хууль тогтоомжид нийцүүлэн хийж байгаа эсэх;

7. Мөнгөний тасалбарыг зөв хэрэглэж, хөтөлж байгаа эсэх;

8. Үйлдэл, орлогын мэдээг зохих журмын дагуу өдөр бүр гаргаж, сар бүр нэгтгэн Нотариатчдын танхимын санхүүд ирүүлдэг эсэх, жилийн эцсийн мэдээг нэгтгэн ирүүлсэн эсэх;

9. Нотариатчдын ёс зүйн хэмжээг чанд сахин ажиллаж байгаа эсэх;

10. Нотариатын хуулийн 19 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу нотариатын үйлдэл хийх эрхээ гагцхүү өөрөө хэрэгжүүлдэг эсэх зэрэг юм.

Шалгалтын явцад бүртгэлийг зохих журам, зааврын дагуу бүртгэдэггүй, архивын материалыг хангалттай сайн бүрдүүлэн авч үлддэггүй, мөнгөний тасалбарыг үйлчлүүлэгч тус бүрд олгодоггүй зэрэг зөрчил дутагдал нийтлэг ажиглагдсан.

Гэрчилж буй үйлдлийг зохих дүрэм, журам, зааврын дагуу хийдэггүй, ажил, үйлчилгээндээ хайнга хандсаны улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад лавлагаа гаргаж өгөх, шүүх, цагдаагийн байгууллагад холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн өгөх,

нотариатч өөрийн хийсэн үйлдлийн үнэн зөвийг батлах боломжгүй болох зэрэг сөрөг байдал үүсдэг.

Иймд нотариатч нь өөрсдийн хийж буй үйлдэлдээ хянуур хянамгай байж, Нотариатын тухай хууль, Нотариатын үйлдэл эрхлэн хийх заавар болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байх шаардлагатай юм.

Сүүлийн үед банк, банк бус санхүүгийн байгууллагын тоо нэмэгдэж байгаа бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад барьцаатай болон барьцаагүй зээл олгох явдал ихэсч байна. Энэ нь хэдийгээр иргэдийн ахуй хангажжаа дээшлүүлэн ажиллахад тус дөхөм болж байгаа сайн талтай боловч нөгөө талаар зарим нэг үл бүтэх этгээдүүдийн хууль бус үйлдэл хийх гэсэн оролдлого нэмэгдсээр байна. Ялангуяа иргэдийн орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээг хуурамчаар үйлдэх, эзнийг нь байхгүйд оронд нь өөр адил төстэй царайтай хүн орлуулан аваачиж, гарын үсэг зуруулан орон сууц захиран зарцуулах итгэмжлэл хийлгэх, хуурамч бичиг баримт үйлдэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хохирол чирэгдэл учруулсан явдал гарсаар байна.

Зарим нэг нотариатч төрийн соёмбо бүхий тамга барьчихаад төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж иргэдэд үйлчлэх ёстойгоо умартан бусдын хусалт гуйлтаар тамга дарах, хөлс зардлын жишгийг мэдсээр атлаа буруу тооцон авах зэргээр үйлчлүүлэгчдэд таагүй сэтгэгдэл төрүүлж байгаа нь

нотариатчдын нэр хүндийг унагах төдийгүй иргэдийн дунд нотариатын үйл ажиллагааны талаарх буруу ташаа ойлголтыг төрүүлэх үндэс болоод байна.

Иймд нотариатч та бид нотариатын үйлдлийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Нотариатын тухай хууль, нотариатын үйлдэл эрхлэн хийх зааврын дагуу эрхлэн явуулж, Нотариатчдын танхимын Мэдээллийн албанаас гаргаж буй мэдээ, мэдээлэл, заавар, зөвлөмжтэй танилцан нэгдсэн нэг мөр ойлголттой байж, нотариатын үйлдлийг мэргэжлийн өндөр төвшинд бие даан, хууль тогтоомжид нийцүүлэн хийж, иргэн, хуулийн этгээдэс эрхээ хэрэгжүүлэх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалахад нь үйлчлэх, тэдэнд эрх, үүргийг тайлбарлан өгч, улмаар нотариатын үйлдэл хийснээс үүдэн гарах үр дагаврыг урьдчилан сануулж, зөвлөгөө өгөх үүргээ ухамсарлан нотариатын үйлдлийг зохих журмын дагуу шаардлага хангасан нөхцөлд гэрчилж байх, гэрчилж байгаа гэрээ, хэлцэл, итгэмжлэлийн утга агуулга хуульд нийцэж байгаа эсэхийг хянаж байх, иргэдийг хохироож чирэгдүүлэггүй түргэн шуурхай үйлчилж, хуульчийн ёс зүй, дэг журмыг сахин ажил үйлчилгээгээ эрхлэн явуулах учиртай.



Оюуны өмчийн эрхийн нэр томъёоны дагалга

Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ю.ЭНХТҮВШИН

Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг	Заявка промышленных образцов	Design application
Өргөдөл, бүтээгдэхүүний загварын зураг, тодорхойлолтоос бүрдсэн бүрдэл.		
Ашигтай загварын мэдүүлэг	Заявка полезной модели	Utility application
Ашигтай загварын хувьд бүртгүүлэх зорилгоор гаргасан өргөдөл, тодорхойлолт, томъёолол, тайлбарлах зургаас бүрдэх баримт бичиг.		
Ашигтай загварын томъёолол	Формула полезной модели	Claim /s/ of utility model
Уг шийдлийн ялгарах шинжийг нотолж эрх зүйн хамгаалалтын хүрээг тогтоосон тодорхойлолт эрхийн хамгаалалтын хүрээг тогтоосон тодорхойлолт.		
Шинэ бүтээлийн томъёолол	Формула изобретения	Claim /s/ of invention
Тухайн шинэ бүтээлийн онцгой ялгарах шинж чанарыг илрүүлэн гаргаж, эрх зүйн хамгаалалтын хүрээг тогтоосон ойлгомжтой, товч, тодорхой илэрхийлэл.		
Шинэ бүтээлийн тодорхойлолт	Описание изобретения	Description of invention
Шинэ бүтээлээр дэвшүүлсэн зорилгод хүрэхэд тухайн шийдлийн өмнөх техникийн төвшнээс онцгой ялгарах шинж чанарыг илрүүлэх, шийдлийн хамаарах салбарын мэргэжлийн хэрэглэгчдэд түүний давуу байдал болон шинэ бүтээлийг ашиглах аргыг хангалттай, бүрэн ойлгомжтой гаргасан цогц мэдээлэл.		
Зураглал	Чертежи	Drawings
Томъёоллын агуулгыг дүрслэн үзүүлсэн дэлгэрэнгүй тайлбар.		

Патентийн мэдүүлэгт хайлт хийх	Проведение поиска по заявке на патент	Search of patent application
Мэдүүлэг хүлээн авах хүртэл дэлхийн аль нэг оронд хэвлэгдээгүй, тус улсад ямар нэг замаар тархаж мэдэгдээгүй, өмнөх бүртгэгдсэн бүтээлээс ялгарах онцлог болон заасан шалгуур байдал.		
Патентийн мэдүүлэгт шүүлт хийх	Проведение экспертизы заявок на патент	Examination of patent application
Тухайн шинэ бүтээлийн техникийн төвшингийн онцгой шинж чанар, үйлдвэрлэлд ашиглах боломж, цоо шинэ үйлдвэрлэх арга ажиллагаанд хийсэн дүгнэлт.		
Патентийн мэдүүлгийг салгах	Разделение заявки на патент	Divide the patent application
Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр мэдүүлгээ 2 буюу түүнээс дээш мэдүүлэг болгон салгах үйлдэл.		
Патент эзэмшигчийн эрх	Права патентобладателей	Patent owner rights
Патент эзэмшигч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвараа ашиглах онцгой эрх.		
Шинэ бүтээлийн улсын нөөцийн сан	Государственный резервный фонд изобретений	State reserve fund of inventions
Оюуны өмчийн газар патент бүхий шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг үр дүнтэй ашиглах зорилгоор нөөцийн санг бүрдүүлж, бүтээлийн патент эзэмших эрхийг патент эзэмшигчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр зохион явуулах үйлдэл.		
Адил төстэй тэмдгийн хайлт	Поиск тождественных знаков	Search for similar marks
Тухайн тэмдэг бүртгэгдсэн бусад бараа, үйлчилгээнд хэрэглэх барааны тэмдэгтэй ижил буюу нийтэд илэрхий болсон тэмдэгтэй ижил буюу төсөөтэйгээс төөрөгдөлд оруулах эсэхэд хийх дүгнэлт.		
Ном зүйг хэвлэн нийтлэх	Публикация библиографии	Publication of bibliography
Патент олгохоор шийдвэрлэсэн шинэ бүтээлийн томъёолол, бүтээгдэхүүний загварын зураг, барааны тэмдгийн нэр, дардсыг патентын хэвлэлд нийтлэх.		

Патентын шинжээч	Патентный эксперт	Patent examiner
Оюуны өмчийн газрын даргын тушаалаар томилогдсон, патентын чиглэлээр ажиллах, дээд боловсролтой нарийн мэргэжлээр мэргэшсэн иргэн.		
Итгэмжлэгдсэн төлөөлөгч	Поверенный	Attorney
Дээд боловсролтой, оюуны өмчийн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан, ял шийтгэлгүй, Монгол Улсын 25 насанд хүрсэн, патентын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан иргэн.		
Лиценз албадан хэрэглэх	Принудительная лицензия	Compulsory Licenses
Шинэ бүтээлийг үндэсний аюулгүй байдал, хүн амын хүнсний хангамж, эрүүл мэнд зэрэг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн, мэдүүлгийн анхдагч огнооноос хойш жил буюу патент олгосон өдрөөс хойш 3 жилийн хугацаанд шинэ бүтээлийг огт ашиглаагүй тохиолдолд хэрэглэх арга.		
Бүртгэлийн хураамж	Регистрационная пошлина	Fee of Registration
Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлэг гаргах, хүчинтэй байлгах, лицензийн гэрээг бүртгүүлэхэд Оюуны өмчийн газарт төлөх төлбөр.		
Сунгалтын хураамж	Пошлина за продление	Fee for renewal
Патентыг хүчинтэй байлгах хураамжийг тогтоосон хугацаагаар буюу эхний 3 жилийн хураамжийг патент олгох шийдвэр гарсан өдрөөс хойш 6 сарын дотор, дараахь хугацааны хураамжийг тухайн хугацаа эхлэхээс 6 сарын өмнө Оюуны өмчийн газарт төлж байгаа мөнгөн хөрөнгө.		
Шударга бус өрсөлдөөн	Недобросовестная конкуренция	The unfair competition
Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагааг хориглох, хязгаарлах, урьдчилан сэргийлэх эрх зүйн болон зохион байгуулалтын үндсийг тодорхойлж хэрэгжүүлэх харилцаа.		
Олон улсын хайлт	Международный поиск	International search
Олон улсын мэдүүлэг бүрт техникийн зохих төвшинг илрүүлэх зорилгоор хийх хайлт.		

Олон улсын хайлтын байгууллага	Международный поисковый орган	International searching authority
Шаардлага хангасан үндэсний аливаа байгууллага эсхүл, Засгийн газар хоорондын аливаа байгууллагыг олон улсын хайлтын байгууллагаар томилох томилолтод хамаарагдсан хуулийн этгээд.		
Олон улсын мэдүүлэг	Международная заявка	International application
Гэрээний дагуу өгсөн мэдүүлэг.		
Олон улсын хайлтын тайлан	Отчет о международном поиске	International search report
Олон улсын хайлтын тайланг тогтоосон хугацаанд тогтоосон маягтаар, зохих хэлээр орчуулж, тайланг мэдүүлэг гаргагчид болон олон улсын товчоонд илгээх үйл ажиллагаа.		
Олон улсын урьдчилсан шүүлт	Международная предварительная экспертиза	International preliminary examination
Мэдүүлсэн шинэ бүтээд нь шинэ бүтээлийн төвшинтэй эсэх, үйлдвэрлэлд хэрэглэх боломжтой эсэхэд хийсэн урьдчилсан дүгнэлт.		
Олон улсын урьдчилсан шүүлтийн дүгнэлт	Заключение международной предварительной экспертизы	International preliminary examination report
Дүгнэлтэд гэрээний заалтыг харгалзан томъёолол тус бүрийг шинэ байдалтай, шинэ бүтээлийн төвшинтэй, хэрэглэгдэх боломжтой эсэхийн шалгуурт заасан олон улсын урьдчилсан шүүлтийн шаардлагын үүднээс хэрхэн тодорхойлогдсоныг нотлох үйл ажиллагаа.		



Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал

“Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил”

“Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал 2004 оны 5 дугаар сарын 20-нд Төрийн ордонд боллоо.

Тус Бага хурлыг ШУА-ийн



эрдэмтэн нарийн бичгийн дарга, академич Б.Рэгдэл нээж, ХЗДХ-ийн дэд сайд Ц.Мөнх-Оргил хуралд оролцогчид баяр хүргэж үг хэллээ.

Хурал АНУ, Герман, Хятад, Солонгос, ОХУ, Монгол, Японы 130-аад төлөөлөгч оролцов.

Тус бага хурлын нэгдсэн хуралдаанд:



Роберт Ла Монт (АНУ)
 (Шүүх эрх мэдлийн шинэтгэлийн зохицуулагч) “Нийтлэг эрх зүй ба эх газрын эрх зүйн харилцан уялдаа” сэдвээр,

Тацабэ (Япон)

“Шүүхийн ил төл, хараат бус байдал” сэдвээр



Довг Суб Сам (БНСУ)
 “Өдийн засгийн хөгжил ба даяаршлын үеийн эрх зүй” сэдвээр



Академич Ж.Амарсанаа
 /ХЗҮТ-ийн захирал/
 “Монгол Улсын эрх зүйн тогтолцоо ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил” сэдвээр

А.С.Пиголкин (ОХУ)
 “ОХУ-ын хууль тогтоомж ба орчин үе” сэдвээр

Юрген Вельнер

“Даяаршил ба хувийн эрх зүй” сэдвээр



Сайто Такаши, (Япов)
 “Газрын харилцааны эрх зүйн зохицуулалт” сэдвээр илтгэл тавилаа.



Масаки Накамура
 (МУИС-ийн докторант, Япон)
 “Монгол Улсын анхдугаар Үндсэн хуулийн мөн чанар” сэдвээр илтгэл тавилаа.



Салбар хуралдааныг нийтийн эрх зүйн, хувийн эрх зүйн гэсэн чиглэлээр зохиолоо

Нийтийн эрх зүйн салбар хуралдааныг доктор, профессор Б.Чимид удирдан явуулав. “Монгол Улсын Үндсэн хуулийн хөгжлийн үечлэлийн асуудалд” сэдвээр доктор, профессор Б.Чимид, “Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлийн асуудалд” сэдвээр доктор, профессор Д.Зүмбэрэлхам, “Харьцуулсан эрх зүйн ба эрх зүйн соёл” сэдвээр МУИС-ийн докторант Х.Тэмүүжин,

в.Зууннасан (БНХАУ)
 БНХАУ-ын эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэл” сэдвээр



Хувийн эрх зүйн салбар хуралдааныг: Хууль зүйн үндэсний төвийн захирал, академич Ж.Амарсанаа удирдан явуулж, “Монгол Улс дахь хувийн эрх зүйн хөгжил, чиг хандлага” сэдвээр шинжлэх ухааны доктор, профессор Л.Баасан, “Монгол Улсын Иргэний хууль тогтоомжийн шинэтгэл” сэдвээр профессор Д.Наранчимэг, Аюуш нар “Монгол Улсын Иргэний хуулийг ХБНГУ-ын Иргэний хуультай харьцуулан судалсан нь” сэдвээр доктор, дэд профессор Т.Мэндсайхан, “Монгол улс дахь газрын харилцааны эрх зүйн тулгамдсан асуудал” сэдвээр доктор, профессор Ш.Батсүх, “Монгол Улс дахь оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал” сэдвээр МУИС-ийн докторант Д.Цолмон, “Дэлхийн Худалдааны Байгууллага ба Монгол Улс” сэдвээр МУИС-ийн докторант Б.Отгонбаяр нар илтгэл тавилаа.

ABA- Asia Law Initiative

Америкийн баарын холбооны “Азийн эрх зүйн санаачилга” төсөл

Азид эрх зүйн ёсыг дэмжих нь:

Америкийн баарын холбоо (АВХ)-ны “Азийн эрх зүйн санаачилга” буюу АВХ-ны АВА-Asia төсөл нь Азийн орнуудын эрх зүйн шинэчлэлийг дэмжихэд техникийн туслалцаа үзүүлэх зорилготой төрийн үйлчилгээний төсөл юм. Уг төслийн удирдлагыг 10 гишүүн бүхий Зөвлөл хэрэгжүүлдэг бөгөөд гишүүдийн бүрэлдэхүүнд АНУ-ын Дээд шүүхийн шүүгч Энтони Кеннеди, Цагаан ордны зөвлөх асан Ллиод Калтер, мөн Цагаан ордны зөвлөх асан Э.В.Калвехауз болон Америкийн өндөр албан тушаал бүхий хуульчид байдаг юм. АВХ-ны анхны эмэгтэй ерөнхийлөгч Роберт Куупер Рамо Зөвлөлийн даргын албыг хашиж байна.

АВХ-ны АВА-Asia төсөлд нь Төв Европын болон Евро-Азийн эрх зүйн санаачилга (АВА-СЕЕЛ) төсөлтэй эн тэнцүү амжилттай ажиллаж байна. АВА-СЕЕЛ төслийн нэгэн адилаар АВХ-ны АВА-Asia төсөл нь АНУ-д болон хилийн чанадад ажиллаж байгаа АВХ-ны мянга гаруй гишүүдийн туршлага, мэргэжлийн дэмжлэгийг хүлээн авах боломжтой байдаг. Ийм учраас АВХ-ны АВА-Asia нь хүлээн авагч оронд өндөр төвшний дэдлага, туршлагатай шинжээч мэргэжилтнүүдээр туслалцаа үзүүлэх боломжтой байна.

АВХ-ны АВА-Asia төслөөс үзүүлд болох туслалцааны хэлбэрүүд

АВХ-ны АВА-Asia төсөл дараах хэлбэрийн туслалцаа үзүүлдэг.

□ Хүлээн авагч оронд удаан хугацаагаар ажиллаж амьдардаг хууль зүйн суурин зөвлөхөөр удирдуулсан техникийн туслалцааны төслүүд;

□ Хүлээн авагч оронд зохиогдох хуулийн сургалт, хөтөлбөрүүд;

□ АНУ-д зохион байгуулагдах тусгай сургалтын хөтөлбөрүүд;

□ Санал болгож буй хууль үнэлгээ хийх, зөвлөгөө өгөх;

□ Зохиох хуулийн сэдвүүдэд дүн шинжилгээ хийж үндсэн материалуудыг бэлтгэх;

□ Тухайн орны шүүх эрх мэдлийн шинэтгэл, хууль зүйн мэргэжлийн шинэчлэлийн хүчин чармайлтын талаар болон хүний эрхийг хангах зорилгоор баримтлал болон баримт бичиг болох Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцыг хэрхэн мөрдөж байгаа байдалд албан ёсны үнэлгээ хийх.

АВХ-ны АВА-Asia төслийн туслалцаа үзүүлэх чиглэл:

□ Бүх төсөл нь АНУ-ын зүгээс оролцогч болон ивээн тэтгэгч нарын сонирхолд нийцэх бус харин Азийн орнуудын хэрэгцээ шаардлага, тэргүүлэх чиглэлд нийцсэн байх ёстой.

□ Төслүүд нь Америкийн хуулийн туршлага, уламжлалыг хүлээн авагч орны хувьд харьцуулсан эрх зүйн үүднээс анхааран үзэж буй хандлагын нэг хэмээн хүлээн зөвшөөрсөн байх ёстой.

□ АВХ-ны АВА-Asia төсөл нь үр ашгтай бизнес хөгжүүлэх арга бий харин төрийн үйлчилгээний чиг үүрэг бүхий төсөл юм. Иймээс АВХ-ны АВА-Asia төсөл нь ашиг сонирхлын зөрөлдөөнөөс ангид, төвийг сахисан, оролцогчдоос санал болгосон техникийн туслалцааг баталгаажуулах зорилгоор ёс зүйн хатуу чанга удирдамжийг бий болгосон. Түүнчлэн тохиромжтой үед нь сайн санааны зарчимд тушиглэн үйлчилгээ үзүүлдэг.

АВХ-ны Азийн төслүүдийн санхүүжилт нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, АНУ-ын Төрийн Департамент зэрэг АНУ-ын засгийн газрын эх үүсвэрээс гадна Форд сан гэх мэт хувийн хандивын сангуудаас өгсөн тусламжийн хөрөнгөөс бүрддэг.

АВХ-ны АВА-Asia төслийн өнөөгийн үйл ажиллагаа дараах асуудалд анхаарал хандуулдаг. Үүний:

- Хуулийн болон шүүх эрх мэдлийн мэргэжлийн хөгжилт;
- Авилга, хээл хахуультай тэмцэх;
- Иргэдийн өмгөөлүүлэх эрх.

АВХ-ны АВА-Asia төслөөс саяхан хэрэгжүүлж дууссан боловч хэрэгжүүлж байгаа зарим төслийн талаар дурдвал:

◆ Афганистаны хэрэгцээг үнэлэх;

◆ Афганистаны арилжааны хуулийн төсөл;

◆ Камбожийн хүний эрхийн хөтөлбөр;

◆ Хятадын хүрээлэн буй орны удирдлага ба ухуулга сурталчилгааны хөтөлбөр;

◆ Авилгын эсрэг бүсийн хөтөлбөр;

◆ Хятад дахь эрх зүйн туслалцаа үзүүлэх төсөл;

◆ Хятад дахь хуульчийн ёс зүй ба эрүүгийн хуулийн талаарх сургалтууд;

◆ Индонезийн Баарыг бэхжүүлэх төсөл;

◆ Филиппиний эрх зүйт ёсны хөтөлбөр;

◆ Тайландын төрийн зөвлөлд туслалцаа төсөл;

◆ Энэтхэгийн эрүүгийн шүүн таслах ажиллагааны хөтөлбөр;

◆ Хятадын шүүх

хуралдааныг үзүүлэн таниулах хөтөлбөр.

Хаяг:

AMERICAN BAR ASSOCIATION
740 15th Street, N.W.
Washington, D.C.20005
P: 202/662-1971
F: 202/662-1884

Email: abaasia@abanet.org
www.abanet.org/aba-asia